

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД
ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ****Ү.Хосбаяр**ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын
тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

Товч агуулга: Монгол улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд УИХ-аас Зөрчлийн тухай, Эрүүгийн, Төрийн албаны тухай зэрэг олон хуулиудыг шинэчлэн найруулж баталснаар тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын үйлчлэх хүрээ тэлж үүнийг дагасан хууль зүйн нэр томьёо, үйл ажиллагаа нэмэгдсэн. Үүний нэг тод жишээ нь ЭХХШТХуулинд тусгагдсан мөрдөн шалгах нууц ажиллагаа юм. Энэхүү илтгэлээр Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж чухам юуг ойлгох, энэ нь гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан арга, ажиллагаа мөн эсэх, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий этгээд нь хэн байх зэрэг асуудлаар санал бодлоо илэрхийлэхийг зорилоо.

Краткое содержание: В рамках правовой реформы были приняты Государственным великим хуралом Закон о правонарушениях, Уголовный кодекс, Закон о государственной службе, в результате которых расширились сфера правового регулирования введены новые понятия, термины. Один из ярких примеров является институции негласного следственного действия. В данной статье автор старался дать определение негласному следственному действию, как понять, является ли оно оперативно-розыскным мероприятием, уполномоченный детектив сотрудник какой службы и т.д.

Түлхүүр үг: Мөрдөн шалгах ажиллагаа, нууцлал, Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа, нэр томьёо, зэрэглэл.

Ключевые слова: Следственное действие, оперативно-розыскная деятельность, негласное следственное действие, термины, категория.

Үндсэн хэсэг

Монгол улсын Их хурлаас баталж 2018 оны 09 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн Хэрэг Хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг хуулиар хүлээсэн /Цагдаагийн байгууллага/ байгууллагаас явуулах гэмт хэргийг шалгах, нотлох ажиллагаа буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа гэх нэр томьёог өөрчилж мөрдөн шалгах ажиллагаа гэсэн нэршилтэй болгон хуульчилж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээс бусад ажиллагааг энэ нэр томьёонд хамааруулан ойлгохоор заажээ.¹ Энэхүү мөрдөн шалгах ажиллагаа нь хэлбэрийн хувьд нууцаар явагдаж болох тухай мөн хуульд бас давхар тусгагдаж мөрдөн шалгах нууц ажиллагаанд багтаасан аргууд нь гүйцэтгэх ажлын аргуудтай нэр, томьёо, агуулгын хувьд ижил байгаа нь “Цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлын арга, түүний онол практикын асуудал” сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байгаа судлаачийн хувьд энэ сэдвийг сонгох шалтгаан болсон юм.

¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4.9

Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж ямар үйл ажиллагааг ойлгох вэ? Хуульд прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагаа гэж хуульчилжээ.² Хуулийн энэ заалтаас аль прокурор зөвшөөрөл олгох, энэ нууц гэдэг ойлголтыг ямар ухагдахуунаар хүлээн авах ёстой вэ? гэдэг асуултууд гарч ирж байна.

Гүйцэтгэх ажлын тухай МУ-ын хуулийн 23-р зүйлд Улсын ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд урьдчилан бичгээр зөвшөөрөл өгсний үндсэн дээр хэрэгжүүлэх гүйцэтгэх ажлын 6-н аргыг хуульчилсан байдаг. Энэ нь гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээллийг шалгах болон Гүйцэтгэх ажлын хэрэг нээн шалгах ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд прокуророос зөвшөөрөл шаардахгүй гэсэн санааг илэрхийлж байдаг. Хуулийн энэ заалт нь гүйцэтгэх байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт үйлдлийг эцсийн хор уршигт хүргэхгүйгээр таслан зогсооход чиглэсэн идэвхтэй үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах нөхцөл бололцоог олгож нууцлал, аюулгүй байдлыг хангах чухал зохицуулалт нь болж өгдөг. Энэ ч утгаараа Монгол улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13 ны өдрийн 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ад зөвхөн Гүйцэтгэх ажил түүний үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, мэдээллийг Төрийн нууцын ангилалд “Онц чухал нууц”, “Маш нууц” –ын зэрэглэлтэйгээр оруулсан.

Тэгвэл мөрдөн шалгах нууц ажиллагаанд хяналт тавих прокурор нь хэн байх вэ? одоогоор практикт мөрдөн шалгах нууц ажиллагаанд Улсын ерөнхий прокурорын тусгайлан эрх олгосон прокурор зөвшөөрөл олгож байгаа ба мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулсан материал нь хэрэг бүртгэлтийн хэрэгт хавсаргагдаж хэрэг бүртгэлтийн хэрэгт хяналт тавьж байгаа прокурор нь түүнийг хянаж байгаа гаж тогтолцоо үйлчилж байна. Тэр бүү хэл хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын эрүүгийн хэргүүдийг прокуророос яллах дүгнэлт үйлдэн шүүх рүү шилжүүлэх явцад тухайн хэргийн яллагдагчид өөрт нь болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд танилцуулах үед эрүүгийн хэрэгт авагдсан мөрдөн шалгах нууц ажиллагааны материалыг үзэж байгаа нь нууцлалын асуудлыг хөндөж байна.

Тэгвэл мөрдөн шалгах нууц ажиллагааны нууц гэх нэр томъёог нууцын ямар түвшинд ойлгох вэ? Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон Албаны нууцын тухай хуулийн төрийн нууцад эсхүл албаны нууцын алинд хамааруулах вэ? Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор одоогоор Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна. Эрх зүйн зохицуулалтын иймэрхүү ойлгомжгүй байдлаас шалтгаалан нууцын ямар ангилал, зэрэглэлтэй нь тодорхой бус тул түүнд хяналт тавих субъект болон мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлэгч субъект нь ч тодорхой бус байх ба мөрдөн шалгах нууц ажиллагаа нь гүйцэтгэх ажлын арга, хэрэгслийг ашиглан явуулж байгаа бие даасан үйл ажиллагаа юу, эсвэл гүйцэтгэх ажил гэж нэрлээд байгаа нууц далд аргаар гэмт хэрэгтэй тэмцэх буюу зарим тохиолдолд эрүүгийн тагнуулын ажил гэж хэсэг эрдэмтдийн нэрлээд байгаа үйл ажиллагааны илрэн гарах нэг хэлбэр үү гэдгээс шууд хамааралтайгаар нууцын ангилал, зэрэглэл нь тодорхойлогдох болж байна.

Гүйцэтгэх ажлын буюу эрүүгийн тагнуулын ажлын илрэн гарч буй хэлбэр талаас нь мөрдөн шалгах нууц ажиллагааг авч үзвэл:

1. Уг ажиллагааг явуулах эрх бүхий этгээд гэж хэн бэ? Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий Тагнуул, Авлигатай тэмцэх газар болон Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий мөрдөгч нар бүгд,

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4.10

үгүй бол эрх бүхий байгууллагуудын дарга нараас мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тусгайлсан эрхийг авсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий мөрдөгч нарын тодорхой хэсэг үү, эсхүл дээрх байгууллагуудын гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий мөрдөгч нар мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах уу гэдэг нь тодорхойгүй байна.³

Уг эрх нь ямар хэлбэрээр баталгаажих вэ? гэдэг нь мөн шийдвэрлэгдээгүй байна. Тухайн байгууллагын даргын бүрэн эрхийн хүрээнд тусгайлан мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх олгосон тушаал байх, үгүй бол ахлах мөрдөгч, чиглэлийн ахлах мөрдөгч гэх мэт тодорхой албан тушаал, ажлын байрны тодорхойлолтоор мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулж өгөх шаардлагатай эсэхийг шийдвэрлэх.

2.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах мөрдөгчийн эрхтэй холбоотой асуудал тодорхойгүй байгаагаас үүдэн тухайн этгээдийн үүрэг, хариуцлага өөрөөр хэлбэл нууцын ямар төрөл, зэрэглэлтэй мэдээлэл, үйл ажиллагаатай харьцах нь зохицуулагдаагүй, үүнээс үүдэн гарах хор уршиг, эрсдэл, нууцын хадгалалт, хамгаалалтын асуудал давхар хөндөгдөж байна.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журамд заасан зарим төрлийн ажиллагааг тухайлбал нууц ажиглалт, нууц үзлэг зэрэг арга хэмжээнүүд нь ихээхэн хэмжээний хүн хүч, хөрөнгө шаардах тул санхүүжилт, зардлын асуудал шийдвэрлэгдээгүй. Гүйцэтгэх ажлын зардлаас санхүүжүүлж болох эсэх мөн тодорхойгүй байна.

4.Мөрдөн шалгах нууц ажиллагааны нууц ажиглалт, үзлэгийг нууцаар хийх зэрэг аргыг хэрэгжүүлэх үүргийг одоогоор хэрэгжүүлж байгаа гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албад, нэгжийн алба хаагчдыг нууц гүйцэтгэх ажилтнуудыг мөрдөгч нэр томьёонд хамруулан ойлгож болох эсэх. Дээрх алба хаагчид нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах үүрэг хүлээхгүй бөгөөд эдгээр алба хаагчдын явуулсан арга хэмжээ нь гүйцэтгэх ажлын арга хэмжээ юу, мөрдөн шалгах нууц ажиллагаа юу гэдгийг ялган зааглах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах нууц ажиллагааны журамд заасан уг ажиллагааг захиалгын дагуу явуулах эрх бүхий нэгж мөн эсэх нь эргэлзээтэй байна.

5.Мөрдөн шалгах нууц ажиллагааг цагдан хорих байранд явуулахдаа тодорхой төрлийн гэмт хэргүүд буюу Хүнийг алах ЭХ-ийн 10.1, Хулгайлах ЭХ-ийн 17.1.2, 17.1.3, Мал хулгайлах ЭХ-ийн 17.12.2, 17.12.3, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ЭХ-ийн 19 дүгээр бүлэг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах ЭХ-ийн 20.7, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангах ЭХ-ийн 20.8, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших ЭХ-ийн 20.9 Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах ЭХ-ийн 20.10 Авлигын гэмт хэрэг ЭХ-ийн 22 дугаар бүлэг Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг ЭХ-ийн 29 дүгээр бүлэг⁴ зэрэг арван төрлийн гэмт хэрэг л үндэслэл болохоор хуульчилж өгсөн нь хүчиндэх, дээрэмдэх, гэр бүлийн хүчирхийлэл, залилах, цахим гэмт хэргүүдэд дээрхтэй ижил арга хэмжээг зохион явуулах зайлшгүй шаардлага тулгарсан үед гүйцэтгэх ажлын аргыг ашиглах боломжтой мэт байгаа боловч мөрдөн шалгах нууц ажиллагааны үед цагдан хорих байранд уг ажиллагааг хэн эрхлэн

³ Улсын Ерөнхий прокурор, Тагнуулын Ерөнхий Газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 19 ны өдрийн А/84, А/57 дугаар хамтарсан тушаалаар баталсан “ Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам” –н 2.1.5, 9.1

⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.7.2.

явуулах нь мөн тодорхой бус байна. Мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага нь тус тусдаа хууль, эрх зүйн зохицуулалттай, бие даасан агентлагууд байгаа нь энэхүү хуулийн зохицуулалт хэрэгжих бодит бололцоо хязгаарлагдмал байна.

Эрх зүйн зохицуулалтын энэхүү хийдэл гэх үү ойлгомжгүй байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй хэрэгцээтэй эрх зүйн зохицуулалт мөн эсэх нь эргэлзээтэй байна. Өөрөөр хэлбэл С.Зоригийн аллага гэж нэрлэгдсэн С.Зориг агсаны амь насыг санаатайгаар хохироосон гэмт хэргийг шалгах явцад хүний эрх ноцтойгоор зөрчигдөж байна гэх нийгмийн үзэгдэлд төрийн эрх барьж байсан хэсэг бүлэг хүмүүсийн зүгээс үзүүлж буй хариу үйлдэл гэж судлаачийн хувьд үзэж байна. Үүнтэй холбоотойгоор Бүгд Найрамдах Казахстан Улсын мөрдөн шалгах нууц ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар товч дурдъя.

Бүгд Найрамдах Казахстан улсад мөрдөн шалгах нууц ажиллагаа болон Гүйцэтгэх ажлын аргуудтай ижил төстэй үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг “Эрэн хайх ажиллагааны тухай” / №154-ХІІІ / хуулиар зохицуулж байгаа ба уг хууль нь анх 1994 оны 09 дүгээр сарын 15 ны өдөр батлагдаж 2018 оны 12 дугаар сарын 26 нд нэмэлт өөрчлөлт оруулжээ.⁵ Уг хуулиар мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглах арга, нууц мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглах аргуудыг ялган нэр томьёоны хувьд давхардуулалгүйгээр нэрлэн тайлбарлаж өгсөн байна. БНКУ-д эрэн хайх ажиллагааг ерөнхий болон тусгай гэж хуваасан ба мөрдөн байцаалтын ажиллагаанд мөн нууц мөрдөн байцаалтын ажиллагаанд ч ерөнхий болон тусгай эрэн хайх ажиллагааг явуулж болох боловч гагцхүү ашиглаж буй аргууд нь нууц болон ердийн мөрдөн байцаалтын ажиллагаанд давхарддаггүйгээрээ онцлогтой байна.

Тухайлбал манай улсын гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан нэг арга болох ажиглалтын арга болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан нууц мөрдөн шалгах ажиллагааны ажиглалтын аргын тухайд хэрхэн явагдах, хоорондын ялгааны талаар тодорхой тайлбар, зохицуулалт байхгүй байгаа бол БНКУ-ын эрэн хайх ажиллагааны тухай хуулиар уг арга нь эрэн хайх ажиллагааны тусгай арга бөгөөд зөвхөн нууц мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглаж байна. Уг арга нь дэлхийн аль ч улс оронд гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр түгээмэл ашиглагддаг арга бөгөөд Болгар улсын Тагнуулын ерөнхий газрын хууль⁶ Канад улсын аюулгүй байдлын албаны тухай хууль⁷ -д ч нууц арга буюу Гүйцэтгэх ажлын арга байхаар хуульчлагджээ.

Манай улсын тухайд гүйцэтгэх ажилд ашиглагддаг арга, түүний нэршлийг шууд хуулбарлан мөрдөн шалгах нууц ажиллагаа гэсэн томьёоллоор хуульчилсан нь практикт ажиллаж байгаа алба хаагчдыг маш их төөрөгдөлд оруулж байна. Ялангуяа эрүүгийн мөрдөгчөөр томилогдон ажиллаж байгаа төгсөгч нараас мөрдөн шалгах нууц ажиллагаа болон гүйцэтгэх ажлын аргуудын хооронд ямар ялгаа байгаа, явагдах дараалал, үйл ажиллагааны хувьд хэрхэн зааглагдах тухай нэгдсэн ойлголт байхгүй байна.

Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрхийн асуудал практик байгууллагад гүйцэтгэх ажлын эрхтэй алба хаагч нар буюу эрүүгийн мөрдөгч нарт хамааралтай гэх ойлголт түгээмэл байна. Энэ ч утгаараа хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулна гэсэн ойлголт байгаа бөгөөд мөрдөн

⁵ Zakon.kz

⁶ Promulgated SG 79/13.10.2015. effective The State Intelligence Agency Act

⁷ CSIS canada

байцаалтын хэрэгт төдийлөн мөрдөн шалгах нууц ажиллагаа явагдахгүй байна. Гэтэл мөрдөн шалгах нууц ажиллагаа нь гүйцэтгэх ажлын аргуудтай ижил нэршилтэй боловч бие даасан үйл ажиллагаа гэж үзэх хууль зүйн дараах үндэслэлүүд байна.

1. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан бус зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах ажиллагааг мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж ойлгохоор хуульчлагдсан.⁸ Гүйцэтгэх ажлын тухай хуульд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд урьдчилан бичгээр өгсөн прокурорын зөвшөөрөлтэйгөөр хэрэгжүүлэх харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, шуудан харилцааг хянах, орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх, нууцаар ажиглалт явуулах, хяналтын худалдан авалт, нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглах зургаан ажиллагааг хуульчилсан⁹ байдаг бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үзлэгийг нууцаар хийх, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах ажиллагаа, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, орон байранд нэвтэрч хяналт тогтоох, орон байрнаас бусад газарт нэвтэрч хяналт тогтоох, тээврийн хэрэгсэлд нэвтэрч хяналт тогтоох, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт гэсэн арван хоёр ажиллагааг хуульчилжээ.¹⁰ Өөрөөр хэлбэл Гүйцэтгэх ажлын хуульд тусгагдаагүй арга, ажиллагаануудыг өөртөө багтааснаараа мөрдөн шалгах нууц ажиллагаа нь бие даасан ажиллагаа мөн.

2. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явагдах үндэслэл, дараалал, явуулах эрх бүхий субъект, төрөл, хэлбэр, нь хуульчилагдсан буюу өөрийн гэсэн зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай учир мөрдөн шалгах нууц ажиллагаа нь бие даасан шинжийг өөртөө агуулж байна. Тухайлбал: үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг явуулахаар хуульчилжээ. “Үндэслэл бүхий сэжиг” гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаархи мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг;¹¹ гэж тайлбарласан байна. Гэтэл гүйцэтгэх ажил явуулах үндэслэл нь мэдээлэл байдаг өөрөөр хэлбэл ил буюу далд эх сурвалжийг заавал шаардана гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр мөрдөн шалгах нууц ажиллагааны явц, үр дүнгийн талаар магадлагаа үйлдэн хэрэгт хавсаргах шаардлага тавигддаг бол гүйцэтгэх ажилд энэ шаардлага тавигдахгүй.

3. Прокурорын тухай хуулийн 25-р зүйлд “Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих” талаар тусгасан нь мөрдөн шалгах нууц ажиллагаа нь гүйцэтгэх ажлаас тусдаа бие даасан, түүний явагдах үндэслэл, хэрэгжих явц, үр дүнд нь прокурор хяналт тавихаар ойлгогдож байна.

Дүгнэлт

Шинээр батлагдан хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаа нь: хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагын мөрдөгч нараас тухайн хэргийн оролцогч нарт мэдэгдэхгүйгээр прокурорын зөвшөөрлөөр тухайн мөрдөгчөөс бие даан хэрэгжүүлж буй ажиллагаа юм.

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4.10

⁹ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23.3

¹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1.3

¹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1,41,23

Тухайн хэргийн оролцогч нар буюу хэргийн сэжигтэн, хохирогч, гэрч, шинжээч, өмгөөлөгч нарт мэдэгдэхгүйгээр прокурорын зөвшөөрлөөр мөрдөгч өөрөө биечлэн гүйцэтгэж байгаа нь нууц гэсэн ойлголтыг илэрхийлж байна.

Мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлэгч субъектын хувьд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч нь өөрөө байх ба энэ ажиллагаанд Гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албад болон нууц гүйцэтгэх ажилтан, гүйцэтгэх ажлын туслах хүчийг татан оролцуулахгүй байх явдал нь төрийн нууцыг хамгаалах нэг хэлбэр юм.

Нөгөө талаас мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах зардлын талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албадаас явуулдаг гүйцэтгэх ажлын арга ажиллагаанаас тусад нь авч үзэх нэг үндэслэл юм. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлэх явцад гүйцэтгэх ажлын зардлыг ашиглах тухай болон гүйцэтгэх ажлын тухай хуульд мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад гүйцэтгэх ажлын зардал ашиглах талаар эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАГДАЖ БҮЙ НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ ШИНЖЛЭН СУДАЛСАН НЬ

USED IN POLICE ACTIVITIES TO ENSURE PUBLIC SAFETY
ANALYSIS OF DEFINITIONS OF TERMS

Б.Баянмөнх

ДХИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Цахим шуудан: bayanmunkh@uia.gov.mn

B. Bayanmunkh

Head of Police law faculty Police institute,
University of Internal Affairs Doctor of Law (Ph.D),
Police Lieutenant Colonel
State Email: bayanmunkh@uia.gov.mn

Хураангуй. Өнөөдөр дэлхий дээр байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, түүнчлэн хүний хүчин зүйлээс хамааралтай осол, сүйрэл, эмх замбараагүй байдал, террорист халдлага, бүс, нутгийн мөргөлдөөн жилээс жилд өсөж, түүнээс учрах хор уршиг, үр дагавар улам бүр нэмэгдэж байна.

Энэхүү өгүүлэлд олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй нэр томъёоны тодорхойлолтуудыг түүвэрлэн авч шинжлэн үзэх, байхгүй байгаа зарим шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтуудыг шинээр боловсруулж, эрх зүйн зохицуулалтад тусгах боломжийн талаар өөрийн санаа бодлоо товч бичсэн болно.

Abstract: Today, the number of natural disasters and dangerous phenomena, as well as human-caused accidents, catastrophes, chaos, terrorist attacks, regional and local conflicts are increasing year by year, and the harm and consequences of them are increasing.

In this article, I have briefly written my thoughts on the possibility of analyzing some of the definitions of terms used in the activities of the police organization to ensure public safety, developing new definitions of some necessary terms that do not exist, and incorporating them into legal regulations.

Түлхүүр үг. Аюул, занал, эрсдэл, аюулгүй байдал, хүч хэрэгсэл, олон нийтийн аюулгүй байдал, онцгой нөхцөл байдал, гамшиг, хор уршиг

Key word. Danger, offer, risk, security, power tools, public safety, special circumstances, disaster, harm

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”¹² гэж заасан нь төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүргийг баталгаажуулж өгсөн бөгөөд энэхүү үүргээ төрийн тусгай институтүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг.

Аливаа нийгэмд төрийн үндсэн үүрэг нь иргэдээ гадна, дотнын аюул заналхийллээс хамгаалж, эрх, ашиг сонирхлыг нь хангах явдал байдаг. Ардчилсан нийгэмд хүний аюулгүй байдлыг хамгаалах гэдгийг хүний жам ёсны эрх, эрх чөлөөг чандлан хамгаалах утгаар ойлгодог.¹³

Хүн төрөлхтөн өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд төрийн тусгай институт /цэрэг, цагдаа, онцгой байдал г.м/ байгуулах замаар аюул заналаас хамгаалах ажлыг явуулсаар ирсэн байдаг. Уг институтын нэг болох цагдаагийн байгууллага нь хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг, улс орны дотоод аюулгүй байдлыг хангахад голлох үүрэг оролцоотой оролцдог төрийн тусгай алба билээ.

Улс орны дотоод аюулгүй байдал, тэр дундаа олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци болон дотоодын олон хууль тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдлөгө болгон ажилладаг. Тэдгээр эрх зүйн эх сурвалжуудаас зөвхөн дотоодын хууль тогтоомж, эрх зүйн актуудад байгаа зарим нэр томъёоны тодорхойлолтуудыг 2 хэсэгт ангилан авч түүвэрлэн авч шинжлэн үзэхийг хичээлээ. Үүнд: а) Монгол Улсын хууль б) Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам гэсэн 2 хэсэгт хуваан эхлээд хуульд тусгагдсан зарим нэр томъёоны тодорхойлолтуудыг авч үзвэл:

Хүснэгт №1.

№	Нэр томъёоны нэр	Нэр томъёоны тодорхойлолт	Хуулийн зүйл
---	------------------	---------------------------	--------------

¹² Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 1992. №1

¹³ Б.Баянмөнх. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. УБ.2018. 5 дахь тал

Цагдаагийн албаны тухай хууль ¹⁴			
1.	Олон нийтийн аюулгүй байдлыг хангах	Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг;	12.1
Гамшгаас хамгаалах тухай хууль ¹⁵			
2.	Гамшиг	Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;	4.1.1
3.	Аюулт үзэгдэл	Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;	4.1.2
4.	Осол	Уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;	4.1.3
5.	Гамшгийн эрсдэл	Гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;	4.1.4
6.	Аюул	Хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;	4.1.5
7.	Эмзэг байдал	Аюулт үзэгдэл, осолд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг;	4.1.6
8.	Голомтын бүс	Гамшиг, аюул, аюулт үзэгдэл, ослын улмаас хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон, эсхүл шууд эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;	4.1.11
9.	Гамшгийн хор уршиг	Гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэрсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг сөрөг үр дагаврыг;	4.1.14
10.	Гамшгийн онцгой нөхцөл байдал	Аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг;	4.1.19
11.	Хорио цээрийн дэглэм	Цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, таслан зогсоох зорилгоор халдварласан, халдвар тээгч, халдварласан байж болзошгүй сэжиг бүхий болон тэдгээрийн харьцагч, хавьтагч хүн, мал, амьтан, эд материалыг тусгай нөхцөлд тогтоосон хугацаагаар бусдаас тусгаарлах, эмчлэх, сувилах, хяналт-ажиглалтад байлгах, ариутгахыг;	4.1.22

¹⁴ Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017. №8

¹⁵ Гамшгаас хамгаалах тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017. №7

12.	Хязгаарлалтын дэглэм	Засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлахыг;	4.1.23
13.	Бэлэн байдал	Гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг.	4.1.24
Галын аюулгүй байдлын тухай хууль ¹⁶			
14.	Гал түймэр	Гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг;	3.1.1
15.	Гал түймрийн аюултай нөхцөл байдал	Гал түймэр гарсан тохиолдолд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд шууд аюул учруулах нөхцөл бүрдсэнийг;	3.1.7
16.	Галын аюултай бүтээгдэхүүн	Галын эх үүсвэрээс болон химийн урвалын үйлчлэлээр хялбар авалцан асах, хорт хий, утаа ялгаруулах, тэсэрч дэлбэрэх аюултай бодис, материалыг;	3.1.12
17.	Объектын гал түймэр	Бүх төрлийн өмчийн хэлбэрийн барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжид гарсан гал түймрийг;	3.1.14
18.	Ой, хээрийн гал түймэр	Ой болон хээрийн бүсэд шатамхай ургамлаар дамжин гал хяналтгүй тархахыг	3.1.15
Онц байдлын тухай хууль ¹⁷			
19.	Онц байдал	Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ.	3
Дайны байдлын тухай хууль ¹⁸			
20.	Дайны байдал	Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болох үед төрийн эрх барих дээд байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт тогтоох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн, цэргийн онцгой дэглэмийг хэлнэ.	3
Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль ¹⁹			
21.	Цуглаан	Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан гэнэ.	3.1
22.	Жагсаал	Иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион	3.2

¹⁶ Галын аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2015. №28

¹⁷ Онц байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 1996. №2

¹⁸ Дайны байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 1998. №6

¹⁹ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль. Төрийн мэдээлэл. 1994. №9

		байгуулалттайгаар жагсан явж,энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал гэнэ.	
--	--	--	--

Харин одоо цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх явцад ашиглагддаг дээрхи хуулиудад тусгагдсан зарим нэр томъёоны тодорхойлолтууд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд хэрхэн тодорхойлж оруулсаныг түүвэрлэн авч үзье.

Хүснэгт №2

№	Журмын нэр	Нэр томъёоны нэршил	Тодорхойлолт
1.	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 500/-ын 500.3	Олон нийтийн аюулгүй байдал	Байгалийн гамшиг, гэнэтийн осол болон байгууллага, хүмүүсээс хүрээлэн байгаа орчин, эд зүйл, механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүй, зохион байгуулалт, техникийн хэм хэмжээг;
2.	Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын харуул, хамгаалалтыг зохион байгуулах журам /код 501/	Улсын онц чухал объект	Монгол Улсын Засгийн газраас цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хамгаалалтанд байхаар тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг;
3.	Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 502/-ын 502.2	Цуглаан	Улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг;
4.		Жагсаал	Иргэд, хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж улс төр, нийгэм эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал шаардлагаа нийтэд илэрхийлж жагсан явж байгаа үйл ажиллагааг;
5.		Хууль бус жагсаал, цуглаан	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7, 9 дүгээр зүйлд зааснаар зохион байгуулахыг хориглосон газар болон эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлэхгүйгээр явуулж буй үйл ажиллагааг;
6.		Өлсгөлөн	Хүний биеийн физиологийн хэрэгцээг нөхөхгүй хүнсний бүтээгдэхүүн, хоол тэжээлийг удаан хугацаагаар хэрэглэх, өвчин эмгэгийн улмаас хоолны шингэц муудах болон хоол тэжээлийг зориудаар хязгаарлах үед үүсэх эмгэг байдлыг;
7.		Суулт	Цуглаан зохион байгуулж буй хэлбэрийг;
8.	Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй	Нийтийн эмх замбараагүй байдал	Олныг хамарсан түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн

	байдлыг хангах журам /код 504/-ын 504.2		эсэргүүцэх нөхцөл байдлыг.
9.	Гамшгийн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 508/-ын 508.2	Гамшиг	Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг;
10.		Аюулт үзэгдэл	хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн мал амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортой мэргэгчид тархах зэргийг;
11.		Техникийн холбогдолтой осол	Үйлдвэрлэл технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг;

Олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор зарим хууль болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд орсон нэр томъёоны тодорхойлолтуудыг хооронд харьцуулан шинжвэл агуулгын хувьд адилхан мэт боловч адилгүй байгаа нь эрх зүйн хувьд маргаан үүсэх хүчин зүйл болж байна.

Хүснэгт №3.

№	Нэр томъёо	Монгол Улсын хууль	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам ²⁰
1.	Гамшиг	Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;	Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг;
2.	Аюулт үзэгдэл	Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэргэгч тархах зэргийг;	Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн мал амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортой мэргэгчид тархах зэргийг;
3.	Осол / Техникийн холбогдолтой осол	Уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис	Үйлдвэрлэл технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг;

²⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2022

		алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;	
4.	Цуглаан	Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан гэнэ.	Улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг;
5.	Жагсаал	Иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал гэнэ.	Иргэд, хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж улс төр, нийгэм эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал шаардлагаа нийтэд илэрхийлж жагсан явж байгаа үйл ажиллагааг;

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглагддаг зарим нэр томъёоны тодорхойлолтууд нь хууль болон журамд агуулгын хувьд адил мэт боловч үг зүйн хувьд харилцан адилгүй байдлаар тусгагдсан байгааг харж болохоор байна.

Түүнчлэн хуульд байгаа зарим нэр томъёоны тодорхойлолтууд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд байх ёстой боловч байхгүй байгаа, мөн журамд тусгагдсан нэр томъёоны тодорхойлолтууд салбар хуульд байх ёстой боловч байхгүй байгаа нь анхаарвал зохих асуудал болж байна. Тухайлбал:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 502/-ын 502.2-д байгаа “Хууль бус жагсаал, цуглаан”, “Өлсгөлөн”, “Суулт” гэсэн нэр томъёоны тодорхойлолтуудыг нэмэлт өөрчлөлт оруулах замаар оруулвал зохицуулалтгүй орхисон дээр харилцаануудыг шийдвэрлэх боломжтой болно. Нөгөө талаараа цагдаагийн алба хаагчид хууль бус жагсаал, цуглаан болон өлсгөлөн, суултын талаар хуульд байгаа нэр томъёог харвал илүү ойлгомжтой, эрх зүйн хүчин чадал нь нэмэгдэх юм.

Онц байдлын тухай хуульд Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 504/-ын 504.2-д байгаа “Нийтийн эмх замбараагүй байдал” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг нэмэлт өөрчлөлтөөр оруулах шаардлагатай гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Онц байдлын тухай хуульд заасан онц байдал зарлах үндэслэл дотор нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэсэн тодорхойлолт байдаггүй. Тэгсэн мөртлөө зарлах үндэслэл дотор эмх замбараагүй байдал гэсэн нэр томъёоны нэршил яваад байдаг. Үүнийг засч сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Үнийн зэрэгцээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд зайлшгүй байвал зохих зарим нэр томъёоны тодорхойлолтуудыг холбогдох хуулиудаас авч оруулж өгөх нь зөв юм. Учир нь өдөр дутам хэв журам сахиулах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид тэр болгон үйл ажиллагаанд шаардлагатай салбар хуулиудыг уншиж, ажиллагаанд ашиглагдах нэр томъёоны агуулга, учир зүйг уншиж, танин мэдэх, ялган ойлгох явдал дутмаг байдаг тул үйл ажиллагааны журамд оруулж өгвөл журмыг

дагаж мөрдөхөд илүү хялбар дөхөм болгох юм. Тиймээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны дараах журамд дор дурдах зарим нэр томъёоны тодорхойлолтуудыг оруулж өгөх шаардлагатай байна.

Тухайлбал, ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 тоот тушаалаар батлагдсан “Онц байдал зарласан үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам” /код 505/-ын 505.2²¹-д “Нэр томъёо” гэсэн хэсгийг шинээр нэмж, Онц байдлын тухай хуульд байгаа “Онц байдал”, “Дайны байдал” гэсэн нэр томъёоны тодорхойлолтуудыг шинээр нэмж оруулах нь зүйтэй.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаанд ашиглагддаг зарим нэр томъёоны тодорхойлолтуудыг салбар хууль болон үйл ажиллагааны журамд тусгагдсан байдлыг түүвэрлэн авч харьцуулан шинжин үзвэл хууль болон журамд нэг нэр томъёоны тодорхойлолтыг агуулгын хувьд адил төстэй боловч үг зүйн хувьд зөрүүтэй байдлаар тодорхойлжээ. Энэ нь цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны явцад эрх зүйн маргаан үүсэх нэг хүчин зүйл болж болох юм.

Түүнчлэн хууль байвал зохих зарим нэр томъёоны тодорхойлолт үйл ажиллагааны журамд тодорхойлсон, мөн үйл ажиллагааны журамд байвал зохих зарим нэр томъёоны тодорхойлолтууд хуульд байгааг анхаарч холбогдох зүйл заалтуудад нь нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн ач холбогдлыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Онц байдлын тухай хуулийн 3.2-д Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 504/-ын 504.2-д байгаа “Нийтийн эмх замбараагүй байдал” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг нэмэлт өөрчлөлтөөр оруулах;

2. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 502/-ын 502.2-д байгаа “Хууль бус жагсаал, цуглаан”, “Өлсгөлөн”, “Суулт” гэсэн нэр томъёоны тодорхойлолтуудыг шинээр нэмж оруулах;

3. Гамшгийн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 508/-ын 508.2-д Гамшгийн тухай хуулийн 3.2-д тусгасан “Гамшгийн эрсдэл”, “Аюул”, “Эмзэг байдал”, “Голомтын бүс”, “Гамшгийн хор уршиг”, “Гамшгийн онцгой нөхцөл байдал”, “Хорио цээрийн дэглэм”, “Хязгаарлалтын дэглэм”, “Бэлэн байдал” зэрэг нэр томъёоны тодорхойлолтуудыг шинээр нэмж оруулах;

4. 505.Онц байдал зарласан үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 505/-ын 505.2 -д “Нэр томъёо” гэсэн хэсгийг шинээр нэмж, Онц байдлын тухай хуульд байгаа “Онц байдал”, “Дайны байдал” гэсэн нэр томъёоны тодорхойлолтуудыг шинээр нэмж оруулах зэрэг болно.

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Дайны байдлын тухай хууль
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

²¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2022. 733 дахь тал

-Онц байдлын тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага:

-Б. Баянмөнх Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. УБ.2018.

-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2022

Сонин сэтгүүл:

-Төрийн мэдээлэл. 1992. №1.

-Төрийн мэдээлэл. 1996. №2

-Төрийн мэдээлэл. 2017. №6.

-Төрийн мэдээлэл. 2017. №12

--o0o--

ОБЪЕКТ, СУБЪЕКТ ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

(Цагдаагийн байгууллагаас явуулах объектын болон субъектын судалгааны жишээн дээр)

Г.Бямбадорж

Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Byambadorj.G

Senior teacher of the police school,
lieutenant colonel of police

Товч агуулга

Объект болон субъект хэмээх ойлголтыг хэл шинжлэл, гүн ухаан, хууль зүйн шинжлэх ухаанд тулгуурлан тодорхойлж цагдаагийн байгууллагаас явуулах объектын болон субъектын судалгааны тухай ойлголт, шинж, төрлийг тэдгээрт үндэслэн тайлбарлаж, объектын болон субъектын судалгааны ялгагдах шинж, тэдгээрийг гүн ухаан, криминологи, криминалистик зэрэг хууль зүйн шинжлэх ухааны олон салбарын онол, үзэл баримтлал, сургаалд түшиглэн тайлбарлаж болох талаар авч үзсэн.

Abstract: Based on the linguistics, philosophy, and jurisprudence, the concepts, characteristics, and types of object and subject research to be conducted by the police were explained. Based on the theories, concepts, and teachings of many fields of legal science, such as philosophy, criminology, and forensics, it was discussed how the distinguishing features of object and subject research can be explained.

Түлхүүр үгс: Объект, субъект, шинжлэх ухаан, танин мэдэхүй, философи, хууль зүйн шинжлэх ухаан, эрх зүйн онол

key words: Object subject, science, cognitive science, philosophical science, science of jurisprudence, legal theory

Үндсэн хэсэг

Хууль зүйн шинжлэх ухаанд хууль зүйн шинжлэх ухааны объектын асуудлыг олон удаа судалж байсан ч маргаантай хэвээр байна. Тухайлбал, объектын тухай ойлголтыг тодруулах мөн хууль зүйн шинжлэх ухааны дэд салбар, тэдгээрийн харилцаа холбоог хөндөх ёстой зарим холбоотой ойлголтууд нь өөрөө нарийн төвөгтэй маргаантай асуудлыг дагуулж байна²².

Шинжлэх ухаан нь объектив бодит байдлын үзэгдэл, үйл явцын үүсэх, хөгжлийн зүй тогтлыг судалдаг. Шинжлэх ухааны объект нь субъектийг танин мэдэх явцад объектив бодит байдлын үзэгдэл, үйл явцын цогц юм²³. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны судалгааны объект гэдэг нь тухайн нутаг дэвсгэр, үзэгдэл, мэдлэгийн талбар, судалгаа хийх үйл явц юм. Өөрөөр хэлбэл, судлаачийн судлах бодит байдлын нэг хэсэг юм²⁴.

Шинжлэх ухааны судалгааны объектыг салбараар нь авч үзвэл Физикийн шинжлэх ухааны объект нь байгаль, судлагдахуун нь бие махбодь ба тэдгээрийн харилцан үйлчлэл, Химийн шинжлэх ухааны объект нь, байгаль судлагдахуун нь бодисын шинж чанар, Социологийн шинжлэх ухааны объект нь нийгэм, судлагдахуун нь хувь хүмүүсийн харилцаа, Түүхийн шинжлэх ухааны объект нь түүхэн ба цаг хугацаа, судлагдахуун нь нийгмийн чухал үйл явдал байна²⁵.

«Объект» гэдэг үг нь (*objectum* - юмс гэсэн латин үгнээс гаралтай) гэдэг нь өргөн утгаараа хүний ухамсар чиглэж буй зүйл мөн бөгөөд түүнийг мэдэрч, төсөөлж, сэтгэж, танин мэдэж болно. Объект нь И.Кантын үзсэнээр субъектын эсрэг, ухамсрын эсрэг оршин буй гадаад ертөнц, бодит зүйл юм. Энэ нь субъектын танин мэдэх үйл ажиллагааны хүрээлэлд байх, гол төлөв, биет материаллаг зүйлс байх бөгөөд тэрээр бодит орчны нэг хэсэг мөний хувьд субьекттэй харилцан хамааралтай оршин байдаг.

Объект гэж нэгэн бүхэл байдлаар үзэгдэж байгаа биднийг хүрээлэн буй орчны хэсгийг хэлнэ. Тийм болохоор объект нь тогтсон байрлал, хэлбэр, дүрс, дотоод, гадаад шинж, бүрдүүлэгч элемент бүхий байна гэсэн үг. Зарим тохиолдолд объект нь субьектын үүрэг гүйцэтгэх нь бий. Тухайлбал, цагдаагийн байгууллага нь өөрөө судалгааны объект байж болох бөгөөд зарим үед өөрөө анхаарал татаж буй объектыг судлагч субьект мөн байдаг.

«Объект» гэдгийг Оксфордын хэлний тайлбар тольд²⁶ «1) Биднээс ангид, бидний ухамсраас үл хамааран оршиж буй гадаад ертөнц, материаллаг бодит байдал; 2) Ямар нэгэн үйл ажиллагаа чиглэж буй үзэгдэл, юмс» гэж дурдсан байна.

«Объект»-ыг мөн Орос хэлний тайлбар тольд²⁷ «1) Хэн нэгний үйл ажиллагаа чиглэсэн, хэн нэгний (ажиглагчийн) анхаарал хандуулсан үзэгдэл, юмс; 2) Субьектын эсрэг, түүний практик болон танин мэдэх үйл ажиллагааны хүрээнд оршин байгаа зүйл; 3) Үйлдвэр, барилга байгууламж, аж ахуйн болон бусад зориулалттай нэгж» гэж үзжээ.

«Объект» нь танин мэдэж буй субьектын мэдрэхүйд далд байдлаар, бүрэн ухамсарлагдаагүй хэлбэрээр төсөөлөгдөх ба түүнийг сэтгэхүйдээ ургуулан бодсоноор танин мэдэхүйн анхдагч өгөгдлүүд тодорч эхэлнэ. Объект нь субьектын зүгээс

²² Сырых В. М. Материалистическая теория права: избр. м., 2011. С. 50.

²³ Сырых В. М. Материалистическая теория права: избр. м., 2011. С. 50.

²⁴ Письмо Министерства образования и науки Российской Федерации от 28.12.2015 № 14-ПГ-МОН-42412.

²⁵ Матурана Умберто, Древо познания Варелы Франсиско / Пер. с англ. ЮА Данилова. - М.: Прогресс-Традиция. - 2001 г.

²⁶ Oxford English Dictionary (second edition, 1991)

²⁷ Словарь русского языка: В 4-х т. Под ред. А.П. Евгеньевой. – М.: Рус.яз., 1999.

тодорхой аргуудыг хэрэглэн танин мэдэх үйл ажиллагаа явуулсны, логик үйлдэл хийсний «үр дүн» болж харагддаг.

Объектыг хуульчлан тогтоосон тохиолдлууд байдаг. Тухайлбал, Дотоодын цэргийн тухай хуулийн 4.1.3-д «улсын онц чухал объект» гэж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг хэлнэ²⁸, Цагдаагийн албаны тухай хуулийн 12.1.5-д «хүний амь нас, эрүүл мэнд, байгал экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах»²⁹ гэх мэтээр хуульд заасан байна.

Объект нь философийн ухагдахуун мөн бөгөөд шинжлэх ухааны салбар бүрд олон янзаар тодорхойлж болох ойлголт юм. Тухайлбал, эрх зүйн зөрчлийн объект нь хууль бус халдлагаар зөрчигдсөн, эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан нийгмийн харилцаа байдаг. Гэмт хэргийн объект нь гэмт халдлагаар зөрчигдөж буй нийгмийн харилцаа, ашиг, сонирхол байдаг. Харин удирдлагын объект нь байгууллага, алба хаагч, ажилтан байна.

Дээрх тодорхойлолтуудаас объектын талаар дараах дүгнэлт хийж болохоор байна:

- Объект нь ажиглагчийн ухамсрын идэвхтэй үйлдлийн үр дүн байна.
- Объектыг мэдэрч, төсөөлж, сэтгэж, танин мэдэж болно.
- Объект нь ажиглагчийн танин мэдэх үйл ажиллагааны хүрээлэлд байна.
- Объектыг судлахын тулд танин мэдэхүйн аргуудыг хэрэглэж болно.
- Объектыг танин мэдсэнээр түүнийг илэрхийлэгч өгөгдлүүд тодорхой болно.

Эдгээр болон бусад дүгнэлтүүдээс цагдаагийн байгууллага өөрийн сонирхлын объектуудыг судалж, мэдэрч, улмаар танин мэдэж болох философи утга ойлгогдож байна.

Ийнхүү объект нь ажиглагчийн идэвхтэй ухамсарлах үйл ажиллагааны явцад, танин мэдэхүйн тодорхой аргуудыг хэрэглэснээр судлагдаж, түүнийг тодорхойлох онцлог шинж чанар, бүрдүүлэгч элементүүд нь илрэн харагддаг болохыг бид харж байна. Тэгвэл «субъект» гэж юу болохыг одоо авч үзье.

«Субъект» (*subjectum* – *төвд нь байх, суурь нь болох* гэсэн латин үгнээс гаралтай) гэдэг нь өргөн утгаараа үйл ажиллагаа, ухамсарыг тээгч бодгаль юм. Субъект нь эерэг утгаараа объектыг буюу гадаад ертөнцийг танин мэдэгч, өөрийн практик үйл ажиллагаагаараа түүнд эерэгээр нөлөөлөгч байдаг. Танин мэдэхүйн субъект гэдэг нь нийгмийн харилцаанд оршин буй ухамсар бүхий хүн байх бөгөөд түүний идэвхтэй ухамсарлах үйл ажиллагаа нь сонирхол татаж буй объектын нууцыг ойлгоход чиглэж байдаг.

Танин мэдэгч субъект нь далд мэдээллийг илрүүлэх, түүнийг олзлох, боловсруулалт хийх, хэрэглэхийн тулд тасралтгүй хөгжиж байх ёстой. Өөрөөр хэлбэл, хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэр дээр байрлах хэв журмын хувьд анхаарал татаж байгаа объектуудыг өөрийн идэвхтэй үйлдлээр танин мэдэхийн тулд тодорхой арга эзэмшсэн байхын сацуу хувь хүний, албаны тодорхой шинжүүдийг өөртөө хөгжүүлнэ гэсэн үг юм.

Ийм тул цагдаагийн байгууллага, хэв журмын алба, хэсгийн байцаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор сонирхол татаж буй объектуудыг, тухайлбал, гэмт хэрэг, зөрчил байнга гардаг газар, цэг, согтууруулах

²⁸ Дотоодын цэргийн тухай хууль. «Төрийн мэдээлэл» эмхэтгэл. 2017. №08.

²⁹ Цагдаагийн албаны тухай хууль. «Төрийн мэдээлэл» эмхэтгэл. 2017. №08.

ундааны зүйл шаглан зардаг мухлаг г.м.-ийг тодорхой арга, тактикийн тусламжтайгаар хяналтандаа авч, байнга анхааралдаа байлгахын тулд эерэг субъектын онцгой шинжүүдийг өөртөө агуулж байх шаардлагатай болж байна.

Субъект нь сөрөг утгаараа гэмт ухамсарыг тээгч, гэмт үйл ажиллагааг өдүүлэгч байж болно. Энэ тохиолдолд субъект нь цагдаагийн байгууллагын тухайд хүн (гэмт хэрэгтэн, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд), эсвэл тодорхой шинжээр нэгдсэн бүлэг хүн (гэмт бүлэглэл, орчиндоо сөрөг нөлөөлөл үзүүлж буй бүлэг этгээд) байна гэж ойлгож болно.

Цагдаагийн байгууллагын сонирхол татаж буй субъектыг тодорхой шинжүүдээр нь дараах байдлаар бүлэглэн ангилж болох бөгөөд янз бүрийн тохиолдолд эдгээр ангиллыг ашиглан субъектыг бүрэн танин мэдэх боломжтой хэмээн бид үзэж байна:

1) Гадаад ертөнцийг, хүрээлэн буй орчинд (объектод) гэмт үйл ажиллагаагаараа нөлөөлөгч бодгаль;

2) Объектод сөргөөр нөлөөлөн өөрчлөгч хүн, эсвэл нэгдмэл бүлэг хүн;

3) Хувийн тодорхой сөрөг шинж чанарыг агуулагч, тээгч (хувь хүн);

4) Нийгмийн тодорхой сөрөг шинж чанарыг агуулагч, тээгч (бие хүн);

5) Хууль зүйн утгаар: сэжигтэн, ялтан, захиргааны хяналтанд буй этгээд;

«Объектын болон субъектын судалгаа» гэсэн холбоо үгс нь тодорхой утга бүхий ухагдахуун болж олон жилийн туршид цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байна. Энэ ухагдахуун нь ямар утгыг агуулж байгаа болохыг авч үзье.

«Судалгаа» гэдэг нь «мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтээлч, тогтолцоотой ажил»³⁰ юм. Аливаа юмны зүй тогтлын учир холбогдлыг тайлах, танин мэдэх үйл ажиллагааг судалгаа гэнэ. Судалгаа гэдэг нь янз бүрийн хүчин зүйлээс хамаарч юмс, үзэгдэл хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг нээн олох, хэрэглээнд ашиглах үйл ажиллагаа юм. Судалгааг явуулахад тогтсон онол, арга зүйг ашиглаж тодорхой үр дүнг гаргаж авдаг.

Судалгаа нь тодорхой сэдэв, эсвэл асуудлын талаарх ойлголтыг бий болгох, хөгжүүлэхийн тулд мэдээллийг цуглуулах, зохион байгуулах, задлан шинжилгээ, дүн шинжилгээ хийх зэргээр явагдана. Судалгаа нь аливаа зүйлийн талаар илүү мэдээлэл олж авахын тулд сураглах, тандах, ажиглах, ярилцах зэрэг идэвхтэй үйлдлүүд, урт хугацааны системтэй ажиллагаагаар хэрэгжинэ.

Судалгааг хийж буй субъектээр нь, зорилгоор нь, хүрэх үр дүнгээр нь, хандах бүлгээр нь, хамарч буй ерөнхий сэдвээр нь гэх зэргээр олон янзаар ангилж болно.

Судалгааг зорилгоор нь: 1) нээх судалгаа; 2) тодорхойлох судалгаа; 3) тайлбарлах судалгаа гэж ангилна.

а.Нээх судалгаа гэдэг нь: Асуудлыг шинээр дэвшүүлж, шинэ үр дүнд хүрэх үйл ажиллагаа юм.

б.Тодорхойлох судалгаа гэдэг нь: Судалгааны асуултын хариултыг эрж олох, юмс, үзэгдлийн холбоо харилцаа, өөрчлөлтийн мөн чанарыг бодитой, үнэн зөв тодруулах үйл ажиллагаа юм.

в.Тайлбарлах судалгаа гэдэг нь: Судалгааны асуудлын шалтгаан, үр дагаврыг олж тогтоох үйл ажиллагаа юм.

Судалгааг явуулж буй аргаар нь 1) эмпирик судалгаа (empirical); 2) онолын судалгаа (theoretical); 3) загварчлах судалгаа (modelling); 4) тооцоолох судалгаа (computational) гэж ангилна.

³⁰ Википедия – чөлөөт нэвтэрхий толь.

Дээрхээс үзэхэд дурдсан судалгааны бүх төрөл, зүйл, аргуудыг, түүнчлэн судалгааны ерөнхий ойлголтыг цагдаагийн байгууллагын объектын болон субъектын судалгаан дээр мөн ашиглаж болохыг харж болохоор байна. Үүнтэй холбоотойгоор «объектын болон субъектын судалгаа» гэсэн ухагдахууныг бид дараах байдлаар тодорхойллоо.

Цагдаагийн байгууллагын «объектын болон субъектын судалгаа» гэдэг нь бидний үзэж байгаагаар «гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор цагдаагийн байгууллагын сонирхол татаж буй объект, субъектын талаар урьдчилан цуглуулсан, бүртгэлд авсан, дүн шинжилгээ хийж эрэмблэн цэгцэлсэн, тасралтгүй баяжуулсан мэдээлэл юм». Үүнээс «объектын болон субъектын судалгаа»-ны дараах шинжүүдийг нэрлэж болохоор байна Үүнд:

- Судалгааг гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ашиглана.
- Цагдаагийн байгууллагын сонирхол татсан объект, субъектыг судалгаанд авна.
- Судалгааг урьдчилан явуулж, бүртгэлд авсан байна.
- Судалгаанд дүн шинжилгээ хийж, эрэмбэлж цэгцэлсэн байна.
- Судалгааг тасралтгүй явуулж, баяжуулсан байна гэх мэт.

«Цагдаагийн байгууллагын сонирхол татаж буй объект» гэдэг нь гэмт хэрэг, зөрчлийг өдүүлэх нөхцлийг бүрдүүлж буй тодорхой байрлал, бөөгнөрөл, цэг, орчин, янз бүрийн зориулалт бүхий байгууламж, үйлдвэр, аж ахуйн газар, олон нийтийн эзэмшлийн талбай зэрэг байж болно.

«Цагдаагийн байгууллагын сонирхол татаж буй субъект» гэдэг нь гэмт хэргийн шалтгааныг үүсгэж болох гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр завдаж байгаа, үйлдэж болзошгүй, ял эдэлсэн, захиргааны хяналтанд байгаа, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, архи, мансууруулах зүйл хэрэглэгч, хадгалагч, борлуулагч, бусдыг уруу татагч, өдөөн турхирагч, гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдэгч, хууль бус орлогоор амьдрагч зэрэг гол төлөв нийгмийн сөрөг этгээд байна. Дээр дурдсанаас гадна эрхэлж буй ажил, албан тушаал, бусад байдлын улмаас цагдаагийн байгууллагын хамгаалалтад байж болох хүмүүс цагдаагийн байгууллагын хувьд анхаарал татсан субъект байж болно.

Цагдаагийн байгууллагын объектын судалгаа нь дараах шинжийг агуулна. Үүнд:

- Тухайн объект, субъектын талаар мэдээлэл агуулагч;
- Тухайн объект, субъектын талаарх мэдээллийн эх сурвалж;
- Тухайн объектын талаар мэдээлэл дамжуулагч гэсэн үндсэн шинжтэй байна.

«Хэсгийн байцаагчийн ажлын заавар»-т хэсгийн байцаагчийн хийвэл зохих объектын судалгааны хэмээх жагсаалтыг гаргасан байх боловч уг жагсаалтад хийвэл зохих субъектын судалгаа мөн багтаж байгаа нь бидний анхаарлыг тааж байна. Эдгээр объектын болон субъектын судалгааны ялгаа зааг, онцлогыг тусгайлан судлах шаардлагатай байна. Хариуцсан нутаг дэвсгэртээ объектын болон субъектын судалгаа хийхдээ хариуцсан нутаг дэвсгэрийн орчны байдлыг судлах, өөр өөрийн арга барилаа боловсруулж, түүнийгээ онол, практиктай хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийнхээ объектын болон субъектын судалгааг бүрдүүлэхдээ оршин суугч иргэд хүн амыг судлахад гол анхаарлаа хандуулж, эерэг харилцаа тогтоож ажиллах нь тэдний дэмжлэг тусалцааг авах нөхцлийг бүрдүүлэнэ. Ахмад болон дунд үеийн цагдаагийн алба хаагчдын нутаг дэвсгэрийн объект, субъектыг төрөлжүүлэн судалж ирсэн практик туршлага нь хэсгийн төлөөлөгч, байцаагч, цагдаа нарт ашигтай цэгцтэй мэдлэгийг бий болгох, тэдний ажлын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэнээрээ ач холбогдолтой гэж үзэж болохоор байна.

Дүгнэлт

Объект болон субъект хэмээх ойлголтыг гүн ухаан, танин мэдэхүйн нийтлэг ойлголт, арга зүйгээр тайлбарлагдахын зэрэгцээ криминологи, криминалистик зэрэг хууль зүйн шинжлэх ухааны уулзварт оршиж буйн хувьд эдгээр болон бусад мэдлэгийн салбарын онол, үзэл баримтлал, сургаалд түшиглэн тайлбарлаж болохоор байна.

Эрх зүйн онолын үүднээс авч үзвэл объект нь нийгмийн харилцаанд оролцогчдын зан байдал бөгөөд түүнд үзүүлэх эрх зүйн нөлөөлөл нь эрх зүйн янз бүрийн субъектүүдийн эрх чөлөө, үүрэг, хариуцлага, эрх мэдлийн тодорхой цар хүрээ, төрөл, хэмжүүрийг тогтооход чиглэгддэг³¹. Энэ нь нийгмийн явцад хувирч өөрчлөгдөж болно. Эрх зүйн объектыг хууль тогтоомж, эрх зүйн актаар хамгаалсан тохиолдолд энэ нь эрх зүйн харилцааны объект болно гэж үзсэн нь илүү үндэслэлтэй байна.

Нөгөө талаар тухайнд объектод нийгмийн бодит үйл явдал, хүн нийгмийн харилцаа, хүмүүсийн зан үйл зэргийг судалж буй тохиолдолд үүнийг эрх зүйн объектын ангилалын хувьд үйл ажиллагааны объект хэмээн үзэж болно.

Субъект хэмээх ойлголтоос ялгаатай бөгөөд өргөн утгаараа үйл ажиллагаа, ухамсарыг тээгч бодгаль хүн юм. Субъект нь эерэг утгаараа нийгмийн харилцаанд оршин буй ухамсар бүхий хүн байх бөгөөд түүний идэвхтэй ухамсарлах үйл ажиллагаа нь сонирхол татаж буй объектын нууцыг ойлгоход чиглэж байдаг. Сөрөг утгаараа гэмт ухамсарыг тээгч, гэмт үйл ажиллагааг өдүүлэгч байж болно. Энэ тохиолдолд субъект нь цагдаагийн байгууллагын тухайд хүн (гэмт хэрэгтэн, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд), эсвэл тодорхой шинжээр нэгдсэн бүлэг хүн (гэмт бүлэглэл, орчиндоо сөрөг нөлөөлөл үзүүлж буй бүлэг этгээд) гэж тайлбарлаж болохоор байна. Субъект нь нийгмийн харилцааны гадна оршдоггүй бөгөөд ихэнхдээ эрх зүйн харилцааны субъект болдог.

Объектын болон субъектын судалгаа нь бидний үзэж байгаагаар дор дурдсан шинжээрээ ялгаатай бөгөөд объектын судалгаанд субъектүүдийн асуудлыг багтааж болохгүй бөгөөд эдгээр нь тус тусдаа бие даасан судалгааны объект болох нь харагдаж байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагаас явуулах объектын болон субъектын судалгааны ялгаатай шинжийг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд: Объектын судалгааны судлах зүйл амьгүй зүйлс байх бөгөөд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ, гэмт хэргийн нөхцөл байдал, нийгэм эдийн засаг, хүн ам зүй зэрэг цагдаагийн байгууллагын сонирхол татсан объект байна. Субъектын судалгааны судлах зүйлс нь амьтай бодгаль хүн буюу буюу цагдаагийн байгууллагын сонирхол татаж буй тодорхой субъект буюу бүлэг этгээд байна.

Объектын судалгааны судлагдахууны хувьд илүү нарийвчилсан байх ба хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, төмөр зам, авто тээврийн хэрэгслийн буудал, зам гүүр, гарц, цэцэрлэгт хүрээлэн, хүн олноор цуглардаг, амарч зугаалдаг газрууд, гэмт этгээд орогнон нуугдаж болох айл өрх, байр, орон сууц, агуй хонгил, дулааны худаг, гэмт хэргийн замаар олсон эд зүйлсийг зарж борлуулах, нууцаар хадгалж болох газрууд, орон сууцны байр, гудамжны байршилт, орчны нөхцөл байдал, гэмт хэргийн нөхцөл байдал түүний онцлог шинж гэх мэт. Харин субъектийн судалгааны судлагдахуун нь тодорхой субъект, бүлэг этгээдийн хувийн мэдээлэл, түүний онцог шинж тэмдэг байна. Тухайлбал, анатоми-физиологийн шинж, үйл хөдлөлийн шинж, сэтгэл зүйн шинж зэрэг нь субъектын судалгааны судлагдахуун болно гэж бид үзэж болохоор байна.

³¹ Поляков А. В. Общая теория права: курс лекций. СПб., 2001. 455–456; Коммуни-кативная концепция права: вопросы теории. СПб., 2003. С. 134–136.

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭЖ БҮЙ СУРГАЛТЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

**THE CURRENT STATE OF TRAINING FOR POLICE OFFICERS WITH CRIME
PREVENTION FUNCTIONS**

Б.Хулан

Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахлах дэслэгч

Khulan.B

Lecturer, University of Internal Affairs, Ph.D
candidate, Police Senior Lieutenant

Д.Булган

ДХИС-ийн УА-ын ЦУСПБ-ийн дэд профессор,
доктор (Ph.D) цагдаагийн дэд хурандаа

Bulgan.D

Associate Professor, Ph.D., Police Lieutenant Colonel, Police management
team, Academy of Management, University of internal affairs.

Товч агуулга. Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон төрлийн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсад сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өссөөр байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үр нөлөөгүй байна уу? алба хаагчдын мэдлэг ур чадвар дутмаг байна уу? эсхүл ажлын ачаалалтай байна гэх мэт олон хүчин зүйлсээс шалтгаалж байна. Тиймээс энэ сэдвийн хүрээнд цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдлэг, ур чадвар олгож буй зарим сургалтын агуулга, хүрээг судаллаа.

Abstract: The police organization is implementing various activities and measures to prevent crime. But crime has been increasing in Mongolia in recent years, so preventive measures are not effective? lack of knowledge and skills of employees? or depending on many factors such as workload. Therefore, within the framework of this topic, the content and framework of some training courses that provide knowledge and skills related to crime prevention to police officers have been studied.

Түлхүүр үг: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн алба хаагч, сургалтын хөтөлбөр.

Keywords: Crime prevention, police officers, training programs.

Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна”, мөн 38 дугаар зүйлийн 2

дахь хэсгийн 7-д Засгийн газар “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч, хэрэгжүүлнэ”³², Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна”³³ гэж тус тус заасан нь урьдчилан сэргийлэх ажил, түүнд хийх үнэлгээний гол эрх зүйн үндэслэл юм.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 2015 оны 9 дүгээр сард “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ)-ыг НҮБ-ын 193 гишүүн орны шийдвэрээр баталсан. Ядуурлыг устгах, байгаль орчноо хамгаалах, хүний тайван амгалан амьдрах эрхийг хангах, энх тайван, шударга ёсыг цогцлоох зэрэг олон улсын хөгжлийн талаарх асуудлыг шийдвэрлэхээр санал болгон дэвшүүлж буй багц зорилтуудыг тусгасан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь хүчирхийлэл, гэмт хэрэг, шударга бус байдлыг бууруулах, аюулгүй, тогтвортой хотуудыг бий болгох (ТХЗ 11), окид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах (ТХЗ 5) зэрэг тогтвортой хөгжлийн 16 дугаар зорилтод хүрэх гол түлхүүр юм³⁴.

“Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд “Цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас бүрдэнэ” гэж заасан. Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог тогтооход тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн газар зүйн байрлал, хүн амын тоо, нүүдэл суурьшил, эдийн засгийн бүтцийн байдал, гэмт хэрэг, нийтийн хэв журмын зөрчлийн гаралт, хөдөлгөөн, тархалтыг харгалзан үзэж зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн ажиллаж байна.

Цагдаагийн төв байгууллагын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгж нь Тэргүүн дэд даргын удирдлагад харьяалагдаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулан, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилт үр дүнг тооцон цагдаагийн төв Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 414 байгууллагын даргад тайлагнана.

Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтэс нь Цагдаагийн албаны тухай болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хариуцан ажилладаг. Мөн нийслэлийн урьдчилан сэргийлэх тасаг, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад гэр бүл хүчирхийлэл, хүүхдийн асуудал хариуцсан алба хаагчид, тээврийн цагдаагийн байгууллагад урьдчилан сэргийлэх хэлтэстэйгээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлж байна. Эдгээр хэлтэс, тасаг нь гэмт хэрэг, осол, зөрчлийг бууруулах,

³² Монгол Улсын Үндсэн хууль (1992)

³³ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)

³⁴ Sustainable development goals.

<https://unfoundation.org/what-we-do/issues/sustainable-development-goals/>

түүнээс урьдчилан сэргийлэх, албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, харилцах ажлыг улсын хэмжээнд төлөвлөн, зохион байгуулах, удирдлагаар хангах, бодлого чиглэл, арга зүй, үйл ажиллагааны стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, боловсронгуй болгох, бусад чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг гүйцэтгэж буй өнөөгийн байдлыг тодорхойлоход урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх хүч хэрэгслийн чадавхыг авч үзэх шаардлагатай.

Чадавх гэдэг ойлголтын талаар судлаачид янз бүрийн тодорхойлолт гаргасан байдаг бөгөөд гол агуулга нь байгууллагын хэтийн зорилгыг хангах стратегийн удирдлагын эцсийн үр дүн юм. Чадавх нь хүч хэрэгслийг бүрдүүлэгч нэгжүүдийн оновчтой бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүн, түүний сургалт, дадлага, техник, хэрэгслийн хангалт зэрэг олон зүйлүүдийг өөртөө агуулдаг³⁵.

Үндсэн хэсэг

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий 11 000 гаруй алба хаагч үүргийг гүйцэтгэн амжилттай хэрэгжүүлэн байна. Эндээс ЦЕГ-ийн урьдчилан сэргийлэх хэлтэст 7, нийслэлийн урьдчилан сэргийлэх тасаг 7, Тээврийн цагдаагийн урьдчилан сэргийлэх хэлтэст 9, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад тус тус 2-3 орон тоотойгоор тус тус ажиллаж байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ахлах мэргэжилтний (хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагч)-ийн албан тушаалын тодорхойлолтыг судалж үзлээ. Үүнд:

Хүүхдийн ГХУС мэргэжилтэн	Хүүхдийн ГХУС ахлах мэргэжилтэн
Албан тушаалын зорилго	
Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн үйлдсэн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.	гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
Албан тушаалын зорилт	
1. Хүүхдийн үйлдсэн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажилд оролцох, төлөвлөх, судлах, боловсруулах, танилцуулах, зааварчлах, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг хангуулах, биелэлт үр дүнг дүгнэх,	1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох; 2. Дээд шатны байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлан гаргасан хөтөлбөр, журам, заавар, тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион

³⁵ Дамдин, П. Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах арга зам. -Уб., 2013.

нэгтгэх;	байгуулах, тогтоосон хугацаанд үр дүнг тооцож тайлагнах;
2. Хүүхдийн үйлдсэн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэд аж ахуй нэгж байгууллагыг татан оролцуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
3. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	4. Хүүхдээс үйлдсэн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих, үр дүн тооцох;
	5. Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Хүснэгт №1. Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчдийн албан тушаалын тодорхойлолт

Дээрх зорилго, зорилтоос харахад нутаг дэвсгэр хариуцсан урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагч нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажилд оролцох, төлөвлөх, судлах, боловсруулах, танилцуулах, зааварчлах, бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих, үр дүн тооцохоор тус тус заасан байна. энэхүү албан тушаалд тавигдах шаардлагыг дараахь хүснэгтээр харуулав.

УР ЧАДВАР

Дүн шинжилгээ хийх	Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; Судалгааны арга зүйн мэдлэгтэй.
Асуудал шийдвэрлэх	Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх.
Багаар ажиллах	Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
Бусад	Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар.

Хүснэгт №2. Албан тушаалд тавигдах ур чадвар.

Хүснэгтээс харахад урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагч дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх ур чадвартай байхыг шаарддаг байна. Энэ нь бидний нэгдүгээр бүлгийн хоёр, гурав дугаар хэсэгт судалсан үнэлгээ хийхтэй холбоотой мэдлэгийг эзэмшсэн, хэрэгжүүлэх ур чадвартай байхыг шаардана гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, алба хаагч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа урьдчилсан үнэлгээ хийж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, энэхүү үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцдаа явцын үнэлгээ хийх бөгөөд эцэст нь нөлөөллийн үнэлгээ хийж, ажил арга хэмжээг дүгнэх, үр дүнг тайлагнана гэсэн үг юм. Ийнхүү урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байх явцдаа хэрэгжилтийн үнэлгээ хийх, үр дүнг тодорхойлох бөгөөд эцэст нь зорилгодоо хүрсэн эсэх, нөлөөллийн үнэлгээ хийх ур чадварыг зайлшгүй эзэмшсэн байхыг шаарддаг байна. Гэтэл энэ ур чадварыг урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчид бакалавр, магистр, болон мэргэшсэн хөтөлбөрүүдээр эзэмшиж байна уу гэдэг асуулт гарч байна.

Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчийг бэлтгэх, сургах буюу мэргэжлийн боловсон хүчин, бие бүрэлдэхүүнийг дотооддоо Дотоод хэргийн их сургуульд, гадаадад ОХУ, БНТУ, БНСУ-ын мэргэжлийн их, дээд сургууль, академиудад захиалгаар бэлтгэгдэж байна.

Дотоод хэргийн их сургуульд цагдаагийн алба хаагч нарыг бэлтгэдэг бүрэлдэхүүн сургууль болох Цагдаагийн сургууль нь Цагдаагийн эрх зүйн тэнхим, Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим, Эрүүгийн процессын эрх зүйн тэнхим, Мөрдөх албаны тэнхим, Гүйцэтгэх ажлын тэнхим, Замын цагдаагийн тэнхим, Дотоодын цэргийн тэнхим гэсэн бүтэцтэйгээр цагдаагийн алба хаагчдыг бэлтгэж байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг дараахь тогтолцоогоор явуулж байна. Үүнд:

- Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт (1 сараас 1 жил хүртэл);
- “Цагдаа ажил-эрх зүй”-ын бакалаврын зэрэг олгох сургалт (2, 3, 4, 5 жилийн өдөр, эчнээ хэлбэрээр);
- “Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” бакалаврын зэрэг олгох сургалт (2 жил);
- “Гэмт явдал судлал-эрх зүй” магистр (2 жил);
- “Цагдаагийн стратеги” магистр (2 жил);
- “Цагдаа судлал” магистр (2 жил);
- “Гэмт явдал судлал” докторын сургалт (3-5 жил).

“Цагдаагийн ажил-эрх зүй”-н бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрөөр 2022-2023 оны хичээлийн жилд тус Их сургуульд III, IV дамжаа хичээллэж байна. Энэхүү хөтөлбөр нь сургалтын агуулга, багтаамжийг 4 жилээр 8 улиралд 120 багц цаг үзэж бакалаврын зэрэг олгохоор тогтоосон. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “аюулгүй байдал, нийгмийн дэг журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны онолын суурь мэдлэгийг ашиглах чадвартай, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг

хангах цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон мэргэжлийн мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшсэн, ... харилцааны ур чадварын шаардлагыг хангасан, ... аливаа өөрчлөлтөд зохицон өөрийгөө хөгжүүлэх чадвартай цагдаагийн алба хаагчийг бэлтгэхэд оршино” гэж заасан³⁶.

Хөтөлбөрт тусгагдсан хичээлийн багцыг тоймлон авч үзвэл мэргэжлийн суурь хичээлийн хүрээнд “криминологи”, “эрүүгийн эрх зүйн ерөнхий анги” болон бусад хичээлүүд мэргэжлийн суурийн сонгон судлах хичээлд “мэргэжлийн гадаад хэл”, “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагаа”, “замын хөдөлгөөний зохицуулалт, аюулгүй байдал”, “хүүхэд ба цагдаагийн ажил”, “байгаль хамгаалах журмын эсрэг зөрчилтэй тэмцэх ажиллагаа”, “гадаадын иргэнтэй холбогдох зөрчлийг шалгах ажиллагаа”, “нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа”, мэргэжлийн хичээлд “цагдаагийн эрх зүй”, “замын хөдөлгөөний хяналт, зам тээврийн ослыг шалгах ажиллагаа”, “олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа”, “тагнах үйл ажиллагааны тактик-2”, “эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий анги”, “эрүүгийн эрх зүйн тусгай анги”, “зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаа” гэх мэт 15 хичээлийг орж байгаа боловч “урьдчилан сэргийлэх ажил”-тай холбоотой хичээл байхгүй байна. Хичээлийн тоо, багц цагийн задаргааг дараах хүснэгтээр харуулав.

Хичээлийн чиглэл	Хичээлийн тоо	Багц цаг
Ерөнхий эрдмийн заавал судлах хичээл	13	34
Ерөнхий эрдмийн сонгон хичээл	1	2
нийт	14	36
Мэргэжлийн суурь хичээл	8	24
Мэргэжлийн суурь сонгон хичээл	3	6
нийт	11	30
Мэргэжлийн хичээл	15	45
нийт	15	45
Ангийн ажил	2	0
нийт	2	0
Дадлага	4	9
нийт	4	9
Бүгд	46	120

Хүснэгт №3. Хичээлийн тоо, багц цагийн задаргаа.

Сургалтын хөтөлбөрт тусгагдсанаар мэргэжлийн суурь хичээлд 8 хичээл байгаа бөгөөд “Захиргааны эрх зүй”, “Иргэн, гэр бүлийн эрх зүй”, “Үндсэн хуулийн эрх зүй”, “Бие хамгаалах бэлтгэл”, “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл”, “Криминологи”, “Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги”, “Тактик, тусгай бэлтгэл” гэсэн хичээлүүдийг судлахаар байна.

“Криминологи”-ийн хичээлийн зорилго нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын албан хаагч болох суралцагчдыг гэмт явдлын нийтлэг болон тусгай шалтгаан, гэмт хэрэгтэн бие хүн болон гэмт хэргийн хохирогч хүний шинж онцлог, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогын үндсэн чиглэл, үзэл баримтлал, цаашдын төлөв хандлагын

³⁶ “Цагдаагийн ажил- эрх зүй” бакалаврын сургалтын хөтөлбөр. УБ., 2019 он.

талаар тодорхой мэдлэг олгох, нийгмийн сөрөг үзэгдлийг судлах арга зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хянах болон гэмт хэрэгтэн, гэмт хэргийн хохирогчтой ажиллах чадвар эзэмшүүлэх, үйл явдалд үндэс суурьтай хандаж, учир шалтгааныг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь үндэслэлтэй, нийгмийн хөгжлийн ерөнхий төлөв, төрөөс баримталж буй үзэл баримтлалаар баримжаалах хандлага төлөвшүүлэхэд оршино” гэжээ.

Криминологийн хичээлийн цаг сэдвийн төлөвлөгөөнөөс харахад “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний тогтолцоо” гэсэн 4 цагийн лекц, “гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа” гэсэн 4 цагийн семинарын хичээл орохоор төлөвлөжээ³⁷. Эндээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаарх мэдлэг олгох нь цаг маш бага бөгөөд урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, түүнд үнэлгээ хийх, арга зүй, аргачлалын талаар тухайлан судлах боломжтой хичээл байхгүй байна. Мөн “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагаа”, “хүүхэд ба цагдаагийн ажил”, “байгаль хамгаалах журмын эсрэг зөрчилтэй тэмцэх ажиллагаа” гэсэн хичээлүүдийг сонгон судлах хичээлийн хүрээнд багтаасан байна.

“Цагдаагийн ажил-эрх зүйн”-н бакалаврын хөтөлбөрөөр суралцан төгсөгчид өмнөх хэсэгт дурдсан урьдчилан сэргийлэх үүрэг бүхий алба хаагчийн ажлын байранд тавигдах шаардлагыг хангахгүй байна. Өөрөөр хэлбэл, тус сургалтын хөтөлбөр нь урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэхтэй холбоотой мэдлэг, ур чадвар олгох талаар тусгаагүй байна.

“Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” сургалтын хөтөлбөр дангаараа урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн алба хаагчийг бэлтгэж байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах, тодорхой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, олон нийттэй харилцах чадвартай, цагдаагийн байгууллагын аль ч зохион байгуулалтын нэгжид ажилласан гэмт хэргээс урьдчилан ажлын агуулга, мөн чанарыг үндсэн үйл ажиллагаандаа хослуулан хэрэглэх хандлагатай мэргэшсэн алба хаагчийг бэлтгэхэд чиглэгдэнэ³⁸” гэж заасан.

д/д	Хичээлийн түвшин	Багц цаг
1	Мэргэжлийн суурь хичээл	36
2	Мэргэжлийн хичээл	38
3	Танхимын дадлагын сургалт	4
4	Танхимын бус сургалт	13
Бүгд		91 багц цаг

Хүснэгт №4. Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний багц цагийн товчоо.

³⁷ 2022-2023 оны хичээлийн жилд заагдах “Криминологи” хичээлийн цаг сэдвийн төлөвлөгөө.

³⁸ Энэхүү хөтөлбөрөөр зөвхөн цагдаагийн байгууллагад ажиллахаас гадна Шүүх, Прокурор, Авлигатай тэмцэх байгууллага, Тагнуулын байгууллага, Үндэсний аюулгүй байдал, Улсын их хурал, Засгийн газрын байгууллага болон гэмт хэрэг, зөрчил, нийгмийн сөрөг үзэгдэлд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагад ажиллах чадвартай “Урьдчилан сэргийлэх ажилтан” бэлтгэх боломжтой юм.

Мэргэжлийн суурь хичээлд “Мэргэжлийн удиртгал”, “эрх зүй, төрийн онол”, “криминологи”, “бие хамгаалах бэлтгэл-1”, “харилцааны болон албаны ёс зүй”, “иргэний эрх зүй”, “захиргааны эрх зүй”, “эрүүгийн эрх зүй ерөнхий анги”, “цагдаагийн эрх зүй”, “галт зэвсэг, тусгай хэрэгсэл”, “тагнах үйл ажиллагааны тактик-2”, “эрүүгийн эрх зүй тусгай анги”, “бие хамгаалах бэлтгэл-2”, “мэргэжлийн гадаад хэл”, “тактик - тусгай бэлтгэл-1”, “цагдаагийн сэтгэл судлал”, “албан хэрэг хөтлөлт” зэрэг 36 багц цагийн хичээл, Мэргэжлийн хичээлд “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”, “криминологи судалгааны арга зүй”, “эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий анги”, “эрүүгийн процессын эрх зүйн тусгай анги”, “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа”, “криминалистикийн техник зүй”, “олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа”, “тодорхой төрлийн гэмт хэргийг судлах, урьдчилан сэргийлэх арга зүй”, “гэмт хэрэг зүйлчлэлийн онол”, “хэвлэл мэдээлэлтэй харилцах”, “тагнах үйл ажиллагааны тактик-3”, “гэмт хэрэг нотолгооны онол”, “криминалистикийн тактик зүй”, “мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй”, “криминалистикийн арга зүй”, “тагнах үйл ажиллагааны тактик-6”, “шүүхийн шинжилгээ” зэрэг 38 багц цагийн хичээлүүдийг судлахаар сургалтын төлөвлөгөөнд тусгагджээ.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” хичээлийн зорилго нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын онолын үндсийг тодорхойлох, түүний агуулга, ач холбогдол, мөн чанарыг танин мэдэх, гэмт хэрэг, зөрчил, нийгмийн бусад сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлын төрөл, хэлбэр, эрх зүйн үндэс, хэрэгжүүлэх тогтолцоо, гадаад зарим орны тэргүүн туршлагын талаар тодорхой мэдлэг эзэмших, чадвар, дадал олгоход оршино гэж тусгасан.

Энэхүү хичээлийн төсгөлд хүрэх үр дүнг дараах хүснэгтээр харууллаа.

Мэдлэг	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт, онолын үзэл баримтлал, агуулга ач холбогдол;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарчим, эрх зүйн үндэс;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо, байгууллага, алба хаагчдын хамтын ажиллагаа;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төрөл, хэлбэр, төлөвлөлт, зохион байгуулалт;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн техникийн арга хэмжээ, ач холбогдол, чиг хандлага;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын стратеги;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын инновац;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил ба олон нийтийн оролцоо;
	Криминологи судалгааны үр дүнг урьдчилан сэргийлэх ажилд ашиглах;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гадаад орны туршлагыг харьцуулан судлах;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт.
Чадвар	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлголт, онолын үзэл баримтлалын талаар олж авсан мэдлэгээ мэдлэгээ хэрэглэх;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ удирдлага болгох зарчмуудыг баримтлах;
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг төлөвлөж,

	зохион байгуулах, үр дүнг тооцох; Орчин үеийн техник, технологи, инновацын бүтээгдэхүүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах, инновацын шинэ бүтээгдэхүүн, үйл ажиллагаа нэвтрүүлэх; Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гадаад орны туршлагыг нэвтрүүлэх, бүтээлчээр ашиглах; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хангах; Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, асуудлыг шийдвэрлэхэд олон нийтийн санаа бодлогыг харгалзах, тэднийг дэмжлэгт түшиглэх, хамтран ажиллах, удирдан зохион байгуулах; Урьдчилан сэргийлэх ажлыг эдийн засгийн үр нөлөөтэй хэрэгжүүлэх.
Хандлага	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, иргэдийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, цогцолбор байдлаар хэрэгжүүлэх, олон нийтийн дэмжлэгт түшиглэх, өргөсөн тангарагтаа үнэнч байх хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

Хүснэгт №5. Хичээлийн төсгөлд хүрэх үр дүн.

Дээрх хөтөлбөр хэрэгжиж байгаа нь хэдий чухал ч гэсэн “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй”-н асуудлыг зааглан үзэж, нарийвчилсан хичээлүүдийг тусгах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчийн ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн “шинжлэх ухааны судалгааны арга зүй”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээ”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, стратеги”, “хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “нөхцөл байдалд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”, “Орчны загварчлалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” гэх мэт тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаарх хичээлийн агуулгуудыг тусгаж, хөтөлбөрт заавал судлах хичээлийн жагсаалтад оруулах нь зүйтэй юм. Мөн урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчдад тавигдах шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийн сайжруулалтыг хийх шаардлагатай юм.

Дүгнэлт. Монгол Улсад 2022 оны байдлаар Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт 35340, Улаанбаатар хотод 24310 /68.8%/, орон нутагт 11019 /31.1 %/, бусад газар /хилийн чанадад/ үйлдэгдсэн 11 /0.1 %/ гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд нийт 9911 хэрэг буюу 39.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 7776 хэрэг буюу 47.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 2139 хэрэг буюу 24.1 хувиар тус тус өссөн байгаа нь урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна гэж дүгнэж болохоор байна.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч байгаа нь сайшаалтай юм. Тухайлбал, яараад яах вэ дээ, аажуу явбал аяндаа хүрнэ, UnFriend хөдөлгөөн г.м маш олон төрлийн аян арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн Хөршийн хяналтын хөтөлбөр, Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны

хөтөлбөр, Эргүүл дэд хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Гэхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарал хандуулж, тэднийг гадаад, дотоодын давтан, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулах, удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтын үндсэн дээр ур чадварын шалгуураар дэвших мерит зарчмыг мөрдөх, ДХИС-ийн “Цагдаагийн ажил-эрх зүй” (Цагдаа судлал)-ын бакалаврын сургалтын хөтөлбөрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хичээлүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн “Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн агуулгыг сайжруулах урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төрлийн хичээлийг нэмэгдүүлэх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, сургалтын хөтөлбөрөөр хүрэх үр дүнг зөв тодорхойлж, түүнд чиглэсэн хичээлүүдийг тусгаж өгөх явдал юм.

--oOo--

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Д.Бямбахүү

Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Byambakhvv.D

Senior teacher of the police school,
lieutenant colonel of police

Товч агуулга

Канад, Америк, Япон, ОХУ, Бразил зэрэг гадаадын зарим улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлдэг иргэний хяналтын зөвлөлийн эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны талаар авч үзэж Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дэмжлэг үзүүлэх иргэний зөвлөлийн санхүүжилт, урамшуулал, ажиллах хугацаа, сонгон ажиллуулах шалгуур үзүүлэлтыг боловсронгуй болгох, гадаадын зарим орнуудыг арга туршлагыг нэвтрүүлэх талаар хөндөж авч үзлээ.

Abstract: The legal regulations and activities of the civil control council, which supervises and supports the activities of the police organization, were studied in comparison with some foreign countries such as Canada, America, Japan, Russia, and Brazil. The funding, incentives, tenure of the Citizens' Council, refinement of selection criteria, and introduction of methods and practices of some foreign countries to the Mongolian police were discussed.

Түлхүүр үг: Цагдаа, иргэний зөвлөл, хөнлөнгийн хяналт, дэмжлэг, цагдаагийн албаны хууль, үйл ажиллагаа, санал

key words: Civil council, police, external supervision, support, police law, activity, suggestion

Үндсэн хэсэг

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын”³⁹ 3.3.2.1-д “Иргэдэд адил тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтална”, 3.3.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”⁴⁰-д “төрийн үйлчилгээг хүртээмжтэй ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”⁴¹-ийн 5.4.5-д “Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн,... цагдаагийн байгууллагын түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 5.4.6-д “Монгол цагдааг хөгжүүлэх, цагдаа иргэдтэйгээ хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасныг үндэслэн 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлж, 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцэн шинэчлэн баталсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий иргэний зөвлөл ажиллахаар заасан байна.

Уг зөвлөл нь зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, санал өгөх; цагдаагийн алба хаагчийн сургалт болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих; цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаар ирсэн гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилд хяналт тавих, тэдгээртэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх; цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх; гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засаг даргаас хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах; цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг сайжруулан өөрийн нутаг дэвсгэр дэх иргэд, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх чиглэлээр санал боловсруулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий иргэний зөвлөлийг гадаадын зарим орны Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй иргэний зөвлөлийн ажиллаж буй туршлагыг энэхүү өгүүлэлдээ авч үзлээ.

Бразил улсын иргэний цагдаа:

Бразилд Иргэний цагдаа гэдэг нь улсын цагдаагийн хүчнийг судлах нэршлийг хэлдэг. Иргэний цагдаа нь Бразилын харьяа нэгж улсуудын нийтийн захиргааны албан товчоонд харьяалагддаг ба тэдний үндсэн үүрэг бол 1988 оны Улсын үндсэн хуулийн 144-р зүйлд заасны дагуу олон нийт дэх дэг журам, ард түмний аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд нийтийн аюулгүй байдлыг хуулийн дагуу хэрэгжүүлэх явдал юм. Бразилын муж бүр өөр өөрсдийн “Иргэний цагдаагийн хэлтэс”-тэй ба эрэн сурвалжлах ажиллагаа, шүүх эмнэлгийн, гэмт хэргийн мөрдлөг зэргийг гүйцэтгэдэг яг л мужийн

³⁹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

⁴⁰ Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан

⁴¹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан

мөрдлөгийн хэлтэс гэсэн үг. Үүний хажуугаар “Цэрэг цагдаа” нь цагдаагийн бие даасан үүргүүдийг гүйцэтгэдэг.

Мөн иргэний цагдаа шүүх цагдаагийн үүрэг, захиргааны болон хамгаалалтын цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тэдгээр нь хууль эрхзүйн дэг журмыг сахин хамгаалахад, олон нийтийн амар амгалан байдлыг бий болгоход болон иргэдийн эрх, эрх чөлөөнд баталгаа гаргахад чухал үүрэгтэй. Тайлбар: Бразилийн иргэний цагдаа 1808 онд Рио Дэ Жанейрод Цагдаагийн ерөнхий төв байранд бий болсон. 1808 онд Бразилийн хааны удмын нүүлгэлтийн үед цагдаа нь бүтэцлэгдсэн, чухал нийгмийн үүрэгтэй болж журамлагдаж эхэлсэн. Шүүхийн ерөнхий газар ба Бразилийн муж тухайн оны 5 сарын 10нд D.Jo оор байгуулагдаж, хэд хэдэн нийтлэг шинж чанартай удирдах газрууд тэнд төвлөрсөн. Жишээ нь: Ouvidor Geral, шоронгийн дарга, 4н баатар, халдлагын ахлагч.

Анхны цагдаагийн ерөнхий газрын даргаар зөвлөлийн гишүүн Paulo Fernandes Viana байсан ба тэрээр эртний Lisbon одоогийн Rio De Janeiro дахь цагдаагийн захиргааны байрыг системчилсэн. Цагдаагийн ерөнхий газар нь Бразилийн улс төрийн чөлөөлөх хөдөлгөөнийг даван туулсан ба эцэстээ 1822 оны 9 сард төгссөн. Иргэний цагдаа нь засгийн газрын эрх мэдлийн үед болон бүгд найрамдах засаглалын үед бүх орон даяар бага багаар хөгжиж байсан. Өнөөдөр, Иргэний цагдаагийн үндсэн хуулийн оршин тогтнож буй асуудал ба түүний эх сурвалж бол засгийн газрын үндсэн хуулийн 144-р зүйл болон 144-н 4-ийг үндэслэсэн. Байгууллага: Бразилд 27 иргэний цагдаагийн байгууллага байдаг. Улсын харьяа муж болгонд 1, 1 оршин байдаг. Тэд цагдаагийн ерөнхий газрын удирдагчийн удирдлага доор байдаг ба түүнийг цагдаагийн комиссын төлөөлөгчид дунд цол хэргэмийнх нь дагуу сонгодог.

Шүүх цагдаагийн үйлчилгээ Цагдаагийн газарт өрнөдөг ба тэдгээр төлөөлөгчийн газрууд жижиг хотуудыг эсвэл том хотын дөрөвний нэгийг шүүн таслах эрхтэй.

Үндсэн бүтэц, бие бүрэлдэхүүн:

- Цагдаагийн дээд зөвлөл
- Засгийн газрын танхим /Цагдаагийн ахлахын зааварчилгаан доор/
- Төлөвлөлтийн болон цагдаагийн ажиллагааны хэлтэс /Ажиллагааг төлөвлөх/
- Цагдаагийн ерөнхий газар /Санхүүжилт/
- Цагдаагийн газрын академи /Мэргэжилтэн бэлтгэх/
- Цагдаагийн хэлтсүүд /Ажиллагааны хэсэг/
- Захиргааны хэлтэс /Захиргааны дэмжлэг/
- Техник, шинжлэх ухааны хэлтэс /Техник, шинжлэх ухааны дэмжлэг/
- /Муж бүрт адилхан ба эдгээр нь салангид байгууллагууд/

Бразилийн иргэний цагдаа нь олон нийт дэх дэг журам, ард түмний аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд нийтийн аюулгүй байдлыг хуулийн дагуу хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага ба эрэн сурвалжлах ажиллагаа, шүүх эмнэлгийн, гэмт хэргийн мөрдлөг зэргийг гүйцэтгэдэг яг л мужийн мөрдлөгийн хэлтэс гэсэн үг. Мөн иргэний цагдаа шүүх цагдаагийн үүрэг, захиргааны болон хамгаалалтын цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тэдгээр нь хууль эрх зүйн дэг журмыг сахин хамгаалахад, олон нийтийн амар амгалан байдлыг бий болгоход болон иргэдийн эрх, эрх чөлөөнд баталгаа гаргахад чухал үүрэгтэй.

АНУ-ын зарим муж, хотуудын жишээ Нью-Йорк хотын иргэний зөвлөл:

Иргэний зөвлөлд тусгай хэрэгсэл хэрэглэсэнтэй холбоотой болон арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, иргэдийн доромжилсон, хэрэг зөрчлийг нь шийдвэрлээгүй тухай гомдол мэдээллийг хүлээн авч Цагдаагийн байгууллагын удирдлага, хяналт шалгалт

явуулах байгууллагад шилжүүлэн өгч шийдвэрлүүлдэг байна.⁴² 2006 онд иргэдийн 7,669 гомдол хүлээн авсан бөгөөд 2,680 (иргэн, албан тушаалтан (ууд) илэрсэн бөгөөд 7,399 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. т

Тус хотод 1955 онд одоогийн төвшнийх биш ч иргэний зөвлөл ажиллаж байсан бөгөөд 1965 онд хотын дарга Жон Линдсид шүүгч Лоуренс Е. \A/a1зИ тэрээр иргэний зөвлөлд хяналт тавих их хэмжээний эрх мэдэл өгөх саналтай байжээ. 1986 онд иргэний зөвлөлийн гишүүд нь цагдаагийн мөрдөн байцаагч нартай холбоотой гомдолд хяналт тавьж чадаж байжээ. 1988 онд иргэний зөвлөлийн үйл ажиллагаатай холбоо бослого Тотрктз талбайд болж байсан бөгөөд нэг талаас иргэд нөгөө талаас авилгад өртөгдсөн цагдаагийн байгууллагын ажилчид байсан тухай Crown Hell-ийн бослогод⁴³ тэмдэглэн үлдээсэн байна. 1993 оноос иргэний зөвлөлийн үйл ажиллагаа нь одоогийн иргэний зөвлөлийн хэлбэрт шилжиж иргэдийн гомдол мэдээллээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж эхэлсэн байна. Гомдлыг онлайн нус.gov/ccrb хягаар авч мөн 311 мэдээллийн системээр дамжуулан, ССНВ шууд, эсвэл хотын хороон дээр хүлээн авах үйл ажиллагааг бүрдүүлсэн байна.⁴⁴ Цагдаагийн байгууллагын ажилчдийн хүч хэрэглэх, авилга авах үйл ажиллагаа иргэний зөвлөлийн хяналтад орж чадсан.⁴⁵

АНУ-ын Луизана муж:

Захиргааны байгууллагад гал унтраах болон иргэний цагдаагийн төрөлжсөн үйлчилгээг албан хаагчид, ажилтнуудын албан тушаалыг оролцуулан байгуулдаг ба “гал унтраах болон иргэний цагдаагийн үйлчилгээ” гэж нэрлэнэ. Гал унтраах болон иргэний цагдаагийн үйлчилгээний зөвлөл нь Хотын гал унтраах болон иргэний цагдаагийн үйлчилгээний зөвлөлийг хотын захиргаанд байгуулна. Зөвлөл нь дотроо дарга, дэд дарга, нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөл нь орон тооны бус таван гишүүнтэй байх ба гишүүд дараах шаардлагыг хангасан байна.

- Зөвлөл нь үйлчилгээ үзүүлж буй хотдоо байрлана
- Тухайн хотын нэр дэвшигчийн шаардлага хангасан
- Тус хотын оршин суугч

- АНУ-ын иргэн Зөвлөлд гишүүнээр томилогдох, нэр дэвших эрхтэй этгээд байна. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа таван жил байна.

Хотын захиргаанаас байгуулдаг. Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, орон тооны бус таван гишүүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөл нь үйлчилгээ үзүүлж буй хотдоо байрлах бөгөөд тухайн хотын нэр дэвшигчийн шаардлага хангасан хотын оршин суугч, АНУ-ын иргэн зөвлөлд гишүүнээр томилогдох, нэр дэвших эрхтэй. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа таван жил байна. Зөвлөл нь иргэдийн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгааг хянах, цагдаагийн албаны хүний нөөцийн бодлого, албан тушаалын зэрэглэлийг батлах, шинэчлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд зөвлөгөө өгөх, туслалцаа дэмжлэг үзүүлэх зэрэг үүрэгтэй.

Канад Улсын Цагдаагийн байгууллагын хөндлөнгийн хяналтын хороо:

Канадын цагдаагийн байгууллага хөндлөнгийн хяналтын хороог байгуулан ажилладаг бөгөөд хорооны дарга, дэд даргаас гадна гурван гишүүнтэй байна. Гурван гишүүнийг Засгийн газраас томилно. Хорооны дарга байнгын гишүүн байх бөгөөд бусад гишүүнийг байнгын болон түр хугацааны гишүүнээр томилж болдог. Гишүүдийг

NYC Civilian Complaint Review Board-CCRB Performance

⁴³ NYC.gov

NYC Civilian Complaint Review Board- History

Gabriel J. Chin ed., New York City Police Corruption Investigation, 1894-1994 (Williams S.Hein 1997) ISBN 978-1-57588-211-6

таван жилийн хугацаатай томилох бөгөөд шаардлагатай тохиолдолд Засгийн газар хугацаанаас нь өмнө чөлөөлж болно. Томилгооны хугацаа дууссаны дараа гишүүнийг дахин томилж болно. Цагдаагийн байгууллагын алба хаагч хорооны гишүүн байхыг хориглоно. Хорооны байнгын болон түр хугацааны гишүүдийн цалинг тэдгээрийн гүйцэтгэх ажилтай холбогдуулан Засгийн газраас тогтооно. Хорооны байнгын гишүүдийг “нийтийн алба хааж байна” гэж үздэг. Хорооны дарга эзгүй, үүргээ биелүүлэх боломжгүй байгаа тохиолдолд Сайд хорооны дэд даргыг үүрэг гүйцэтгэгчээр томилж болно. Хорооны дарга санхүүгийн жил өндөрлөснөөс хойш 3 сарын дотор тухайн жилийн хорооны үйл ажиллагаа, зөвлөмж бүхий жилийн тайланг Сайдад хүргүүлэх бөгөөд Сайд тайлангийн хувийг Парламентын хоёр танхимд чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор хүргүүлдэг. Засгийн газраас таван жилийн хугацаатай томилдог, дарга, дэд дарга, гурван гишүүний бүрэлдэхүүнтэй, хорооны дарга нь байнгын, бусад гишүүд нь байнгын болон түр хугацааны гишүүнээр хугацаатай томилогддог байна. Хорооны байнгын гишүүдийг “нийтийн алба хааж байна” гэж үздэг. Хороо нь цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хорооны үйл ажиллагаа, жилийн тайланг хууль зүйн сайдад тайлагнах, зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Канад Улсын Ванкувер хотын Цагдаагийн иргэний зөвлөл:

Канад улсын Ванкуверт Цагдаагийн зөвлөл ажилладаг. Цагдаагийн иргэний зөвлөлийн даргаар Ванкуверийн хотын дарга ажилладаг ба нэг гишүүнээр нь Ванкувер хотын захиргааны нэг гишүүн томилогдох бөгөөд бусад 5 гишүүн нь орон нутгаас томилогддог байна. Ванкуверын Цагдаагийн зөвлөл нь Цагдаагийн тухай хуульд зааснаар хараат бус, бие даасан, бүрэн эрхийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Цагдаагийн зөвлөл нь хотын захиргаатай онцгой харилцан хамааралтай байдаг бөгөөд улс төрийн шийдвэр гаргах үйл явцаас цагдаагийн газрыг бүрэн тусгаарлан ажилладаг.

Иргэний зөвлөлийн даргаар Ванкувер хотын дарга ажилладаг ба нэг гишүүнээр нь Ванкувер хотын захиргааны гишүүн, бусад гишүүдэд энгийн иргэдээс томилогддог байна. Цагдаагийн тухай хуульд зааснаар хараат бус, бие даасан, бүрэн эрхийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд улс төрийн шийдвэр гаргах үйл явцаас цагдаагийн газрыг бүрэн тусгаарлан ажилладаг.

Оросын Холбооны улс⁴⁶: Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “ОХУ-ын Дотоод явдлын яам, харьяа агентлагуудын олон нийтийн зөвлөлийн тухай” 668 дугаар зарлигаар ОХУ-ын төрийн эрх барих албан тушаалтан, эрх бүхий байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага, хууль сахиулах байгууллагууд, дүүргийн болон бусад байгууллага тэр тусмаа мэргэжлийн холбоод, ОХУ-ын дотоод хэргийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд, түүнчлэн цагдаагийн байгууллага, иргэдийн олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд ОХУ-ын Дотоод явдлын яамны дэргэд болон Дотоод явдлын яамны харьяа байгууллага, агентлагуудын дэргэд олон нийтийн зөвлөлийг байгуулжээ.

Олон нийтийн зөвлөл нь шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд зөвлөх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Олон нийтийн зөвлөл нь дараах үндсэн чиг үүрэгтэй:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон холбоодын ашиг сонирхлыг төлөөлж нийгмийн хэв журмыг хамгаалах орчинд улс төрийн оролцоог хангах,

⁴⁶ Албан бус орчуулга

профилактики эрхийн зөрчил, олон нийтийн аюулгүй байдлыг хангах түүнчлэн улс төрийн үйл ажиллагааг гэмт явдалтай тэмцэх орчинд хангах,

- Дотоод хэргийн байгууллагууд, олон нийтийн нэгдэл, холбоодын тулгамдсан асуудлууд, иргэний инициатив, концепц, хөтөлбөрүүдийг эргэн харж сайжруулахад гардан оролцох,

- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар олон нийтийн анхаарлын төвд байгаа болон бусад асуудлаар иргэд, олон нийтэд мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийхэд оролцох,

- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн санаа бодолд дүгнэлт хийж үр дүнгийн талаар дотоод хэргийн байгууллагуудын удирдлагад мэдээлэл хийх,

- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх холбооны хууль, бусад эрхийн актуудын төсөлд дүн шинжилгээ хийх,

- Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны “ОХУ-ын Дотоод явдлын яам, харьяа агентлагуудын олон нийтийн зөвлөлийн тухай” 668 дугаар зарлигаар байгуулагдсан ОХУ-ын төрийн эрх барих албан тушаалтан, эрх бүхий байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага, хууль сахиулах байгууллагууд, дүүргийн болон бусад байгууллагууд тэр тусмаа мэргэжлийн холбоод, ОХУ-ын дотоод хэргийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд, мөн түүнчлэн цагдаагийн байгууллага, иргэдийн олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд Олон нийтийн зөвлөлийг байгуулсан. Зөвлөл нь Дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль, бусад эрхийн актуудад дүн шинжилгээ хийх, дотоод хэргийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал бодолд үнэлэлт, дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх зэрэг үүрэгтэй ажилладаг байна.

Япон улс:

Ерөнхий сайдын дэргэд Төрийн олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлийг байгуулан ажилладаг. Тус зөвлөл нь зөвлөлийн дарга, 5 гишүүнээс бүрдэх ба зөвлөлийн дарга нь Ерөнхий сайд байна. Зөвлөл нь улсын олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг удирдаж, цагдаагийн ажилтны сургалт, харилцаа холбоо, мэдээлэл, технологийн дүн шинжилгээ, криминологи, гэмт хэргийн статистик болон цагдаагийн байгууллагын тоног төхөөрөмжид хяналт тавьж ажиллахаас гадна хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж олон нийтийн аюулгүй байдал ба хэв журмыг сахиулах үйл ажиллагаанд хяналт тавьдаг болно. Зөвлөлийн үйл ажиллагааг Цагдаагийн байгууллагын тухай хууль, Япон улсын төрийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг явуулах тухай журмаар зохицуулагддаг.

Япон улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд Орон нутгийн (Засаг захиргааны нэгжийн) олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл ажилладаг. Засаг захиргааны нэгжүүдийн засаг даргын харьяалалд Орон нутгийн олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл байна. Уг орон нутгийн зөвлөл нь нийслэл, аймгийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухай хуульд заасны дагуу нэр заагдсан аймагт 5, нэр заасан аймгаас бусад аймагт 3 гишүүнтэйгээр байгуулагддаг. Орон нутгийн зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг удирдана. Уг орон нутгийн зөвлөл нь Төрийн аюулгүй байдлыг сахин

хамгаалах зөвлөл болон бусад Орон нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлтэй нягт холбоотой ажиллана.

Орон нутгийн зөвлөл нь Японы нэр заагдсан аймгуудад 5, бусад аймгуудад 3 гишүүнтэйгээр байгуулагддаг. Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг удирдаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах зэрэг үүрэгтэй ажилладаг байна. Мөн зөвлөл нь Төрийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл болон бусад Орон нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөлүүдтэй нягт холбоотой ажиллаж байна.

Дэд дүгнэлт

Канад, Америк, Япон, ОХУ, Бразил зэрэг гадаадын зарим улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг, дэмжлэг үзүүлдэг иргэний хяналтын талаар эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны талаар туршлага, Монгол Улсын цагдаагийн байгууллагын онцлогийн харьцуулан судалснаар Монгол Улсад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих чиг үүрэг бүхий Иргэний зөвлөл байгуулах, тогтвортой ажиллуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж байна. Үүнд Англи улсад иргэний зөвлөл байгуулагдаж, тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулсан боловч улс төрийн шалтгаанаар хэдхэн жилийн өмнө татан буугдсан туршлагыг Монгол Улс сайтар судалж, нэвтрүүлэх, цаашид хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Санал

1.Монгол Улсын цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих чиг үүрэг бүхий Иргэний үндэсний зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын дэргэд бий болгож, аймаг, нийслэлийн иргэний зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулж ажиллах;

2.Иргэний зөвлөлийн гишүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс тэдний ажиллах хугацааг 5-6 жил байхаар Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;

3.Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 62 дугаар зүйлийн 3 дэх хэсэгт “Иргэний зөвлөлийн гишүүн нь сүүлийн 5 жил цагдаа, прокурор, шүүгч, төрийн улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй, ял шийтгэлгүй, ашиг сонирхлын зөрчилгүй Монгол Улсын иргэн байна” гэсэн шалгуурыг 3 жил болгон багасгаж оруулах;

4.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа түүний онцлог, тулгамдаж буй асуудал зэргийг мэдэх цагдаагийн ахмад ажилтанг, цагдаагийн байгууллагын иргэний зөвлөлд ажлуулж, тэдгээрийн үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах;

5.Иргэний зөвлөлийг тасралтгүй ажиллах боломжийг бүрдүүлэхийн тулд Иргэний зөвлөлийн гишүүдийг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга тэргүүдэд, уг зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийг аймаг, нийслэлийн тухайн жилийн төсөвт суулган шийдвэрлэдэг байх нь зүйтэй;

6.Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 62 дугаар зүйлийн 10 дах хэсэгт “Иргэний зөвлөлийн төсөв болон гишүүдэд олгох мөнгөн урамшлыг аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ” гэснийг “Иргэний зөвлөлийн төсөв, ажлын байр, шаардлагатай техник хэрэгсэл, үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэлийн тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэнэ” гэж өөрчлөх;

7.Канад, Америк, Япон, ОХУ, Бразил зэрэг гадаадын зарим улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг, дэмжлэг үзүүлдэг иргэний хяналтын талаарх эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны арга туршлагыг судалж нэвтрүүлэх гэх мэт саналуудыг дэвшүүлж байна.

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ
ХАРЬЦУУЛАН ШИНЖИХҮЙ НЬ**
COMPARATIVE ANALYSIS ON LEGAL REGULATIONS OF CONFLICT
INVESTIGATING AND RESOLVING ACTIVITIES IN CERTAIN FOREIGN
COUNTRIES

**МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн магистрант,
М.Амартунгалаг**

Amartungalag.M
A graduate student,
Law School of National
University of Mongolia,

Хураангуй. Нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг сахиулах зорилгоор тусгайлан эрх олгогдсон этгээд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргадаг.

Энэхүү өгүүлэлд а)Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ практикт хэрэгжиж буй нөхцөл байдал; б)Канад, Унгар, Казакстан улсуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтай харьцуулж, судлаачийн үүднээс өөрийн үзэл бодлын талаар товч авч үзсэн болно.

Executive Summary. In order to maintain the norms of social relations and living conditions between people in the society that ensure social peace, the right to freedom and inviolability of people, the integrity of property, and the normal operation of enterprises and organizations, a specialized authorized officers make decision on administrative norms.

In this article, I made a research on following subjects and made discussion from my point of view a) the situation of the practical implementation of the Revised Law on Conflict Investigation and Resolution of Mongolia; b) the legal regulations of law on conflict investigation and resolution of Canada, Hungary, and Kazakhstan are compared with certain regulations of Law on Conflict Investigation and Resolution of Mongolia.

Түлхүүр үг. Зөрчил, эрх бүхий албан тушаалтан, хүлээлгэх шийтгэл

Key word. Violations, authorized officers and penalties

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал,

нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁴⁷ гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг хангах, нийгмийн дэг журмыг хангах үүднээс эрх бүхий субъектээс нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргадаг.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдийн заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн шийдвэрийг хэлдэг.

А. Монгол Улсад 1990-ээд оноос өрнөсөн эрх зүйн шинэчлэл, Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх зорилтын хүрээнд зөрчил, түүнийг шалган тогтоох, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэгтгэн зохицуулах зорилгоор Захиргааны хариуцлагын тухай хуулийг⁴⁸ (1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр), мөн төрийн хяналт шалгалт болон салбарын хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрөлжсөн хуулиудыг батлан хэрэгжүүлж иржээ. Захиргааны хариуцлагын тухай хууль нь захиргааны зөрчил, түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байан ганц хууль бөгөөд энэхүү хууль нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд дорвитой өөрчлөлт ороогүй, 1995, 1997, 2004, 2006 онуудад нийт 20 гаран удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт хийгдээгүй байжээ.⁴⁹

2013 оноос хууль болон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд шалган шийдвэрлэхээр тодорхойлсон төрөлжсөн хуулиудад салбарын хүрээнд үйлдэгддэг зөрчлийг тодорхойлж, улмаар шалган тогтоох, хянан шийдвэрлэх журмыг тухайн салбарын асуудлыг зохицуулсан хуулиар буюу өөр өөр байдлаар хуульчилж хэрэгжүүлсээр ирсэнийг өөрчлөх цаг болсон гэж үзсэн байдаг.

Тухайн цаг үед зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтын ажиллагаатай адилтган зохицуулсан нь салбарын онцлог нэрийн доор салбар бүрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өөр өөр стандарт тогтоон хэрэгжүүлж байна. Тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар зөрчлийг 14 хоногт багтаан хянан шалгахгаар⁵⁰ заасан бол Өрсөлдөөний тухай хуульд 60 хоногт багтаан шалгахгаар⁵¹ зааж байсан нь эрх зүйн маргаан үүсэх нөхцөл болж байжээ.

⁴⁷ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

⁴⁸ <https://legalinfo.mn/mn/detail/280>

⁴⁹ https://nli.gov.mn/pdf/eruugiin_bolon_zahirgaanii.pdf

⁵⁰ <https://legalinfo.mn/mn/detail/280> Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт

⁵¹ Өрсөлдөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт

Тиймээс УИХ, ЗГ-аас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хууль шинэчлэх ажлын хэсгийг байгуулж, төслийг боловсруулж хэлэлцүүлсэний үр дүнд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталж⁵², 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг эрх бүхий албан тушаалтнууд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч нэгээс бусад тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд бус харин өөр бусад хуулийн шинэчлэлтийг дагалдуулан Зөрчлийн тухай хуульд тодорхой зөрчлийг хуульчилсантай холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх субъектийн харьяалал тогтооход чиглэсэн байна.⁵³

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал нь нутаг дэвсгэрийн харьяалал болон эрх бүхий албан тушаалтны харьяалаар тогтоогдоно. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн тодорхой ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр харьяалах нутаг дэвсгэрээс гадна явуулж болох бөгөөд зөрчил хэд хэдэн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлийн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага шалган шийдвэрлэхээр хуульчилсан байна.⁵⁴

Өнөөдрийн байдлаар зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийг 31 байгууллагын 216 нэгжид харьяалагдах 10011 эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж байгаа бөгөөд Улсын ерөнхий прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих бие даасан хэлтэс ажиллаж байна.

Монгол Улс 2017 оноос нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн хэм хэмжээ, түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг Зөрчлийн тухай хуулиар, харин гарсан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тус тус зохицуулж эхэлсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийн шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.⁵⁵

Б. Бид энэ хэсгээр гадаадын зарим улс орон буюу Канад, Унгар, Казакстан улсуудад Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэрхэн явагддаг, түүний эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалттай харьцуулалт хийхийг хичээлээ.

Монгол, Канад, Унгар, Казакстан улсуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжуудын нэршлийг харьцуулан авч үзье.

⁵² Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

⁵³ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас хэсэгчилэн авав.

⁵⁴ Ю.Оюунаа. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ.2021. 39 дэх тал

⁵⁵ Зөрчлийн хууль тогтоомжийн эмхтгэл. УБ.2018. 167 дахь тал

Хүс
нэгт №1

Асуулга	Монгол Улс	Канад улс	Унгар улс	Казакстан улс
Хуулийн нэр	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	Зөрчлийн тухай хууль	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль	Захиргааны зүйн зөрчлийн тухай хууль
Бүлэг зүйл	18 бүлэг	4 бүлэг, 17 зүйл	31 бүлэг, 254 зүйл	53 бүлэг, 920 зүйл

Дээрхи хүснэгтээс үзвэл Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль нь 53 бүлэг, 920 зүйлтэй байгаа нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай процессын хууль нь зөрчлийн тухай материаллаг хуультайгаа хамтад нь оруулсантай холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн Канад болон Унгар улсуудад зөрчлийн тухай материаллаг хууль болон зөрчил шалган шийдвэрлэх процессын харилцааг хамтад нь оруул сон юм байна. Унгар улсын хуулийн нэршил нь шийдвэрлэх ажиллагаа гэсэн үг орсон бол Канад , Казакстан улсуудын хувьд зөрчлийн тухай хууль хэмээн нэрлэжээ.

Канад Улсын Зөрчлийн тухай хууль

1992 онд батлагдсан Канад Улсын Зөрчлийн тухай хуульд⁵⁶ “зөрчил” хэмээх хэргийн шинэ ангиллыг тусгасан бөгөөд энэ төрлийг хэргийг шалган шийдвэрлэх зорилгоор “зөрчлийн тухай мэдэгдэх хуудас”-ны шинэ системийг нэвтрүүлжээ. Энэ нь хөнгөн зөрчил болон эрүүгийн гэмт хэрэг хоорондын ялгааг тодорхой болгож өгснөөр хөнгөн зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, торгуулийн хэрэгжилтийг сайжруулах, маргаангүй хэргийг шүүхээс хасаж шүүхийн ачааллыг бууруулахыг зорьсон байна.⁵⁷

1.Канад Улсын Зөрчлийн тухай хууль

- 1.1.Зөрчлийн хууль тогтоомж
- 1.2.Зөрчлийн хуудас, түүнийг бүрдүүлж хүргүүлэх
- 1.3.Тээврийн хэрэгслийн зогсоолын зөрчил
- 1.4.Насанд хүрээгүй хүн ба түүний хэргийг хянан шийдвэрлэх шүүх

2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа

- 2.1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх
- 2.2.Зөрчилд холбогдогчид олгох сонголтууд
- 2.3.Мэдүүлэг өгөх журам
- 2.4.Шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргах журам
- 2.5.Зөрчил хянан шийдвэрлэх
- 2.6.Шийтгэл оногдуулах шүүхийн шийдвэр

⁵⁶ Contraventions Act (S.C. 1992, c. 47). <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-38.7/fulltext.html#right-panel>

⁵⁷ Contraventions Act Evaluation, Final Report. Department of Justice Canada, Office of Strategic Planning and Performance Management, Evaluation Division. November 2010. <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/cp-pm/eval/reprap/10/ca-lc/cae.pdf>

2.7.Эс үйлдэхүйд шийтгэл оногдуулах

3.Шүүхийн шийдвэрийг хянах

3.1.Шүүхийн шийдвэрт гомдол гаргах

3.2.Зөрчилд холбогдогчийн эзгүйд гаргасан шийдвэрийг хянах

3.3.Шүүх хуралдааны дараа шийдвэрийг хянах 7

4.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх журам

4.1.Шүүхээс албадлагын арга хэмжээ авах

4.2.Саатуулах, эсхүл хорих арга хэмжээ

4.3.Торгууль төлөх бусад хэлбэр⁵⁸

Канадын улсын Зөрчлийн тухай хуулиас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой онцлог бүхий зохицуулалтыг түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Зөрчлийн тухай хуулийн дагуу шүүхээс зөрчил үйлдсэн этгээдэд хорих шийтгэл оногдуулахгүй. Харин тэрээр торгуулийг заасан хугацаанд төлөөгүй бол түүний торгуулиа төлөх хүсэл байгаа эсэхээс хамаарч дараагийн арга хэмжээг авна. Тухайлбал, торгуулиа төлөх боломжтой боловч төлөх хүсэлгүй байгаа зөрчил үйлдсэн этгээдэд хорих хүртэл шийтгэл оногдуулж болно. Торгуулиа төлөх хүсэлтэй боловч төлөх боломжгүй зөрчил үйлдсэн этгээдийн хувьд торгуулиа үе шаттайгаар төлөх, эсхүл хугацааг сунгаж бусад хэлбэрээр төлөх боломжийг олгохоор хуульд зохицуулсан байна.⁵⁹

Канадын улсын Зөрчлийн тухай хуулийн 1.2. Хууль сахиулах байгууллагаас зөрчлийн хуудасны хуулбарыг зөрчилд холбогдогчид хүргүүлэх ба дараах байдлаар хүргэнэ (§10):

- хувь хүнд – хуулбарыг зөрчилд холбогдогчид биечлэн өгнө. Хэрэв хуулбарыг зөрчилд холбогдогчид биечлэн өгөх боломжгүй бол түүний хамгийн сүүлд бүртгэгдсэн оршин суугаа газарт нь хүргэж, тэнд байгаа 18-аас доошгүй насны хүнд хуулбарыг үлдээнэ;

- хуулийн этгээдэд – хуулбарыг тухайн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтанд биечлэн өгнө, эсхүл хуулийн этгээдийн төв оффис руу баталгаат шуудангаар илгээнэ;

- Канад Улсад оршин суудаггүй хувь хүнд – хуулбарыг түүний хамгийн сүүлд бүртгэгдсэн оршин суугаа газар руу нь баталгаат шуудангаар илгээнэ. Баталгаат шуудангаар илгээсэн зөрчлийн хуудас нь түүний хуулбарыг шуудангаар илгээснээс хойш 7 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Дээрхи зохицуулалтаас үзвэл Канад улсад мэдээллийн цахим технологи ашигладаггүй, баталгаат шуудан ашиглах, биеэр хүргэж өгөхөд ихээхэн ач холбогдол өгдөг нь харагдаж байна.

⁵⁸ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

⁵⁹ Канад Улсын Зөрчлийн тухай хуулийн 1.1 Зөрчлийн хууль тогтоомж

Зөрчлийн хуулийн 2.2-д зөрчилд холбогдогчид олгох сонголтуудын талаар тусгажээ. Зөрчлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар зөрчилд холбогдогч нь зөрчлийн хуудас хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дараах процессын аль нэгийг сонгоно:

(а) торгуулийг төлөх: - гэм буруугаа хүлээн зөвшөөрч, зөрчлийн хуудсанд заасан газарт (зөрчлийн хуудаст заасан) торгуулийг төлөх;

(б) мэдүүлэг өгөх: - гэм буруугаа хүлээн зөвшөөрч, Зөрчлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлэг өгөх;

(в) шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргах: - Зөрчлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргах;

Зөрчлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зөрчилд холбогдогчийн мэдүүлэг өгөх журмыг зохицуулсан байна. Зөрчилд холбогдогч буюу зөрчлийн хуудас хүлээн авсан этгээд нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч, зөрчлийн хуудсанд заасан шүүхэд, цагт, эсхүл тухайн шүүхийн оффисын эрх бүхий албан тушаалтанд мэдүүлгээ өгнө. Зөрчилд холбогдогч нь оногдуулах торгууль буюу бусад хариуцлага, эсхүл торгууль төлөх хугацааны талаар мэдүүлэг өгнө.

Холбогдох шүүх, эсхүл түүний оффисын эрх бүхий албан тушаалтан нь мэдүүлгийг зөрчлийн хуудасны хамт дараах журмаар хянан шийдвэрлэнэ. Үүнд тухайн зөрчлийн хэргээр шүүх хуралдаан явуулахгүйгээр мэдүүлэг авах (эсхүл авахгүй) бөгөөд зөрчилд холбогдогчийг бууруутай гэж үзвэл түүнд торгууль оногдуулна, эсхүл торгуулийн хэмжээнээс хамаарч тухайн зөрчилтэй холбоотой аман нотлох баримт авна, эсхүл шүүх хуралдааныг Ерөнхий прокурорын⁶⁰ оролцоотой хийнэ.

Зөрчлийн хуудасны дагуу эхлүүлсэн зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

- зөрчилд холбогдогч нь Зөрчлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан бол;

- зөрчилд холбогдогч нь насанд хүрээгүй бөгөөд зөрчлийн хуудас хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Зөрчлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд тусгасан сонголтуудын аль нэгийг хийгээгүй бол.⁶¹

Канад улсад зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэж хариуцлага хүлээлгэдэг байна. Өөрөөр хэлбэл тус улсад Зөрчлийн шүүх⁶² гэж тусгайлсан чиг үүрэг бүхий шүүх ажилладаг байна.

⁶⁰ <https://www.justice.gc.ca/eng/trans/transition/2015/tab2.html> Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор (Minister of Justice and Attorney General) - 1868 онд батлагдсан Хууль зүйн яамны тухай хууль (Department of Justice Act)-д заасны дагуу Хууль зүйн сайд нь Хууль зүйн яамыг удирдахын зэрэгцээ тус улсын Ерөнхий прокурорын албан үүргийг хамт хариуцна. Хууль зүйн яам нь сайдын энэ хоёр үүрэгт нь дэмжиж ажиллана.

⁶¹ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

⁶² Зөрчлийн тухай хуульд “зөрчлийн шүүх” гэж тухайн мужийн Губернаторын захирамжаар томилогдсон бөгөөд тухайн мужийн нутаг дэвсгэрийн харьяалалд үйлдэгдсэн зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхийг ойлгоно гэжээ

Унгар Улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль.

Унгар улс 2012 онд “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль” баталсан байна. Уг хуулийн 1-5 дугаар бүлэгт зөрчлийн тухай ерөнхий зохицуулалт, 6-21 дүгээр бүлэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам, 22 дугаар бүлэгт шийдвэр гүйцэтгэл болон зөрчлийн бүртгэлийн тогтолцооны талаарх зохицуулалт, 23-31 дүгээр бүлэгт бусад зөрчил буюу Зөрчлийн хуулийн тусай ангийн зохицуулалтуудыг агуулжээ.⁶³

Тус хуулиар “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь хөөн хэлэлцэх хугацаа 6 сар байх бөгөөд зөрчил үйлдсэнээс хойш 2 жил өнгөрсөн бол зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй” хэмээн тодорхойлжээ.

Зөрчилд дараах төрлийн шийтгэл оногдуулдаг. Үүнд:

- баривчлах /1-60 хоног/;
- торгууль ногдуулах /5000-150000 форинт, хэрэв баривчлах шийтгэл оногдуулах хэмжээний зөрчил гаргасан бол 300000 форинт хүртэл/;
- нийтэд тустай хөдөлмөр хийлгэх /6-180 цаг/;

Зөрчлийн улмаас оногдуулсан шийтгэлийн ялтай байх хугацаа 2 жил байна. Энэ хугацаа нь давтан үйлдсэн зөрчилд хүндрүүлэх нөхцөл болдог. Үүнээс гадна эрх хасах, эд хөрөнгө хураах, хориглох, сануулах арга хэмжээ авах боломжтой байдлаар зохицуулсан.

Тус хуульд өсвөр насны хүүхэд, цэргийн алба хаагчдад хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан зохицуулсан.

Зөрчил гаргасан этгээдэд шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллага:

- Нийслэл, аймгийн Засгийн газрын алба;
- Энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд Цагдаагийн байгууллага, Үндэсний татвар, гаалийн алба;
- Захиргааны баривчлах шийтгэл оногдуулах зөрчилд орон нутгийн шүүх;
- Энэ хуулиар зөрчил үйлдсэн этгээдэд газар дээр нь торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны жагсаалтад орсон байгууллага, албан тушаалтан багтана.

Унгар Улсын Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуулийн 43 дугаар зүйлд зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог зохицуулсан байна. Прокурор Зөрчлийн албаны үйл ажиллагаа, авч буй арга хэмжээ хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, мөн зөрчлийн бүртгэлийн тогтолцоонд хууль ёсны хяналт тавьж ажилладаг.

Дээрх байгууллага прокуророос тавьсан шаардлага хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн бол хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, шийдвэрийг өөрчлөх, буцаах арга хэмжээ авах ба энэ тухай прокурорт мэдэгдэх үүрэгтэй.

⁶³ (3)45 Szabalysertesi elzarassal is buntetheto, valamnt e torvenyben meghatarozott szabalysertes miatt elso fokon a joroshnrysog joe el

Хэрэв Зөрчлийн алба прокурорын шаардлагыг хангаагүй тохиолдолд прокурор 30 хоногийн дотор хүчин төгөлдөр шийтгэвэрийн эсрэг орон нутгийн шүүхэд хандах бөгөөд энэ тухайгаа Зөрчлийн албанд мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээж авсан Зөрчлийн алба 8 өдрийн дотор хэргийн холбогдох материалыг харьяаллын дагуу шүүхэд хүргүүлнэ.⁶⁴

Зөрчил шалган тогтоох ажиллагааны явцад шаардлагатай үйл ажиллагаа явуулах, эд хөрөнгө хураах асуудлын хүрээнд зөрчил шалгах эрх бүхий байгууллага, хууль тогтоомжийн дагуу үйлдэл дээр нь шууд торгох эрх бүхий албан тушаалтан зөрчлийн эд мөрийн баримт болох эд зүйлийг хурааж авах эрхтэй. Ингэхдээ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1/ Зөрчлийн эд мөрийн баримт байх;
- 2/ энэ хуулиар хурааж авахыг зөвшөөрсөн эд зүйл байх.

Мөн хурааж авсан эд мөрийн баримтыг хэрхэн хадгалах, өмчлөх эрх бүхий этгээдэд буцааж олгох, ийм этгээд байхгүй тохиолдолд улсын өмчид шилжүүлэх, олон өмчлөгчтэй байвал хэнд нь буцааж олгох, хэрэглэх боломжгүй эд мөрийн баримтыг устгах тухай зохицуулалтыг оруулжээ.⁶⁵

Зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах тухай шийдвэрийг зөвхөн шүүх гаргана.

Давж заалдах хэлбэр нь санал, давж заалдах өргөдөл, гомдол байна. Бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Зөрчлийн албаны шийтгэвэр, эсхүл арга хэмжээ авах тухай шийдвэрийн эсрэг санал, бусад шийдвэр, арга хэмжээ болон авах ёстой байсан арга хэмжээг авалгүй орхигдуулсан тохиолдолд гомдол, эсхүл шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах өргөдөл гаргана.⁶⁶

Давж заалдах хугацааны тухайд тухайн шийдвэрийг танилцуулснаар, авах ёстой байсан арга хэмжээг авалгүй орхигдуулсан тохиолдолд энэ тухай мэдээлэл авсан өдрөөс эхлэн 8 хоног байна. Хуулиар хориглосон, давж заалдах эрхгүй хүнээс гаргасан, эсхүл хугацаа хоцорсон, эсхүл давтан нэг асуудлаар гаргасан тохиолдолд зөрчлийн алба, прокурор, шүүх санал, гомдол, давж заалдах өргөдлийг хүлээж авахаас татгалзана.

Унгар Улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуульд ажиллагаанаас зарим онцлог зохицуулалтуудыг авч үзвэл

- Тус улсад Зөрчлийн алба үйл ажиллагаа явуулдаг;
- Баривчлан шийтгэл оногдуулах хэмжээний зөрчил гаргасан бол торгууль оногдуулж болдог;
- Хуульд өсвөр насны хүүхэд, цэргийн алба хаагчдад хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан зохицуулсан зэргийг дурдаж болохоор байна.

Казакстан улсын Захиргааны зөрчлийн тухай хууль

⁶⁴ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

⁶⁵ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

⁶⁶ (2) Jogorvoslatok a kifogas, a fellebbezes es panasz. E torveny eltero rendelkezesenek hianyaban a)
(4) A jogorvoslati hatarido-e torveny elterro rendelkezesenek hianyaban2 a kozlestol, az intezkedes elmunasztasa eseten az Errol vola tudomasszerzestol szamitott nyloc nap.
(5) az arra nem jogosulttyl, szormazy, az ismnotelten azonos tartalomasztasa tartalommal az arra nem jogosulttyl valamint az azonos tartalommal.

Бүгд найрамдах Казахстан улсын парламент нь 2014 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 53 бүлэг, 920 зүйл анги бүхий “Захиргааны эрх зүйн зөрчил”-ийн тухай хуулийг баталж, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар захиргааны хариуцлагад тооцох үндэслэл, зарчмыг тогтоох, ямар үйлдлийг зөрчилд тооцох, зөрчил гаргасан этгээдэд ямар төрийн байгууллага, албан тушаалтан, ямар шийтгэлийг, ямар журмаар оногдуулах асуудлыг зохицуулдаг. Тухайлбал уг хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Захиргааны шийтгэл гэж зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах болон зарим эрхийг хасах тухай хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан, шүүхийн зүгээс авч хэрэгжүүлж буй албадлагын арга хэмжээ мөн” гэж заажээ.

Мөн “захиргааны шийтгэл нь зөрчил гаргасан этгээдийг хүмүүжүүлэх, хууль журмыг сахих, хүндэтгэх байдлыг дээшлүүлэх, зөрчил гаргагч болон бусад этгээдийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх ба хувь хүн, хуулийн этгээдийн нэр хүндэд халдах, доромжлох, бие махбодь, сэтгэл санааны хохирол учруулах зорилго агуулахгүй⁶⁷ гэж заажээ.

Тус улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль дахь зарим онцлог заалтаас дурдахад, энэ хуулийн 74 дүгээр зүйлд Бүгд Найрамдах Казахстан улсын иргэншлийг авахад саад учруулсан албан тушаалтан хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тенгегээр торгууль ногдуулдаг.

Харин энэ үйлдлээ 1 жилийн хугацаанд давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлэх хэмжээний тенгегээр торгодог. Харин хуулийн 73 дугаар зүйлд гэр бүлийн харилцаан дахь зарим хууль бус үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан бөгөөд тухайлбал “хүнийг зүй бусаар хараах, басамжлан доромжлох, гэрийн эд хогшлыг эвдэж сүйтгэсэн, гэр бүл ахуйн харилцаанд гарсан, тэдний амгалан тайван байдлыг алдагдуулсан, хүндэтгэлгүй хандсан зэрэг эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд, хэрэв энэ үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулаагүй 3 хүртэлх хоногийн хугацаанд захиргааны баривчилгаанд татдаг, хэрэв энэ үйлдлээ 1 жилийн дотор давтан үйлдвэл 10 хоног баривчилдаг бол 2-оос дээш удаа энэ төрлийн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тенгегээр торгууль ногдуулах шийтгэл оногдуулдаг байна.

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу дараах төрлийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Үүнд:

1. Сануулах;
2. Торгох /хувь хүнд нэг өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин, албан тушаалтанд 700 дахин, аж ахуйн нэгжид 1000 дахин, томоохон хуулийн этгээдэд 2000 дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний торгууль ногдуудаг/;

⁶⁷ Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 40 дүгээр заалтын 1-5 дахь хэсэг

3. Зөрчил үйлдсний үр дүнд олж авсан эд хөрөнгө, эд мөрийн баримт эсхүл зөрчил үйлдсэн зүйлийг хураан авах;
4. Зөрчил гаргахад хэрэглэсэн эд зүйл, багаж хэрэгслийг хураан авах;
5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах /1 сараас 2 жил хүртэл/;
6. Тусгай зөвшөөрөл хураах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг зогсоох /6 сар хүртэл хугацаагаар/, данс битүүмжлэх;
7. Үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсвэл зогсоох /10 хоног хүртэл/;
8. Хууль бусаар барьсан болон баригдаж байгаа барилгыг албадан буулгах;
9. Захиргааны баривчилгаа /30 хоног хүртэл/, баривчилгааны хугацааг 3 цагаас хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно⁶⁸ гэж заасан.

Үүнээс үзэхэд захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд оногдуулсан хамгийн хүнд шийтгэл нь захиргааны баривчилгаа бол хуулийн этгээдийн хувьд их хэмжээний торгууль ногдуулах эсхүл үйл ажиллагааг нь зогсоох, зарим тохиолдолд тодорхой үйл ажиллагаа явуулах лиценз, эд хөрөнгө хураах зэрэг зохицуулалт оруулсан байна.

Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн хуульд дараах Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд байхгүй дараах шинэлэг зохицуулалт байна гэж харлаа.

Энэхүү зохицуулалт нь бол зөрчил гаргасан иргэнд тухайн зөрчлийг анхны удаа гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тенгегээр, тухайн үйлдлээ нэг жилийн дотор давтан гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлэх хэмжээний тенгегээр торгодог явдал юм.

Түүнчлэн манай Зөрчлийн тухай хуульд тусгагдсан танхайрах, гэр бүлийн хүчирхийлэлд хамаарах үйлдлүүдийг гаргасан тохиолдолд тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулаагүй 3 хүртэлх хоногийн хугацаагаар баривчилдаг, хэрэв энэ үйлдлээ 1 жилийн дотор давтан үйлдвэл 10 хоног баривчилдаг, 2-оос дээш удаа энэ төрлийн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээр тенгегээр торгодог нь манай Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хуульд тусгавал зохих шинэлэг зохицуулалт гэж харж байна.

Хүснэгт №2

Монгол Улс	Канад Улс	Унгар улс	Казакстан улс
1. торгох; 2.баривчлах; 3.эрх хасах. ⁶⁹	1. торгох; 2.баривчлах; 3.бусад.	1.баривчлах; 2.торгууль ногдуулах; 3.нийтэд тустай хөдөлмөр	1. Сануулах; 2. Торгох 3. Зөрчил үйлдсний үр дүнд олж авсан эд хөрөнгө, эд мөрийн баримт эсхүл зөрчил үйлдсэн

⁶⁸УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

⁶⁹ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

		хийлгэх;	зүйлийг хураан авах; 4. Зөрчил гаргахад хэрэглэсэн эд зүйл, багаж хэрэгслийг хураан авах; 5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах; 6. Тусгай зөвшөөрөл хураах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг зогсоох; 7. Үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсвэл зогсоох; 8. Хууль бусаар барьсан болон баригдаж байгаа барилгыг албадан буулгах; 9. Захиргааны баривчилгаа ⁷⁰
--	--	----------	--

Дээрхи хүснэгтэд зөрчилд оногдуулах шийтгэлүүдийг харьцуулан авч үзвэл дээрхи 4 улсуудын хуулиудад торгох, баривчлах гэсэн шийтгэлүүд байгаа бол Монгол, Казакстан улсуудад эрх хасах шийтгэл байна. Түүнчлэн дээрхи 4 улсын зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын төрлүүдээс Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд сануулах, эд зүйл хураан авах, үйл ажиллагааг зогсоох, хориглох, барилга албадан буулгах шийтгэлүүд байгаа нь онцлог шийтгэл гэж үзэж байна. Унгар улсын хуульд тухайн зөрчилд баривчлах шийтгэл оногдуулсан ч түүнийг торгох шийтгэлээр сольж болдог зохицуулалт байгаа нь судалж үзвэл зохистой туршлага гэж үзэж байна.

Дүгнэлт. Монгол Улсаас бусад Казакстан, Канад, Унгар улсуудын зөрчил шалгаж буй процессын ажиллагаануудыг бүгд материаллаг хуультайгаа хамтад нь нэг хууль болгон нэгтгэн оруулж ирсэн нь зөрчил болон зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаа нь нэг бүхэл цогц ажиллагаа гэж үздэгтэй холбоотой гэж үзэж байна.

Канад Улсын хувьд зөрчил үйлдсэн иргэнд зөрчлийн хуудас өгдөг бөгөөд энэхүү зөрчлийн хуудсыг биечлэн хүргэж өгөх, эсхүл баталгаат шуудангаар хүргэдэг, цахим сүлжээ ашигладах талаар хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй байгаа нь сүлжээний баталгаа хангагдаагүй, эсхүл зөрчил бүрийг шүүхээр заавал оруулж шийдвэрлэдэг тогтолцооноос үүдэлтэй гэж үзэж байна. Түүнчлэн Казакстан улсын зөрчилд хүлээлгэж буй шийтгэлийн төрөл бусад улсуудынхаас олон байгаа нь зөрчил тус бүрийн онцлогт нь тохируулж шийтгэл оногдуулах бодлого баримталсанаас харагдаж байна.

Казакстан, Канад, Унгар улсуудын зөрчил шалгаж буй процессын ажиллагаануудыг өөр өөрийн улс орны хууль зүйн бодлого, баримталж буй үзэл хандлага гэж үзэж болохоос гадна дэг журам сахиулах арга барилтай холбоотой гэж үзэж байна.

⁷⁰ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах зохицуулалтуудыг Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг сайжруулах боломж байна гэж үзэж байна. тухайлбал:

1. Канад улсын Зөрчлийн тухай хуульд заасан жишгээр Зөрчлийн төрөлжсөн шүүх байгуулах талаар судалгаа хийж, үр нөлөөг нь тодорхойлох

2. Унгар улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуульд заасан “баривчлах шийтгэлтэй зөрчлийг өндөр мөнгөн дүнтэй торгуулиар сольж болох зохицуулалтыг судалж, нэвтрүүлэх

3. Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд өсвөр насны хүүхдэд хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан тусгаж өгөх

4. Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд заасан зөрчил давтан үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан зохицуулалтыг нэвтрүүлэх, мөн зөрчилд хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг зөрчлийн хор аюул, учруулсан хохирлын хэмжээнээс нь хамааруулан нэмэгдүүлэх зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Зөрчлийн тухай Монгол Улсын хууль
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль
4. Өрсөлдөөний тухай Монгол Улсын хууль
5. Канад Улсын Зөрчлийн тухай хууль
6. Унгар улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль
7. Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль

Ном, гарын авлага

8. Ю.Оюунаа. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ.2021
9. Зөрчлийн хууль тогтоомжийн эмхтгэл. УБ.2018

Сэтгүүл

10. Төрийн мэдээлэл. 1992. №1.
11. Төрийн мэдээлэл. 2017. №24.

Судалгааны материал

12. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын материал
13. УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгийн 2021 онд хийсэн орчуулгын судалгааны материал

Цахим эх сурвалж:

14. <https://legalinfo.mn>
15. <https://nli.gov.mn>

16. <https://laws-lois.justice.gc.ca>

17. <https://www.justice.gc.ca>

ЦАГДААГИЙН СУРГАЛТЫН ХАРИЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE STUDY OF POLICE TRAINING

Д.Батдаваа

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн
сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн
багш, докторант, цагдаагийн хошууч

D. Batdavaa

Police School of the University of Internal Affairs Teacher and
doctoral student of the Department of Police law, police major

Товч агуулга: Монгол Улсад цагдаагийн ажилтан авахад тавигдах шаардлага, цагдаагийн ажилтны шалгаруулалт болон цагдаагийн албан хаагч бэлтгэх сургалт зэрэгт тулгамдаж буй зарим асуудлууд юу болох тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замууд болон гадаадын зарим оронд асуудлыг шийдсэн шийдэлүүдийг Монгол Улсын цагдаагийн ажилтан бэлтгэхэд хэрхэн хэрэгжүүлж болох талаар илтгэлд тусгалаа.

Abstract: What problems are the requirements for hiring police officers, selection process and trainings to become police officers in Mongolia. This scientific-researching report is aimed to define what opportunities are the training for police officers in Mongolia and how we resolute other foreign countries good resolution to policing of our country.

Түлхүүр үг: бэлтгэх⁷¹, асуудал⁷², тулгамдах⁷³

Оршил

Цагдаагийн байгууллага төрийн тусгай алба бөгөөд албаны үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд захирамжилсан актаар хэрэгжидэг. Цагдаагийн албан хаагч нь ард олны амар тайван амьдралыг сахин хамгаалах Монгол улсын үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 7 дугаар хэсэгт заасан төрийн үүргийг биелүүлж ажилдаг. Монгол улс цагдаагийн ажилтан бэлтгэх асуудалд Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль холбогдох дүрэм журмыг баримталж ирсэн, одоо их, дээд сургууль төгссөн бакалаврын, бүрэн дунд цэргийн алба хаасан иргэдийг 3 сараар цагдаа, цагдаа-жолоочоор мэргэжлээр цагдаагийн ахлагч, цагдаагийн офицерыг 1 сараар Ахлагчийн сургуульд бэлгэж байна. Цагдаагийн сургуульд цагдаагийн офицерыг Цагдаагийн ажил-эрх зүй, Цагдаа судлал хөтөлбөрөөр бүрэн дунд боловсролтой иргэнийг 4 жил, бакалавртай иргэнийг 2 жил өдрийн ангиар, эчнээ ангид бакалавртай иргэнийг 3 жил, бүрэн дунд боловсролтой иргэнийг 5 жилээр бэлтгэдэг.

⁷¹ Бэлэн болгож зэхэх гэсэн утгатай үйл үг

⁷² Судлах шийдвэрлэвэл зохих зүйл, ажил хэрэгч санаа

⁷³ Сандрах тэвдэх, тулгарах гэсэн утгатай үйл үг

Монгол Улсад цагдаагийн ажилтан бэлтгэн гаргахад ололттой, сайшаалтай тал их ч тулгамдаж буй асуудалууд байна.

Ихэнх судалаачид цагдаагийн ажилтан бэлтгэхэд тулгамдаж буй асуудлуудаас илүү цагдаагийн албанд ажиллаж буй цагдаагийн албан хаагчдад тулгамдаж буй асуудалыг хөндөн авч үздэг. Цагдаагийн ажилтаны одоогийн ажлын үр дүнг сайжруулахын тулд цаашид цагдаагийн ажилтаныг бэлтгэхэд анхаарал хандуулах нь хамгийн зөв шийдэл. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолд Монгол хүнийг аюулгүй амьдрах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах, хууль сахиулах байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн баталгааг дээшлүүлэхээр заасан байдаг. Цагдаагийн албанд орох шаардлагыг өндөрсгөснөөр чадварлаг, сайн бэлтгэгдсэн албан хаагчид цагдаагийн байгууллагын зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлэх, хуулийг дээдлэн ажиллах, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт зэрэгт маш их ач холбогдолтой.

Цагдаагийн ажилтан бэлтгэхэд тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, түүнээс гарах арга замыг судлан илрүүлж зохих хариу арга хэмжээг авах нь чухал юм. Иймд энэхүү илтгэлдээ цагдаагийн ажилтан бэлтгэхэд тулгамдаж буй зарим асуудлуудыг шийдвэрлэх, арга зүйн талаар өөрийн саналаа тодорхой судалгааны хүрээнд гаргахыг хичээлээ.

Үндсэн хэсэг

Хүмүүс маш олон шалтгаанаар цагдаагийн мэргэжлийг сонгодог. Хүн бүрийн үзэл бодол өөр учраас маш олон талаас харж сонгодог. Тэгвэл АНУ-ын Өмнөд Дакотагийн Их Сургуулийн профессор Карол А. Арчбөүлд “гадаад дотоодын олон цуврал кино, нэвтрүүлэг, шоугаар цагдаагийн алба нь маш сэтгэл хөдөлгөм сайхан, үргэлж гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг барьж авдаг, амар ажил гэдэг ойлголтийг нийгэмд төрүүлдэг. Гэвч үнэн хэрэгтээ тэдгээр кино нэвтрүүлгээр гарч байгаа зүйлүүд нь Цагдаагийн албаны хамгийн оргил гэсэн хэсгүүдэд ач холбогдол өгөн нэвтрүүлж гаргадагаас жил бүр маш олон хүмүүс цагдаагийн ажилтан болохоор шийддэг.” хэмээн үзсэн байна. АНУ-ын судлаач Баро А.Л болон Бурлинггэйм Д. нар хүмүүс цагдаагийн мэргэжлийг сонгодог шалтгаануудыг гаргасан байна. Үүнд: Хүмүүст туслах боломжтой, цалин өндөр, ажлын аюулгүй байдал сайн, сэтгэл догдлом сайхан, нэр хүнд.⁷⁴ гэж хариулсан байна. Үүнээс хархад цагдаагийн мэргэжлийн онцлог, давуу талтай байдлыг харж цагдаагийн мэргэжлийг сонгодог байна. Мөн АНУ-ын судлаач Бөүвмэн,Т. эмэгтэй болон эрэгтэй хүмүүсээс цагдаа болох хүсэл, тэмүүлэлийн тухай асуухад маш ижилхэн хариултууд өгсөн байна. Мөн АНУ-ын Нью Йорк Хотын Цагдаагийн Газар дахь цагдаагийн ажилтан сонгон шалгаруулж авах судалгаагаар ерөнхийдөө цагдаагийн ажилтан болохыг хүсэх хүсэл нь арьс өнгө үл хамаарч бүх үндэс ястанууд адилхан байдаг. хэмээн Карлан, П.Э болон Биксбэ нар судалсан байна.⁷⁵ Дээрхи судалгаануудаас хархад жендрийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүс цагдаад орох ижил хүсэлтэй мөн арьс өнгө, яс үндэс үл хамаарч цагдаагийн албанд орох хүсэлтэй хүмүүс их байдаг нь харагдаж байна.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн Цагдаагийн алба гэсэн 4 дүгээр зүйлд “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн

⁷⁴ Carol A.Archbold “Policing”.2012.

⁷⁵ www.sagepub.com>files>50820_ch_5

хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.”⁷⁶ хэмээн заасан байдаг. Монгол улс цагдаагийн ажилтаныг сонгон шалгаруулах, албан хаагч бэлтгэх, ажилд авах гэсэн ерөнхий дараалалаар цагдаагийн ажилтан бэлтгэж байна.

Нэг. Цагдаагийн ажилтан авахад тавигдах шаардлагууд:

Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралтийн Цагдаагийн байгууллагын хөжлийн хөтөлбөрийн нийтлэг үндэслэлд “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолд Монгол хүнийг аюулгүй амьдрах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах, хууль сахиулах байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн баталгааг дээшлүүлэхээр⁷⁷ заасан байдаг. Тиймээс цагдаагийн албаны шаардлага өндөр байх нь цагдаагийн албанд орох албан хаагчийг шалгаруулж авахаас эхэлнэ. “Манай улсын хувьд ажил мэргэжилд тавих шаардлага, ур чадварын жагсаалт хараахан гараагүй...”⁷⁸ байдаг байна. Монгол улсад цагдаагийн ажилтан шалгаруулж авахдаа зарлагдаж байгаа ажлын байр /албан тушаал/-д тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан хүн цаашид албаны шалгалтанд орох эрх нь нээгддэг байна.

Цагдаа дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмийн хоёрт мэргэжлийн шалгалтанд орох иргэнд тавигдах шаардлага гэсэн хэсэгт 2 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт Тусгай албан тушаалд ажиллах иргэн Төрийн албаны тухай хууль болон цагдаагийн байгууллагын тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль болон цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад алба хаах журам”-д заасан нийтлэг болон эрүүл мэнд бие бялдар, боловсрол, мэргэжил, ёс зүйн шаардлага хангасан байна.⁷⁹ гэж заасан байдаг. Олон улсад хууль сахиулагчид, түүн дотроо цагдаагийн ажилтнуудын мэдлэг, чадвар, хандлагад тавих шаардлагын жагсаалтыг төрөл бүрийн хэлбэрээр гаргасан байна. Тухайлбал, ОХУ-д Хууль сахиулахуйн бакалаврын хөтөлбөрийн стандартдаа ерөнхий 16 цогц чадамж, мэргэжлийн 39 цогц чадамж эзэмшүүлэхээр заасан бол Их британи, Умард Ирландын нэгдсэн Вант улсад Цагдаагийн хөгжлийн үндэсний товчооноос NPIA (National Policing Improvement Agency) цагдаагийн мэргэжлийн хүрээг (Policing Professional Framework PPF) Төрийн үйлчилгээний чадвар, Мэргэжлийн чадвар, Манлайллын чадвар, Шийдвэр гаргах чадвар, Бусадтай хамтран ажиллах чадвар, Хувийн чанар зэрэг үзүүлэлтээр албан тушаалын зэрэг бүрээр 4 тодорхойлж, Үндэсний мэргэжлийн стандартаар (NOS)5 баталгаажуулжээ.⁸⁰

Монгол улсын цагдаагийн алба хаагчид тавигдах мэргэжлийн стандарт олон улсад хүлээн зөвшөөрөгдөх шаардлагтай байна. Гадаадын зарим улсын тэргүүлэх судлаач, шинжээчид Монгол Улсын цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийх нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй,

⁷⁶ Төрийн мэдээлэл эмхтгэл. 2017.,№8 Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найрууллага/.2017

⁷⁷ Цагдаагийн байгууллагын хөжлийн хөтөлбөр. 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралт

⁷⁸ Б.Одончимэг.Цогц чадамжид суурилсан сургалтын технологи ба хүний нөөцийн бодлогын асуудал илтгэл. 2015.

⁷⁹ Цагдаа дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам

⁸⁰ Б.Одончимэг.Цогц чадамжид суурилсан сургалтын технологи бай хүний нөөцийн бодлогын асуудал илтгэл. 2015.

шуурхай хүргэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ гэж дүгнэж, олон улсын, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл (реформ) хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэж, ард иргэдийн итгэлийг эргэн олж авах болон зөвлөлт маягийн цагдаагийн арга барилаас орчин үеийн цагдаагийн загварт шилжихэд Монгол Улсын Засгийн газар, Цагдаагийн төв байгууллага болон олон улсын холбогдох байгууллагуудын байнгын анхааралд, идэвхтэй оролцоо шаардлагатай⁸¹ хэмээн зөвлөсөн.

Тэгвэл Гадаадын улс орнуудад цагдаагийн ажилтанд ямар шаардлага тавигддаг вэ? БНХАУ 2006 онд цагдаагийн сонгон шалгаруулах шалгуурт өөрчлөлт орж зөвхөн цагдаагийн академи, их сургуульд сурсан мэргэжлийн хүмүүс цагдаа болно гэсэн шаардлагыг өөрчилсөн.⁸² АНУ-ын цагдаагийн ажилтан авах шаардлага нь муж, улс бүртээ харилцан адилгүй боловч Цагдаагийн ажлын ерөнхий стандартын шаардлага гэж тавигддаг.

Хүснэгт1. АНУ-ын Цагдаагийн ажилтан болоход тавигдах стандарт шаардлага⁸³

Ажлын Стандарт Шаардлага	
АНУ-ын харъяалалтай /АНУ-ын жолооны үнэмлэхтэй байх	Оршин суух шаардлага
21 нас буюу түүнээс дээш	Боловсрол-Хамгийн багадаа Бүрэн дунд боловсролтой
Өндөрийн хэмжээ жинтэй хамааралтай	Хараа-агентлагуудад ялгаатай
Гэмт хэргийн бүртгэл-Хүнд гэмт хэрэг үйлдээгүй байх	

Үүнээс дүгнэхэд Монгол улсад цагдаагийн албанд орох шалгуур, шаардлагууд Англи, Герман зэрэг орнуудыг бодвол илүү өндөр ч цагдаагийн ажилтанд тавих мэргэжлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага дутагдалтай байгаа бөгөөд хэрвээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт шаардлагатай болбол цагдаагийн ажилтан бэлтгэхэд маш чухал нөлөөтэй юм. Мөн түүнчлэн хүлээн зөвшөөрөгдсөн ажлын стандартыг тогтоохдоо олон улсын жишигээр зарим тулгамдсан асуудлуудыг харгалзан үзэж, шийдвэрлэхэд анхаарах хэрэгтэй байна. Тухайлбал,

1.Биеийн өндөрөөр зарим хүмүүс тэнцэхгүй тохиолдол гардаг гэвч оюуны өндөр чадавхитай, ур чадвар, мэдлэг, туршлага илүү ч өндөрөөр тэнцэхгүй тохиолдол гардаг. Энэ нь илүү сайн ажилтанаа алдаад явуулж байгаа хэрэг юм. Тухайлбал, Герман улс цагдаагийн албанд орох биеийн өндөрийг эмэгтэй-доод тал нь 163 см, эрэгтэй дотоод тал нь 165 см байхыг шаарддаг бөгөөд биеийн өндрийн дээд хэмжээ нь 195 см гэж заасан байна.⁸⁴ Англи улсын цагдаагийн байгууллага цагдаагийн албанд орох шаардлагандаа өндрийн хэмжээг заадаггүй⁸⁵ нь зарим орноос нилээн ялгаатай байдаг.

2. Эрүүл мэнд- үүнд оюун санааны хувьд цоо эрүүл ч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжсэн бодлого илүү оруулах. Жишээ нь: Англи улсад оюун санааны хувьд эрүүл тодорхой үүрэг, даалгаварыг гүйцэтгэх чадвартай хөгжлийн бэрхшээлтэй

⁸¹ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралт

⁸² china.org/code_police/article_0520

⁸³ Carol A.Archbold “Policing”.2012.

⁸⁴ www.ehow.com/list_6759791_requirements

⁸⁵ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

иргэдийг ажил хийхийг дэмжсэн бодологотой бөгөөд тэднийг албан өрөөнд хийж чадах ажилд нь томилж оруулдаг⁸⁶.

3.Хараа-Цагдаагийн албанд хараа сайн байх нь эрүүл мэндийн нэг үзүүлэлт болдог тэгвэл зарим талаар холын хараа муу хүмүүс байдаг. Тэр хүмүүсийг цагдаагийн албанд оруулах боломж бүрдүүлэх, Жишээ нь Англи улсын цагдаагийн газраас холын хараа бага зэрэг муу хүмүүс цагдаагийн оффис өрөөнд ажиллах боломжтой байдаг.⁸⁷

4.Олон нийттэй харилцах чадварыг нэг шалгуур болгож оруулах нь цагдаагийн ажилтан болоход нилээн чухал. Тухайлбал, Герман улсын цагдаагийн газрууд ажилчин авахдаа Олон нийттэй харьцах харилцааны чадварийг үүн дотроо Англи, Герман хэлээр харилцах чадварыг шаарддаг.⁸⁸ Энэ нь эх хэлээр болон гадаад хэлээр бусадтай харилцахад асуудалгүй байхыг шаардсан шаардлага байдаг. АНУ цагдаагийн ажилтан авахдаа олон нийттэй харилцах чадварыг маш чухалд тооцдог. Мөн БНХАУ цагдаагийн ажилтан авахдаа өөртөө итгэлтэй олон нийтийн өмнө үг хэлэх болон мэтгэлцээн хийх чадварийг тавидаг.

Мөн түүнчлэн Англи улсад олон нийттэй харилцах, асуудал шийдвэрлэх чадвар өндөр байхыг шаарддаг. Иймээс цагдаагийн мэргэжлийн олон улсын стандарттай болохдоо дээр дурьдсан зүйлийг харж үзэх нь цагдаагийн ажилтан бэлтгэхэд асуудалыг шийдэхэд их ач холбогдолтой юм.

Хоёр. Цагдаагийн ажилтны сонгон шалгаруулалт:

Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын сул орон тоог тус албан тушаалд анх орох иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж, нөхөх мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж явуулдаг. Зарлагдаж байгаа ажлын байр /албан тушаал/-д тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон мөн хуульд заасан үндэслэлээр албанаас хүсэлтээрээ чөлөөлөгдсөн иргэд зарласан сул орон тоонд өрсөлдөхөөр бүртгүүлэх эрхтэй⁸⁹ байдаг.

Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолын хавсралт Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмын 3 дугаар бүлэг мэргэшлийн шалгалтын төрөл, үнэлгээ гэсэн хэсэг 3 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт Мэргэшлийн шалгалтыг офицерийн болон ахлагчийн албан тушаалын гэсэн ангиллаар явуулна.⁹⁰ хэмээн заасан байдаг. Мөн тус журмын 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт Шалтгалтыг дараах төрөлөөр явуулна; 3.5.1 Баримт бичгийн шалгалт, 3.5.2 Бие бялдарын бэлтгэлийн шалгалт; 3.5.3 Ерөнхий мэдлэг (сорил)-ийн шалгалт; 3.5.4 Ур чадварын шалгалт 3.5.5 Ярилцлага гэсэн шалгалтуудын төрөлөөр явуулна хэмээн заасан байдаг. Монгол улсад цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэнээс мэргэшлийн шалгалтуудыг явуулж мөн тус журамын 3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт шалгалтанд орсон иргэн нь тухайн төрлийн шалгалтанд тэнцсэн тохиолдолд дараагийн шалгалтанд орох эрхтэй.⁹¹ хэмээн заасан байдаг. Тухайн журамд шалгалтын төрөлүүдийг тус тусад нь шалгах үзүүлэлт, үйл явцыг оруулж өгсөн байна.

⁸⁶ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

⁸⁷ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

⁸⁸ www.ehow.com/list_6759791_requirements

⁸⁹ www.police.gov.mn/news/contenty/type/118

⁹⁰ Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолын хавсралт. Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам

⁹¹ Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолын хавсралт. Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам

Хүснэгт 2. Монгол Улсад Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэдээс авах шалгалтын үе шатууд⁹²

Сонгон шалгаруулах үе шатууд (үргэжлэх нийт хугацаа 2 сар)	
Баримт бичгийн шалгалт	Өрсөлдөж байгаа ажлын байранд тавигдсан ерөнхий шаардлагын боловсрол (иргэний баклавар болон түүнтэй адилтгах боловсролын дипломын голч дүн 2.0-оос доошгүй байх), мэргэжил, мэргэшил, ажлын туршлага гэсэн 4 үзүүлэлтээр явагдана 4 үзүүлэлт тус бүрт тэнцсэнээр энэ шалгалтанд тэнцэнэ.
Эрүүл мэндийн шалгалт	Эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэгийг нийслэлд Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн эмч нар хийнэ. Эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд шалгалтанд орох эрхтэй байна. (Биеийн өндөр-169 ба түүнээс дээш, жин-илүүдэлгүй, хараа-маш сайн Эрүүл мэнд-эрүүл байх)
Бие бялдарын бэлтгэлийн шалгалт	Нас хүйсийн ангилалаар цагдаагийн төв байгууллагаас тогтоосон нормативыг ханган биелүүлэх шаардлага тавигдах ба 10 хүртэл оноогоор дүгнэнэ.
Ерөнхий мэдлэг (сорил)-ийн шалгалт;	Иргэний төрийн бодлого, төрийн алба болон холбогдох бусад хууль тогтоомжийн мэдлэгийн түвшинг тодорхойлно. 35,түүнээс дээш оноо авсан иргэнийг шалгалтанд тэнцсэн тооцно. -Хуульчийн сонгон шалгаруулалт болон төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд тэнцсэн оноог хууль эрх зүйн шалгалтанд тэнцсэнд тооцно.
Ур чадварын шалгалт	Тухайн иргэний албан хэрэг хөтлөлт, гадаад хэлний мэдлэг, компьютерийн өргөн хэрэглээний программ ашиглах болон мэргэшлийн тусгай ур чадварыг 15 хүртлэх оноогоор үнэлнэ.
Ярилцлага	Тухайн иргэний ажиллах байр (албан тушаал)-ны зорилго, зорилт чиг үүргийн талаар болон уг албан тушаалыг эрхэлхэд шаардлагатай мэдлэг хандлага, тухайн иргэний зан байдал, түүний төлөвшил хандлага, хүсэл сонирхолыг тодруулах зорилгоор урьдчилан бэлтгэсэн асуултын хүрээнд иргэнтэй ярилцаж шалгана.

Монгол улс цагдаагийн ажилтан сонгон шалгаруулахдаа олон төрлийн үе шаттай шалгалтуудыг иргэдээс авч тэнцсэн нь Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалтанд хамрагдах боломжтой болдог. Дараах хүснэгтээс АНУ-ын цагдаагийн ажилтан сонгон шалгаруулах шалгалтын үе шатуудыг харж болох бөгөөд зарим нь гадаадын зарим орны цагдаагийн байгууллагууд хэрэгжүүлээгүй шинэ технологи, аргыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа юм.

Хүснэгт3.АНУ-ын цагдаагийн ажилчин сонгон шалгаруулах шалгалтын үе шатууд:⁹³

Сонгон шалгаруулах үе шатууд (үргэжлэх нийт хугацаа 6 сар)
--

⁹² Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолын хавсралт. Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам

⁹³ Carol A.Archbold “Policing”.2012. page 170-174

Анкет бөглөх	
Бичгийн шалгалт	Унших, үгийн баялагийн чадвар болон зарим тохиолдолд дүн шинжилгээ хийх болон асуудал шийдэх чадварыг шалгадаг.
Бие бялдарын Шалгалт	Суниалт, суулт, болон зүрхний ачаалал даах чадварын хэмжээг шалгах тодорхой зайны гүйлт багтдаг.
Ярилцлага	Бүх цагдаагийн агентлаг газруудын 99% нь мэргэжилтнүүдийн зөвлөлтэй ярилцлаганд орно.
Эрүүл мэнд Сэтгэл зүйн шалгалт	Үзлэг нь-сонсох, харааны тест, амьсгалын тест, Рентгэн, зүрхний цахилгаан бичлэг, зүрх уушигны тестүүд болон хар тамхины тестүүд.- Цагдаагийн агентлаг газруудын 72% нь сэтгэл зүйн тест хийдэг Minnesota Multiphasic Personality Inventory (MMPI) ажилд орох хүнээс сэтгэл зүйн байдлыг шалгах. Сэтгэл зүйн тестүүд хий солио, шизофрени, сэтгэл гутрал зэрэгийг шалгадаг.
Зөрчил гаргасан байдал	Цагдаагийн агентлаг газруудын 99% нь хувь хүний нөхцөл байдлын судалгаа явуулдаг.
Худал яригч илрүүлэгчийн шалгалт	Орон нутгийн цагдаагийн агентлаг газруудын 50% нь худал яригч илрүүлэгчээр шалгалт авдаг.
Үнэлгээний төв	Цагдаагийн ажилчдын ажиллах нөхцөл болон хариуцлагийг дууриасан нөхцөл байдлын олон дасгалуудыг авдаг. Нөхцөл байдлын дасгал нь ажилд орох хүний багаар ажиллах чадвар, харилцааны чадвар, болон олон нийтэд нөлөөлөх чадвар зэргүүдийг шалгадаг.

Монгол улсын хувьд цагдаагийн ажилтан сонгон шалгаруулж авах тогтолцоо өндөр ч сонгон шалгаруулалт явуулахад хэрэгжүүлж болох зарим чухал асуудал байна. Үүнд;

1.Монгол улс цагдаагийн ажилтан сонгон шалгаруулж авахдаа нилээн олон үе шаттай зохион явуулж байгаа ч албан хаагчийн сэтгэл зүйд маш их анхаарлаа хандуулах хэрэгтэй. Жишээлбэл, АНУ-ын цагдаагийн агентлаг газруудын 72% нь сэтгэл зүйн тест хийдэг Minnesota Multiphasic Personality Inventory (MMPI)- Миннесотын Олон үе шаттай Зан араншинг Тогтоогчоор ажилд орох хүнээс сэтгэл зүйн байдлыг шалгаж авдаг. Сэтгэл зүйн тестүүд хий солио, шизофрени, сэтгэл гутрал зэргийг шалгадаг.⁹⁴ Энэ нь зарим хүмүүст хэтэрхий сонин хачин санагдах болов ч цагдаагийн ажилтан авахдаа сэтгэл зүйн хувьд сайн бэлтгэгдсэн ажилтныг ажлын байран дээр гаргах нь илүү ач холбогдолтой.

2.Бичгийн шалгалтандаа илүү логик, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх чадварууд шаардсан шалгалтуудыг түлхүү оруулж өгөхөд анхаарах хэрэгтэй байна. Жишээ нь: Англи улс тооны шалгалт авдаг⁹⁵, мөн АНУ-д унших, үгийн баялагийн чадвар болон зарим тохиолдолд дүн шинжилгээ хийх болон асуудал шийдэх чадварыг шалгадаг⁹⁶ байна. Энэ нь ажилтныг илүү хянуур, нямбай, аливааг олон талаас харахад нь маш их чухал чадвар болох юм.

⁹⁴ Carol A.Archbold “Policing”.2012. page 170-174

⁹⁵ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

⁹⁶ Carol A.Archbold “Policing”.2012. page 170-174

3.Харилцааны болон баг хамт олны дунд орж ажиллах чадварт анхаарах хэрэгтэй байна. Жишээ нь АНУ-ын цагдаагийн газрууд өөрсдөө үнэлгээний төвтэй байдаг бөгөөд энэ төв цагдаагийн ажилчдын ажиллах нөхцөл болон хариуцлагийг дууриасан нөхцөл байдлын олон дасгалуудыг авдаг. Нөхцөл байдлын дасгал нь ажилд орох хүний багаар ажиллах чадвар, харилцааны чадвар, болон олон нийтэд нөлөөлөх чадвар зэргүүдийг шалгадаг.⁹⁷ Харилцааны чадвар, олон нийтэд хандсан чадваруудыг олж илрүүлж гаргаснаар илүү сайн ажилчдыг шилж, бэлтгэх ач холбогдол өндөр юм.

4.Хамгийн чухал зүйл нь Манай Монголд цагдаагийн ажилчныг авахдаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжуулж мэдээлдэг энэ нь зарим хүмүүс хүрэх нь зарим талаар дутмаг байдаг. Их өрсөлдөөнтэй нарийн шалгууртай гэдэг шалтгаанаар хүмүүс эмээдэг. Тэгвэл цагдаагийн ажилтан бэлтгэх үйл ажиллагааг бүр ахлах сургууль өсвөр үеийнхнээс эхэлдэг байх нь зөв шийдэл гэж бодож байна. Жишээ нь: Гадаадын зарим орон ялангуяа АНУ-ын хувьд цагдаагийн ажилтан бэлтгэхдээ 10 жилийн сургуулиас их сургууль, коллежуудаар орж чадвар, мэдлэг маш сайн хүүхэд залуустай уулзан ажлаа суртчилан таниулж эртнээс юу бэлтгэх, ямар болзол шаардлага хангасан талаар таниулж ажилд авах үйл явцаа эхэлдэг⁹⁸.

Гурав. Цагдаагийн албан хаагчийг бэлтгэх сургалт:

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн Цагдаагийн албаны сургалтын байгууллага гэсэн 17-р зүйлийн 1 дэхь хэсэгт “Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно.”⁹⁹ хэмээн заасан. Цагдаагийн ажилчныг дотоод болон гадаадад бэлтгэдэг. Тухайлбал, Монгол Улсад Ахлагчийн сургууль, Цагдаагийн сургууль, Төгсөлтийн дараах зэрэг сургуулиуд үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Ахлагчийн сургууль нь цагдаагийн ахлагч бүрэлдэхүүнийг 3 сарын хугацаатай бэлтгэж, цагдаагийн алба хаагчаар төгсгөдөг бөгөөд мөн бүрэн дунд боловсролтой иргэдийг 1 жилийн хугацаагаар сургалтанд хамруулж цагдаагийн мэргэжил олгохоор бэлтгэж байна¹⁰⁰. Цагдаагийн сургууль 4 жилийн хугацаатайгаар сургалтыг явуулж, цагдаагийн офицер бүрэлдэхүүнийг бэлтгэн төгсгөдөг. Төгсөлтийн дараах сургалтанд цагдаагийн албанд ажиллаж байгаа бакалавараас дээш зэрэгтэй удирдах ажилтнуудыг 2 жилийн хугацаатай сургалтанд хамруулж, удирдах албан тушаалыг бэлтгэн гаргадаг байна. Мөн магистр, докторын сургалтыг 2-3 жилийн хугацаатай сургаж байгаа юм.¹⁰¹ Мөн одоогийн байдлаар Оросын Хобооны Улс болон Бүгд Найрамдах Турк, Солонгос зэрэг гадаадын улсуудын мэргэжлийн их, дээд сургууль, академид захиалгаар мэргэжлийн цагдаа бэлтгэж байгаа юм.

Хүснэгт4. Монгол Улсын Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан мэргэшүүлэх сургалтын тогтолцоо.¹⁰²

№	Мэргэжлийн чиглэл	Сургалтын хугацаа	Эзэмших боловсролын
---	-------------------	-------------------	---------------------

⁹⁷ Carol A.Archbold “Policing”.2012. page 170-176

⁹⁸ Carol A.Archbold “Policing”.2012. page 170-176

⁹⁹ Төрийн мэдээлэл.2017.,№08 Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найрууллага/.2017

¹⁰⁰ Д.Батдаваа.Монголын цагдаагийн ахлагчийн сургалтыг зарим улсын түвшинд харьцуулан авч үзэхэд анхаарах асуудал илтгэл. 2015

¹⁰¹ Д.Батдаваа.Монголын цагдаагийн ахлагчийн сургалтыг зарим улсын түвшинд харьцуулан авч үзэхэд анхаарах асуудал илтгэл. 2015

¹⁰² О.Уулзахжаргал. Цагдаагийн байгууллагын сургалтын тогтолцоо түүнд анхаарах асуудал илтгэл. 2015

			зэрэг
Нэг. Мэргэжлийн сургалт			
1.	Цагдаа	1 сар – 1 жил хүртэл	Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт
2.	Цагдаа-хууль сахиулагч	4-5 жил (өдөр, эчнээ)	Бакалавр
Хоёр. Боловсролын зэрэг ахиулах сургалт			
1.	Хууль зүй	1,5- 2 жил	Магистр
2.	Хууль зүй	3-5 жил	Доктор (Ph.D)

АНУ-ын цагдаагийн ажилтан бэлтгэх сургалт нь 3 үе шаттай:¹⁰³

1. Цагдаагийн академийн сургалт- Цагдаагийн ажилтан бэлтгэх анхны сургалтын үе.

2. Ажлын сургалт/Цагдаагийн албан хаагчийн хөтөлбөр- Шинэ цагдаагийн академийн дараах сургалт

3. Үйлчилгээний сургалт- Цагдаагийн академийн сургалт болон цагдаагийн ажлын сургалтыг төгссөний дараа явагддаг сургалт.

Дээрхи 3 сургалтаар АНУ цагдаагийн албан хаагчаа бэлтгэн, мэргэшүүлдэг. Энэхүү сургалтууд нь тус тусдаа онцлогтой бөгөөд гол зүйл нь цагдаагийн ажилчдыг дээрхи 3 үе шаттай сургалтанд заавал хамрагдсан байхыг шаарддагаараа илүү цагдаагийн ажилтныг мэргэшихэд нь маш их ач холбогдолтой байдаг.

Англи улсад цагдаагийн ажилтан бэлтгэх Шаллагчийн хөтөлбөр буюу Нийслэлийн цагдаагийн шаллагчийн хөтөлбөр мөн өндөр түвшиний чадавхижуулах хөтөлбөр, Цагдаагийн үйлчилгээний ирээдүйн манлайлагчдийг дэмжих, хөгжүүлэх хөтөлбөрүүдээр сургалтын үйл ажиллагаа нь явагддаг.¹⁰⁴

Монгол Улсад цагдаагийн ажилтан бэлтгэхэд хамгийн чухал зүйл болох сургалттай холбоотой зарим тулгамдсан асуудлуудыг шийдэх хэрэгтэй байна. Гадаад, дотоодын хамтарсан олон улсын эрдэм шинжилгээний хуралаар Монголын цагдаагийн байгууллагад цагдаагийн ажилтан бэлтгэх болон сургалтын хүрээнд зарим хийж болох санал зөвлөмжийг хүргэсэн байдаг. Тухайлбал Өнөөгийн цагдаагийн боловсролд эмпирик судалгаа дутагдаж байгааг цохон тэмдэглэж, эрдэм шинжилгээний судалгаа хийх төв, тэтгэлгийн систем зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэх суралцагч, сонсогч, судлаачдын шаталсан хэлбэрийн сургалтууд, магистр, докторын зэрэг хамгаалах явдлыг дэмжих.

Хурдацтай өөрчлөгдөж буй нийгмийн хөгжлийг даган өнөөгийн шаардлага хангахуйц боловсон хүчин бэлтгэн гаргахын тулд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг байнга шинэчилж байх¹⁰⁵ зэрэг нилээн олон санал зөвлөмжүүдийг гаргасан байдаг.

Цагдаагийн ажилтан бэлтгэхэд сургалтанд тулгамдаж буй асуудлуудыг зөв шийдвэрлэснээр сайн ажиллах хүчин бэлтгэгдэн гарна. Дараах зарим асуудалыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

1. Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалтын хугацааг илүү нэмэх одоогоор 13 долоо хоног бэлтгэгдэж байгаа ч түүнээс илүү хугацааг бэлтгэхэд зарцуулах

¹⁰³Study.com.how_to_become_a_police_

¹⁰⁴ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

¹⁰⁵ www.leu.gov.mn/page/1531.shtml?sel=1592

хэрэгтэй байна. Учир нь сонсогчид маш шахуу хөтөлбөрөөр нэгэн зэрэг олон хичээлүүдийг үзээд ойлгох болоод их ачаалалд дасаагүй хүмүүс амархан ядрах, нойрмоглох, хичээлийн бие даалт хийхгүй байх үүнээс үүдээд үзсэн хичээлийн өөрийн болгож эзэмших зэрэг дутагдалтай талууд ажиллагдаж байна. Гадаадын цагдаагийн байгууллагуудын сургалт нь Жишээ нь БНХАУ-52 долоо хоног¹⁰⁶, Англи улс-104 долоо хоног¹⁰⁷, Герман-доод тал нь 52 долоо хоногоос 156 долоо хоног¹⁰⁸ бэлтгэдэг. Мөн АНУ-ын цагдаагийн академийн үргэлжлэх дундаж хугацаа нь 19 долоо хоног буюу 761 цаг (хээрийн сургалтыг оруулахгүйгээр) байдаг. Сургалтын цагийн дундаж хэмжээ нь (онолын болон дадлагын сургалт оруулаад) 1370 цаг байдаг.¹⁰⁹

2. Цагдаагийн сургалтын цахим орчинтой уялдуулан явуулах нь их ач холбогдолтой учир нь суралцагчдын цахим орчинд илүү ажиллах чадвар нэмэгдэхээс гадна алсын зайн сургалтыг явуулах боломжтой. Жишээ нь Шинэ Зеландийн цагдаагийн академиуд зарим хичээлүүдээ цахимаар ордог¹¹⁰ бөгөөд хичээлийн бие даалт, хичээлтэй холбоотой мэдээлүүдийг цаг алдалгүй авах ашигтай.
3. Цагдаагийн албан хаагч бэлтгэхдээ гадаад хэлний хичээлийг оруулснаар суралцагчид өөрсдийн хэрэгтэй мэдээлэл, цахим ном, сурах бичиг, сургалттай холбоотой мэдээ, мэдээлэлийг гадаад хэл дээр үзсэнээр илүү өргөн боломж нээгдэнэ. Мөн гадаад хэлийг практикт түлхүү оруулах хэрэгтэй байна учир нь Монгол Улс БНХАУ, ОХУ гэсэн хоёр их гүрний дунд оршдог тиймээс жил бүр маш олон мянган гадаадын жуулчид манай улсаар аялаж, амарч, баяр, наадамуудыг үзэн манай улсаар өмнөд хойд хөршрүү дамжин аяладаг. Зарим жуулчид хуулгай, дээрэм зэрэг олон асуудалд ордог бөгөөд гадаад хэлний түвшин багаас болоод цагдаагийн албан хаагчид гадаадын жуулчидтай шууд харилцан ойлгох хүндрэлтэй байдаг бөгөөд тэдэнд тулгарсан асуудлуудыг шийдэхэд заавал орчуулагч хэрэг болдог тиймээс цагдаагийн албан хаагч бэлтгэхэд гадаад хэлний чадваруудыг маш сайн сайжруулах хэрэгтэй байна.
4. Мөн цагдаагийн албан хаагчийг цаашид зэрэг ахиулан сурах мөн төрөл бүрийн чадавхижуулах, мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Жишээ нь АНУ, Англи зэрэг улсуудад ажилтануудаа өндөр түвшний чадавхижуулах хөтөлбөр, цагдаагийн үйлчилгээний ирээдүйн манлайлагчдийг дэмжих, хөгжүүлэх эрчимжүүлсэн хөтөлбөр сургалтыг маш олон зохион байгуулж явуулдаг бөгөөд дэмжлэг үзүүлдэг.¹¹¹
5. Цагдаагийн ажилтан бэлтгэх сургалтанд ёс зүй, сэтгэл зүй, харилцааны хичээлүүдийг түлхүү практикт суурилсан хэлбэртэй оруулах нь цаашид албан хаагч болоход бие бялдараас сэтгэл зүйн хувьд сайн бэлтгэгдэнэ. Тухайлбал АНУ-д цагдаагийн ажилтан бэлтгэхдээ ёс зүй, сэтгэл зүй, харилцааны практик хөтөлбөрийг ажлын байранд дээр шууд дадлагаар оруулж өгсөн байдаг бөгөөд энэ хөтөлбөрөөс суралцагчдыг цагдаагийн албан ажилд тэнцэх тэнцэхгүй нь тодорхойлогддог байна.¹¹²

¹⁰⁶ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

¹⁰⁷ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

¹⁰⁸ www.takepart.com.article>2015/06/29

¹⁰⁹ www.sagepub.com>files>50820_ch_5

¹¹⁰ www.newcop.co.nz/recruitment

¹¹¹ www1.gdufs.edu.cn>kecheng.shijian

¹¹² per.lacity.org/recruit1

6. Цагдаагийн албан хаагч бэлтгэхэд мэдээллийн технологи, компьютерийн хичээлүүдийг практикт суурилсан байдлаар хичээлийн хөтөлбөрт түлхүү оруулж өгөх хэрэгтэй бөгөөд суралцагчид жигд хөгжихөөс гадна илүү чадвар эзэмших юм.

Байгууллагын дотоод, гадаад соёл төлөвшөөгүй, байгууллагын үнэт зүйлийг бий болгож чадаагүй, боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдээгүй, менежерийн сонголт учир дутагдалтай бөгөөд удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо бий болоогүй, алба хаагчдын гадаад хэлний мэдлэг хангалтгүй, шинэ мэдээлэл олж авах арга барилд суралцаагүй, багаар хамтран ажиллах чадвар муутай, алба хаагчдыг цол, албан тушаалын байдлаар ялгаварлан гадуурхах хандлага бий болсон, төсөв хомсдолтой, төсвийн зарцуулалт оновчтой биш зэрэг бэрхшээл, сул тал байсаар байна.¹¹³ Иймээс “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” батлан гаргах үндэслэл нь болсон байна. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт сайн явагдах нь Монгол Улсад цагдаа бэлтгэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдэх их ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Монгол улсад мэргэжлийн цагдаагийн ажилтан бэлтгэхэд тулгамдаж буй олон асуудлууд байна. Эдгээрийг шийдэхийн тулд зөв шийдэл, арга зүйг олох хэрэгтэй юм. Бид зарим асуудлыг шийдэхдээ бусдын туршлагаас харж, боломжтой нийцэж болох зарим шийдэлүүдийг хийж хэрэгжүүлснээр асуудлаас гарч чадна.

Санал

1. Монгол улсад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн цагдаагийн ажилтанд тавигдах шаардлага байхгүй¹¹⁴ байна. Иймээс мэргэжлийн цагдаагийн ажилтанд тавигдах шаардлагийг гаргахдаа зарим зүйлсийг харгалзан үзэж гаргах нь чухал байна. Үүнд: Цагдаагийн ажилтанд биеийн өндөрийн хэмжээ шаарддаг нь зарим цагдаагийн ажилтан болохыг маш их хүсдэг чадварлаг, оюуны өндөр чадвартай хүмүүс тэнцэж чаддаггүй мөн зарим оюун санаа цоо эрүүл ч аливаа даалгаварыг гүйцэтгэх чадвартай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, хараа бага зэрэг сул хүмүүсийг төрөөс дэмжсэн, мөн олон нийттэй харилцах чадварыг шаардсан шаардлага зэрэгт бодлого хэрэгтэй байна.

2. Цагдаагийн ажилтан шалгаруулж авахдаа хууль эрх зүй, сэтгэл зүй, ёс зүй, харилцаа, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх зэрэг чадваруудыг илүү харгалзан үзэх хэрэгтэй байна. Мөн цагдаа болох хүсэл, мөрөөдөлтэй чадвар сайн өсвөр үе, залууст үйл ажилагаагаа суртачилан таниулах, тэднийг эртнээс бэлтгэлтэй байлгах нь цагдаагийн ажилтан бэлтгэх хамгийн чухал зүйл.

3. Цагдаагийн ажилтан бэлтгэхдээ бие бялдар болон мэдлэгээс гадна сэтгэл зүй болон ёс зүй, харилцааны практик сургалтыг суралцагчдад илүү чухал болохыг заах хэрэгтэй байна. Сэтгэл зүй, ёс зүй болон харилцааны талууд дээр нь сонсогчдыг илүү сайн бэлтгэвэл ирээдүйд илүү сайн мэргэжлийн ажилтан болно.

4. Цагдаагийн сургалтанд суралцаж буй суралцагчдын ихэнх нь ямар нэг давхар ажил хийх боломжгүй байдаг учраас тэдэнд сургалтанд суухад санхүүгийн хүндрэл гардаг тиймээс төрөөс сургалтанд суух сонсогчдын аль нэг сургалтын зардалд

¹¹³ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралт

¹¹⁴ Б.Одончимэг. Цогц чадамжид суурилсан сургалтын технологи бай хүний нөөцийн бодлогын асуудал илтгэл. 2015.

хөнгөлөлт үзүүлэх чухал байна. Мөн зарим хөнгөлөлт болон хариуцлагын гэрээний зохицуулалтыг хийж болох юм. Жишээ нь сонсогчид ажлын байртай болсны дараа гэрээний зарчимаар хөнгөлөлтийн зардлыг төлж болох бөгөөд илүү хариуцлагыг бий болгоно.

5.Суралцагчдын гадаад хэл болон компьютер, цахим орчинд ажиллах түвшинг практикт суурилсан байдлаар түлхүү орж суралцагчдын чадварыг сайжруулбал тэд цахим орчинд гадаад хэл дээрхи олон ном, сурах бичиг мэдээллийг олж авах, цахим орчинд ажиллах мөн ажлын байранд гараад гадаадын жуулчидтай харилцаж, ойлголцоход ямар нэгэн асуудал учрахгүй байх юм.

6.Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалтыг илүү урт хугацаагаар явуулах нь сургалцагчдад ачаалал даах болон цагийн зохион байгуулалтыг хийх чадварыг тэр чинээгээрээ нэмж өгөх бөгөөд аливаа сэтгэл зүй, ёс зүй, гадаад хэлний практик сургалтуудыг нэмэлтээр өгөх нь илүү чухал бөгөөд чадвар нь улам сайжирна.

7.Цагдаагийн албан хаагчдийг цаашид зэрэг ахиулан сурах мөн төрөл бүрийн чадавхижуулах, мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх.

8.Төрөөс цагдаагийн ажилтан бэлтгэхэд илүү дэмжлэг тусалцаа, бодлого хэрэгтэй байна. Илүү сайн бодлого, төлөвлөлт нь илүү сайн мэргэжлийн, мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэн гаргахад хамгийн их ач холбогдолтой.

--o0o--

ГЭМТ ХАЛДЛАГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖҮҮД

TIPS TO PREVENT CRIME

Б. Наргулан

Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Nargulan.B

Police School of the University of Internal Affairs
Senior Lecturer, Department of Police Law,
police lieutenant colonel

Товч агуулга: Хүн бие махбодийн болон бусад нөхцөл байдлаараа гэмт хэрэг үйлдэх боломжийг олгодог бөгөөд түүнээс урьдчилан сэргийлэх, гудамж талбайгаар явах, тээврийн хэрэгслээр зорчих, цахим халдлагаас хэрхэн сэргийлэх талаар зөвлөмжүүдийг хүргэж, гэмт халдлагад өртсөн үед өөрийгөө хэрхэн хамгаалах талаар авч үзсэн.

Summary: A person's physical and other circumstances allow him to be attacked by a criminal, and to prevent it, he provided recommendations for walking on the streets, traveling by vehicle, and preventing electronic attacks, and how to protect himself when he was attacked by a criminal.

Түлхүүр үг: Урьдчилан сэргийлэх, гэмт халдалга, гудамж, тээврийн хэрэгсэл, гэр орон сууц, дугуйн зам

Keywords: Prevention, crime, street, vehicles, homes, bicycle path

Хүн бие махбодийн болон нийгмийн нөхцөл байдлыг тодорхойлоход чиглэгддэг гэмт хэрэг үйлдэх боломжийг олгодог эсвэл өдөөх орчин гэмт хэрэг гарахгүйн тулд эдгээр нөхцлийг өөрчлөх явдал юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдэг нь “Гэмт хэргийн эрсдэлийг урьдчилан таамаглах, хүлээн зөвшөөрөх, үнэлэх, түүнийг арилгах, бууруулах арга хэмжээ авах” гэж тодорхойлсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эхний алхам бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогчтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь хамтын үүрэг гэдгийг ухамсарлах явдал юм. Энэ бол олон нийтийн асуудал эсвэл цагдаагийн асуудал биш. Энэ нь зөвхөн иргэд, олон нийт, хамт олны зүгээс зохих ёсоор шийдвэрлэх боломжтой нийгмийн асуудал юм.

Гэмт хэрэг гарахын тулд гурван зүйл байх ёстой; хүсэл, чадвар, боломж. Үүнийг бас гэмт хэргийн гурвалжин гэж нэрлэдэг. Хүн гэмт хэрэг үйлдэхийг "хүсэж", гэмт хэрэг үйлдэх "чадвартай" байж болох ч "боломж"-ыг нь үгүйсгэвэл ямар ч гэмт хэрэг гарахгүй. Түүхээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн зорилго нь гэмт хэрэгтнүүдийг баривчлах явдал байв. Энэ зорилго нь чухал хэвээр байгаа хэдий ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн өртгийг бууруулах зорилт чухал ач холбогдолтой болсон. Бидний зорилго бол иргэдэд өдөр тутмын амьдралдаа шийдвэр гаргахад нь туслах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Гэмт хэрэг үйлдлийг шинж тэмдгээр нь хөнгөвчлөх, хориглох боломжтой физик орчин. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам бол “Нийт орчин”-ыг төлөвлөх явдал юм. Энэ нь цагдаагийн реактив стратегийн эсрэг зүйл юм.

Итгэл үнэмшил төрүүлсэн бодлогоор гэмт хэргийг бууруулах боломжтой болзошгүй гэмт хэрэгтнүүдийг гэмт хэргийн үйл ажиллагаанаас татгалзах, хойшлуулах тэдний үйлдэл, эсвэл тодорхой зорилтоос зайлсхийх хэрэгтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг арга нь иргэд өөрсдөө гэмт халдлагад өртөхөөс сэргийлэх явдал бөгөөд дараах зөвлөмжийг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

Гудамж талбайд гэмт халдлагаас сэргийлэх нь

Оршин суугаа хаягийн харьяа цагдаагийн нэгжийн эсвэл цагдаагийн хэлтсийн яаралтай утасны дугаарыг мэдэж авах шаардлагатай.

- ~ Яаралтай тусламжийн утасны дугаарыг утасныхаа ойролцоо байлга (наалт, соронз гэх мэт).
 - ~ Яаралтай тусламжийн утасны дугаарыг хувийн гар утсандаа програмчлаарай.
- Явган явах үед дараах асуудлуудыг мөрдөж явах шаардлагатай.
- ~ зохион байгуулалттай танилцана уу. Хичээл болон харанхуй болсны дараа хичээлийн байр, явган хүний зам, байгууламж, зогсоолууд хангалттай хамгаалалттай, гэрэлтүүлэг сайтай байгааг харахын тулд оюутны хотхонд судалгаа хий.
 - ~ Өөрийн хүрэх хамгийн аюулгүй замыг төлөвлөх; гэрэлтүүлэг сайтай, ачаалал ихтэй зам, гудамж сонгох.
 - ~ Хичээлийн хуваариа эцэг эх, итгэлтэй найзуудтайгаа хуваалцаж, утасны дугаараа өгөөрэй.
 - ~ Шөнийн цагаар аль болох гэрэлтүүлэг сайтай газруудад наалдаж, тусгаарлагдсан газруудаар дамжин өнгөрөх гудамж, "богино зам"-аас зайлсхий.

- ~ Багаар аялж, шөнө ганцаараа гарахаас зайлсхий.
- ~ Шөнийн цагаар оюутны хотхоны дагалдан яваа үйлчилгээг ашиглана уу.
- ~ Яаралтай тусламжийн дуудлагын хайрцаг хаана байрлаж байгааг мэдэж, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар сур.
- ~ Хэрэв таныг дагаж байгаа бол чиглэлээ өөрчилж, хамгийн ойрын бизнес, гэр рүүгээ яв; хаалгыг нь тогшиж, хэн нэгнийг цагдаа дуудахыг хүс. Таныг дагаж буй хүний тайлбарыг анхаарна уу.
- ~ Хажуугийн хажуугаар явж, бут сөөг болон бусад нуугдмал газраас зайлсхий.
- ~ Найз эсвэл өрөөний найздаа хаашаа явж байгаагаа, хэдэн цагт буцаж ирэхээ хэлээрэй.
- ~ Эргэн тойрондоо болон эргэн тойрныхоо хүмүүст сонор сэрэмжтэй байгаарай.
- ~ Түрийвчээ биедээ ойртуулж, чанга атгах; түрийвчээ дээлний дотор талын халаасанд эсвэл өмдний урд халаасандаа хийж яваарай.
- ~ Түлхүүрээ түрийвч, үүргэвчнээсээ тусад нь байлга.
- ~ Өөрийгөө цүнх, боодолд хэт ачаалж болохгүй, хөдөлгөөнийг тань хязгаарласан гутал өмсөхөөс зайлсхий.
- ~ Өөртөө итгэлтэй алхах; толгойгоо өргөөд эргэн тойрноо хар.
- ~ Хэрэв жолооч зогсоод зам асуувал машинаас зайгаа бариарай.

Гэр орон сууцанд гэмт халдлагаас сэргийлэх нь

- ~ Хаалгаа үргэлж түгжиж байгаарай; унтаж байхдаа эсвэл зүгээр л коридороор явж байхдаа ч гэсэн.
- ~ Танихгүй хүмүүсийг танай өрөөнд эсвэл танай цогцолбор руу бүү оруул. Орох гэж буй хүнийг танихгүй бол хаалгаа бүү нээ.
- ~ Үл мэдэгдэх хүмүүсийг "арын хаалга" руу бүү оруулаарай; Тэд хэнд зочилж байгааг асууж, нийтийн аюулгүй байдлыг хангахыг санал болго.
- ~ Хамгаалалтгүй зочдыг оршин суух танхимд (пицца хүргэх, найз нөхөд гэх мэт) оруулахын тулд гаднах хаалгыг онгойлгож болохгүй.
- ~ Алдагдсан эсвэл хулгайд алдсан байрны түлхүүрээ нэн даруй оршин суух газрынхаа ажилтнуудад мэдэгдээрэй.
- ~ Цоож, хаалга, цонхны эвдрэл гарсан тохиолдолд Residence Life компанийн ажилтнуудад мэдэгдээрэй.
- ~ Өрөөндөө байхгүй үед түлхүүрээ өрөөндөө орхиж болохгүй.
- ~ Өрөөндөө хэзээ буцаж ирэх тухай мессежийг хаалган дээрээ бүү үлдээ.
- ~ Хэрэв та нэг хонох эсвэл хэд хоног явахаар төлөвлөж байгаа бол өрөөний найз эсвэл найздаа хэлээрэй.
- ~ Оршин суух танхим эсвэл ойролцоох аливаа сэжигтэй хүн, үйл ажиллагаа (хуульчдыг оролцуулан) байгаа талаар өөрийн оршин суух танхимын ажилтан, Олон нийтийн аюулгүй байдал эсвэл цагдаад мэдэгдээрэй.
- ~ Үнэт зүйлсээ хамгаалж, үнэтэй эд зүйлсийг таних мэдээллээр сийлээрэй.
- ~ Шөнийн цагаар, ялангуяа нэг, хоёрдугаар давхарт амьдардаг бол хаалга, цонхоо үргэлж түгжиж байгаарай.
- ~ Иргэний үнэмлэх, түлхүүр, түрийвч, чекийн дэвтэр болон бусад үнэт зүйлсээ ил задгай орхиж болохгүй.
- ~ RA, Residence Life ажилтнууд болон хөршүүдтэйгээ танилцаарай

Тээврийн хэрэгслээр зорчихдоо анхаарах зүйлс

- ~ Машинаа харагдахуйц гэрэлтүүлэг сайтай газар байрлуулах; фургон болон ачааны машины дэргэд зогсоол хийхээс зайлсхий.
- ~ Бүх эд зүйлсийг, ялангуяа үнэт зүйлсийг харагдахгүй байлгах; Ачааны машинд CD тоглуулагч/цавх гэх мэтийг салгах эсвэл байрлуулах.
- ~ Машины эвдрэлээс зайлсхийхийн тулд байнга засвар үйлчилгээ хийлгээрэй.
- ~ Машинаа үргэлж түгжээтэй байлгаарай.
- ~ Машинаа үйлчилгээнд үлдээхдээ бусад түлхүүрээ ав.
- ~ Машиндаа ойртохдоо түлхүүрээ бэлдээрэй. Дотогшоо орохын өмнө хэн ч нуугдаж байгаа эсэхийг шалгахын тулд машиныхаа дотор болон доороос шалгана уу.

Дугуйн замаар явахдаа анаарах зүйлс

- ~ Шөнийн цагаар унадаг дугуй унахдаа дугуйны гэрэл ашиглах.
- ~ Унадаг дугуй унахдаа үргэлж дуулга өмс.
- ~ Замын хөдөлгөөний бүх дүрмийг дагаж мөрдөх; уулзвар дээр зогсох ёстой; явган зорчигчид явах эрхтэй.
- ~ Хүрээлэн буй орчиндоо анхаарал хандуулах; явган зорчигчдыг хажуугаар нь өнгөрөхдөө анхааруул.
- ~ Зогсоолын гарцаар гарах эсвэл зогсоолоор машин жолоодохдоо болгоомжтой байгаарай.
- ~ Эргэх эсвэл зогсохдоо гараараа зөв дохио өгөх.
- ~ Эгнээ гарахын өмнө гараараа дохио өгнө. Зөвхөн аюулгүй үед л эгнээгээ орхи.
- ~ Унадаг дугуйгаа хүнд даацын U-түгжээ эсвэл гинжээр бэхлээрэй. Боломжтой бол ядаж урд дугуй болон хүрээгээ дугуйны тавиур эсвэл бусад суурин зүйлд түгжээрэй.
- ~ Унадаг дугуйгаа хаалганы үүдэнд, шатан дээр эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орох замыг хааж болохгүй. Дугуйн тавиур ашиглах.
- ~ Унадаг дугуйгаа таних дугаарыг сийлбэрлэж эсвэл бүрмөсөн тэмдэглэж, олон нийтийн аюулгүй байдал эсвэл цагдаад тэмдэглэнэ үү.

Явган явахдаа анхаарах зүйлс

- ~ Харанхуй, хоосон, эзгүй газар нутгаас зайлсхийх; гэрэлтүүлэг сайтай замыг ашиглах.
- ~ Ялангуяа шөнийн цагаар ганцаараа алхах/гүйх/гүйхээс зайлсхий. Найзаасаа чамтай хамт явахыг хүс. Оройн цагаар оюутны хотхоны эргэн тойронд таныг дагалдан явахын тулд нийтийн аюулгүй байдлын алба руу залгана уу.
- ~ Хөдөлгөөнд саад учруулахгүй хувцас, гутал өмс.
- ~ Хүрээлэн буй орчиндоо үргэлж сонор сэрэмжтэй, анхаарал болгоомжтой бай. Аюултай байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэх, хариу үйлдэл үзүүлэхэд тань муугаар нөлөөлдөг чихэвч зүүхээс зайлсхий.
- ~ Сэжигтэй үйл ажиллагаа эсвэл чимээ шуугианыг нэн даруй мэдэгдээрэй.
- ~ Дуу чимээ гаргах төхөөрөмжийг үргэлж биедээ авч явах, хэрэв та аюулд орсон гэж сэжиглэж байгаа бол хэрэглээрэй. Гэрэлтэй газар эсвэл барилга руу нүүж, үймээн дэгдээнэ. Яаралтай байдлын үед 102 руу залгах эсвэл цэнхэр гэрэлтэй яаралтай тусламжийн утсыг идэвхжүүл.

Цахим халдлагаас сэргийлэх арга

- ~ Өдрийн цагаар АТМ ашиглахыг хичээгээрэй. Хэрэв та шөнө явах ёстой бол ганцаараа явах хэрэггүй.
- ~ Гэрэлтүүлэг муутай эсвэл гудамжнаас тодорхой харагдах АТМ-аас зайлсхий.
- ~ Хүмүүс АТМ-ийн эргэн тойронд тэнүүчилж, машин дотор сууж байгааг анхаараарай.
- ~ Гүйлгээгээ урьдчилан бэлдээрэй. Машин дээр их цаг зарцуулж болохгүй.
- ~ Хувийн таних дугаараа (ПИН) хэнд ч бүү өг! Олон хулгайч тантай утсаар холбогдож, цагдаа, хамгаалалтын ажилтан эсвэл банкны ажилтан гэж мэдэгдэн ПИН дугаарыг чинь хулгайлахыг оролдох болно. Цээжлээд, хэтэвчиндээ бичгээр хуулбарлаж болохгүй.
- ~ Нэг бол АТМ-ын баримтаа хадгалаарай, эсвэл ураад хая.

Аюул халдлага болохоос өмнөх үед:

- ~ Боломжтой бол болзошгүй аюулаас холдох; гудамж хөндлөн гарч хурдаа нэмэгдүүлээрэй.
- ~ Ойролцоох бүлэг хүмүүстэй нэгдээрэй.
- ~ Хэрэв аюул заналхийлэх нөхцөл байдал ойртож, хүмүүс ойрхон байвал хашгирах, хашгирах эсвэл тэдний анхаарлыг татахын тулд чадах бүхнээ хий. 102 руу залгах болон галын дохиоллыг идэвхжүүлэх нь хувийн аюулгүй байдлын системийн нэг хэсэг гэдгийг санаарай. 102 дуудлага нь ихэнх төлбөртэй утаснаас үнэ төлбөргүй байдаг бөгөөд цэнхэр гэрэлтэй яаралтай тусламжийн утаснууд нь ихэвчлэн оюутны хотхоны олон хэсэгт байрладаг бөгөөд таны нөхцөл байдлын талаар яаралтай тусламжийн үйлчилгээнд мэдэгдэхийн тулд товчлуурыг дарахад л хангалттай.
- ~ Ойролцоох машины зогсоолд байх машины дохиололыг дугаргах.
- ~ Хэрэв та зэвсэгт гэмт хэрэгтэнтэй тулгарвал гэмт этгээдийн шаардлагыг биелүүлбэл өөрийгөө гэмтээх эрсдэлийг багасгаж чадна. Гэсэн хэдий ч таны амь насанд аюул тулгарвал зугтахын тулд чадах бүхнээ ашигла.

Санал:

1.Цахим орчны аюулгүй байдлын түвшинг өндөрсгөж, цахим аюул, заналын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, найдвартай нөөцөөс мэдээллийг сэргээх, мэргэжлийн байгууллагад хандах гэх мэт;

2. Хэрэглэгчийн нэр, нэвтрэх үг, дансны нууц дугаар зэрэг нь аливаа онлайн гүйлгээ, төлбөр тооцоо болон таны хувийн мэдээлэлд байнга хэрэглэгддэг. Иймд үсэг, тоо, бусад тэмдэгт оролцуулсан 8-аас доошгүй тэмдэгтээр нэвтрэх үгээ сайжруулж, түүнийгээ гурван сар тутамд тогтмол сольж хэвшээрэй. Мөн олон вэб сайтанд нэг л нэвтрэх үг ашиглах нь таныг эрсдэлд оруулах тул хэрэглэдэг үйлчилгээ, вэб сайт бүртээ өөр нэвтрэх үг ашиглах;

3. Компьютерийг удирдах, хэрэглэх эрхийг зааглан ялгаж, ердийн хэрэглэгчийн эрхийг хамгийн бага түвшинд байлгах зарчим баримтлах, эрхийн түвшинтэй уялдуулан мэдээ, мэдээлэлд хандах үйл ажиллагааг зохион байгуулах;

4. Оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй үйлдлийн систем, хэрэглээний болон вирусын эсрэг програм хангамж ашиглах, үйлдвэрлэгчээс гаргасан аюулгүй байдлын шинэчлэлтийг цаг тухайд нь авч хэрэгжүүлж хэвших;

5. Цахим орчинд мэдээллээ алдах, ашиглах боломжгүй болох, хууран мэхлэгдэх, залилуулах зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдээс ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэхэд сургаж дадлагажуулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

--o0o--

**ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧААС БОРООХОЙ, ЦАХИЛГААН
ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ
ЗАРИМ АСУУДАЛ**

**SOME PROBLEMS RELATED TO THE PROCEDURES AND PRECAUTIONS FOR
USING BATON AND ELECTRICAL BATON FROM INTERNAL MILITARY OFFICERS**

Г.Мэндбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн
сургуулийн Дотоодын цэргийн албаны тэнхимийн
ахлах багш, хошууч

Mendbayar. G

Department of Internal Troops Service of the Police
School, University of Internal Affairs Mongolia Senior
Lecturer, Major

Хураангуй: Дотоодын цэргийн алба хаагчаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх харьцах, ашиглах хадгалах, талаар болон хууль эрх зүйн болон бороохой, цахилгаан гүйдлээр цохигч хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтыг сайжруулахтай холбоотой асуудлыг тусгасан.

Summary: Issues related to the use of special tools, handling, storage, and legal and baton use and improvement of training are provided for the internal military servicemen in the implementation of their duties required by law.

Түлхүүр үг: Дотоодын цэрэг, Цагдаагийн байгууллага, Нэг бүрийн тусгай хэрэгсэл,

Keywords: Internal troop, police department, special tools,

Дотоодын цэргийн байгууллага нь улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох үндсэн чиг үүргийг гүйцэтгэхдээ нэг бүрийн тусгай хэрэгслийг холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэл журмын дагуу албаны үйл ажиллагаанд ашиглана.

Мөн үндсэн чиг үүргээс гадна Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын цэрэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх үед дотоодын цэрэгт галт зэвсэг тавьж олгохыг хориглодог байна.

- гудамж, талбай зэрэг олон нийтийн газарт үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, иргэний болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах

- гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоох

- /хорих ангиас оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох

- шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах

- гэрч, хохирогчийг хамгаалах

- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх;

- шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжоор болон эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах зорилгоор явуулж байгаа цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд оролцох.¹¹⁵

Иймд Дотоодын цэргийн алба хаагч зарим тохиолдолд өөрийн болон бусад хүмүүсийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хор уршиг учруулах аюултай тулгардаг.

Дотоодын цэргийн алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ тусгай хэрэгслийг хуулинд заасан үндэслэл журмын дагуу хэрэглэх зайлшгүй шаардлага гардаг. Тэр дундаа Дотоодын цэргийн алба хаагч нь нэг бүрийн тусгай хэрэгслийг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэдэг.

Мөн хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд анги, салбарын байрлал, эсхүл түүний гадна албан үүрэг, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэх үед дотоодын цэргийн алба хаагч тусгай хэрэгсэл, галт зэвсгийг холбогдох хууль, цэргийн нийтлэг дүрэмд заасан журмын дагуу хэрэглэнэ.¹¹⁶ гэж заасан байна.

Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх эрхтэй байна.

Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна гэжээ.¹¹⁷ Үүнд:

- гав;

- бороохой;

- цахилгаан гүйдлээр цохигч;

- нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

- резин болон хуванцар сумтай буу;

- нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.

Дотоодын цэргийн алба хаагч дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэнэ.¹¹⁸ Үүнд:

- өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулыг таслан зогсоох;

- гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах;

- зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй этгээдийг түр саатуулах;

¹¹⁵Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам Дотоодын цэргийн чиг үүрэг, эрх хэмжээ код 1/100

¹¹⁶Дотоодын цэргийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.3 дэх заалт

¹¹⁷Дотоодын цэргийн тухай хуулийн 21-р зүйлийн 21.1 дэх заалт

¹¹⁸Дотоодын цэргийн тухай хуулийн 22-р зүйлийн 22.1 дэх заалт

- түр саатуулагдсан этгээдийг цагдаагийн байгууллагад албадан хүргэх үед хүч хэрэглэн оргон зайлахаар завдсан, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх;
- хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;
- сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар довтолсон, эсхүл эсэргүүцсэн;
- хамгаалалтад байгаа объект, ачаа тээш, зорчигч, албаны байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөн, хамгаалалтад байгаа объектыг бүслэн хаасныг чөлөөлөх;
- дотоодын цэргийн алба хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тавсан шаардлагыг үл биелүүлж, хүч хэрэглэн эсэргүүцсэн;
- нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах, хамгаалалтад байгаа объект, ачаа тээшийг хууль бус халдлагаас хамгаалах;
- тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;
- хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан бусад тохиолдолд.

Дотоодын цэргийн алба хаагч нь албан үүрэг гүйцэтгэлийн онцлогоос хамааралтайгаар нэг бүрийн тусгай хэрэглэх эрхийг нь ялгамжтай зааглаж өгсөн байна. Тухайлбал:


Доор дурдсанаас бусад тохиолдолд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бэртэл гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно: Үүнд:

- Дотоодын цэргийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;
- галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсэргүүцсэн;
- амиа хорлож болзошгүй.

Дээр дурдсан үндэслэлээс бусад тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг дотоодын цэргийн алба хаагч тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргана¹¹⁹ гэж хуулинд тусгайлан зааж өгчээ.

Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, сэжигтэй этгээдийг аюул учруулахгүйгээр хяналтад авахад биеийн хүч хэрэглэх боломжгүй гэж алба хаагч үзсэн бол бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу, цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэж болно.

Дотоодын цэргийн байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүгээ гүйцэтгэхдээ дараах төрлийн резинэн бороохойг албандаа ашиглаж байна. Тухайлбал:



¹¹⁹Дотоодын цэргийн тухай хуулийн 22-р зүйлийн 22.3 дэх заалт

 80 см урттай хатуу шахмал резинэн бороохой	 100 см урттай хатуу төмөр голтой резинэн бороохой	 Г Хэлбэрийн бариултай шахмал резинэн бороохой	 80 см урттай, үзүүр хэсэгтэй булзуутай. Пүрштэй шахмал резинэн бороохой
---	--	--	---

Бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу хэрэглэх

- бороохойг хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах болон бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зэргээр хэрэглэх;

- бороохойг зайнаас хэрэглэхдээ хөдөлгөөнтэй хослуулах бөгөөд хэт ойрын зайнаас довтолж буй тохиолдолд гар, хөлийн цохилттой хослуулан хэрэглэвэл зохих;

- бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх;

- нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж, эсхүл алба хаагчийн амь бие, эрүүл мэндэд хохирол учруулахаар довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний тус газарт цохихгүй байхыг эрмэлзсэн байвал зохино гэж холбогдох зааварт зааж өгсөн байна.¹²⁰

Дотоодын цэргийн алба хаагчийн резинэн бороохойг хүний биед хэрэглэхийг зөвшөөрдөг дараах хэсгүүд байдаг. Тухайлбал:

- Дал хавсарч цохих
- Гар, хөлийн булчингийн хэсэг
- Зузаан гуяны хэсэг орчимд¹²¹

Гар, хөлийн булчингийн болон зузаан гуяны хэсэг орчимд резинэн бороохойг хэрэглэхдээ дагууд нь гуядаж ороолгох маягаар цохино. Учир нь хүний арьс, мах, булчин, шөрмөсний ширхэг дагуу байдалтай байдаг. Тиймээс хөндлөн цохивол эдгээр дурдсан хүний биеийн хэсэгт арьс, мах, булчин, шөрмөс тасрах, хөхрөх, няцрах, яс хугарах гэх зэрэг хүнд бэртэл, гэмтэл авч улмаар хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах эрсдэл бий болно.

Резинэн бороохойг хүний биед хэрэглэхийг хориглох тохиолдлууд:

Зөвшөөрснөөс бусад хүний биеийн хэсэг нь хориглох нөхцлийг бүрдүүлдэг байна. Тухайлбал:

- Хүний толгойны хэсэг;
- Цээж хэвлийн хэсэг;
- Гарын сарвууны хэсэг;

¹²⁰ Хууль зүй, дотоод цэргийн сайдын 2018 оны А/57 тушаалын 1-р хавсралт “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд, хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”-ын 3.8.1 дахь хэсэг

¹²¹ Ш.Чулуун “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2015 он 103 дахь тал

- Эмзэг эрхтэн;
- Гар, хөлийн булчин болон зузаан гуяны хэсэгт хөндлөн цохих;

Цагдаагийн алба хаагч дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд бороохой хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- Тусгай хэрэгслийг хэрэглэсний үр дүнд дахин хэрэглэх үндэслэл арилсан;
- Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүн;
- Хүүхэд /насанд хүрээгүй/;
- Ухаангүй согтуу хүн;
- Өндөр настан;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- Бэртэл гэмтэл нь илэрхий мэдэгдэж байгаа хүний тухайн гэмтэл дээр хэрэглэх;

Цахилгаан гүйдлээр цохигч хэрэгсэл

 Гар чийдэнтэй /том/ Хүчдэлийн эх үүсвэр 7.2 Вольт	 <u>JP-351-II</u> Гар чийдэнтэй, тогонд залгаж цэнэглэдэг. Хүчдэлийн эх үүсвэр: 7.2 вольт	 JP-512 Гар чийдэнтэй дунд Хүчдэлийн эх үүсвэр: 7.2	 Гар чийдэнтэй, жижиг хэмжээтэй	 Хэмжээ: 24x4 6x140м<1.9 цахилгаан чичиргээнд<0.8А гэрэлтүүлэг
--	---	---	--	--

Дотоодын цэргийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигчийг дараах байдлаар хэрэглэхээр зааварт нарийвчлан зааж өгчээ.¹²² Үүнд:

- Хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигчыг хэрэглэх зорилгоо тодорхойлж, хүний биед хувцасны гадна талаас хүргэн долгион нэг газар 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар хүргэн, байрлалыг сольж хэрэглэх бөгөөд энэ хугацаа нь араатан амьтанд 10 секундээс илүүгүй байхаар тооцогдоно.

- хүний арьсанд шууд хүрэлцэхэд түлэгдэх эрсдэлтэйг анхаарч боломжтой бүх тохиолдолд хүний биеийн ил харагдах хэсэгт хэрэглэхгүй байна.

- Дотоодын цэргийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгоо тодорхойлж, цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед чиглүүлэн хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж хэрэглэх бөгөөд энэ хугацаа нь араатан амьтанд 5 секундээс илүүгүй байхаар тооцогдоно.

Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны үйлчлэл нь хүний биеийн булчинлаг хэсэг зангирах, өвдөлт өгөх, мэдрэлийн систем түр сарних хэлбэрээр 5 минут үйлчлэх бөгөөд 20 минутын дараа үйлчлэл бүрэн

¹²² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/57 тушаалын 1-р хавсралт “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд, хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”-ын 3.9.1 дахь хэсэг

арилна.¹²³

Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны хэвийн ажиллагаа, унтраалгыг шалгаж, ажиллуулах бөгөөд бороо, устай газарт хэрэглэхээс зайлсхийх, чийгтэй газарт хадгалахыг хориглоно.

Цахилгаан гүйдлээр цохигчийн дуу, чимээг ашиглаж болох бөгөөд 1-5 секундээс илүү хугацаагаар нэг дор ажиллуулахаас татгалзах нь зүйтэй юм.

Дүгнэлт

Дотоодын цэргийн алба хаагч нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох сөрөг дагавараас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн албаны тусгай хэрэгслийг хэрэглэхдээ ашиглах аргачлал болон холбогдох аюулгүйн арга хэмжээг баримтлан ажиллах шаардлагатай. Энэ нь алба хаагчийн эрх зүйн баталгааг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж байна.

НҮБ-ийн байгууллагаас гаргасан холбогдох олон улсын гэрээ, конвенцийг албаны үйл ажиллагаандаа хэвшүүлж баримтлан мөрдлөг болгон ажиллах нь хүний эрхийг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж түүний баталгаа нь болж өгнө.

Санал

1. Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/06 тушаалаар батлагдсан Дотоодын цэргийн анги, тусгай салбар /салаа/-т мөрдөх аюулгүйн арга хэмжээний зааварт Дотоодын цэргийн алба хаагчаас албан үүрэг гүйцэтгэх үед тусгай хэрэгсэлтэй харьцах үед сахих аюулгүйн арга хэмжээг нэмж тусгах.

2. Дотоодын цэргийн алба хаагч нарт тусгай хэрэгсэлтэй харьцах, ашиглах хадгалах, талаар болон хууль эрх зүйн, чадварыг нэмэгдүүлэх сургалтыг тогтмол зохион явуулах.

3. Тусгай хэрэгсэлтэй харьцах, ашиглах хадгалах, биеийн хүчтэй хослуулан хэрэглэх, практикт гарсан алдаа дутагдал, сургамжинд тулгууралсан судалгаа хийж, судалгааны үр дүнг агуулсан эрдэм шинжилгээний бүтээл болгох, сурах бичиг, гарын авлага, диссертаци, магистрын ажил, эрдэм шинжилгээний өгүүллүүд хэвлэн гаргах, эдгээрийг сургалтанд болон практикт ашиглах.

Ашигласан материал

1. Дотоодын цэргийн тухай хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. ХЗДХС,УЕП-ын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/57 тушаалын хавсралт “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд, хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”
5. Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам
6. Ш.Чулуун “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2015 он
7. Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд 1990.09.07

¹²³ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/57 тушаалын 1-р хавсралт “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд, хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”-ын 3.9 дахь хэсэг

ГЭРЛЭН ДОХИОНЫ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

ORIGIN AND DEVELOPMENT OF LIGHT SIGNALS NEEDS

Н.Ганбат

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн
тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Ganbat.N

Head of Traffic Police Department of Police college at
University of Internal Affairs, Police lieutenant colonel

Товч агуулга. Гэрлэн дохио гэдэг нь гэрлэн дохиот төхөөрөмжийн дохио өгөгчийг нэрлэдэг. Гэрлэн дохио нь замын хөдөлгөөнд оролцогчдыг дохиогоор удирдан тодорхой байдлаар эмх цэгцэнд оруулдаг бол төрөл бүрийн хэлбэр, өнгөтэй замын хөдөлгөөний тэмдэг нь бүгд өөр өөрийн гэсэн утгатай байх ба зөвхөн явж буй урсгалын эсрэг чиглэлд замын хөдөлгөөнийг зохицуулна.

Энэхүү өгүүлэлд замын гэрлэн дохио үүссэн түүх болон гэрлэн дохионд тавигдах шаардлага, ангилал болон Улаанбаатар хот дахь төвийн зарим уулзварын гэрлэн дохио, замын тэмдэглэлийн өнөөгийн байдлыг авч үзэн нэвтрэлтийг нэмэгдүүлэх зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

Abstract: A traffic light is a signal generator of a traffic light device. Traffic lights direct traffic participants in a certain way by signaling, in construct traffic signs of various shapes and colors all have their meaning and regulate traffic only in the opposite direction.

In this article, the history of traffic lights, the requirements and classification of traffic lights, and the current status of traffic lights and road signs at some central intersections in Ulaanbaatar city are briefly discussed, and some ways to increase access are briefly discussed.

Түлхүүр үг. Автомашин, замын гэрлэн дохио, замын тэмдэг, замын тэмдэглэл, уулзвар, явган зорчигч, нэвтрэх чадвар,

Keywords: Cars, traffic lights, road signs, traffic notes, intersections, pedestrians, accessibility.

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-д “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”¹²⁴ гэж заасан нь иргэн замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөл боломжоор хангагдсан байх гэсэн утгыг давхар агуулж байна.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйл /Нийтийн хэв журам хамгаалах/-ийн 11.1.3-д “замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах”¹²⁵ гэж заасан байдаг нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хүлээж байгаагаар тодорхойлогдож байна. Тиймээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хөдөлгөөн зохицуулж буй замын гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэгээний ойлголт болон үүсэл хөгжлийн талаар эхэлж авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

¹²⁴ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

¹²⁵ Төрийн мэдээлэл. 2017. №6. Цагдаагийн албаны тухай хууль

Замын хөдөлгөөний техник хэрэгслийн тусламжтайгаар зохицуулах аргачлалыг хүн төрөлхтөн XVIII зууны үеэс нэтрүүлж эхэлсэн ба үүнийг европын хэд хэдэн орны түүхээс харж болно.

Монгол Улсын авто замын гэрлэн дохионы үүсэл хөгжил хамгийн анхны гэрлэн дохиог 1962 онд ЗХУ-ын тусламжтайгаар суурилуулж байжээ. Улмаар 1969 онд МУИС-ийн уулзвар, Төв шуудангийн уулзвар, Сансарын тунелын баруун уулзварт гэрлэн дохио суурилуулсан байна.¹²⁶

Харин 2004 оноос эхлэн хуучин лампан гэрэлтэй гэрлэн дохионуудыг лед гэрэлтэй гэрлэн дохионуудаар сольж эхэлжээ. Өдгөө Улаанбаатар хотын хэмжээнд 152 уулзвар, явган хүний гарц хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохиотой болж 2.3 дахин нэмэгджээ.

Олон улсын хэмжээнд хэрэглэгдэж байгаа замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионуудыг хийцийнх нь хувьд босоо болон хэвтээ гэрлэн дохио гэж хоёр хуваана. Ихэнх улс орнууд босоо байрлалтай гэрлэн дохиог хэрэглэх бөгөөд ийм гэрлэн дохионы улаан гэрэл нь дээд талдаа байрлана.

Зарим цөөн тооны улс орнууд хэвтээ байрлалтай гэрлэн дохиог хэрэглэх ба ийм гэрлэн дохионы улаан гэрэл нь эсрэг хөдөлгөөний тал байрладаг. Улаанбаатар хотод Солонгос улсын KETC компанийн KET2100 загварын хэвтээ гэрлэн дохиог ашигладаг бөгөөд одоогийн байдлаар 156 гэрлэн дохиог авто замын уулзвар болон явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор ашиглаж байгаа.


Монгол Улсын авто замын гэрлэн дохионы зохион байгуулалт Замын хөдөлгөөний удирдлагын төвийн цахим сайтаас авсан мэдээллээр авто замын өргөн буюу явган хүний гарцны урт 14 метр гэж бодоход явган зорчигчийн хурдыг 1.2 м/сек гэж үзээд ногоон гэрлийн асаах хугацааг хамгийн багадаа 12 секундээр тооцож асаадаг гэнэ. Явган зорчигчийн аюулгүй зам хөндлөн гарах нөхцөлийг хангах үүднээс ногоон гэрлийн асаах хугацааг тухайн явган хүний гарцын урт буюу авто замын зорчих хэсгийн өргөн, тухайн гарцаар нэвтрэн өнгөрч буй явган зорчигчийн тоо зэргээс хамааруулан олон улсын стандартыг дагуу явган хүний алхааны хурдыг 1 м/с-ээс 1,4м/с-ээр тооцоолон бодож өгдөг байна.

Замын хөдөлгөөн зохицуулахад улаан, шар, ногоон өнгийн гэрэл бүхий босоо буюу хэвтээ байрлалтай дохио хэрэглэнэ. Босоо байрлалтай дохионы гэрэл нь улаан, шар, ногоон өнгийн дарааллаар дээрээс доош, хэвтээ байрлалтай дохионы гэрэл нь мөн дарааллаар зүүн гар талаас баруун гар тийш байрлана. Явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулахад явган хүний дүрс бүхий дээд талдаа улаан, доод талдаа ногоон өнгийн гэрэлтэй дохио хэрэглэнэ. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио нь ногоон сум бүхий нэг буюу хоёр нэмэгдэл дохиотой, мөн ногоон гэрэл нь чиг заасан сумтай байж болно.

Дэлхийн хамгийн анхны гэрлэн дохиог морин тэрэгний хөдөлгөөнийг хянах, явган зорчигчдыг зам дагуу аюулгүй өнгөрөөх боломжийг олгох зорилгоор 1868 оны 12-р сарын 10-нд Их Британийн нэгдсэн вант улсын нийслэл Лондон хотод, Парламентын ордны гадаа төмөр замын инженер Жон Пик Кнайт-н зохион бүтээсэн байна. Уг дохио нь 6 м өндөр, 1.2 метр урт гартай хийгээр ажилладаг гэрлэн дохио байжээ.¹²⁷

¹²⁶ http://www.traffic-institute.mn/g_instruction/g-03/g-03-00/g-03-00-01.html

¹²⁷ <http://www.ubtraffic.mn/home/v/78920>



Тус гэрлэн дохио нь гар ажиллагаатай ба өдрийн цагаар цагдаагийн ажилтан гэрлэн дохионы гар /семафор/-ыг өргөж буулган тээврийн хэрэгслүүдийг хөдөлгөөнөө цааш үргэлжлүүлэх үү, зогсох уу гэсэн дохиог өгдөг байсан байна. Гэрлэн дохионы гар /семафор/ нь хөндлөн байрлалтай байвал “Зогс”, харин 45 градусын налуу байвал болгоомжтой зорчихийг илэрхийлдэг байжээ.

Харин шөнийн цагаар гэрлэн дохионы гар /семафор/ жолооч, явган зорчигчдод харагдахгүй учраас гарны оронд улаан болон ногоон өнгийн гэрэл асан хөдөлгөөнийг зохицуулдаг хийн чийдэнтэй байсан бөгөөд улаан өнгийн гэрэл дохио нь “зогсох”, ногоон өнгийн дохио нь “болгоомжтой байх” утгыг илэрхийлдэг байжээ. Гэрлэн чийдэнг хийгээр ажиллуулдаг тул ашиглалтын хугацаа богино байсан ба шөнийн цагаар гэрлэн чийдэн дэлбэрч, тэднийг хянаж байсан цагдаагийн ажилтнуудыг шархдуулсан харамсалтай тохиолдол гарч байсан байна.

Анхны автомат буюу хүний оролцоогүйгээр ажилладаг гэрлэн дохио

Анхны автомат буюу хүний оролцоогүйгээр өөрөө дохиогоо сольдог автомат ажиллагаатай гэрлэн дохиог 1910 онд Чикаго хотын оршин суугч Эрнест Сиррин зохион бүтээж патентын эрхийг авсан байна.

Түүний бүтээл гэрэлтүүлэггүй бөгөөд "Stop" буюу Зогс" болон "Proceed" буюу "Явах" бичиг эргэлддэг байсан байна.

1900-аад оны эхээр дэлхий маш хурдацтай хөгжиж, аж үйлдвэржилт хөгжихийн хэрээр хотууд улам бүр хөл хөдөлгөөнтэй болж, мөн автомашин зохион бүтээсэнтэй холбоотойгоор авто замууд дахь ачаалал эрс нэмэгдсэн тул замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай болсон байна.


Замын хөдөлгөөний удирдлагын төв

2010 оны 07 дугаар 01-ны өдөр Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнд хяналт тавьж, хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохиог удирдан замын хөдөлгөөнийг оновчтой, шуурхай зохион байгуулах үүрэгтэй Замын хөдөлгөөний удирдлагын төв

байгуулагдсан ба тухайн үед 65 уулзвар, явган хүний гарцын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохиотой байсан. Өдгөө Улаанбаатар хотын хэмжээнд 152 уулзвар, явган хүний гарц хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохиотой болж 2.3 дахин нэмэгдээд байна.¹²⁸

Замын тэмдэглэгээ нь замын хөдөлгөөнд тодорхой хэмжээний дэг журам гаргах боломжийг олгодог. Мэдээжийн хэрэг, одоогийн байдлаар замын аль ч хэсэгт зөв хөдөлгөөнийг зохион байгуулах боломжтой маш олон замын тэмдэг байдаг. Гэсэн хэдий ч тэмдэглэгээгүйгээр хийх боломжгүй юм.

Шөнийн цагаар тэмдэглэгээ нь жолооч нарт тусалдаг. Хатуу цагаан шугамын тусламжтайгаар



¹²⁸ <http://www.olloo.mn/n/70215.html>

зорчих хэсгийн ирмэгийг тэмдэглэсэн бөгөөд энэ нь шөнийн цагаар ойлголтыг ихээхэн сайжруулдаг.

Орчин үеийн замын тэмдэглэгээний түүх алс холын 1911 оноос эхэлдэг. Маш олон машинтай байхад замын комисс ямар нэгэн байдлаар хөдөлгөөнийг цэгцлэх ёстой гэсэн дүгнэлтэд хүрсэн. Тэр үед ганцхан засмал зам байсан энэ нь Мичиган мужид байсан.

Энэ зам дээр анхны цагаан тусгаарлах зурвасыг тавьсан юм. Энэ зурвасын зорилго нь маш энгийн байсан бөгөөд энэ нь замыг хоёр урсгалд хуваасан байв. Дараа нь бусад замд ижил төстэй тэмдэглэгээ хийж эхэлсэн. Хожим нь төв цагаан тууз нь замын хөдөлгөөнийг хуваах гол хэрэгсэл болсон.

Ер нь тэр үед замын тэмдэглэлийн талаар нэлээдгүй туршилт хийдэг байсан. Германд бүр хар тэмдэглэлтэй байсан. Гэсэн хэдий ч хар өнгийн тэмдэглэгээ нь үр дүнгүй байсан тул орчин үеийн тэмдэглэгээнд энэ өнгийг бараг ашигладаггүй гэж таамаглахад хялбар байдаг. Цагаан, хар өнгийн хослолыг одоогоор босоо тэмдэглэгээнд ашиглаж байна. Хар ба цагаан судлууд нь ихэвчлэн бүх төрлийн саад тогтор, хашаа болон бусад босоо замын байгууламжийг заадаг.

Цаг хугацаа өнгөрөхөд автомашины тоо тасралтгүй нэмэгдэж, зөвхөн нэг тусгаарлах эгнээ нь хөдөлгөөнийг зохион байгуулахад хангалтгүй байв. Энэ үе шатанд хэд хэдэн төрлийн замын хэвтээ тэмдэглэгээ үүсч эхлэв.

Өөр өөр хотуудад замын хяналтын газрууд өөрсдийн сонголт, нэг буюу өөр тэмдэглэгээний хэрэгжилтийг санал болгодог. Эцсийн дүндээ Замын мэргэжлийн хяналтын газрынхан энэ чиглэлээр тодорхой стандартчилал хийх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Жолооч нарыг төөрөгдүүлэхгүйн тулд тэмдэглэгээ нь хаа сайгүй ижил байх ёстой байв. Энэ шийдвэрийн дараа бүх зүйл нэг стандартад нийцсэн тул замын тэмдэглэгээг өөрчлөх ажил нэлээд хурдан явагдсан. Бүх саналыг өмнө нь авч үзэж, зөвшөөрсний дараа л хэрэгжүүлдэг байсан. Одоогийн байдлаар бид тусгай ГОСТ-той бөгөөд үүний дагуу бүх замын тэмдэглэгээг ашигладаг. Энэхүү ГОСТ нь бүх боломжит тэмдэглэгээний тодорхой тодорхойлолтыг агуулдаг.¹²⁹

Замын гэрлэн дохио

Явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулахад явган хүний дүрс бүхий дээд талдаа улаан, доод талдаа ногоон өнгийн гэрэлтэй дохио хэрэглэнэ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио нь ногоон сум бүхий нэг буюу хоёр нэмэгдэл дохиотой, мөн ногоон гэрэл нь чиг заасан сумтай байж болно.

Гэрэл дохио нь дор дурдсан утгатай байна:

а/ногоон гэрэл дохио нь хөдөлгөөнийг зөвшөөрнө. Ногоон гэрэл анивчих нь түүний зөвшөөрсөн утгыг өөрчлөхгүй бөгөөд хориглох гэрэл асах гэж байгааг анхааруулна;

б/шар гэрэл дохио нь гэрэл дохио солигдох гэж буйг анхааруулах бөгөөд энэ дүрмийн 5.2-т зааснаас бусад тохиолдолд хөдөлгөөнийг хориглоно;

в/анивчсан шар гэрэл дохио нь хөдөлгөөнийг зөвшөөрөх бөгөөд тухайн уулзвар буюу явган хүний гарц зохицуулгагүй болсныг мэдээлж болгоомжтой явахыг анхааруулна;

г/улаан гэрэл дохио буюу түүний анивчих нь хөдөлгөөнийг хориглоно. Улаан гэрэл дохиотой хамт ассан шар гэрэл дохио нь хориглосон утгыг өөрчлөхгүй бөгөөд ногоон гэрэл дохио асах гэж байгааг анхааруулна.

¹²⁹<https://sdmontag.ru/blog/2-istoriya-poyavleniya-dorozhnoj-razmetki.html?fbclid=iwar1trfmdzstrxj9nzx0vcfrzmritythhki6lkqmlwxnrr9wjzj7r-rawag>

Нэмэгдэл гэрэл дохио нь зөвхөн сум заасан чигийн хөдөлгөөнийг зохицуулна. Зүүн гар тийш чиг заасан сум бүхий гэрэл дохио нь зүүн гар тийш болон буцаж эргэх хөдөлгөөнийг зохицуулна.

Нэмэгдэл гэрэл дохио асаж байвал сум заасан чигт хөдөлгөөнийг зөвшөөрөх бөгөөд асаагүй (гэрлэн дохионы зохицуулгатай үед) бол уг чигт хөдөлгөөнийг хориглоно. Энэ тохиолдолд үндсэн гэрэл дохио нь нэмэгдэл дохионы сум зааснаас бусад чигийн хөдөлгөөнийг зохицуулна.

Монгол улсын гэрлэн дохионы төрөл, бүтэц болон суурилуулах ерөнхий шаардлагыг “Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4980:2014 болон “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4598:2014¹³⁰ -р тодорхойлсон байдаг.

Гэрлэн дохио тавих шалгуур

Гэрлэн дохио зохицуулгыг нэвтрүүлснээр уулзвар дахь хамгийн аюултай цэгүүдийг алга болгодог бөгөөд, ингэснээр хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд нөлөөлдөг. Гэвч үүнтэй зэрэгцээд гэрлэн дохио байрлуулсан уулзвар зам дээр ч гэсэн тээврийн хэрэгслийн түгжрэл гардаг. Иймд гэрлэн дохио зохицуулга нь тийм ч үр дүнтэй зүйл биш бөгөөд тээврийн хэрэгслийн урсгалын эрчмийн болон Зам тээврийн ослын нөхцөл байдал болон тооноос шууд хамааралтай. Уулзвар зам болон явган хүний гарам дээр гэрлэн дохион зохицуулгыг дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелж байгаа тохиолдолд байрлуулна.

Нөхцөл 1. Гол болон туслах замууд дээрх хөдөлгөөний эрчмийн аюулын зэргийн хослолоор. Ажиглалт хийгдэж буй уулзвар дахь тээврийн хэрэгслүүдийн урсгалын эрчим нь байгаа үзүүлэлтээс багагүй байх үед

Нөхцөл 2. Тээврийн хэрэгслийн болон явган зорчигчдын урсгал-эрчмүүдийн аюулын зэргийн хослолоор. Жирийн ажлын өдрийн 8 цагийн аль нэг цагийн турш автозамын 2 чиглэлд 600 нэгж/цаг автомашин явж өнгөрдөг (тусгаарлах зурвастай зам дээр 1000 нэгж/цаг) ба энэ үед энэхүү уулзвараар хамгийн ачаалалтай хэсгээр нь 150 хүн/цаг ихгүй хүн нэвтэрч байвал.

Хүн ам нь 10.000-аас ихгүй суурин газар нөхцөл 1 ба 2-ын үзүүлэлтүүдийг 30%-иар багасгаж тооцно.

Нөхцөл 3. Хэрэв нөхцөл 1 ба 2 бүрэн хэмжээгээр биелэгдэхгүй харин 80%-тай биелэгдэж байвал гэрлэн дохионы зохицуулгыг нэвтрүүлдэг.

Нөхцөл 4. Зам тээврийн ослын тоогоор тодорхойлогдоно. Тухайн уулзвар дээр сүүлийн 12 сарын турш 3-аас багагүй ЗТО гарсан (гэрлэн дохио тавьснаар осол аваар багассан байвал) ба нөхцөл 1 ба 2-ын аль нэг нь 80%-тай биелэгдэж байвал гэрлэн дохион зохицуулга нэвтрүүлсэн нь үр дүнтэй байна.¹³¹

Хүснэгт №1.Авто замын гэрлэн дохионы техникийн үндсэн шаардлага. Монгол улсын “Авто замын гэрлэн дохио. Техникийн үндсэн шаардлага” MNS4980:2014 стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохионд тавигдах шаардлага	
1	Т.2.а Индексийн гэрлэн дохио байна.
2	Улаан, шар, ногоон гэсэн дараалалтай байна.
3	Бүх гэрлүүд нь LED гэрэлтэй байх ба ажлын гадаргуугийн хэмжээ 300мм байна.

¹³⁰https://transportation.police.gov.mn/resource/traffic/media/huuli/MNS_4597-2014_Temdeg_er_shaaardlaga.pdf

¹³¹ Зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, нөхцлийг тогтоох зарим арга хэмжээ

4	Гэрлэн дохионы улаан, шар, ногоон гэрлүүдийн гэрэлтэх чадвар нь 500cd-с багагүй байна.
5	Цахилгаан тэжээл нь 220V 50Hz-д ажилладаг байна.
6	Гэрлийн саравч нь 240мм-ээс багагүй байна.
7	Тоос шороо, ус нэвтрэхгүй битүүмжлэлтэй байна.
8	IP 65 стандарт шаардлагыг хангасан байна.
9	Механик гэмтэл гарсан үед хэсэгчлэн солих, засварлах боломжтой байна.
10	Гэрлэн дохио нь шинэ, урьд өмнө хэрэглэгдэх байгаагүй байна.

Төрөл ба үндсэн үзүүлэлтүүд

3.1 Гадаргуу, замын хашлага, замын байгууламжийн элементүүд, замын нөхцөл сайжирсан замын зорчих хэсэг дээр замын тэмдэг, гэрлэн дохиотой хослуулан ашигладаг бие даасан шугам, бичээс болон бусад тэмдэглэлийг хэвтээ тэмдэглэл гэж үзэх ёстой.

3.2 Хэвтээ ба босоо гэсэн хоёр бүлэг тэмдэглэл байдаг. Тэмдэглэгээний төрөл бүрт цифрүүдээс бүрдсэн тоог өгдөг бөгөөд энэ нь эхний дугаар нь тухайн тэмдэглэл хамаарах бүлгийн дугаар (1 - хэвтээ, 2 - босоо), хоёр дахь нь тухайн бүлгийн тэмдэглэлийн дарааллын дугаар, гурав дахь нь тэмдэглэлийн төрөл юм.

3.3 Тэмдэгтийн төрөл бүрийн тоо, хэлбэр, өнгө, хэмжээ, зориулалтыг хавсралтад өгсөн болно (хүснэгт ба). Сум, үсэг, тооны хэтжээг хавсралтад өгсөн болно (зураг -).

3.4 Хэвтээ тэмдэглэл нь байнгын болон түр зуурын байж болно. Түр замын тэмдэглэгээний функц нь замын ажлын үргэлжлэх хугацаа эсвэл тэдгээрийг танилцуулах шаардлагатай болсон үйл явдлаар хязгаарлагддаг.

1.4, 1.10, 1.17 -аас бусад замын түр тэмдэглэл нь улбар шар өнгөтэй байх ёстой бөгөөд үүнийг хурдан арилгах боломжтой материалаар хийсэн байх ёстой.

3.5 Замын тэмдэглэлийн шугамыг ашиглах дүрмийг ГОСТ R 52289¹³² -д өгсөн болно.





Замын гэрлэн дохио, замын тэмдэглэлийн хоорондын зохицлын өнөөгийн байдал

Улаанбаатар хотын хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулахаар тавигдсан гэрлэн дохионуудийн 63 нь 4 замын уулзварын, 46 нь 3 замын уулзварын (online-81 offline- 28) 47-н явган хүний гарц дээр тавигдсан гэрлэн дохио (online-29 offline- 18) байна. Нийт ажиллаж байгаа- 156 зам засварын ажлаар буусан -7 байршил байна.

Төвөөс удирдаж байгаа явган -16, Төвөөс удирдаж байгаа уулзвар -72 нийт 88 уулзварыг төвөөс удирдаж байна. Нийт 163 гэрлэн дохио байгаагаас зарим нэг онцлох уулзварыг сонгон авч үзвэл:

Хүснэгт №2. МУИС-ийн уулзвар

¹³²https://transportation.police.gov.mn/resource/traffic/media/huuli/MNS_4597-2014_Temdeg_er_shaardlaga.pdf


Үе		МУИС										Нийт	
		Бүтэн үе											
Горим		1-р үе		2-р үе		3-р үе		4-р үе		5-р үе			
													
Тээврийн хэрэгслийн гэрлэн дохио асах хугацаа	00:00-06:00	15	сек	11	сек	39	сек	25	сек	25	сек	115	сек
	06:00-10:00	15	сек	20	сек	45	сек	31	сек	29	сек	140	сек
	10:00-17:00	15	сек	20	сек	45	сек	31	сек	29	сек	140	сек
	17:00-22:00	15	сек	20	сек	45	сек	31	сек	29	сек	140	сек
	22:00-00:00	15	сек	11	сек	39	сек	25	сек	25	сек	115	сек
Явган зорчигчийн гэрлэн дохио асах хугацаа	Улаан гэрэл		сек		сек		сек		сек		сек		
	Ногоон		сек		сек	15	сек	9	сек	7	сек		
	Анивчсан ногоон		сек		сек	15	сек	13	сек	12	сек		
	Нийт ногоон гэрэл		сек		сек	30	сек	22	сек	19	сек		

МУИС-ийн уулзвар ертөнцийн зүгээр баруунаас зүүн тийш явах энэ уулзварын гэрлэн дохио нь сувагчлал хийсэн болхоор зөв байна.

МУИС-ийн уулзвар ертөнцийн зүгээр зүүнээс баруун тийш явах чиг гэрлэн дохио явах нэмэлт секц асахгүй байгаа нь гэрлэн дохио тэмдэглэл зөрчигдөхгүй байна. МУИС-ийн уулзвар ертөнцийн зүгээр урдаасаа хойш чиглэлд уулзварын тэмдэглэл нь (зүүн эргэх, чигээрэй, баруун эргэх буюу чигээрэй) явах гэрлэн дохио (зүүн эргэх, чигээрэй, чигээрэй буюу баруун эргэх) нь баруун нэмэлт ассан үед гэрлэн дохио болон тэмдэглэл хоёр зөрчилдөж байна.

МУИС-ийн уулзвар ертөнцийн зүгээр хойноосоо ургаш чиглэлд уулзварын тэмдэглэл нь (зүүн эргэх, баруун эргэх буюу чигээрэй, баруун эргэх) явах гэрлэн дохио (зүүн эргэх, чигээрэй, баруун эргэх) нь баруун нэмэлт ассан үед гэрлэн дохио болон тэмдэглэл хоёр зөрчилдөж 1-р үе болон 2-р үеийн гэрлэн дохио асах үед урдаас баруун эргэх нэмэлт секц асах үед гэрлэн дохио хэвтээ тэмдэглэл 2 зөрчигдөж байна.

Хүснэгт №3. Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвар

Үе		Хүнсний 4								Нийт	
		Бүтэн үе									
Горим		1-р үе	2-р үе	3-р үе	4-р үе						
Тээврийн хэрэгслийн гэрлэн дохио асах хугацаа	00:00-06:00	22	сек	22	сек	23	сек	23	сек	90	сек
	06:00-10.00	24	сек	25	сек	36	сек	25	сек	110	сек
	10.00-17.00	24	сек	25	сек	36	сек	25	сек	110	сек
	17.00-22.00	26	сек	26	сек	29	сек	29	сек	110	сек
	22:00-00:00	22	сек	22	сек	23	сек	23	сек	90	сек
Явган зорчигчийн гэрлэн дохио асах хугацаа	Улаан гэрэл		сек		сек		сек		сек		
	Ногоон	9	сек	9	сек	9	сек	9	сек		
	Анивчсан ногоон	10	сек	10	сек	10	сек	10	сек		
	Нийт ногоон гэрэл	19	сек	19	сек	19	сек	19	сек		

Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвар ертөнцийн зүгээр урдаасаа хойш чиглэлд уулзварын тэмдэглэл нь (зүүн эргэх буюу чигээрээ, баруун эргэх буюу чигээрээ) явах

гэрлэн дохио (зүүн эргэх, чигээрээ буюу баруун эргэх) нь баруун нэмэлт ассан үед гэрлэн дохио болон тэмдэглэл хоёр зөрчигдөж байна.

Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвар ертөнцийн зүгээр зүүнээс баруун чиглэлд уулзварын тэмдэглэл нь (зүүн эргэх буюу чигээрээ, чигээрээ, баруун эргэх) явах гэрлэн дохио нь (зүүн эргэх, чигээрээ, чигээрээ буюу баруун эргэх) зөрчилгүй байна.

Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвар ертөнцийн зүгээр баруунаас зүүн чиглэлд явах уулзварын тэмдэглэл нь (зүүн эргэх, чигээрээ, баруун эргэх) явах гэрлэн дохио нь (зүүн эргэх, чигээрээ, баруун эргэх) байна. Хүнсний 4-р дэлгүүрийн уулзвар ертөнцийн зүгээр хойноос урагш чиглэлд уулзварын тэмдэглэл нь (зүүн эргэх, чигээрээ, баруун эргэх) явах гэрлэн дохио нь (зүүн эргэх, чигээрээ, чигээрээ буюу баруун эргэх) байна.

Улаанбаатар хотын уулзвар, явган хүний гарцын гэрлэн дохионы ажиллах дараалал болон асах хугацааг тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдын тоо, уулзварын бүтэц буюу хөдөлгөөн зохион байгуулалт, зэргэлдээ уулзварын нэвтрүүлэх чадвартай уялдуулж, хөдөлгөөнд оролцогч тал бүрд тэгш эрхтэйгээр, уулзварын хөдөлгөөн нэвтрүүлэх чадвар, хөдөлгөөний аюулгүй байдал хамгийн их байхаар тооцоолон өгдөг.

Мөн уулзваруудын хоорондын зай, тухайн замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн тоо хурдад нийцүүлэн зэргэлдээ байрласан 2-5 уулзварыг холбож ногоон гэрийн долгион үүсгэсэн байдаг ба энэ нь тухайн аль нэг уулзвараар ногоон гэрлээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл зэргэлдээ байрласан нэг буюу хэд хэдэн уулзвараар ногоон гэрлээр нэвтрэн гарахаар тохируулсныг хэлнэ.¹³³

Нэмэлт секцтэй гэрлэн дохио дээр нэгдүгээр эгнээнд чигээрээ буюу баруун гэсэн тэмдэглэлийг тавьж хэрэглэх нь жолоочид буруу ойлголт түрүүлж, замын хөдөлгөөний эрчмийг удаашруулж гэрлэн дохио тэмдэглэл хоёр зөрчигдөж байна.

Замын тэмдэглэл нь гэрлэн дохиогоо дагаж тэмдэглэлээ засварлаж хийх нь чухал. Иймд тэмдэглэлийг термо-пластик, хүйтэн хуванцар эсвэл бусад ижил төстэй материалаар хийсэн тэмдэглэл нь дор хаяж нэг жил, будаг, лакаар дор хаяж 6 сар ажиллах ёстой.

Замын тэмдэг, тэмдэглэгээний ашиглалтыг сайжруулах зорилгоор дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Авто замын хөдөлгөөнд шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээг байршуулах хангалттай газар байгаа эсэх.
- Тэмдэг, тэмдэглэгээний дохионы тавцан шаардлагатай эсэх.
- Мөргөх өндөр эрсдэлтэй газраас аль болох хол байршилд хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан эсэх.

Гэрэлтүүлэг

- Гудамжийг гэрэлтүүлэгтэй байхаар төлөвлөсөн эсэх.
- Шинэ уулзвар дээр болон одоо ашиглагдаж буй замын холбоос дээр гэрэлтүүлгийг харгалзан үзсэн эсэх.
- Хамгийн оновчтой байршлуудад гэрэлтүүлгийн шонг байршуулсан эсэх. (жишээ нь: хамгаалалтын хашлагын ард талд)¹³⁴

Дүгнэлт

Замын дагууд тэмдэг, тэмдэглэлээр сайтар хангаж жолооч нарыг чиглүүлж өгөх нь тээврийн хэрэгсэлүүд замаас гарах осол аваар үүсэхээс урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын нэн чухал хэсэг юм байна.

¹³³ <http://www.ubtraffic.mn/home/v/28825>

¹³⁴ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном. УБ.2018. 86 дахь тал

Тэмдэг болон тэмдэглэлийг жолооч нарт заавар, мэдээлэл өгөх, ойртож буй замын талаар мэдэгдэхэд зориулан ашигладаг ч үүнийг иргэд тэр бүр мэддэггүй нь зам тээврийн осол гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна. Тухайлбал, эргэлт болон эргэлтийн шинж байдал гэх мэт авто замын чиглэлийн өөрчлөлтүүд, харагдах байдал эсвэл гүйцэж түрүүлэхэд тохиромжгүй байдал, уулзварын өмнө хурдаа сааруулах эсвэл зогсох шаардлагатай эсэх, эгнээний хэлбэр эсвэл замын өргөний өөрчлөлтүүд, замын ажил явагдах гэх мэт тохиолдолд замын нөхцөл байдал түр өөрчлөгдөж байгааг иргэд мэдэрсч замын хөдөлгөөнд оролцох явдал юм.

Өнөөдөр Улаанбаатар хотын замын тэмдэг тэмдэглэл болон замын гэрлэн дохионы хоорондын харилцан хамаарлыг авч үзвэл зөрчилтэй байдал цөөнгүй байгааг холбогдох байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авч зохих арга хэмжээ авах шаардлага тулгарч байна. Тухайлбал, замын хөдөлгөөний ачаалал ихтэй хүнсний 4-р дэлгүүрийн уулзвар ертөнцийн зүгээр урдаасаа хойш чиглэлд уулзварын тэмдэглэл нь явах гэрлэн дохио нь баруун нэмэлт ассан үед гэрлэн дохио болон тэмдэглэл хоёр зөрчигдөж байгаа нь зам тээврийн осол гарахад нөлөөлж байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Санал

1. Нийслэлийн авто замын газар, Тээврийн цагдаагийн алба Улаанбаатар хотын замын тэмдэг, тэмдэглэгээнүүд замын гэрлэн дохиотой зөрчилдөж байгаа хэсгүүдийг илрүүлэх хамтарсан ажлын хэсгийг байгуулж, өнөөгийн бодит байдлыг тодорхойлох;
2. Тээврийн цагдаагийн албанаас тэмдэг, тэмдэглэлийн арчлалтад хяналт тавьж, “Улаанбаатар зам засварын газар” орон нутгийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт мэдэгдэл шаардлагыг тогтмол хүргүүлж, хамтран ажиллах;
3. Замын тэмдэг стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхийг төрийн бус байгууллагын тусламжтайгаар судалгаа хийлгүүлэх;
4. Замын тэмдэг, тэмдэглэгээ шаардлагатай газраа байрлаж, үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг судалж, илрүүлэх ажлыг Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн авто замын газартай хамтарч хэрэгжүүлэх гэх мэт.

--o0o--

ГУДАМЖ ТАЛБАЙД АРХИДАН СОГТУУРАХ ЯВАЛТАЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

SOME OF THE PROBLEMS OF DRINKING ALCOHOL
IN PUBLIC PLACES

Д.Нямдорж

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн хошууч

Nyamdorj.D

Police School of the University of Internal Affairs
teacher Department of Police Law, police majior

Товч агуулга: Энэхүү өгүүллээр гудамж талбай зэрэг олон нийтийн эдэлбэр газарт иргэд согтууруулах ундааны зүйл хэрэглэн согтуурсны улмаас үйлдэгдэх гэмт

хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчны өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: In this article, we aim to determine the current state of the legal environment aimed at preventing and suppressing crimes and violations caused by the consumption of alcoholic beverages in public spaces such as streets and squares, and creating conditions for citizens to live in a safe environment.

Түлхүүр үг:

Архидан согтуурахтай тэмцэх, гудамж талбай, нийтийн эдэлбэр газар, аюулгүй орчин

Keywords: Anti-alcoholism, streets, public spaces, safe environment

Үндсэн хэсэг:

Хот суурин газрын гудамж талбай, орон сууцны гадна байрлах саравч, цэцэрлэг, сургуулийн хашаа зэрэг олон нийтийн эдэлбэр газарт согтууруулах ундааны зүйлийг ил, далд хэрэглэж буй иргэдтэй бид цөөнгүй таардаг.

Эдгээр иргэдийн зүгээс үйлчилгээний газарт согтууруулах ундааны зүйл үнэтэй борлуулагддаг учир өөрсдөд ая тухай гэсэн олон нийтийн газрыг сонгон, тэндээ согтууруулах ундааны зүйлийг хэрэглэн өөрсдийн эрх чөлөөгөө эдэлж байна гэж үзэж байхад. Гудамж талбай олон нийтийн эдэлбэр газарт Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн иргэд чанга дуу чимээ гаргах, бусдыг үл хүндэтгэх, өөр хоорондоо болон бусадтай үл ойлголцон маргалдах, ойр орчмоор нь өнгөрч яваа хүүхэд, хөгшдийг айлгаж ичээх, зэргээр бидний ирээдүй болсон үр хүүхэд, залуучуудад буруу үлгэр дуурайлал үзүүлэх байна гэж үздэг хүмүүс бас бий.

Тэгвэл Согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжээд удаагүй байна. Энэ хуулийг Монгол Улсын Үндсэн хууль¹³⁵, Зөвшөөрлийн тухай хууль¹³⁶, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль¹³⁷, Хүнсний тухай хууль¹³⁸, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль¹³⁹, Эрүүл ахуйн тухай хууль¹⁴⁰, Гаалийн тухай хууль¹⁴¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бөгөөд уг хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс өмнө хэрэглэж байсан “Архидан согтуурахтай тэмцэх туулийг хүчингүй болгосон байна.

Шинэ, хуучин хуулийг ерөнхийд нь харьцуулан үзвэл Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль нь 7 бүлэг, 41 зүйлтэй

¹³⁵ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

¹³⁶ Зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны ... дугаарт нийтлэгдсэн.

¹³⁷ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

¹³⁸ Хүнсний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

¹³⁹ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 02

дугаарт нийтлэгдсэн.

¹⁴⁰ Эрүүл ахуйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹⁴¹ Гаалийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

ба шинэлэг сайн талыг нь авч үзвэл “Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, архидаан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архидаан согтуурахтай тэмцэж ажлыг зохицуулах¹⁰ арга замыг ойлгомжтой, дэлгэрэнгүй байдлаар нэг бүрчлэн зааж өгсөн зэрээр маш олон талаараа илүү болжээ.

Мөн хуулийн хориглох заалтад “Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа, 21 нас хүрээгүй, жирэмсэн хүмүүсийг согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно¹² гэж заасан мөртлөө хэрэглэж болохгүй газар, цэгийг тодорхой зааж өгөөгүй учир гудамж талбай олон нийтийн газарт зэрэг хүссэн газраа согтууруулан ундааны зүйл хэрэглэх боломжтой болгосон нь учир дутагдалтай мэт.

Харин өмнө хэрэглэж байсан “Архидаан согтуурахтай тэмцэх тухай хууль” нь 5 бүлэг, 16 зүйлээс¹¹ бүрдэж байсан ба шинээр хэрэгжиж буй хуулиас 2 бүлэг, 25 зүйлээр бага ба хийж хэрэгжүүлэх ажлыг ерөнхий заасан зэргээс харахад олон талаараа учир дутагдалтай боловч уг хуулийн гуравдугаар бүлэгт:

7 дугаар зүйл. “Согтууруулах ундаа хэрэглэх”, худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл

7.1. Дараахь газарт согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно:

7.1.1. төрийн болон төрийн бус байгууллагын албан байр;

7.1.2. согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байр;

7.1.3. хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газар;

7.1.4. оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр;

7.1.5. орон сууцны орц, хонгил;

7.1.6. гудамж, талбай, цэцэрлэг;

7.1.7. галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар;

7.1.8. нийтийн тээвэр, хүнсний болон барааны зах, худалдаа, үйлчилгээний газар зэрэг олон нийтийн газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт” гэж хэрэглэхийг хориглосон газар, цэгийг тодорхой заасан нь өнөөдрийн хэрэгжиж буй шинэ хуулиас давуу байж болох юм.

Шинээр хэрэгжиж буй хуулийг хэрэгжихээс өмнө болсон хуулийн үйл явцыг судлан үзвэл Архидаан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийн 2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Гудамж талбай зэрэг олон нийтийн зарим газруудад согтууруулах ундааны зүйл хэрэглэх, нийтэд ил тод, нээлттэй барьж явах, лац, ломбо, баглаа, боодлыг нь хөндсөн байдалтай авч явахыг хориглох, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлнэ” гэж тусгайлан заасан байсан боловч “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хууль” гэсэн нэршлээр өөрчлөн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газар, цэгийг заасан” зүйл, хэсгийг огт оруулаагүй байна.

Дээрх хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуулийн үзэл баримтлалын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд 2022 оны 06 дугаар сарын 30 өнөр, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр тус тус хэлэлцүүлэн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан.

Өнөөдрийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс хэд

хоногийн дараа буюу 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэлээдгүй хэдэн нэмэлт өөрчлөлт оруулсан боловч мөн л согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газар, цэгийн талаар нэмэлт өөрчлөлт ороогүй байгаа нь гудам талбай олон нийтийн газарт согтууруулах ундааны зүйлийг хэрэглэж болно гэдгийг бататгаж байна.

Согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хуулийн цөөнгүй зүйл, хэсэгт “Нийтийн эдэлбэр газар” гэж заажээ уг нэр томъёог ¹Монгол улсын газрын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх хэсэгт “Нийтийн эдэлбэрийн газар” гэж зохих журмын дагуу нийтээр ашиглахаар тогтоогдсон төрийн өмчийн газрыг гэж томъёолсон байна.

Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн офицер нартай хийсэн уулзалтаар Нийтийн зориулалттай орон сууцны гадна хүмүүс архидаад байна, архи ууж байсан хүмүүс хоорондоо зодолдоод байна, чанга дуу чимээ гаргаад амраахгүй байна, хажуугаар нь явж байсан хүүхдүүдийг айлгаад байна гэсэн утга бүхий дуудлага мэдээллийг тухайн оршин суугч иргэдийн зүгээс маш ихээр ирүүлдэг.

Цагдаагийн алба хаагч нар түргэн шуурхай очиж гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй эсэхээс хамаарч шийдвэрлэдэг. Дээрх дуудлага мэдээллийн дийлэнх тохиолдол нь гудамж талбай, цэцэрлэг, сургуулийн хашаа зэрэг олон нийтийн газар согтууруулах ундааны зүйл хэрэглэн согтуурсан зүй бус үйлдэл байдаг. Өмнө хэрэгжиж байсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар бол уг зөрчлийг гаргасан хүн тус бүрт хориглосон газарт архидан согтуурсан гэсэн үндэслэлээр арга хэмжээ явах, шаардлага биелүүлэхгүй, байгаа болон зөрчлөө таслан зогсоохгүй байгаа хүмүүсийг эрүүлжүүлэх зэргээр шийдвэрлэдэг байсан бол шинээр хэрэгжиж буй Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр гудамж талбайд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүнд ямар нэгэн арга хэмжээ тооцохгүй боломжгүй болсон. Учир нь уг хуульд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглосон газар, цэгийг зааж өгөөгүй ба хориглосон заалт байхгүй.

Одоо урин дулааны цаг ирж байгаа тул гудамж талбайд архидан согтуурч буй дуудлага мэдээлэл ихсэн хандлагатай байна. Мөн иргэдийн зүгээс хуульд хориглосон заалт байхгүй гэдгийг мэдэх тусам гудамж талбайд архидан согтуурах нь ихсэх байх. Шинээр хэрэгжиж буй уг хуулийг хэрэгжиж эхэлсэн анхны сард цагдаагийн алба хаагчид нэг мөр ойлгон хэрэгжүүлээгүйн улмаас гудамж талбайд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн цөөнгүй иргэдэд хуучин хуулийн хуульд заасан арга хэмжээг оногдуулж хуулийг буруу хэрэглэсэн зөрчил гарсан. Одооч энэ талаар мэдээгүй цагдаагийн алба хаагч нар цөөнгүй байгаа талаар ярилцсан.

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт хориглосон газарт архидан согтуурсан зөрчлийн сүүлийн 5 жилийн судалгаа

Он	Үйлдэгдсэн зөрчлийн тоо	Торгуулийн хэмжээ, мөнгөн дүн
2018	364	9,100,000
2019	656	16,400,000
2020	1090	27,250,000

2021	1080	27,000,000
2022	1041	26,025,000

Мөн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны 1 дүгээр сард хориглосон газарт архидан согтуурсан 178 хүнийг 4,450,000 төгрөгөөр торгосон байна. Харин 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хуульд хориглосон газрыг зааж өгөөгүй байтал мөн оны 1 дүгээр сард 92 хүнийг хориглосон газарт архидан согтуурсан үндэслэлээр торгож шийдвэрлэсэн нь нэг талдаа хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлээгүй гэдэг нь харагдаж байгаа боловч нөгөөтээгүүр иргэдээс олон нийтийг газарт архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулаад байна гэсэн бусдын эрх зөрчигдсөнд үндэслэн хариуцлага тооцсон байх тул цаашид бидэнд энэ төрлийн маргааныг шийдвэрлэх хууль, эрх зүйн хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг харуулж байна.

Мөн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн нийт дуудлага мэдээллийн 1,5 хувь буюу 24 нь гудамж талбай олон нийтийн газарт архидан согтуурч улмаар бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж амраахгүй байна гэжээ. Үүнээс харахад иргэдийн аюулгүй орчинд, амгалан тайван амьдрах эрх зөрчигдөж байгааг харуулж байна.

Дүгнэлт

Гудамж талбай нийтийн эдэлбэр газарт согтууруулах ундааны зүйл хэрэглэж буй иргэдээс бидний ирээдүй болсон үр хүүхдүүд буруу үлгэр дуурайлал авах өндөр эрсдэлтэй, мөн таны эрх бусдын эрхээр хязгаарлагдана гэсэн зарчмын дагуу тухайн орчин нөхцөлд амарч буй иргэд болон оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амгалан тайван амьдрах нөхцөлийг ноцтой зөрчиж байна гэж дүгнэхээр байна.

Санал

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд Согтууруулах ундааны зүйлийг ууж, хэрэглэхийг хориглосон газруудыг нэмж оруулах үүнд:

1. төрийн болон төрийн бус байгууллагын албан байр;
2. согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байр;
3. хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газар;
4. оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр;
5. орон сууцны орц, хонгил;
6. гудамж, талбай, цэцэрлэг;
7. галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар;
8. нийтийн тээвэр, хүнсний болон барааны зах, худалдаа, үйлчилгээний газар зэрэг олон нийтийн газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт” гэж нэмэлт өөрчлөлт оруулах санал дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
2. Зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны ... дугаарт нийтлэгдсэн.

3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

4. Хүнсний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

5. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

6.Эрүүл ахуйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

7.Гаалийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

--о0о--

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

КРИПТОВАЛЮТ АШИГЛАН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

LEGAL REGULATION OF CRIME COMMITTED USING CRYPTOCURRENCY,
CURRENT SITUATION

П. Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын
эрх зүйн тэнхимийн ахлах багш, Цагдаагийн дэд хурандаа

P.Erdenebaatar

Senior teacher, Police Lieutenant Colonel of Department Criminal
Procedure Law, Police school of University of Internal Affairs

Б. Билэгжаргал

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх
зүйн тэнхимийн лаборант, магистрант цагдаагийн дэд ахлагч

B.Bilegjargal

Assistant teacher, Police Deputy Leader of Department Criminal
Procedure Law, Police school of University of Internal Affairs

Товч агуулга: Монгол Улсад криптовалютын зах зээл биткойны ханшийн өсөлтийн эхний үе болох 2017 оны сүүлээс эрчимтэй хөгжиж эхэлж, криптовалютын зах зээлийн арилжаанд оролцдог, дотоодын биржүүдэд албан ёсны бүртгэлтэй нийт 150 гаруй мянган иргэд, аж ахуйн нэгж байдаг гэсэн тоог Монгол банкны 2021 оны Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаанд дурдсан байна. Монгол улсын хүн амын дунд криптовалютын талаар мэдлэг мэдээлэл дутмаг, ямар түвшинд байгаа талаар тодорхой мэдээлэлгүйгээс шалтгаалж залилах гэмт хэрэгт өртөх магадлал өсөж байна. Залилах гэмт хэрэгийн талаар тодорхой судалгаа хийгдээгүй нь энэ асуудлыг судлах, энэ төрлийн аргаар үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн

шалгах ажиллагаа явуулах, прокурорын хяналт тавих хэрэгцээ шаардлагын талаар авч үзсэн.

Abstract: The probability of fraud crime is increasing due to the lack of knowledge and information about clear information about its level of cryptocurrency among the people of Mongolia. The fact that there is no specific research on the crime of fraud shows that there is a need to study this issue, to conduct an investigation into this type of crime, and to supervise the prosecutor. The lack of specific research on the crime of fraud indicates the need to study this issue, to conduct investigations into this type of crime, and to supervise the prosecutor.

Түлхүүр үг: Виртуал хөрөнгө, Санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ), блокчэйн криптовалют, цахим залилан.

Keyword: Virtual stock, Financial Action Task Force (FATF), Blockchain Crypto exchange, cyber fraud.

Үндсэн хэсэг.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ-аас (FATF) гаргасан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартад (ФАТФ-ын 40 зөвлөмж) 2018 оны 10 дугаар сард Зөвлөмж 15-д орсон өөрчлөлтөд тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь “виртуал хөрөнгөд” нэгэн адилаар үйлчлэхээр тогтож, ФАТФ-ын хүлээн зөвшөөрсөн нэр томьёонд “виртуал хөрөнгө” болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” нарыг тодорхойлсон байна.

Виртуал хөрөнгө нь шинэ технологийн үндсэн дээр үүссэн, цаашид ч техник, технологийн хөгжлийг дагаад шинээр санхүүгийн үйлчилгээний тоо ихсэж, түүнийг дагаад гарах эрх зүйн зохицуулалтууд нэмэгдэх хандлагатай байна.

ФАТФ-аас гаргасан нэр томьёонд виртуал хөрөнгө гэж дижитал хэлбэрээр арилжаалагдах, хувирах, шилжүүлэгдэх боломжтой төлбөр тооцоонд эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах боломжтой үнэ цэнийг ойлгоно гэж тодорхойлжээ. Тухайлбал, дижитал хэлбэрээр илэрхийлэгдсэн албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаас болон бусад санхүүгийн хөрөнгийг тусгайлан оруулаагүй байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь виртуал хөрөнгийг албан ёсны мөнгөн дэвсгэртэд хөрвүүлэх, олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих, виртуал хөрөнгийн шилжүүлэг гүйцэтгэх, виртуал хөрөнгийг хадгалах, хэтэвч үүсгэх, виртуал хөрөнгийг удирдах хэрэгслийг зохицуулах, виртуал хөрөнгийг худалдахтай холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байх бөгөөд шилжүүлэг гэдэгт иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс нэг виртуал хөрөнгийг өөр виртуал хөрөнгийн төрөлд эсхүл нэг данснаас өөр дансанд шилжүүлэхийг ойлгож байна.

Виртуал хөрөнгө нь хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээг өндөр нууцлалтай, түргэн шуурхай, хялбар, зардал багатайгаар хүргэх, уламжлалт санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжгүй этгээд ашиглах боломжтой зэрэг давуу талуудыг үүсгэж байгаа ч олон улсын стандартад нийцсэн хяналт, зохицуулалтгүйгээр өмч хөрөнгийг нуун дарагдуулах, хөрөнгийн эс үүсвэрийг нууцлах, татвараас зайлсхийх, гэмт хэрэгтнүүд болон террорист этгээдүүдийн санхүүгийн гүйлгээг дамжуулах, мөнгө угаах болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Дээр дурдсан ФАТФ-ын зөвлөмжид виртуал хөрөнгөтэй холбоотой шаардлага нэмэгдсэний дагуу бусад орнууд ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх үүднээс өөрсдийн

хууль тогтоомжийг шинэчилж, нэгэнт хэрэглээнд нэвтэрсэн виртуал хөрөнгийг зохицуулах, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарт тавигдах шаардлага, үүргийг тодорхойлж өгснөөр виртуал хөрөнгийг хөрөнгө (asset) гэж албан ёсоор хүлээн зөвшөөрч өөрсдийн хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж байна.

Виртуал хөрөнгө нь дижитал хэлбэрээр буюу тодруулбал цахим орчинд, биет бус хэлбэрээр байдаг бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол улсын иргэн, хуулийн этгээд виртуал өмч, хөрөнгө эзэмшдэг эсэх мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд байгаа эсэх мөн эрсдэлийг тодорхойлсон талаар албан ёсны судалгаа байдаггүй боловч виртуал хөрөнгө олж авах, шилжүүлэх, үйлчилгээ авах нь зөвхөн Монгол улсын хил хязгаараар хязгаарлагдахгүй тул олон улсын эрхтэй төлбөрийн карт ашиглан интернэтээр дамжуулан хэн ч хэзээ ч ашиглах бололцоо нээлттэй байна. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр криптовалют олборлодог тоног төхөөрөмж манай улсад хэдийнээ нэвтэрч иргэд, хуулийн этгээд орлого олох зорилгоор худалдан авч байршуулсан тухай мэдээлэл гарсан байдаг.

Эндээс үзэхэд виртуал хөрөнгө эзэмшигч болон үйлчилгээ үзүүлэгч хүн, хуулийн этгээд Монгол Улсад байгаа гэж үзэх боломжтой бөгөөд одоо хүчин төгөлдөр хууль, тогтоомжийг судлахад Иргэний хуульд л биет бус хөрөнгийн тухай зохицуулалт байдаг ч виртуал хөрөнгийн нарийвчилсан зохицуулалт байхгүй мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт л төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх харилцааг зохицуулсан, Татварын ерөнхий хуульд цахим хөрөнгөөс татвар авах зохицуулалт байхгүй, Авлигын эсрэг хуульд болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлэгт виртуал хөрөнгийг бүртгүүлэх шаардлага тавигдаагүй, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд ийм төрлийн үйлчилгээ үзүүлэгч нь аль байгууллагаас тусгай зөвшөөрөл авах болон зохицуулагч байгууллага нь аль байгууллага байх талаарх зохицуулалт байхгүй байна.

Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд виртуал хөрөнгийн гүйлгээг тусгайлан зохицуулаагүй, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (МУТСТТ) болон Үй олноор зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамруулаагүй, санхүүгийн үйлчилгээ хүртэгч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа хийгдэхгүй байна. Иймд, эрх зүйн зохицуулалтгүй байгаа нь өмнө нь дурдсан тус технологийн шийдлийг буруугаар ашиглаж, үүсэж болох эдийн засаг, хүн хуулийн этгээдэд хохирол учруулах, түүнчлэн гэмт хэргийг мөрдөн шалгах, түүнд тавих прокурорын хяналтыг сайжруулах асуудал өнөө үед тавигдаж байна. Цаашилбал, хариуцлагын тогтолцоогүй, виртуал хөрөнгө эзэмшигч өмч хөрөнгөөрөө хохирох тохиолдолд тухайн хэргийг хэрхэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүнд хяналт тавих, шийдвэрлэх үйл явц тодорхойгүй байна.

Технологийн дэвшлүүд ар араасаа гарч, зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх нь санхүүгийн инновац болон үр ашигтай байдлыг үүсгэж цаашлаад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж буй хэдий ч зарим төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь гэмт хэрэгтэн, террористуудад мөнгө угаах эсвэл өөрсдийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх арга замуудыг бий болгож байдаг. Эдгээр технологийн дэвшилтэт шийдлүүдийн нэг нь виртуал хөрөнгө юм.

Виртуал хөрөнгө гэдэг нь дижитал хэлбэрээр арилжих, шилжүүлэх боломжтой бөгөөд төлбөр, тооцоо мөн хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох үнэ цэнэ

бүхий дижитал буюу биет бус хөрөнгө юм. Гэхдээ үүнийг фиат мөнгө, үнэт цаас болон бусад санхүүгийн хөрөнгийн дижитал хэлбэр гэж ойлгох нь оновчгүй юм.

Улс орнуудад виртуал хөрөнгийг ашигладаг дараах төрлийн санхүүгийн үйл ажиллагаанууд түгээмэл явагдаж байна. Үүнд:

- Виртуал хөрөнгийн арилжаа;
 - Онлайн цахим платформыг ашиглан виртуал хөрөнгийг шилжүүлэх, арилжаалах үйлчилгээ. Зарлагдсан ханшийн дагуу виртуал хөрөнгийг өөр хооронд нь эсхүл фиат мөнгөнд шилжүүлэн арилжаалдаг;
 - Арилжааны зориулалтаар шинээр виртуал хөрөнгө гаргах үйлчилгээ.
- Виртуал хэтэвчний үйлчилгээ;
 - Хэрэглэгчдийн өмнөөс виртуал хөрөнгө эсхүл фиат мөнгийг төвлөрүүлж, хадгалан арилжаа явагдахад туслах үүрэгтэй оролцдог үйлчилгээ.
- Анхдагч зах зээл дээр койн гаргах;
 - Виртуал хөрөнгийг олон нийгэд санал болгох үйлчилгээ.
- Виртуал хөрөнгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ;
 - Виртуал хөрөнгийг худалдан авах, виртуал хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ.

- Виртуал хөрөнгийн биржийн үйл ажиллагаа
 - Виртуал хөрөнгийг хооронд нь болон албан ёсны мөнгөн тэмдэгтэд арилжаа зарчмын хүрээнд худалдан авагч болон худалдагчийн хооронд урьдчилан тохирсон үнийн дагуу арилжаанд зуучлагчийн үйлчилгээ.

Виртуал хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь дараах үйл ажиллагаанаа явуулдаг хувь хүн болон хуулийн этгээдийг хэлнэ.

1. Виртуал хөрөнгө болон фиат мөнгөний арилжаа;
2. Виртуал хөрөнгө хоорондын арилжаа;
3. Виртуал хөрөнгийн шилжүүлэг¹⁴²;
4. Виртуал хөрөнгө эсвэл түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүдийн удирдлага, хадгаламж;
5. Виртуал хөрөнгийг худалдах, худалдан авахтай холбоотой санхүүгийн үйлчилгээ.

Виртуал хөрөнгийн хамгийн түгээмэл хэлбэрийн нэг нь “crypto currency” буюу криптовалюта бөгөөд 2008 онд биткойныг бүтээснээр¹⁴³ анхны цахим мөнгөн дэвсгэрт эхлэл тавигдсан гэж үздэг.

Тархсан P2P сүлжээ гэдэг нь сүлжээнд оролцогч буюу зангилаанууд нь газар зүйн хувьд тархсан байдаг ба аль ч хоёр зангилаа хоорондоо байршлаас үл хамааран ямар нэг серверээр дамжилгүйгээр өөр хоорондоо шууд холбогддог сүлжээ юм.

• DLT технологи нь мэдээллийг тархсан P2P сүлжээний оролцогч нар дээр хадгалдаг технологи бөгөөд уламжлалт өгөгдлийн сангийн системээс ялгарах гол ялгаа нь төвлөрсөн өгөгдлийн сан болон төвлөрсөн удирдлагын функц байхгүйд оршино¹⁴⁴.

• Блокчэйн гэдэг нь DLT технологийн гол төлөөлөгч бөгөөд мэдээллийн гинжин хэлхээ юм. Блокчэйнд тогтсон хэмжээтэй блок үүсгэж, үүн дотроо мэдээллийг хадгалах ба эхний блок дүүрэхэд дараагийн шинэ блок үүсгэдэг. Эдгээр блок нь хэйш функцээр

¹⁴² Виртуал хөрөнгийн хувьд виртуал хөрөнгө шилжүүлэх гэж хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг данс, хаягнаас нөгөө данс, хаяг руу шилжүүлэх гүйлгээ хийхийг хэлнэ.

¹⁴³ Хамгийн анх блокчэйн технологийн талаар 2008 онд Сатоши Накамото гэдэг этгээдийн нийтэлсэн “Биткойн: P2P электрон мөнгөний тогтолцоо” судалгааны ажлын нийтлэлд дурдагдсан байдаг.

¹⁴⁴ Distributed Ledger. Available: <https://www.investopedia.com>.

кодлогдсон байх ба блокийг цаг хугацааны дагуу жагсааж, блок тус бүр яг өөрийн өмнөх блокийн мэдээллийг өөр дотроо хадгалах байдлаар гинжин бүтцийг үүсгэнэ.

- Криптограф хэйш функц нь оруулсан өгөгдлийн уртаас үл хамааран тогтсон урттай хэйш утгуудыг буцаадаг. Оролтын зөвхөн нэг тэмдэгт өөрчлөгдөхөд гаралтын хэйш утгууд нь эрс ялгаатай байна. Энэ шинж чанарыг ашиглан, гүйлгээний өгөгдөл болон бусад бүх өгөгдлийн хувьд засвар ороогүй болохыг баталгаажуулах боломжийг олгодог.

- Ухаалаг гэрээ гэдэг¹⁴⁵ нь дундын зуучлагч буюу хуульч, нотариатгүйгээр хоёр этгээд гэрээ байгуулсныг баталсан компьютерийн код бөгөөд тухайн гэрээний нөхцөл, үүрэг, хариуцлагыг багтаасан байна. Анх этереум нь ухаалаг гэрээг оруулсан блокчэйн гэдгийг гаргаж, түүний дараагаар олон тооны блокчэйн ухаалаг гэрээг оруулж ирсэн. Ухаалаг гэрээ нь зөвхөн нөхцөл, үүргийг заахаас гадна автоматаар биелэх боломжтой байдаг.

Блокчэйн технологийн хамгийн чухал, онцлох давуу тал нь төвлөрсөн бус тархсан бүтэцтэй бөгөөд сүлжээнд байгаа бүх компьютер блокчэйний халдашгүй чанарыг үргэлж баталгаажуулж байдаг ба хэн нэгэн, эсвэл аль нэг компани үүн доторх өгөгдөл түүний бүрэн бүтэн байдлыг удирдах боломжгүй байдагт байгаа юм. Блокчэйний бүх зангилаа ижил мэдээллийг агуулж байдаг болохоор “А” зангилаан дахь өгөгдөл эвдэрч гэмтвэл блокчэйний хэсэг болж чадахгүй, учир нь өгөгдөл нь бусад “В” болон “С” зангилааны өгөгдөлтэй ижил байж чадахгүй болно.

Блокчэйн технологи нь хөгжлийн эхний шатандаа явж байгаа тул цөөнгүй сорилт, шийдвэрлэх шаардлагатай асуудал бий. Технологи, институци, хууль эрх зүйн орчны зохицуулалтын хувьд блокчэйн технологийн потенциалыг бизнес, эдийн засагт бүрэн нэвтрүүлж, үр өгөөжийг нь хүртэхэд дараах гол сорилт тулгарч байна:

- Тархсан сүлжээнд хяналт, баталгаажуулалтыг хурдтай хийхэд өндөр хурдтай тооцоолон бодох чадвартай компьютер, их хэмжээний дата хадгалах сервер, тэдгээрийг ажиллуулах эрчим хүч шаардлагатай. Эдгээр асуудалд оновчтой шийдэл олоогүй цагт блокчэйн технологи олон салбарт нэвтэрч, өргөн тархах боломж хязгаарлагдмал юм. Ялангуяа их хэмжээний эрчим хүчний хэрэглээ нь дэлхийн дулаарлын эсрэг олон улсын гэрээ, конвенцитай хэрхэн уялдах нь тодорхой бус байна. Үү

- Тухайн гүйлгээ буюу мэдээллийн үнэн зөв эсэхийг сүлжээний нийт оролцогч нийтээр баталгаажуулж байгаа нь блокчэйний хэмжээ томрох тусам улам их цаг хугацаа, эрчим хүч шаардана. Блокчэйний хэмжээ томрох тусам сүлжээний нийт оролцогч бүр дээрх мэдээллийг яг адил байлгах нь бэрхшээлтэй тулгарна.

DLT ашигласан системд хяналтыг хэрхэн тавих нь тодорхойгүй байна.

Тухайн системд хяналт хийх эрх аль нэг хяналтын байгууллагад өгөгдсөн тохиолдолд тухайн байгууллага нь халдлагын бай болж болох тул хяналтын хэрэгсэл, нууц түлхүүр алдагдвал системийн нийт мэдээлэл эрсдэлд орно.

- Блокчэйн технологи амьдралд нэвтрэхийн хэрээр хувийн мэдээлэл цахим орчинд их хэмжээгээр байрших болж, кибер аюулгүй байдлын асуудал улам хүчтэй тавигдах болно. Энэ үед мэдээллийн нууцлал алдагдахгүй байх, хакерын үйл ажиллагаанаас сэргийлэх сайн шийдэлгүй байх нь уг технологи өргөн нэвтрэх боломжид саад учруулах эрсдэлтэй.

- Блокчэйн аливаа салбарт нэвтрэхийн хэрээр технологийн нэгдсэн стандарт, эрх зүйн орчны баримтлах нийтлэг дүрмүүд, зохицуулалт зэрэг хэм хэмжээ тодорхой болох

¹⁴⁵ <https://forexdigital.net/mn/> 2022 оны 08 дугаар сард хандав.

шаардлагатай. Харин одоогийн байдлаар нэгдсэн хууль дүрэм, мөрдөх стандарт алга байна.

• Блокчэйн технологийг судалж нэвтрүүлэхэд аливаа байгууллагаас багагүй хэмжээний хүн хүч, хөрөнгө зардал шаардагдана. Үүнийг ажил хэрэг болгохын тулд институцийн бүтэц, зохион байгуулалтаас эхлээд санхүүгийн эх үүсвэр зэргийг оновчтой шийдвэрлэх шаардлагатай. Харин технологийг нэвтрүүлснээр хүртэх өгөөжийг бодитоор нарийвчлан тооцох нь амаргүй юм.

Эдийн засгийг тулгуураар нь өөрчлөх боломжтой сүүлийн үеийн технологи нь DLT гэж зарим мэргэжилтнүүд үзэж байна. Технологи санхүүгийн тогтолцоог хурдацтай өөрчилж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, арга барилыг нэвтрүүлж буй тул зохицуулагч нарын хувьд ч, бизнесийн байгууллагуудын хувьд ч финтек чухал сэдэв болжээ. DLT нь мэдээллийг хурдтай, хямд дамжуулахаас гадна аюулгүй байдал, нууцлалыг өндөр түвшинд хадгалах боломжийг олгож байна.

Блокчэйн технологи бизнесийн олон салбарт инновацыг бий болгох боломжтой гэгдэж буй. Дундын зуучлагчийг халж, төвлөрсөн бус нээлттэй орчинд мэдээллийн дамжуулалт, хяналт, баталгаажуулалт, хадгалалтыг хийдэг энэхүү технологи гүйлгээ, шилжүүлэг явуулах үйл явц, бүртгэл хадгалалт, тэдгээрт тавих хяналт зэргийг үндсээр нь өөрчлөх онцлогтой ажээ. Эдгээр технологи нэвтэрснээр Биткойны хувьд хамгийн амжилттай яваа криптовалютуудын нэг юм. Энэ төрлийн криптовалютыг тодорхой нэг этгээд эсвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс удирдах боломжгүй бөгөөд блокчэйн технологи дээр тулгуурлан зөвхөн интернет сүлжээгээр дамжуулан койн эзэмшигчийн зүгээс удирдах боломжтой байдаг¹⁴⁶. Тухайлбал койныг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэх процессыг блокчэйн технологи бүртгэж байдаг бөгөөд аливаа гуравдагч этгээд (жишээлбэл банк) буюу төрийн эрх бүхий байгууллагын оролцоо, зөвшөөрөл шаардлагагүй байдгаараа онцлогтой.

Монгол Улсаас Google-ийг ашиглаж хийсэн “bitcoin” гэсэн хайлтын давтамж 2017 оны дунд үеэс эхлэн огцом нэмэгдсэн бөгөөд 2017 оны арван нэгдүгээр сард хайлтын тоо нь “ханш”-ын талаар хийсэн хайлтаас давсан байна. Энэ нь Монгол Улсын иргэд биткойний талаар ам. долларын ханшнаас ч илүү сонирхож байгааг илтгэх бөгөөд дэлхийд дахинд ч мөн адил 2017 оны тавдугаар сараас эхлэн буюу биткойний ханш огцом өсөж эхэлснээс сар орчмын дараа google хайлт огцом нэмэгджээ. Монгол Улсад биткойний талаарх хайлтын дүн нь нэмэгдэж байгаа хэдий ч түүний суурь технологи блокчэйнний талаарх хайлтын дүн төдийлөн их биш (8 дахин бага), бусад криптовалютын талаарх хайлт ч мөн адил их биш байгаа нь биткойний талаарх энэхүү сонирхол нь үнийн өсөлтөөс шалтгаалсан үзэгдэл болохыг харуулж байна¹⁴⁷.

Trade.mn нь Монгол Улсад криптовалютын цахим биржийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсаас криптовалютын арилжаа хийх сонирхолтой иргэдэд данс нээж, арилжааны захиалгыг олон улсын криптовалютын биржүүдтэй холбож өгдөг байна. Одоогоор 2000 орчим иргэн данс нээлгэсэн байгаа бөгөөд 100 орчим нь идэвхтэй арилжаа хийдэг юм байна. Идэвхтэй арилжаа хийж буй иргэдийн өдрийн нийт гүйлгээ 10-20 мянган ам.доллар орчим байдаг. Иргэдэд данс нээхдээ арилжааны банкны данстай давхар холбогддог. Trade.mn-ий удирдлага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх хүрээнд өндөр дүнтэй гүйлгээний мэдээллийг Монголбанктай хуваалцах боломжтой гэж үзсэн байна.

¹⁴⁶М.Түвшинжаргал, “Виртуал хөрөнгийг эрх зүйн үүднээс тодорхойлох нь” судалгаа, <https://legaldata.mn/b/1032>, 2022 оны 08 дугаар сард хандав.

¹⁴⁷ Мөнгө-Санхүү-Баялаг (Эдийн засгийн анхдугаар чуулган) Уб., 2018. 83 дах тал

Цахим орчинд арилжаалагдаж буй койнууд нь бидний өдөр тутмын амьдралд хэрэглэдэг мөнгөн дэвсгэртийг бодвол арилжаалахад харьцангуй амар хялбар боловч блокчэйн дээрх арилжааны мэдээллийг олж авах боломжгүй байдаг. Мөн виртуал орчинд явагдаж байдаг учир хариуцах субъектийг тодорхойлоход хүндрэлтэй тул хууль сахиулах байгууллагаас хяналт тавих боломж тун хязгаарлагдмал юм. Энэ байдал нь залилах, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх таатай орчин нөхцөл болдог.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд цахим орчинд тэр дундаа мөнгөөр гүйлгээ хийгддэг платформуудыг гэмт хэрэг үйлдэх арга хэрэгслээ болгон ашиглах явдал ихээхэн газар авч байна. PWC2-ийн 2020 оны Олон улсын эдийн засгийн гэмт хэрэг, залилах гэмт хэргийн судалгаагаар 5000 оролцогч хамрагдан, харилцагчийн залилах, кибер гэмт хэрэг, хөрөнгө завших зэрэг залилах гэмт хэргийн улмаас нийтдээ 42 тэрбум ам.доллар алдсан нь тогтоогдсон. Энэ дунд хамгийн эрсдэлтэй, их хэмжээний мөнгө алдаж болохуйц цахим хэрэгслүүдийн нэгээр яах аргагүй криптовалютын арилжаа тооцогдож байна. Учир нь цахим мөнгөн дэвсгэрт гэгдэх койнууд нь ямар нэг бүтээгдэхүүн, үнэт зүйлээр баталгааждаггүй виртуал үзүүлэлт гэж хэлж болох бөгөөд үнэ цэнэ нь койныг авах иргэн, хуулийн этгээдийн эрэлтээр тодорхойлогдож өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл хэн ч тухайн койныг аваагүй үед үнэ цэнэ нь 0 төгрөг гэсэн үг юм. Энэ нь койн худалдаж авсан иргэн, хуулийн этгээд их хэмжээгээр мөнгөө алдах эрсдэл өндөр байхын зэрэгцээ аливаа санхүүгийн гэмт хэргийн хохирогч болох магадлал өндөр байгаа юм.

Криптовалюттай холбоотой үйлдсэн залилах гэмт хэргүүдээс хамгийн анхаарал татахуйц их мөнгө залилсан явдал нь Onecoin-ийн кейс бөгөөд энэ нь бүх цаг үеийн хамгийн том крипто луйвар гэж тооцогддог. Одоогийн байдлаар аварга том Понзи схем гэгддэг Onecoin-ийн луйврыг 25 тэрбум ам.доллар залилсан гэж үздэг¹⁴⁸. Тус хэргийг 2017 онд хааж удирдагч нь 90 жилийн ял сонссон боловч энэ залилах гэмт хэрэг одоо хүртэл үргэлжилсээр байгаа юм.

Onecoin хэзээ ч криптовалют болоогүй бөгөөд энэ технологи нь анхнаасаа хуурамч байсан байна. Үүний дараагаар Bitconnect¹⁴⁹, Pincoin¹⁵⁰ зэрэг луйврууд орж, эдгээрийн учруулсан хохирлын хэмжээ мөн хэдэн тэрбум ам.доллараар хэмжигддэг. Дэлхийн зарим улсууд криптовалютыг хууль ёсны гэж үзэж гэмт хэрэг, татвартай холбогдох зохицуулалтуудыг хийсэн байдаг бол зарим улсад хуулиар зөвшөөрдөггүй. Тухайлбал, Франц, ОХУ, Сингапур зэрэг улсад криптовалютыг хүлээн зөвшөөрч холбогдох зохицуулалтуудыг хуульчилсан бол Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Өмнөд Солонгос Улсууд хэтэрхий өндөр эрсдэлтэйгээс гадна аливаа санхүүгийн гэмт хэрэг үйлдэгдэх таатай орчин нөхцөл болж байна гэж үзсэн тул энэ төрлийн үйл ажиллагааг хориглосон байдаг.

Виртуал хөрөнгө буюу криптовалюттай холбоотой асуудал нь Монгол улсын хувьд шинэлэг салбар юм.

Гэвч цахим орчинд залилуулсан гэмт хэрэг¹⁵¹ 2015 онд 17, 2016 онд 69, 2017 онд 136, 2018 онд 590, 2019 онд 641 2020 онд 1828, 2021 онд 6558, гэмт хэрэг болж тус тус өссөн бөгөөд 2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийг 2019 онтой харьцуулахад 53.6 дахин 8 буюу жилээс жилд өссөн статистик тоон мэдээлэл гарч байгаа тул криптовалюттай холбоотой гэмт хэргүүд ойрын хугацаанд ихээхэн тоо хэмжээтэй үйлдэгдэхийг

¹⁴⁸ <https://en.wikipedia.org/> 2022 оны 08 дугаар сард хандав.

¹⁴⁹ <https://en.wikipedia.org/wiki/Bitconnect> 2022 оны 08 дугаар сард хандав.

¹⁵⁰ <https://www.coindesk.com/tag/pincoin/> 2022 оны 08 дугаар сард хандав.

¹⁵¹ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, “Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа”, 2021 он.

үгүйсгэхгүй. Түүнчлэн сүүлийн саруудад Ард койн, IN койнууд олны анхаарлыг ихээхэн татаж байгаатай холбоотой хүмүүсийн хандалт өндөр байгааг ашиглан хуурамч төсөл, койнууд гаргах замаар их хэмжээний мөнгө залилах гэмт хэрэг гарах эрсдэл өндөр байна. Учир нь ямар ч этгээд койн зохиох боломжтой бөгөөд интернетэд холбогдсон байхад л хангалттай юм. Түүнээс гадна зөвхөн хуурамч төсөл, койнуудаар залилах гэмт хэрэг үйлдэгдэх албагүй юм.

Бодит хэрэгжиж буй койнууд дээр ч залилах гэмт хэрэг үйлдэгдэж болох юм. Тодруулбал, койн худалдан авагчийн мэдлэг, мэдээлэлгүйг далимдуулах зохиомол байдал бий болгох буюу койны үнийг зориудаар өсгөх, бууруулах замаар залилах гэмт хэрэг үйлдэх боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, койн бол ямар ч бүтээгдэхүүн, үнэт зүйлээр баталгааждаггүй хоосон виртуал үзүүлэлт гэж өмнөх хэсэгт дурдсан. Энэ нь зөвхөн хэдэн хүн, хуулийн этгээдийн арилжаан дээр үнэ нь хэлбэлзэж байдаг зүйл юм. Жишээлбэл, иргэн А нь иргэн Б-ээс 0 төгрөгийн үнэтэй койныг 100 төгрөгөөр авах захиалга өгч энэ нь баталгаажвал тухайн койны үнэ сүүлд хийгдсэн арилжааны үнийн дүнгээр буюу 100 төгрөгөөр тодорхойлогдох юм. Өөрөөр хэлбэл нийт гаргасан койны ихэнх нь тухайн койныг гаргасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэлд байхад тухайн этгээдүүд койны үнийг тогтоох боломжтой болно. Хэрэв койны ихэнхийг эзэмшиж буй хүн, хуулийн этгээд койны үнийг зохиомлоор өсгөвөл мэдээлэлгүй иргэд үүнийг ашигтай койн гэж үзэн их хэмжээгээр худалдан авах магадлалтай. Энэ үед койны үнийг буцааж, унагах замаар койн худалдаж авсан хүн, хуулийн этгээд их хэмжээний алдагдалд оруулах боломжтой юм.

Монгол улсын хувьд хамгийн амжилттай яваа зарим нэг гаргасан койны 90 орчим хувийг долоохон хүн эзэмшдэг¹⁵² гэсэн мэдээлэл байна. Энэ нь хэрэв тухайн 7 этгээд нэгдмэл сонирхолтой этгээдүүд бол койны үнийг зохиомлоор өсгөж, бууруулах боломжтой юм.

Монголын криптовалютын зах зээлийн хувьд биткойны ханшийн өндөр өсөлтийн эхний үе болох (5000\$-19800\$ хүрч) 2017 оны сүүлээс эрчимтэй хөгжиж эхэлсэн байдаг. Энэ үеэс дотоод иргэд, аж ахуйн нэгжүүд хувьд криптовалютыг хөрөнгө оруулалтын хэрэгслээр сонирхож эхэлсэн бөгөөд сошиал сувгаар дамжуулан зохицуулалтгүйгээр өөр хоорондоо арилжаалах болон гадаадын биржүүдэд бүртгүүлэх, арилжаанд оролцох сонирхол маш их нэмэгдсэн байна.

Мөн сошиал зар, сурталчилгаанд үндэслэн иргэд хоорондын арилжаа ихэссэнээр нэг нэгнийгээ хууран мэхлэх, залилах асуудал эрс нэмэгдэж байсан бөгөөд нөгөө талаар гаднын хуурамч вэбсайт, биржээр үйлчлүүлэх зэрэг маш их асуудлуудтай учирч байсан байна.

Монгол Улсын иргэн, хуулийн этгээд төрөл бүрийн криптовалютын арилжаанд оролцож байгаатай холбогдуулан арилжааны банк болон санхүүгийн байгууллагуудаас энэ талаар хэрхэн ажиллах зөвлөмж, чиглэл хүссэн хүсэлтүүд ирүүлж байжээ. Криптовалютын эрх зүйн болон зохицуулалтын орчин Монгол Улсад бүрдээгүй байгааг санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийнхээ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо албан ёсоор мэдэгдэж байсан байна¹⁵³.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн хөгжил, тогтвортой байдлыг хангах чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэт цаасны, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн

¹⁵² <https://www.coingecko.com/en/coins/> 2022 оны 08 дугаар сард хандав.

¹⁵³ <http://www.frc.mn/> Санхүүгийн зохицуулах хорооны мэдэгдэл. 2017 оны 10 дугаар сар

хоршооны үйл ажиллагаа, санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэн баталгаажуулж, бодлогоор зохицуулдаг.

Олон улсын зах зээл дээр сүүлийн үед олноор бий болж байгаа БитКойн /Bitcoin/, Итериум /Ethereum/ зэрэг криптовалютуудаар төлбөр, тооцоо гүйцэтгэх, арилжаа хийх нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулиар зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа юм. Япон улсаас гаралтай БитКойн цахим орчинд гарч ирснээс хойш олон зуун криптовалют бий болоод байгаа ч дэлхийн улс орнууд бодлого, зохицуулалтын нэгдсэн шийдэлд хараахан хүрээгүй байгаа юм. Үүний хажуугаар криптовалют нэрээр олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж, ашиг хонжоо олох үйл ажиллагаа хийгдэж байгааг анхааруулж, ийм зүйлд хууртахуаас сэрэмжлэхийг зөвлөж байна. Тухайлбал, Уанкойн /Onecoin/ үүний нэг жишээ юм. Тайланд, Герман, Унгар, Мальт, Хятад, Бельги, Энэтхэг зэрэг орнуудад Уанкойнтой холбоотой үйл ажиллагааг сэрэмжлүүлэх, хориглох, таслан зогсоохоо мэдэгдэж байжээ.

Эдгээрийн зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэл, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг интернэт, нийгмийн сүлжээ ашиглан хууль бусаар хийх явдал цөөнгүй гарч байна. Төрийн зохицуулалтад хамаараагүй, хамаарахаас зайлсхийсэн хуулийн этгээдээс гаргаж байгаа болон зуучилж байгаа бонд, даатгагдсан бонд, хувьцаа, олон нийтийн зээл, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт зэрэг зөвшөөрөлгүй хэрэгсэлд хөрөнгө оруулж, хохирол амсахаас сэргийлэхийг нийт ард иргэддээ анхааруулж байжээ. Хэрэв та өөрийн итгэл үнэмшлээр төрийн зохицуулалтгүй, зөвшөөрөгдөөгүй санхүүгийн аливаа үйл ажиллагаанд хөрөнгө, мөнгөө оруулбал энэ нь Иргэний хуулиар зохицуулагдах харилцаа тул ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг өөрөө бүрэн хариуцахыг Санхүүгийн зохицуулах хороо албан ёсоор мэдэгдсэн байна.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар гарч буй койнуудын хувьд дээрх тохиолдолтой ижил төстэй зүйл ажиглагдаагүй боловч ийм төрлийн койнуудад залилах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.

Иймд криптовалют (койн)-ын үнэ хэн нэг этгээд эсхүл ямар нэг хүчин зүйлийн нөлөөгөөр үргэлж өөрчлөгдөж хэлбэлзэж байдаг тул эрсдэл өндрөөс гадна хоосон чанартай учир залилах гэмт хэргийн хохирогч болж болзошгүй байна. Мөн ийм шинж чанартай байдаг учраас өнөөдөр арилжаалагдаж буй койнууд төлбөрийн хэрэгсэл болон гүйлгээнд ашиглагдах боломжгүй байдаг.

Иргэн, хуулийн этгээдийн хувьд бага хугацаанд их ашиг олох зорилгоор буюу хөрөнгө оруулалтын хэрэгсэл талаас нь хандаж криптовалютын арилжаа хийх нь элбэг ажиглагддаг. Ийнхүү хөрөнгө оруулахдаа хямдхан койн учир өсөх магадлалтай, маркетинг сайтай байгаа учир найдвартай гэсэн бодлоор их хэмжээгээр нь авах хандлагатай байгаа бөгөөд энэ нь эрсдэл ихтэй юм. Учир нь хэрэв койныг анхны арилжааных нь үед авахад өсөх бололцоогүй эсхүл бүр хуурамч төсөл байсны улмаас залилах гэмт хэргийн хохирогч болох мөн хоёрдогч зах зээлийн үед үнэлгээ нь хөөсөрсөн койн авч бодит үнэлгээ дээрээ очиход хөрөнгө мөнгөөрөө хохирох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй байдаг. Гэхдээ судалгаа сайн хийж мэдлэг, мэдээлэлтэйгээр арилжаанд оролцоход зарим тохиолдолд ашиг хийх боломжтой гэдгийг үгүйсгэх аргагүй юм.

Ингэхийн тулд аливаа койны үнэ хямд эсхүл үнэтэй байхад ач холбогдол өгөлгүй койн гаргасан хүн, хуулийн этгээдүүдийн мэдээлэл нээлттэй эсэх мөн тухайн гаргасан нийт койны зах зээлийн үнэлгээ хэд вэ зэрэгт анхаарлаа хандуулж хөрөнгө оруулалт хийх нь чухал.

Койныг гаргасан хүн, хуулийн этгээдүүд болон койны зах зээлийн нийт үнэлгээний талаар coinmarketcap.com эсхүл coingecko.com гэсэн сайтуудаар орж мэдээлэл авах боломжтой бөгөөд эдгээр нь олон улсад арилжаалагддаг койнуудын мэдээллийг агуулсан мэргэжлийн сайт юм. Ийнхүү дээрх нөхцөл байдлуудыг ухамсарлах үүднээс тодорхой мэдлэг, мэдээлэлтэйгээр криптовалютын арилжаанд оролцох нь санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болно. Монгол улсад цахим валюттай холбоотойгоор санхүү, мөнгөн хөрөнгөөр хохирох асуудал хууль сахиулах байгууллагад ихээхэн бүртгэгдэх болсон, энэ нь хийсвэр цахим хэлбэрээр гэнэн итгэмтгий буюу залуу үеийн ихээхэн хамарч байна. Энэ нь хууль эрх зүйн орчин болоод цахим валютын талаарх ханшийн хэлбэлзэл зэргийн талаар мэдлэг дутмаг, зайлшгүй мэддэг байх эрхийг хөндөх юм.

Цахим валютаас шалтгаалж хохирох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бодит эрсдэл учирсан тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хяналт тавих хууль эрх зүйн зохицуулалтыг хүрээнд эрхээ хэрхэн хамгаалах, улмаар нийгэм эдийн засагт нөлөөлөх эерэг сөрөг үр дагаврын талаарх ойлголтыг агуулсан болно.

Блокчэйн гэж криптовалютын ард байгаа технологи уламжлалт гүйлгээнээс ялгаатайгаар, cryptocurrencies валютын гүйлгээ нь банк эсхүл бусад санхүүгийн байгууллагуудаас зохицуулагддаггүй. Хэн нэгэн зоосоор дамжуулан төлбөр хийх бүрд тухайн төлбөр нь блокчэйн гэж нэрлэгддэг цахим дансны дэвтэрт бүртгэгддэг байна.

2018 оноос хойших криптовалютын хурдацтай өсөлтийн дүнд дэлхий даяар криптовалют маш ихээр гарах болсон. Манай улсад ч мөн ялгаагүй цахим мөнгөний зах зээл хүрээгээ тэлж ард иргэд криптовалютыг сонирхох, худалдан авах, худалдах нь нэмэгдэж блокчэйн суурьтай криптовалютын мэдлэгийг олон нийтэд түгээх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Дэлхий даяар криптовалютын хэрэглээ нэмэгдсэнээр олон тооны улсууд тэдгээрт тохирох эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг 2014 оноос хойш хэрэгжүүлж эхэлсэн байна. Гэхдээ улс орнууд криптовалютын талаар өөр хоорондоо ялгаатай буюу зарим тохиолдолд эрс тэс ялгаатай байдлаар зохицуулалт хийж байгааг онцлох нь зүйтэй юм. Тодруулбал, БНХАУ, Пакистан гэх мэт улсуудад криптовалюттай холбогдох бүх асуудлыг буюу арилжаалах, олборлох, төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглах зэргийг хориглосон байхад Япон улсад криптовалютыг төлбөр тооцооны хэрэгслээр хүлээн зөвшөөрөөд зогсохгүй криптовалюттай холбоотой бизнес эрхлэгчдийн холбоо байгуулагдаж, тухайн төрлийн бизнесийн үйл ажиллагаанд тавигдах норм, стандартуудыг боловсруулж, мөрдүүлж байна. Ерөнхийдөө криптовалютыг хамгийн өргөн хүрээнд зохицуулсан улсуудад Япон, Канад, Европын Холбооны гишүүн улсууд, АНУ, БНХАУ, Аргентин, Австрали, Өмнөд Африк хамаарна. Тэгвэл дараах хэсгүүдэд криптовалютын эрх зүйн статус, түүнтэй холбогдох эрх зүйн зохицуулалт хийх боломжтой асуудлыг харьцуулан судалж, Монгол улс дахь криптовалютын өнөөгийн байдлын талаар дэлгэрүүлэн авч үзье. Криптовалютын гол мөн чанар нь төрийн байгууллага эсвэл төв банкнаас хараат бус буюу нэгдсэн байдлаар зохицуулагддаггүй, төв банкны баталгааг агуулдаггүй байх явдал юм. Иймд одоогоор криптовалютыг хууль ёсны фиатвалют гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдол алга байна. Энэ нь түүний гол мөн чанар болох төрийн байгууллага эсвэл төв банкнаас хараат бус буюу нэгдсэн байдлаар зохицуулагдаагүй, төв банкны баталгааг агуулаагүй зэрэг шинжүүдтэй холбоотой. Иймд, зарим улсууд криптовалютыг ихэвчлэн үнэ цэнэ бүхий “бараа” гэж үзэх хандлагатай байдаг.

Монгол Улсын криптовалютын зах зээл биткойны ханшийн өсөлтийн эхний үе болох 2017 оны сүүлээс эрчимтэй хөгжиж эхэлсэн ба криптовалютын зах зээлийн

арилжаанд оролцдог, дотоодын биржүүдэд албан ёсны бүртгэлтэй нийт 150 гаруй мянган иргэд, аж ахуйн нэгж байдаг гэсэн тоог Монгол банкны 2021 оны “Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа”-нд дурдсан байна. Үүнээс үзэхэд Монгол улсын нийт хүн амын ойролцоогоор 4 хувь нь л криптовалютын арилжаанд оролцдог байна. Харин нийт хүн амын дунд криптовалютын талаар мэдлэг мэдээлэл ямар түвшинд байгаа, мөн тодорхой мэдээлэлгүйгээс шалтгаалж хууран мэхлэлт, залиланд өртөж буй эсэх талаар тодорхой судалгаа хийгдээгүй нь энэ асуудлыг судлах, энэ төрлийн аргаар үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, прокурорын хяналт тавих хэрэгцээ шаардлага бий болсоныг харуулж байна.

Судалгааны “ММСГ” агентлаг Монгол улсын залуучуудын криптовалютын талаарх ойлголт, хандлагыг тодруулах зорилгоор 18-34 насны нийт 235 иргэнийг судалгаанд хамруулсан байна. Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалж судалгааны тоон мэдээллийг онлайн орчинд буюу Google Forms софтверийн тусламжтайгаар цуглуулсан бол судалгааны мэдээллийг SPSS23 программ ашиглан боловсруулжээ. Судалгаанд 18-34 насны нийт 235 иргэн оролцсоноос 188(80%) нь буюу дийлэнх нь 18-24 нас, харин үлдсэн 47(20%) нь бол 25-34 насны залуус байна.

Оролцогчдоос криптовалютын талаар сонсож байсан эсэхийг тодруулахад нийт оролцогчдын 164 (65.3%) нь сонсож байсан, харин үлдсэн 86 (34.7%) нь сонсож байгаагүй хэмээн хариулсан.

Энэхүү судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 55 хувь нь хадгаламжид хөрөнгө оруулалт хийсэн гэжээ. Мөн 19 хувь нь үл хөдлөх хөрөнгө, 17 хувь нь хувьцаа, 17 хувь нь газар, 5 хувь нь үнэт цаас бонд гэж хариулсан бол дэлхий нийтийн анхаарлыг татаад байгаа криптовалют, койнд хөрөнгө оруулсан хэсэг нь багагүй хувийг эзэлж байна.

Гэхдээ судалгаанд оролцсон иргэдийн 35 хувь нь энэ тухай хангалттай ойлголттой гэсэн бол 65 хувь нь хөрөнгө оруулалтын өгөөж өндөр гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, хадгаламж, хувьцаа, бонд, үнэт цаастай харьцуулахад криптовалют, койн нь өгөөжтэй гэж үзсэн учраас хөрөнгө оруулалт хийх нь түүнийг дагаад нэмэгдэж байгааг үгүйсгэх аргагүй.

“Хадгаламжийн хүү буурч, инфляцын түвшин өссөн учраас иргэд мөнгөө зөвхөн банканд хадгалаад байлгүй, үр өгөөжтэй, эрсдэлээ даах байдлаар хөрөнгөө хэрхэн өсгөх вэ гэдэг асуулттай тулгарч байна” гэсэн утгатай хариулт олон хүн өгчээ. Тиймээс 58 хувь нь криптовалют, койн худалдаж авах талаар сонирхож байна. Гэхдээ нөгөө талаас “Та бүхэн мөнгөө алдвал хариуцлагаа өөрсдөө үүрээрэй, төр хариуцахгүй шүү” гэх тайлбар, мэдэгдлээс болж 14 хувь нь луйвар гэдэгтэй санал нийлжээ. Харин бусад нь эргэлзээтэй байгаа гэсэн байна. Тэдэнд мэдээлэл дутуу, хууль эрх зүйн орчин яаж эргэхийг хүлээж байна гэсэн үг.

Судалгаагаар дотоодын зах зээлд хамгийн их танигдсан нь Ард Койн. Нийт оролцогчдын 83 хувь нь ямар нэгэн байдлаар АрдКойны талаар мэдээлэл авч, 37 хувь нь худалдаж авахаар судалж үзсэн гэжээ. Криптовалют, койн эзэмшигч, арилжаалагчдыг дийлэнх хувь нь 23-30 насныхан байгаа нь анхаарал татсан нэг үзүүлэлт. 40-өөс дээш насныхан бол энэ зах зээлд яаран орохгүй байгаа аж.

Монгол Улсад хамгийн их эзэмшигчтэй Ард болон ИНС койнд хөрөнгө оруулсан шалтгааны тухайд “төслийн багт итгэдэг” гэсэн хариулт олноор өгсөн байна. Тиймээс худалдаж авахдаа юун түрүүнд гаргаж буй байгууллагын нэр хүнд, нэгжийн үнэ, ирээдүйн зорилго, санхүүгийн чадамж, арилжаалагдах биржийг чухалчилдаг байна. Гаргасан байгууллага, гол төлөөлж буй хүн нь криптовалют, койны үнэ цэнийг

нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй гэж арилжаанд оролцогчдын 68 хувь нь үзэж, 52 хувь нь худалдаж авчээ.

Тэдний 42 хувь нь өөрсдийгөө анхлан суралцагч гэсэн бол 7 хувь нь мэргэжлийн түвшний мэдлэгтэй гэсэн байна. Мөн 55 хувь нь 1 саяас дээш төгрөгийн хөрөнгө оруулсан бөгөөд 23-30 насныхан хамгийн хөрөнгө оруулалт хийсэн байгаа юм.

Арилжаалагчдын 49 хувь нь өөрийн цалингаас бага багаар хөрөнгө оруулсан гэж хариулсан бол 41 хувь нь хадгаламжаасаа, 6 хувь нь гэр бүл найз нөхдөөсөө зээлж, 2 хувь нь өөрийн өмч хөрөнгөө зарж, 4 хувь нь бусад байдлаар гэсэн хариулт өгсөн байна. Сонирхолтой нь 54 хувь нь ашигтай оролцсон бол 5 хувь нь бага зэрэг алдагдалтай гэсэн хариулт өгчээ.

Харин криптовалют, койны талаарх мэдээллийг 66 хувь нь Фейсбүүкээс, 31 хувь нь найз нөхдөөс, 17 хувь нь дотоодын вэб сайтаас, 17 хувь нь инстаграммаас авсан байна.

Монгол Улсад криптовалютыг сонирхох явдал ихсэж байгаатай уялдуулан криптовалютын эрх зүйн статусыг тодорхой болгож энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Ашигласан материал:

1. Distributed Ledger. Available: <https://www.investopedia.com>.
2. <https://forexdigital.net/mn/>
3. <https://legalinfo.mn/mn/detail/15115>
4. М.Түвшинжаргал, “Виртуал хөрөнгийг эрх зүйн үүднээс тодорхойлох нь” судалгаа, <https://legaldata.mn/b/1032>
5. Мөнгө-Санхүү-Баялаг (Эдийн засгийн анхдугаар чуулган) УБ., 2018.
6. <https://en.wikipedia.org/>
7. <https://en.wikipedia.org/wiki/Bitconnect>
8. <https://www.coindesk.com/tag/pincoin/>
9. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, “Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа”, 2021 он.
10. <https://www.coingecko.com/en/coins/>
11. <http://www.frc.mn/> Санхүүгийн зохицуулах хорооны мэдэгдэл.
12. <https://academy.ard.mn/blog/digital-assets>
13. <https://academy.ard.mn/blog/what-is-blockchain>
14. https://lemonpress.mn/news/crypto_zohitsuulalt/

--o0o--

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ

PROBLEMS OF MONEY LAUNDERING CRIME

Б.Батцэрэн

Цагдаагийн сургуулийн эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч

Battseren.B

*Police School Criminal Justice, Associate
Professor of Criminology Department,
police major*

Товч агуулга: 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан “гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамааруулж заасан байсныг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Эдийн засгийн гэмт хэргийн бүлгийн 18.6 дугаар зүйлд “мөнгө угаах” гэмт хэрэгт хамаарах үйлдлүүд гэж үзсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцид заасан агуулгаар гэмт хэргийн шинжийг тодорхойлсон нь тухайн гэмт хэргийн ойголт, зүйлчлэлийн талаар нэг мөр ойлгох хэрэгцээ шаадлага гарсан.

Abstract: Article 155 of the Criminal Code of 2002 states that the crime of "acquiring and selling property obtained by committing a crime" is a crime against the right to property, and in the updated version of the Criminal Code, Article 18.6 of the Economic Crimes Group includes actions related to the crime of "money laundering" seen.

The United Nations General Assembly adopted on November 15, 2000, the Convention against Transnational Organized Crime and the United Nations Convention against Corruption, defined the nature of the crime, and the need to understand the definition and categorization of that crime was necessary.

Түлхүүр үг: Мөнгө угаах, конвенци, бүрэлдэхүүн, FATF, гэмт хэрэг

Key word: Money laundering, conventions, lineups, FATF, crime

Нэг. Мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүн

Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох нь чухал. Мөнгө угаах гэмт хэргийн объектив тал нь дараах идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байжтүүнийг а/авсан, б/ээмшсэн, в/ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор г/өөрчилсөн, д/шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг е/нуусан, ё/далдалсан идэвхтэй үйлдэл байна. Энэ гэмт хэрэг нь эдгээр идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй хийгдсэнээр төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм.

Мөнгө угаах гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай үйлдэл байна. Энэ гэмт хэрэг нь шунахай сэдэлтэй, хуульд заасан зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг, түүнээс үүсэх хор уршигт хандах хүсэл зоригийн шинж нь гэмт хэрэг, түүнээс учрах хохирлыг ухамсарлаж, урьдаар мэдсэн мөртлөө хүсэж, үйлдлээрээ бий болгосон байдаг.

Энэ гэмт хэргийн зорилго нь богино хугацаанд их хэмжээний ашиг олоход бус, харин гэмт хэрэг үйлдэж олсон орлогын эх үүсвэрийг нуун далдлах, өөрчлөн хувиргах, ул мөр үлдээхгүй байхад чиглэгддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах тусгай зорилготой байна. Хэрэв энэ зорилго тогтоогдохгүй байвал гэмт хэргийн субъектив тал үгүйсгэгдэнэ¹⁵⁴.

Дэлхий нийтийн хэмжээнд зохион байгуулалттай гэмт хэргүүд улам нарийсч олноор үйлдэгдэн гарч, цаашид өсөн нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд үүний дотор мөнгө угаах гэмт хэрэг тодорхой байр суурийг эзэлж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь Олон улсын эрүүгийн эрх зүйд харьцангуй шинэ төрлийн гэмт хэрэгт тооцогддог хэдий ч энэ гэмт хэрэг нь улс, үндэстэн дамнасан шинжтэй, нууц хэлбэрээр үйлдэгддэг, тухайн улсын эдийн засаг, банк санхүүгийн системд ноцтой хохирол учруулдаг нь мөнгө угаах гэмт хэргийн онцлог нь болдог. Мөнгө угаах гэмт хэргийн нийгмийн хор аюул нь өөрийн нутагт дэвсгэрт мөнгө угаах боломж олгож өгсөн улс орон юуны өмнө хууль бус ажиллагааныхаа ул мөрийг нуун далдлах бололцоог гэмт этгээдүүдэд олгож, ингэснээр улс орны санхүүгийн системийн тогтвортой нэгдмэл байдал алдагдан, улс орны дотоодод болоод ялангуяа байгууллага, иргэдийн эрх ашигт халдаад зогсохгүй эдийн засгийн хямралд хүргэдэг нийгэмд аюултай үйлдэл юм.

Түүнчлэн энэ хэргийн улмаас олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээ авдаг нь эдийн засгийн системд их хэмжээний хохирол учруулах сөрөг нөлөөтэй.

Мөнгө угаах гэмт хэрэг нь зөвхөн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй түүгээр дамжин тухайн улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулдаг.

Мөнгө угаах гэмт хэргийн зорилго нь:

1. Хууль бус орлогоо нуун дарагдуулах. Гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон орлого, эд хөрөнгөө төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд албадан хураалгахаас зайлсхийх, бултуулах зорилгоор мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх.
2. Эрүүгийн хариуцлагаас зайлсхийх: Гэмт хэрэгтнүүд хууль бус орлогыг өөрсдөөсөө холдуулах замаар эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхыг хичээдэг.
3. Татвараас зайлсхийх. Хууль бус орлогод ногдох татвараас зайлсхийх зорилгоор мөнгө угаах гэмт хэргийг үйлдэнэ.
4. Ашиг орлогоо нэмэгдүүлэх. Хууль бусаар олсон орлогыг нуун дарагдуулаад улмаар дахин шинэ бизнесийн үйл ажиллагаанд “хөрөнгө оруулалт”-ыг хийснээр тэдгээрт орлогын шинэ боломж, эх үүсвэр нээгдэнэ.
5. Орлогоо хууль ёсны болгох. Хүн худалдаалах, мансууруулах бодисын наймаа, авлига, санхүүгийн залилан зэрэг төрөл бүрийн гэмт хэргийн дүнд олсон орлогоо хууль ёсны болгох, гэмт хэрэгтнүүд нь нэгэнт угаасан мөнгөн хөрөнгөөр шинэ үйл ажиллагааг санхүүжүүлж, улмаар эрхлэн явуулж байгаа

¹⁵⁴ Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий ба тусгай анги. УБ., 2012, 414 дэх тал.

тэрхүү шинэ бизнес нь хууль ёсны болсноор олон давуу талыг бий болгодог байна.

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон хөрөнгө, орлогынхоо эх үүсвэрийг нуун далдалж, уг мөнгө болон эд зүйлсийг хууль ёсны мэтээр халхавчлан хэлбэр дүрсийг нь хувиргаж, эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах, өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтнүүдийн зорилго нь гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө чөлөөтэй ашиглах, захиран зарцуулах явдал бөгөөд үүний тулд уг орлогоо “хууль ёс”-ны дагуу олсон мэт болгож мөнгөө “цэвэрлэж угаах”, хууль бус орлогоо хууль ёсны салбараар дамжуулж, гарал үүслийг нь нуун дарагдуулах, эцэст нь ашиг хонжоо олох үйлдлийг олон улсад “мөнгө угаах” гэж нэрлэдэг. Үүнээс үзвэл мөнгө угаах гэмт хэрэг нь биет” хохирогчгүй /victimless/, хор хохирол /harm/ нь шууд бус /indirect/, хохирлын хэмжээ /unknown size/ нь бодитоор тодорхойлогддоггүй зэрэг шинжийг агуулна.

Мөнгө угаах гэдэгт гэмт хэрэгтнүүд хууль бус (албан тушаал, авлигын гэмт хэрэг үйлдэж) аргаар олсон мөнгийг зах зээлд нууцаар оруулж эргэлдүүлэн өсгөн үржүүлж хууль ёсны мэт ил болгохыг хэлдэг. Ялангуяа олон улс, үндэстэн дамнасан гэмт хэрэгтнүүд хууль бус аргаар олсон асар их хэмжээний мөнгөө эрх зүйн зохицуулалт болон санхүүгийн сахилга хяналтын тогтолцоо сул, хууль, хяналтын байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу, ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадвар дорой, авлигад идэгдсэн орнуудын зах зээлд нууцаар нэвтрүүлэн хамгийн ашигтай бизнест эргэлдүүлэн өсгөн үржүүлж хууль ёсны болгодог.

Түүнчлэн гэмт хэргийн замаар олсон мөнгөө гадаадын оффшор (offshore гэдэг нь англиар “эргийн гадна”, “хилийн гадна” гэсэн утгыг илэрхийлдэг) бүсэд байрладаг банкны дансанд хадгалуулаад уг мөнгөнөөсөө банкаар дамжуулан шууд төлбөр хийлгэж эд хөрөнгө худалдан авч ил болгох нь ч бий.

Мөнгө угаах гэмт хэрэг нь санхүү, эдийн засгийн тогтолцооны хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдалд заналхийлэл учруулдаг олон улсын шинжтэй, нарийн зохион байгуулалттай үйлдэгддэг эдийн засгийн гэмт хэрэг юм. Олон улсын эрүүгийн эрх зүй дэх мөнгө угаах гэмт хэргийн /AML/ ойлголт нь дараахь байдлаар тодорхойлогдоно.

Үүнд:

1. “Predicate offence” буюу суурь гэмт хэрэг үйлдэгдсэн байх;
2. “Criminal property” буюу гэмт хэргийн хөрөнгө гэдэгт хууль бус үйл ажиллагаанаас бий болсон мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгө, орлого хамаарна;
3. “Knowing” буюу хууль бус орлого гэдгийг мэдсээр байж хийсэн хууль бус үйлдэл байна. Үүнийг олон улсын эрүүгийн эрх зүйд “mental element” гэж нэрлэдэг;
4. “Laundering” буюу гэмт хэргийн хөрөнгийг хууль бус гэдгийг мэдсээр байж авсан, ашигласан, эзэмшсэн, хувиргасан, өөрчилсөн, шилжүүлсэн, нуун дарагдуулсан, худалдсан, худалдан авсан, зөөвөрлөсөн үйлдлийг ойлгоно.

Мөнгө угаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжийг бүрэн дүүрэн тодорхойлоход бохир мөнгө, хар мөнгө гэсэн ойлголтуудыг заавал авч үзэх шаардлагатай.

Дээрх хар болон бохир мөнгийг “цагаан” буюу “цэвэр” болгох ажиллагааг “мөнгө угаах” гэхээс гадна гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлс, ашиг орлогын эх үүсвэрийг нуун далдалж хууль ёсны мэтээр халхавчлан эдийн засгийн эргэлтэд оруулах, хэлбэр дүрсийг хувиргах бүхий л үйлдэл, ажиллагааг мөнгө угаах гэж ойлгож болно.

Гэмт явдал судлалын хүрээнд мөнгө угаах үзэгдлийг “хууль бус эх сурвалж буюу орлогыг нууж, хууль ёсоор олсон мэт болгон хувиргах ажиллагаа” гэж тодорхойлсон байдаг.

Мөнгө угаах үе шат

Мөнгө угаах аргын хэд хэдэн төрөл байдаг байна. Үүнд:

Нэгд: Хоёр шатлал бүхий загвар;

Хоёрт: Гурван шатлал бүхий загвар;

Гуравт: Дөрвөн шатлал бүхий загвар;

Эдгээрээс хамгийн өргөн тархсан арга бол гурван шатлал бүхий загвар юм. Энэ арга нь Нэгд, Placement (байршуулах) буюу бохир бөгөөд бэлэн мөнгийг санхүүгийн өөр хэрэгслээр солих буюу биежүүлэх; хоёрт, Layering (нуун далдлах) буюу мөнгө угаагч болон бохир эх сурвалжийг тусгаарлах; гуравт, Integration буюу зарим тохиолдолд зах зээлд буцаан оруулах гэх нэршил бүхий үе шаттай байдаг ажээ. Тухайлбал:

Байршуулах үе шат - Placement

•Хууль бусаар хар тамхи, мансууруулах бодис, зэвсгийн наймаа, садар самуун, порнограф, хүний наймаа, далд эдийн засгийн орлого, татвараас займчуулсан мөнгө, хөрөнгө, хуурамч мөнгийг жинхэнэ болгож солих зэрэг үйл ажиллагаанаас олсон их ХЭМЖЭЭНИЙ "бохир" бэлэн мөнгийг санхүүгийн төлбөрийн харьцангуй биет, илүү том хэлбэрт шилжүүлэн үнэт цаас, чек, валют, бараагаар солих үйл ажиллагаа явагддаг. Түүнээс гадна угаасан мөнгөний тодорхой хэсгийг парламент, ерөнхийлөгчийн сонгууль, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, захиалгат аллага, олон улсын терроризмыг санхүүжүүлэх, авилга хээл хахууль зэрэгт ашигладаг байна.

Нуун далдлах үе шат - Layering

•Хууль ёсны орлого мэт харагдуулах зорилготойгоор нэгэнт байршуулсан мөнгөө эргэлтэнд оруулдаг. Жишээлбэл, худалдан авсан үнэт цаас, аяллын чекээ эргүүлэн зарах эсвэл гадаад худалдаа эрхэлж буй мэт харагдуулах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх хяналтын механизм бүрдүүлээгүй орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг.

Буцаан төвлөрүүлэх үе шат - Integration

•Нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны юм шиг харагдах болсон мөнгөө эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлдэг ажээ. Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбодог. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор хууль бус үйл ажиллагаанд зарцуулахыг зорьдог.

Эх сурвалж: (Монгол банк, 2020)

Мөнгө угаахад хэрэглэгддэг хэд хэдэн гол арга хэлбэр байдаг. Үүнд:

- Банкны салбарт мөнгө угаах
- Бизнесийн салбарт мөнгө угаах
- Хөрөнгө арилжаагаар дамжуулж мөнгө угаах
- Гадаадын банкаар дамжуулан мөнгө угаах
- Зээлийн хэлбэрээр мөнгө угаах гэх зэрэг

Мөнгө угаах нь гэмт хэрэгтнүүдийн хувьд хууль бус орлогын эх үүсвэрээ аливаа эрсдэлд оруулалгүйгээр түүнээс олсон ашиг, орлогоо чөлөөтэй ашиглахад туслах, санхүүгийн аюулгүй байдлаа хамгаалахад чиглэгдсэн маш чухал үйл явц юм.

Мөнгө угаах хэлбэр

Авлигатай холбоотой: МУЭ/ТСТ арга хэмжээний хүчийг сулруулах улмаар мөнгө угаалтыг хөнгөвчлөхөд хүргэж болзошгүй авлига (албан тушаалтнуудад хахууль өгөх), үүнд улс төрийн нөлөөтэй хүмүүс (УТНХ)-ийн боломжит нөлөөлөл багтана.

Валютын арилжаа/бэлэн мөнгөний хөрвүүлэлт: илрүүлэлтийн эрсдлийг багасгахын тулд улс хооронд зөөвөрлөх, эсвэл валютын арилжааны тайлагналтад сул шаардлага тавьдаг байдлыг ашиглах, тухайлбал мөнгийг өөр улс руу тээвэрлэхийн тулд замын чек худалдан авах. Бэлэн мөнгө зөөвөрлөгчид/валют зөөвөрлөх: гүйлгээний/бэлэн мөнгөний тайлагнах арга хэмжээнээс бултахын тулд валютыг нууцаар шилжүүлэх.

Мөнгө тушаах бүтцийг өөрчлөх (Structuring/surfing): Мэдээлэх үүрэг хүлээлгэн тогтоосон босго хэмжээнээс зайлсхийхийн тулд олон гүйлгээг (дансанд мөнгө тушаах, данснаас зарлагадах, шилжүүлгүүд) янз бүрийн хүмүүс их хэмжээний мөнгийг жижиг дүнтэйгээр зарим үед олон тооны дансанд шилжүүлэх арга юм.

Зээлийн картууд, чекүүд болон энгийн вексель (promissory note) г.м: Ихэвчлэн өөр улсын санхүүгийн байгууллага дахь мөнгөнд/санд нэвтрэх хэрэгслээр ашигладаг.

Шилжүүлэх боломжтой үнэт эдлэлийг худалдан авах (үнэт чулуу, үнэт металл г.м): Өмчлөлийг нь нуух, эсвэл илрүүлтэд өртөхгүй байдлаар зөөх болон санхүүгийн салбар дахь МУТСТ арга хэмжээнээс зайлсхийх техник – жишээ нь очир эрдэнийг өөр улс руу зөөх.

Үнэтэй хөрөнгө худалдан авах (үл хөдлөх хөрөнгө, морин уралдаан, автомашин г.м): Гэмт хэргийн орлогоор өндөр үнэ бүхий арилжих боломжтой бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр гэмт хэргээс олсон орлого гэдгийг нь нууж, тайлагнах шаардлагад бага хамааралтай байдлыг ашиглах.

Бараа солилцоо (бартер): Санхүүгийн салбарын МУТСТ арга хэмжээнээс зайлсхийхийн тулд мөнгө болон санхүүгийн хэрэгслийг хэрэглэхгүйгээр героиныг алтны гулдмайгаар шууд солилцох. Бэлэн бус шилжүүлгийг хэрэглэх: Илрүүлэлт болон хураан авах арга хэмжээнээс зайлсхийхийн тулд санхүүгийн байгууллагуудын хооронд ихэвчлэн нөгөө улс орон руу электрон шилжүүлэг хийх.

Нууц банк/албан бус гуйвуулгын үйлчилгээ (hawala, hundi г.м): Итгэлцлийн сүлжээн дээр суурилсан албан бус механизмыг ашиглан мөнгө гуйвуулах. Голдуу уламжлалт банкны салбартай зэрэгцэн оршдог бөгөөд зарим улс оронд хууль бус (албан бус) гэж тооцогддог байна. Уг сүлжээг мөнгө угаагч болон терроризмыг санхүүжүүлэгч этгээдүүд ашиглан хөрөнгийг илрүүлтэнд өртүүлэхгүй, өөрсдийн хяналтанд буй мөнгөний гарал үүслийг нуун шилжүүлдэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ажиллагаа: санхүүгийн тунгалаг байдлын хууль зохицуулалтуудаас зайлсхийхийн тулд худалдааны санхүүжилтын замууд болон бараа бүтээгдэхүүнийг ашиглан ихэнх тохиолдолд нэхэмжлэхийг өөрчлөх.

Тоглоомын үйл ажиллагаанууд (казино, морин уралдаан, интернетээр бооцоотой тоглох г.м): Мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах буюу хууль ёсны тоглогчоос хожлын тасалбарыг худалдан авах; казиногийн чипийг гэмт хэрэгтэй холбоотой гүйлгээнд төлбөрийн хэрэгсэл болгон хэрэглэх; онлайн мөрийтэй тоглоомыг гэмт хэргийн орлогыг нуухад ашиглах.

Ашгийн бус байгууллагыг ашиглах (ТББ): Террорист санг өсгөн арвижуулах, мөнгөний эх үүсвэр болон мөн чанарыг нуун далдлах, террорист санг түгээхэд ашиглах.

Санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх: Арилжих боломжтой хэрэгслүүдийг худалдан авах замаар гэмт хэргийн орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.

Холих (mingling=бизнесийн хөрөнгө оруулалт): Мөнгө угаалтын үндсэн алхам буюу гэмт хэргийн орлогыг хууль ёсны мөнгөтэй холилдуулан эх үүсвэрийг нь нуун далдлах юм.

Халхавч компаниуд/корпорацуудыг ашиглах: Хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.

Оффшор банкууд/бизнесүүд, тухайлбал итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч компанийг ашиглах: хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс сэргийлж, дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх.

Итгэмжлэгдэгч, итгэлцлүүд, гэр бүлийн гишүүд болон гуравдагч талуудыг ашиглах: Хууль бус хөрөнгийг хянаж буй этгээдүүдийг таньж мэдэхээс сэргийлэх зорилготой.

Гадаадын банкны дансуудыг ашиглах: Дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас холдуулах болон хууль бус хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх.

Бусдын хувийн мэдээлэл/баримт бичгийг хулгайлан ашиглах/ (identity fraud/false identification): мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх олон аргуудтэй холбоотой этгээдийг таньж мэдэхээс зайлсхийх.

Мэргэжлийн үйлчилгээний “хаалгач”-дыг ашиглах (хуульчид, нягтлан бодогчид болон боркерууд г.м): Хөрөнгийн эцсийн өмчлөгчид болон хууль бус мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилготой юм. Түүнчлэн гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаах “мэргэжлийн” зөвлөгөө өгөхөөр авлига авсан мэргэжилтнүүдийг хамааруулж болно.

Төлбөрийн шинэ технологиуд: мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх сүүлийн үеийн төлбөрийн технологиуд. Жишээлбэл, гар утсанд суурилсан гуйвуулга болон төлбөрийн систем. (Монгол банк, Санхүү мэдээллийн алба, 2020)

Хоёр. Эрүүгийн эрх зүйн зохицуулалт: Монгол улсын Эрүүгийн хууль

Улсын Их Хурлаар 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар Монголбанкны дэргэд Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ыг байгуулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 болон 2019 онуудад нэмэлт өөрчлөлт оруулснаар хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, олон улсын стандарт, шаардлагын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг нэмэгдүүлсэн. Ингэснээр дараах мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд зааснаар:

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол” 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Гэмт хэргийг байнга тогтвортой үйлдэх, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол 1 жилээс

5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ. Зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд 2015 оноос өмнө мөнгө угаах гэмт хэрэгт хүлээлгэх ялын хувьд авч үзвэл торгох, хорих ялуудын аль нэгийг үндсэн ялаар, эд хөрөнгө хураахыг нэмэгдэл ялаар хэрэглэж ирсэн байдаг бол 2015 оноос хойш Эрүүгийн хуульд бие хүнд зорчих эрх хязгаарлах, хорих ялын аль нэгийг, хуулийн этгээдэд торгох ял хэрэглэхээр хуульчилжээ.

Зүйл заалт	2008.02.01-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 ¹ дугаар зүйл	2009.12.24-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2014.01.16-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2015 оны Эрүүгийн хууль. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл
Үндсэн бүрэлдэхүүн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	Эд хөрөнгө хурааж, 5-10 жил хүртэл хугацаагаар хорих	Эд хөрөнгө хурааж, 5-10 жил хүртэл хугацаагаар хорих	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5-12 жил хүртэл хугацаагаар хорих	1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	Эд хөрөнгө хурааж, 10-15 жил хүртэл хугацаагаар хорих	Эд хөрөнгийг хурааж, 10-15 жил хүртэл хугацаагаар хорих	Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох (хуулийн этгээдэд хамааралтай)	5-12 жил хүртэл хугацаагаар хорих

Хүндрүүлэх бүрэлдэхүүн	-	-	-	Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж 120.000- 400.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох (хуулийн этгээдэд хамааралтай)
---------------------------	---	---	---	--

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “мөнгө угаах” гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнд “зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар зорчих эрх хязгаарлах эсхүл зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар хорих ял” хүлээлгэхээр заажээ. Энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хөнгөн гэмт хэрэгт хамаарах бөгөөд болгоомжгүйгээр үйлдэгддэг гэмт хэрэгт оногдуулах ялтай адил байна. Мөн хөнгөн гэмт хэрэг дотроо ялын хувьд хамгийн багад тооцогдох юм. Учир нь хөнгөн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээ 6 сараас 5 хүртэлх жил байдаг.

Мөн түүнчлэн Монгол Улсыг FATF-ын саарал жагсаалтад оруулахдаа “Монгол Улс цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахдаа дараахь арга хэмжээг авна: Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын МУТС эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, МУТСТ үүргээ зөрчсөн тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах” гэж заасан. Эдгээрээс харвал манай улсыг мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулж буй ялын хэмжээнд анхаарах шаардлагатайг удаа дараа анхааруулсан байна. Тийм ч учраас FATF-аас манай улсыг мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах шаардлагыг хүргүүлсээр байгаа.

2015 оны Эрүүгийн хуулиар хуулийн этгээдийг гэмт хэргийн субъектээр тооцож, оногдуулах ялыг чангатгасан нь олон улсын жишигт нийцсэн зохицуулалт болжээ. Одоогийн мөрдөж буй Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж торгох ял оногдуулж байна. Ямар төрлийн үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран хуулийн этгээдэд торгох ял оногдуулдаг. Дан ганц хуулийн этгээдийг торгоод өнгөрөх бус тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад мөн ял оногдуулж байна.

Хөөх хэлэлцэх хугацаа:

Хөөх хэлэлцэх хугацаа гэж гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага хүлээлгэхээс татгалзахыг ойлгоно.

Зүйл заалт	2008.02.01-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 ¹ дугаар зүйл	2009.12.24-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2014.01.16-нд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 ¹ дугаар зүйл	2015 оны Эрүүгийн хууль. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл
------------	---	---	---	--

Үндсэн бүрэлдэхүүн	5 жил өнгөрсөн	5 жил өнгөрсөн	5 жил өнгөрсөн	1 жил өнгөрсөн
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	15 жил өнгөрсөн	15 жил өнгөрсөн	15 жил өнгөрсөн	5 жил өнгөрсөн
Хүндрүүлэх бүрэлдэхүүн	25 жил өнгөрсөн	25 жил өнгөрсөн	15 жил өнгөрсөн	12 жил өнгөрсөн

Дээрх хүснэгтээс харахад, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг илт богино болгосон байна. НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албанаас Олон Улсын валютын сангийн хувьд мөнгө угаах үндсэн гэмт хэрэгт хэрэглэх хөөн хэлэлцэх хугацаа 12-15 жил байвал зохимжтой гэж тэмдэглэжээ.

Дүгнэлт, санал

Мөнгө угаах гэмт хэрэг нь олон зууны турш байсан, одоо ч байгаа, улам бүр хөгжиж байна. Иймд эрх зүйн орчинг сайжруулж, хяналтыг чангатгах хэрэгтэй бөгөөд үүнд улс орнуудын хамтын ажиллагаа шаардлагатай. Монгол улс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд онцгой анхаарах хэрэгтэй, үгүй бол хөгжиж буй орны хувьд эдийн засгийн хөгжилд ихэ хэн сөрөг нөлөөтэй юм.

Терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг, олон улсын байгууллага, банк, гадны хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгжүүд, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй сан, буяны байгууллага, татвар төлхөөс зайлсхийх, хар зах зээл дэх бэлэн мөнгөний эргэлтийг зогсоох, мансууруулах бодис, галт зэвсгийн худалдаа, хүний наймаа, хууль бус эсхүл халхавчилсан үнэт цаасны арилжаа зэрэг зохион байгуулалттай үйлдэгддэг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх арга нь дээрх гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх бөгөөд энэ бүх нахцөлийг харгалзаж Монгол улс эрх зүйн орчиндоо мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоо оновчтой тодорхойлох шаардлагатай

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлолгүй “Гэмт хэрэг” гэдэг томъёоллоор хуульчилсан нь уг гэмт хэрэгтэй тэмцэх тэмцэл ахуйн хүрээнд маш “үр дүнтэй” хийгдэж мөнгө угаах гэмт хэргээр ял оногдуулсан тоогоор дэлхийд “толгой цохих” үр дүнд хүрнэ. Мөнгө угаах гэмт хэрэг ахуйн хүрээнд, тохиолдлын шинжтэй үйлдэгддэгийг анхаарч хууль боловсруулах, батлах шатанд уг гэмт хэргийн зорилго, учруулж болох аюул, хор уршиг, дэлхий нийтээр уг гэмт хэрэгтэй тэмцэх болсон зорилго, ач холбогдлыг анхаарч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан заалтыг эргэн харах шаардлагатай.

Ашигласан материал

Хууль, эрх зүйн акт

1. Монгол улсын эрүүгийн хууль, 2015 он
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он
3. 1988 оны НҮБ-ын “Мансууруулах болон сэтгэгцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”
4. 200 оны НҮБ-ын “Авилгын эсрэг конвенц”
5. 2000 оны “Палермогийн конвенци”
6. Монгол банк, сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага, УБ хот, 2020 он

7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт ФАТФ-ын зөвлөмж, 2019 он
8. МХХ, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, 2017 он
9. СЗХ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх нь, 2020 он
10. ТЕГ, Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх зарим асуудал, 2020 он
11. Жанцан С. Монгол улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий ба тусгай анги. УБ., 2012 он
12. С.Гантулга нар “Эрүүгийн эрх зүй” ерөнхий анги УБ., 2020 он
13. Г.Гантөмөр нар “Эрүүгийн эрх зүй” ерөнхий анги УБ., 2020 он

Гадаад эх сурвалж

14. Robin Booth. Money Laundering Law and Regulation: A Practical Guide. 2011, Oxford, p4-6.
15. U.S. Code § 1956 - Laundering of monetary instruments
16. Proceeds of Crime Act 2002. UK.,
17. Act on Prevention of Transfer of Criminal Proceeds. Act No. 22, Japan, 2007.
18. The Criminal Code Of The Russian Federation. 1996.
19. Criminal Law of the People's Republic of China. 1997.

Цахим эх сурвалж:

- 1) <https://www.google.com/amp/s/shuftipro.com/blog/40-surprising-facts-and-statistics-about-money-laundering-2021-update/>
- 2) https://ec.europa.eu/info/business-economy-euro/banking-and-finance/financial-supervision-and-risk-management/anti-money-laundering-and-counteracting-financing-terrorism_en
- 3) <https://www.knowyourcountry.com/mongolia1111>

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

RESTRAINT METHODS CONCEPT AND LEGAL REGULATION

В.Амарсанаа

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Amarsanaa.V

Lecturer, Department of criminal law and criminology,
University of internal affairs, doctor (Ph.D), police major

Хураангуй: Өгүүлэлд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаарх үеийн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан байдлыг хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний

төрөлтэй харьцуулан, эрдэмтэн, судлаачдын үзэл санаанд үндэслэн, уг ойлголтын талаарх тодорхойлолт гаргахыг зорилоо. Мөн хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тулгарч буй зарим бэрхшээлийг нээн илрүүлэхэд өгүүллийн зорилго оршино.

Abstract: The article aims to define the concept based on the ideas of scientists and researchers, comparing the state of detention in the periodic Criminal Procedure Code with the types of detention in the ongoing Criminal Procedure Code. The purpose of the article is also to reveal some of the challenges posed by Article 14.9 of the law on Criminal Procedure and the state of enforcement of restraint.

Түлхүүр үгс: Байцаан шийтгэх ажиллагаа, олон улсын гэрээ, сэжигтэн, шүүгдэгч, эрх, эрх чөлөө, яллагдагч.

Keywords: Proceedings, international agreements, suspect, defendant, rights, freedoms, accused.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойшх хугацаанд Эрүүгийн процессын шинжлэх ухааны албадлагын арга хэмжээний нэг төрөл болох цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний (Цаашид–ТСАХ гэх) үндэслэл нь хувьсан өөрчлөгдөх, шинэчилсэн агуулгаар баяжих, хүний эрх суурьтай хөгжих, дэлхий нийтийн эрх зүйн соёл, чиг хандлага, Монгол Улсын Олон улсын Гэрээ, Конвенцид нийцүүлэх, дэлхийн хөгжилтэй орнуудын ололтыг нутагшуулах зэргээр боловсронгуй болж ирсэн. Гэхдээ энэ үйл явц нь тийм ч богино хугацаанд явагдаагүйгээс гадна, түүхийн олон мөчлөгийг давж, өнөөгийн зэрэгт хүрчээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ”¹⁵⁵ гэж заасан. Тэгэхээр, халдашгүй чөлөөтэй байх эрх нь Үндсэн хуулиар баталгаажуулсан, ямар ч албан тушаалтан, эрх ямбатан дур мэдэж, хувийн эрх ашгийн төлөө халдаж болохгүй туйлын эрх болно.

Цагдан хорих ТСАХ-тэй холбоотой түүхийн зарим эх сурвалжийг дурдвал, 1926 оны Монгол Улсын Шүүн таслах газраас аливаа хэргийг байцаах ба шийтгэх тухай хуульд уг арга хэмжээ анхлан тусгагдсан. 1935 онд батлагдсан “Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 22 дугаар зүйлд дараах байдлаар заасан. Үүнд:

22 дугаар зүйл. Аливаа байцаагдан байгаа хүмүүсийг оргон зайлахгүй болгохын тулд хэрэглэх аргуудын тухай:

1. Хэрэгтэн хүмүүсээс мөрдөн байцаалтын газар хүрэлцэн ирэх буюу шүүх таслах газар биеэр хүрэлцэн ирэх ба хэрэв оршин суугаа газраасаа шилжвэл тэр тухайгаа мэдэгдэж байна гэж гарын үсэг зурсан хуудсыг гаргуулах.

¹⁵⁵ Совд Г. “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх” /Харьцуулсан эрх зүй/, УБ, 1999, 51 дэх тал.

2. Оршин суугаа орон нутгаасаа ахин гарахгүй гэж мөн гарын үсэг зурсан хуудсыг гаргуулах.

3. Бусад итгэмжтэй хүмүүс хоёроос доош бусаар буюу хөрөнгөөр даалгах.

4. Хөрөнгө хогшлыг барьцаалуулах.

5. Хорих.

Мөн энэ хуулийн 23 дугаар зүйлд: “Дээр дурдсан эдгээр аргуудын дотроос чухам ямар арга хэрэглэвэл зохихыг тухайн байцаагчаас тогтооход хэрэг дутам түүний хүнд, хөнгөн ба хэрэгтэн хүний урьд одоогийн зан байдал хийгээд, уул хэргийн байдал нь ард олонд ямар холбогдолтой болох, үйлдсэн гэмт хэргийн баримт юу болох, хэргийн үнэн магадыг илрүүлэхэд саад боогдол гарах эсэхийг байцаагдах явдлаас зайлсхийх зэргийг тус тус хянан үзэж, шийдвэрлэн тогтоовол зохино гэж заасан бөгөөд, тайлбар хэсэгт: Хорих аргыг хэрэглэхдээ гагцхүү уул хүнийг сул байлгавал хэргийн байцаан, үнэн магадыг илрүүлэхэд саад, тогтор гарах буюу оргон зайлахыг сэрэмжлэх, эсхүл ард олонд онц аюултай болбол шууд барьж, хорьж болно”¹⁵⁶ гэж цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг нэг өгүүлбэрт багтаан гаргасан байна. Эндээс үзэхэд, “Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай” хууль нь хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болзошгүй, оргон зайлж болзошгүй, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн гэх үндэслэлүүдэд анхаарал хандуулж, зөвхөн эдгээр үндэслэлээр хүнийг хорьдог байжээ.

1949 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ЭБШ хуулийн 187 дугаар зүйлд: “Цагдан хорих явдлыг ТСАХ болгох нь гагцхүү шүүхээс 1 жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял ногдох гэмт хэргийн талаар гүйцэтгэгдэж болох бөгөөд, түүнд яллагдагч этгээд нь мөрдөн байцаалт ба шүүхээс нуугдан зайлах буюу эсхүл түүний биеийг сул байлгавал үнэнийг илрүүлэхэд саад болох буюу нийгэмд аюултай гэж үзэх гүйцэт үндэс бүхий байх тухайд тийнхүү цагдан хорих арга хэмжээ авна”¹⁵⁷ гэж тусгажээ. Эдгээр үндэслэлүүд нь 1935 онд батлагдсан “Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай” хуульд заасантай төстэй боловч, (1 жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял ногдох гэмт хэрэгт) Эрүүгийн хуулийн санкцийн хүнд, хөнгөнөөс хамаарч цагдан хорих ТСАХ авах заалтыг тусгаснаараа ялгаатай байна.

Тэгвэл 1963 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх (Цаашид – ЭБШ гэх) хуульд цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг бүр ч ойлгомжгүй байдлаар тусгасан байна. Энэ хуулийн 94 дүгээр зүйлд: Цагдан хорих явдлыг ТСАХ болгож, хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэргүүд, түүнчлэн аюултай буюу онц аюултай гэмт хэргүүдэд гагцхүү хэргийн аюултай байдлыг харгалзан, энэ хуулийн 12 дугаар зүйлийн шаардлагын дагуу хэрэглэж болно¹⁵⁸ гэж заажээ. Өөрөөр хэлбэл, хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэргүүд болон аюултай ба онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хорих бөгөөд, бусад этгээдэд уг ТСАХ-ээс бусад (оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах; хүмүүс буюу олон нийтийн байгууллагын даалтанд өгөх гэх мэт) арга хэмжээний аль нэгийг сонгон хэрэглэх боломжийг олгосон байна.

Гэхдээ бусад үндэслэлээр цагдан хорих ТСАХ авах үндэслэл тусгагдаагүй гэж үзэж болохгүй юм. Энэ хуулийн 87 дугаар зүйлд: “Яллагдагч нь урьдчилсан мөрдөн байцаалт буюу шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит үнэнийг

¹⁵⁶ Баярсайхан Б., Дашням Ч. нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он) УБ. 2012. 114 дэх тал.

¹⁵⁷ Мөн тэнд. 153 дахь тал.

¹⁵⁸ Мөн тэнд. 219 дэх тал.

тогтооход саад болж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох бүрэн үндэстэй байгаа ба түүнчлэн таслан сэргийлэх тогтоолыг биелүүлэхийн тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь яллагдагчид дор дурдсан ТСАХ-ний аль нэгийг хэрэглэх эрхтэй” гэж заагаад, ТСАХ-ний төрлүүдийг заасан.

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно” гэж цагдан хорих нийтлэг үндэслэлийг оновчтой оруулсан гэхэд болно. Үүнээс гадна, энэ хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1. өмнө нь авсан ТСАХ-г зөрчсөн; 2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан; 3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр мөн адил цагдан хорих ТСАХ авахаар заасан байна.

ЭХХШТ хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан цагдан хорих ТСАХ нь бусад төрлийн ТСАХ-тэй харьцуулахад яллагдагч, шүүгдэгчийн эрх, эрх чөлөөг их хэмжээгээр хязгаарладаг хамгийн хатуу хэлбэрийн арга хэмжээ юм. Учир нь яллагдагч, шүүгдэгчийг хорих байранд хорьсноор, тэдний чөлөөтэй шилжих, бусадтай чөлөөтэй харилцах, хүссэн зүйлсээ хэрэглэх (дуртай хоолоо идэх, дуртай зүйлээ хийх), тав тухтай орчинд оршин байх, гэр бүл, ойр дотны (эцэг, эх, үр хүүхэд, эхнэр, нөхөр, хамаатан садан, найз нөхөд) хүмүүстэйгээ чөлөөтэй уулзах, ажил албаа эрхлэх, ашиг олох гэх мэт олон эрх чөлөө, ашиг сонирхол нь шууд хязгаарлагддаг байна. Иймээс цагдан хорих ТСАХ нь гагцхүү өөр төрлийн ТСАХ авснаар ЭХХШТ хуульд заасан зорилгыг биелүүлэх боломжгүй тохиолдолд хэрэглэдэг, албадлагын эцсийн арга хэмжээ. Тиймээс цагдан хорих ТСАХ-г зөвхөн шүүхээс авна. Харин хуульд заасан төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокурорт цагдан хорих ТСАХ авахын тулд Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газар, Улсын ерөнхий прокурорын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагыг хуульчилсан¹⁵⁹.

Академич С.Нарангэрэл “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан шийдвэрлэх арга хэмжээний нэг”¹⁶⁰ хэмээн тайлбарласан бол доктор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн”¹⁶¹ гэж тодорхойлжээ. Д.Цогтсайхан “...цагдан хорих арга хэмжээ гэдэг бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зугтаалгахгүй, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хуулийн дагуу явуулахад саад хийлгэхгүй, цаашид гэмт хэрэг шинээр үйлдэх бололцоо олгохгүй байх зорилгоор тэдний хувийн эрх, эрх чөлөөг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж байгаа эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгайлан тогтоосон албадлагын арга хэрэгсэл”¹⁶² гэжээ. Д.Ширэндэв “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг

¹⁵⁹ ЭХХШТХ-ийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судласан тайлан, 2017.

¹⁶⁰ Нарангэрэл С. Эрх зүйн их толь бичиг, 2 дахь хэвлэл. УБ, 2008, 552 дахь тал.

¹⁶¹ Бат-Эрдэнэ Б. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги. УБ, 2004, 265 дахь тал.

¹⁶² Цогтсайхан Д. “Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ”, Шүүх эрх мэдэл 1, 2014, 40-45

гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд, мөрдөгч, прокурорын санал болгосноор шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд, нийгмээс тусгаарлаж, Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ юм”¹⁶³ гэж тайлбарласан. Судлаач Д.Цогтсайханы цагдан хорих ТСАХ-ний талаарх тодорхойлолт нь оргон зугтаалгахгүй байх, байцаан шийтгэх ажиллагаанд саад хийлгэхгүй байх, шинээр гэмт хэрэг үйлдэх бололцоо олгохгүй байхад чиглэсэн зорилгыг гүйцэлдүүлэхэд хандсан бол, судлаач Д.Ширэндэв цагдан хорих ТСАХ-г ерөнхий байдлаар тодорхойлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл санаанд нийцүүлэн 1963 оноос үйлчилж эхэлсэн ЭБШ хуульд 1994 оны 3 дугаар сард зарчмын шинжтэй өөрчлөлт оруулснаас хойших арваад жилийн хугацаанд монголын нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарч, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон ЭБШ хуулийг үндэсний хууль тогтоомжийн түүхэн уламжлал, туршлага, хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг чиг хандлага, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн талаарх олон улсын гэрээний заалтын үзэл санааг тусган, шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигджээ.

2002 оны ЭБШ хуулийн 68 дугаар зүйлд зааснаар цагдан хорихдоо “Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно” гэж хуульчилсан байсныг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар халсан.

Учир нь цагдан хорих ТСАХ нь хүний эрхийг хязгаарлаж байдаг, хамгийн хүнд хэлбэрийн албадлагын арга хэмжээ болохын хувьд ЭБШ хуулийн 68.1-д заасан үндэслэл тогтоогдвол шууд цагдан хорих боломжтой байсныг өөрчлөн, хүний эрхийг хамгаалах үүднээс уг заалтыг хасах нь цагдан хорих ТСАХ авахдаа хүний эрхийг хамгаалах, үндэслэлгүйгээр (өөрийн үзэмжээр) цагдан хорих явдалд өндөр хяналт тогтоох боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзжээ. Энэ хуулийн 68.2.1-д “өмнө нь авсан ТСАХ-г зөрчсөн”, 68.2.2-т “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан”, 68.2.3-т “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн” гэх үндэслэлүүдээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих ТСАХ авдаг байсан бол 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүд харьцангуй өөр шинжүүдийг агуулсан.

Тэртээ XVIII зуунд Италийн нэрт эрдэмтэн Чезаре Беккариа “Хуульд хорих ялаар шийтгэгдэх, энэ үндэслэлээр баривчилж, цагдан хорьж болох гэмт хэргийн шинжийг зааж өгсөн байх ёстой. Сургаар нь хүмүүс айж сандрах, оргон зугтах, яллагдагч, түүний хамсаатан хэргээ хүлээх, хохирогчдоо дахиад халдах, эсхүл гэмт хэргийн ул мөрийг баллах магад гэсэн үндэслэлээр хүнийг баривчилдаг. Гэхдээ эдгээр үндэслэл нь заавал хуульд бэхжүүлэгдсэн байх ёстой агаад, үйлчилж буй хуулиар тогтоосон зарчмаас л эхтэй биш бол ямагт хүний эрхийг хязгаарлах талдаа байдаг шүүхийн үзэмжийн асуудал байж огт болохгүй”¹⁶⁴ гэж тэмдэглэн үлдээжээ.

¹⁶³ Ширэндэв, Д. “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”, магистрын дипломын ажил, 20 дахь тал.

¹⁶⁴ Эрдэнэбат Г. Орчуулгын бүтээл: Чезаре Беккариа, Гэмт хэрэг ба ялын тухай, Хорихоор баривчлах тухай, УБ, 2021, 88 дахь тал.

Хууль тогтоогчдын зүгээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн тухай Олон Улсын Гэрээ, Конвенциудад заасан эрхийг мөрдөн шалгах ажиллагааны явцад хангах, хуулийг сайжруулах зорилгоор 2002 оны ЭБШ хуулийг хүчингүй болгож, шинээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр соёрхон батласан.

Уг хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Шүүх дараах үндэслэлийн аль нэг нь байвал яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргана” гэж тусгаад, цагдан хорих ТСАХ авах дараах үндэслэлүүдийг заасан. Үүнд:

1.1. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;

1.2. шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.3. гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.4. урьд нь авсан ТСАХ-г зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй¹⁶⁵.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан цагдан хорих ТСАХ-г авч хэрэгжүүлэх үндэслэлийн талаар “...Цагдан хорих арга хэмжээг тухайн хүнийг цээрлүүлэх, шийтгэх хэрэгсэл болгон ашиглахыг халах зорилгоор хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт, үндэслэл бий болсныг үндэслэн, прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсаны дараа яллагдагчид тодорхой үндэслэлээр ТСАХ авч болох зохицуулалтыг хуульчилсан”¹⁶⁶ хэмээн тайлбарлажээ.

Яллагдагч, шүүгдэгч нь гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт, үндэслэл бий болсон тохиолдолд, цагдан хорих ТСАХ авах болсноор, ЭБШ хууль хэрэгжиж байсан үед цагдан хорих ТСАХ авагдсан хүмүүсийн үзүүлэлттэй харьцуулахад, шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмаар цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгчдийн үзүүлэлт харьцангуй багассан тоо мэдээтэй байна.

Хүснэгт №1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан тоон үзүүлэлт (2008-2017 оны хооронд)

Он	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Нийт
Цагдан хоригдсон хүний тоо	4485	4190	3797	3991	3854	3110	2651	3005	3030	1860	33973

2002 оны ЭБШ хууль хэрэгжиж байсан үед (2008-2016) нийт цагдан хоригдсон хүний тоо шинэ ЭХХШТ хууль хэрэгжсэн үеэс харьцангуй их байгаа болох нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, 2017 онд цагдан хоригдсон хүний тоо өмнөх онуудтай харьцуулахад 2 дахин багассан байна. Уг бууралтын гол шалтгаан нь нэг талаас ЭХХШТ хуулийн 14.9 дүгээр зүйлд зааснаар цагдан хорих үндэслэл (үндэслэл бүхий баримт, мэдээлэл дээр суурилж, цагдан хорих ТСАХ авдаг болсон) тогтоогдвол, энэхүү ТСАХ-г авахаар хуульчилсантай холбоотой хэмээн дүгнэж болох боловч, нөгөө

¹⁶⁵ Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. <https://www.legalinfo.mn/law/details/11634>.

¹⁶⁶ Танилцуулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн тухай, Засгийн газар.

талаас ЭХХШТ хуульд байгаа цагдан хорих үндэслэлүүд нь практикт хэрэгжих байдал нь хүндрэлтэй байгаагаас шалтгаалаад, мөрдөгч, прокуророос цагдан хорих ТСАХ авахаар гаргасан саналын тоо цөөрч, үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа эсэх талаарх баримт нь хангалттай бус байдгаас үүдээд, шүүхээс яллагдагчид цагдан хорих ТСАХ авах байдал багассан байж болох талтай.

Зарим судлаачид “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийн баталгааг илүү бүрдүүлэх, хангах шаардлагын үүднээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, түүгээр мөрдөх ажиллагаатай холбогдох бүхий л санал, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэлэлцүүлэх, нягтлан шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах, оролцогчдын дүр төрхийг халхавчлах төхөөрөмж ашиглах, мөн биечлэн байлцахгүйгээр холбоо харилцааны техник, хэрэгсэл ашиглан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, сэжиг, таамгаар удаан хугацаагаар хорьж, хэрэг хүлээлгэх явдлыг зогсоох, шуурхай, богино хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах шаардлагаар цагдан хорих хугацаа 24 сар байсныг 18 сар болгож, шүүгчийн зөвшөөрөлгүй баривчлах 72 цаг байсныг 48 цаг болгосон нь хүний эрхийн баталгаа, хууль ёсны ашиг сонирхлыг нь хангах, хамгаалахад зохих ахиц гарсан”¹⁶⁷ гэж үзэж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударгаар шүүлгэх эрхийг хангах асуудлыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон, шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино”¹⁶⁸ гэж тусгасан.

Гэсэн хэдий ч хуулийн зарим заалтууд нь ойлгомжгүй, алдаа, дутагдалтай байдлаар хуульчлагдсаны улмаас бодит амьдралд хэрэгжихэд хүндрэлтэй байгаагаас шалтгаалж, практикт нилээд маргаан дагуулаад байна. Тухайлбал, нэг талаас мөрдөн шалгах ажиллагааг өмнөх хуультай харьцуулахад богино хугацаанд хийж гүйцэтгэх боломжийг хангаж, хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн нь сайшаалтай боловч, нөгөө талаас хуульд заасан цагдан хорих ТСАХ авах үндэслэл учир дутагдалтай байдлаар хуульчлагдсанаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж байна хэмээн үзэхээр байна. Жишээлбэл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2018 онд хийж гүйцэтгэсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлангийн хүрээнд 59 прокурорын дунд явуулсан анкетын судалгааны ихэнх оролцогчид “Гэмт хэрэг үйлдсэн, оршин суух тодорхой хаяггүй хүнийг цагдан хорих боломж хязгаарлагдмал байгаагаас яллагдагч /шүүгдэгч/ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж байна”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлийг нотлоход хүндрэлтэй. Гэтэл шүүхээс заавал нотлох баримт шаарддаг. Үүнээс болж гэмт хэрэг үйлдсэн хүн мөрдөн байцаалтаас оргодог”¹⁶⁹ гэсэн асуудал дээр нэгдмэл байр суурь илэрхийлсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2014 онд хийсэн “Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт” сэдэвтэй, бодлогын судалгааны тайланд, цагдан

¹⁶⁷ Бямбаа Ж., Эрхэсхулан Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ. 2018. 298 дахь тал.

¹⁶⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/12694>.

¹⁶⁹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн судалгааны төв, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, судалгааны тайлан, УБ, 2018, 42 дахь тал.

хорих ТСАХ-г хэрэгжүүлэх явцад учирч буй бэрхшээлийг тодорхойлох үүднээс шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн дунд судалгаа явуулсан байна.

Судалгаанд 46.5% буюу 66 шүүгч, 32.4% буюу 46 прокурор, 21.1% буюу 30 өмгөөлөгч хамрагдсанаас 81% нь “өнөөгийн (2002 оны ЭБШ хууль) цагдан хорих ТСАХ авч байгаа тогтолцоог өөрчлөн, сайжруулах шаардлагатай” гэж үзсэн бол цагдан хорих ТСАХ-г хэрэгжүүлж байгаа практик тогтолцоог боловсронгуй болгохын тулд нэн тэргүүнд авах ёстой арга хэмжээг 42.3% нь “цагдан хорих арга хэмжээний процессын тодорхойгүй байдлыг сайжруулах”, 28.5% нь “хууль эрх зүйн орчныг шинэчлэх”¹⁷⁰ гэжээ. Уг судалгааны үр дүнд 2002 оны ЭБШ хуульд заасан цагдан хорих ТСАХ авч буй үндэслэл, процесс ажиллагааг шинэчлэн, өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд, энэ арга хэмжээг хууль эрх зүйн орчныг шинэчлэхээс эхлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Цагдан хорих ТСАХ-тэй холбоотой дээрх хоёр судалгааны ажлыг харьцуулан судлаад, дараах дүгнэлтийг гаргах боломжтой байна. Үүнд: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2014 онд хийсэн “Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт” сэдэвтэй, бодлогын судалгааны ажлын хүрээнд явуулсан анкетын судалгааны үр дүнд “Цагдан хорих арга хэмжээний процессын тодорхойгүй байдлыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай” гэсэн дүгнэлт гарсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2018 онд хийж гүйцэтгэсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлангийн хүрээнд 117 шүүгч, 59 прокуророос анкетын аргаар судалгаа авч, цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг нэмэгдүүлэх шаардлагатай юу? гэсэн асуултад 117 шүүгчийн 38.5% нь “шаардлагагүй”, 33.3% нь “хуучин хуулийн зөвхөн сэжигтэн, яллагдагч оргон зайлж болзошгүй гэсэн үндэслэлийг нэмэх шаардлагатай”, “шаардлагагүй” гэж 25.6% нь хариулжээ. Харин судалгаанд хамрагдсан 59 прокурорын 81.4% нь “цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг нэмэх шаардлагатай”, 18.6% нь “шаардлагагүй” гэсэн байна.

Энэхүү анкетын судалгааны явцад, санал асуулгад оролцогчдын дийлэнх нь “Цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг нэмэх шаардлагатай” хэмээн хариулснаас гадна “оршин суух тодорхой хаяггүй, оргон зайлж болзошгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж, мөрдөгч, прокурор, шүүхээс дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байх гэсэн үндэслэлүүдийг нэмэх шаардлагатай” гэж санал өгчээ. Эндээс үзэхэд, 2002 оны ЭБШ хууль хэрэгжиж байсан үеийн судалгааны үр дүн нь цагдан хорих арга хэмжээний процессын тодорхойгүй байдлыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг шинэчлэх шаардлага зайлшгүй үүссэн болохыг тод харуулж байгаа юм. Энэ үзэл хандлагын дагуу 2017 онд ЭХХШТ хууль батлагдсан бөгөөд, цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг шинэчилсэн. Гэтэл шинэчлэгдэн, өөрчлөгдсөн үндэслэлүүд нь өмнөх хуулийн үндэслэлүүдтэй нэгэн адил шүүмжлэлийг араасаа дагуулж, практикт хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэсэн хэвээр байгаа нь илхэн харагдаж байна.

Дүгнэлт

1. Цагдан хорих ТСАХ гэдэг нь гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт явуулах мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагааг хуулийн дагуу явуулахад саад хийлгэхгүй, мөрдөн байцаалт,

¹⁷⁰ Ариунболд А., Билгүнзаяа Х., Өлзийлхам Э. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт, Бодлогын судалгааны тайлан, УБ, 2014, 21-22 дахь тал.

шүүхээс оргон зугтаалгахгүй, цаашид гэмт хэрэг шинээр үйлдэх бололцоо олгохгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын аюулгүй байдалд заналхийлэхгүй байдлыг хангах зорилгоор, мөрдөгч, прокурорын үндэслэл бүхий саналыг харгалзан, шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд, нийгмээс тусгаарлаж, Үндсэн хуульд заасан хувийн эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ юм.

2. Хууль тогтоогчдын зүгээс цагдан хорих ТСАХ авах үндэслэлд буй ойлгомжгүй байдлууд болон практикт ашиглахад үүсэх хүндрэлүүдийн талаар олон талт суурь судалгаа, нийтийг хамарсан асуулга зохион байгуулж, энэ чиглэлээр амжилттай хэрэгжиж буй олон улсын сайн туршлагыг судлалгүйгээр, зөвхөн хүний эрхийг дээдлэн хүндэтгэж, халдашгүй байдлыг хангах гэсэн чиглэлд баригдаж, цагдан хорих үндэслэлийг дутуу, дулимаг гаргасан болох нь учир дутагдалтай байна. Тиймээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенциуд болон Үндсэн хуульд тусгасан хүний эрх, эрх чөлөөний талаарх заалтуудад нийцсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтыг бүрэн хангасан цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүдийг нээн илрүүлэх шаардлага үүсээд байна.

Ашигласан материал

1. Ариунболд А., Билгүнзаяа Х., Өлзийлхам Э. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт, Бодлогын судалгааны тайлан, УБ, 2014.

2. Бат-Эрдэнэ Б. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги. УБ, 2004.

3. Баярсайхан Б., Дашням Ч. Нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он) УБ. 2012.

4. Бямбаа Ж., Эрхэсхулан Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ. 2018. 298 дахь тал.

5. Нарангэрэл С. Эрх зүйн их толь бичиг, 2 дахь хэвлэл. УБ, 2008.

6. Совд Г. “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх” /Харьцуулсан эрх зүй/, УБ, 1999.

7. Танилцуулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн тухай, Засгийн газар.

8. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн судалгааны төв, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, судалгааны тайлан, УБ, 2018.

9. Цогтсайхан Д. “Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ”, Шүүх эрх мэдэл 1, 2014.

10. Ширэндэв Д. “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”, магистрын дипломын ажил.

11. Эрдэнэбат Г. Орчуулгын бүтээл: Чезаре Беккариа, Гэмт хэрэг ба ялын тухай, Хорихоор баривчлах тухай, УБ, 2021.

12. Эххштх-ийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судласан тайлан, 2017.

13. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. <https://www.legalinfo.mn/law/details/11634>.

14. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/12694>.

ХҮНИЙ ЭРХИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Б. Баярболд

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш,
цагдаагийн ахлах дэслэгч, /хууль зүйн магистр/

Bayarbold.B

Police School at University of Internal Affairs, Department
of Public Law, Lecturer police senior lieutenant, /master of law/

Хураангуй: Монгол улсад ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор Монгол улсын үндсэн хуулинд заагдсан хүний эрх ноцтой зөрчигдөх асуудлууд гарсаар байгаа бөгөөд тухайн тулгамдаад байгаа асуудлыг хөндөх, мөн шийдвэрлэхлэх гарц гаргалгааг гаргахыг эрмэлзсэн болно.

Abstract : Due to the outbreak of the Kovid-19 pandemic in Mongolia, there are still serious human rights violations enshrined in the Constitution of Mongolia, and efforts are being made to address the issues and find solutions.

Түлхүүр үг: Хүний эрх, эрх чөлөө, Ковид-19 цар тахал, хол хорио, халдашгүй, чөлөөтэй байх, ялгаварлан гадуурхал, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал, тусгаарлах байр, жендерийн тэгш бус байдал, гэр бүлийн хүчирхийлэл.

Keywords: Human rights and freedoms, Kovid-19 epidemic, quarantine, inviolability, freedom, discrimination, universal preparedness for disaster protection, isolation, gender inequality, domestic violence.

Оршил

“Хүний эрх гэдэг нь хүнд төрөлхөөс заяасан хүн гэдэг ойлголттой салшгүй уялдаа холбоотой авя үзэх, жам ёсны заяагдмал шинжтэй, тухайн улс үндэсний эрх зүйн хэм хэмжээгээр баталгааг бүрдүүлэхэд хүний субъектив эрхийг хэлнэ”¹⁷¹

Хүний эрхийг хамгаалахад дан ганц хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх механизм байгаад зогсохгүй иргэд өөрсдөө хүний эрхийн талаар мэдлэгтэй байх нь нэн чухал. Хүн өөрийнхөө болон бусдын эдлэх ёстой эрхийг мэдэж, мэдэрч байх явдал нь хүний эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх зайлшгүй урьдчилсан нөхцөл мөн. Хүний эрхийн хэм хэмжээ, тэдгээрийг хамгаалах механизмын талаарх мэдлэг нь өөрийн болон бусдын эрхийг шаардах, хамгаалах чадавхийг бий болгоно.

Дэлхий нийтэд шинэ сорилт, бэрхшээлийг бий болгож буй Ковид-19 цар тахалтай тэмцэх, хүн ам, эрүүл мэнд, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах, эрсдэл багатай даван туулахын тулд улс орнууд хүчин чармайлт гаргаж байна. Монгол Улс энэ хүрээнд тодорхой арга хэмжээг авч, Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай

¹⁷¹Ш.Нарантуяа “Цагдаа ба хүний эрх” УБ., 2010он., 6 дахь тал

хуулийг баталсан. Тус хуулийн хэрэгжилтэд Хүний эрхийн Үндэсний Комисс чиг үүргийн дагуу хяналт тавин ажилладаг байна.

Засгийн газар Ковид-19 цар тахлаас иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн. 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хамтарсан мэдэгдэл хийж, шинэ төрлийн өвчин нь хүнээс хүнд халдварладаг болохыг зарлаж, мөн сарын 26-ны өдөр Засгийн газрын тогтоол гарч, шаардлагатай тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслийн ханган нийлүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хязгаарлаж¹⁷², 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хилийн чанадаас Монгол Улсад зорчих хөдөлгөөнийг хориглох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлжээ¹⁷³.

Үндсэн хэсэг

Амьд явах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрх

“Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно.” (Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалт)

Энэхүү эрх нь хүн бүрт олгогдож буй аж төрөх /амьдрах/ боломж юм. Амьд явах эрх нь хүний амь насыг аливаа хууль бус халдлага, аюул заналхийллээс бүх талаар хамгаалах, хүн хэвийн нэр төртэй амьд явах эрх зүйн хийгээд нийгэмшлийн, эдийн засаг, экологийн болон бусад нөхцлөөр хангах төрийн үүргийг буй болгоно.¹⁷⁴

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хурдацтай тархаж, түргэн хугацаанд хүндэрч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж байгаа уг халдварт өвчнийг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр цар тахал болохыг зарласан юм. 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар коронавируст халдвар дэлхийн 221 улсад бүртгэгдэж, уг өвчнөөр 127349248 хүн өвдсөнөөс 2787593 хүн нас бараад байна.¹⁷⁵

Хүний амь нас, нийтийн эрүүл мэндийг хамгаалах нь Ковид-19 цар тахлын үед баримтлах хүний эрхийн нэн тэргүүний зорилт юм. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлд баталгаажуулсан хүний амьд явах эрхийг ямар ч үед, онц байдал зарласан нөхцөлд ч хязгаарлаж болохгүй¹⁷⁶. Халдварт өвчний үед хүний амь нас, нийтийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн Засгийн газрын үүрэг болохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Хороо тэмдэглэсэн байна¹⁷⁷.

Ковид-19 цар тахлаас хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах талаар Монгол Улс зохих амжилт гаргаж байгаа хэдий ч цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний амь нас хохирсон тохиолдол цөөнгүй гарлаа. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг хязгаарлаж, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал зарласан үед ажил үүргээ гүйцэтгэж буй эцэг эхийн ажил, цагийн хуваарийг оновчтой зохион байгуулаагүйгээс бага насны хүүхдүүд харж хандах хүнгүй

¹⁷² Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол.

¹⁷³ Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоол.

¹⁷⁴ Б.Нармандах “Хүний эрх”. УБ., 2009 он

¹⁷⁵ <https://covid19.who.int/>

¹⁷⁶ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

¹⁷⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Хорооны 2019 оны 36 дугаар Ерөнхий зөвлөмжийн 5, 7, 26 дахь хэсэг.

гэртээ үлдэн ахуйн осолд өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, хөл хорионы үед гэр бүлийн хүчирхийллийн улмаас иргэд нас барсан тохиолдлууд гарсан. Түүнчлэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеэр үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад үүргээ гүйцэтгэх явцад нь тулгарсан гарцаагүй нөхцөл байдлын талаар шийдвэр гаргахдаа хүний амь нас, аюулгүй байдлыг хамгаалахыг нэн тэргүүнд тавих, хүнлэг харьцах чиглэл өгөгдөөгүй, багаар ажиллаж буй хэд хэдэн байгууллагын албан хаагчид хэрхэн шийдвэр гаргах зарчим, чиг үүргийн хуваарилалт, хамтын ажиллагааны уялдаа холбоо, мэдээлэл солилцох суваг тодорхой бус байснаас иргэд эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ авч чадахгүй хугацаа алдсан, нас барсан зэргээр хүний эрхийн ноцтой зөрчил гарчээ.

Баримт

2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн оройн 22 цаг орчим Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороон дахь “Эмээлт” авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтрэхээр Архангай аймгаас ирсэн Приус-30 маркийн автомашинтай 5 том хүн, 2 хүүхэд нийт 7 зорчигч хүрэлцэн ирсэн. Уг 7 хүн 12 дугаар сарын 6-ны өдөр коронавируст халдваргүй гэсэн түргэвчилсэн шинжилгээний хариу авсан боловч ПГУ шинжилгээнд хамрагдаагүй байсан. Тухайн үед Архангай аймагт ПГУ шинжилгээний аппарат байгаагүй. Товчоонд ирэхдээ эдгээр хүмүүсийн нэг 58 настай, иргэн “О”-гийн биеийн байдал тааруу, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай байжээ...

(Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабын удирдлагын багийн гишүүний 2020 оны 12 дугаар сарын 8-ны өдөр хийсэн мэдээлэл¹⁷⁸)

Үүнээс гадна тусгай үүргийн нислэгээр ирж “Корпорейт” зочид буудалд тусгаарлагдаж байсан 39 настай иргэн “Т”, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд хэсэгчилсэн хөл хорионд байсан иргэн “С” өндрөөс унаж, мөн батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болж, “Монголика” зочид буудалд тусгаарлагдаж байсан 70 настай иргэн өрөөндөө нас барсан тохиолдол тус тус гарчээ. Эдгээр золгүй явдлыг гадны нөлөөтэй эсэхийг цагдаагийн байгууллага шалгаж байна. Нөгөө талаас Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий алба хаагчдын хайхрамжгүй байдал, хяналтаа бүрэн тавьж чадаагүй зэрэг нь эдгээрт зохих ёсоор нөлөөлсөн байж болзошгүй юм.

Эрүүл мэндийн хувьд зайлшгүй шалтгааны улмаас Улаанбаатар хотод эмчлүүлэхээр ирсэн иргэнийг шинжилгээнд хамрагдаагүй гэсэн шалтгаанаар олон цаг авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дээр саатуулсны улмаас иргэн эрүүл мэндийн тусламж авч чадалгүй амь насаа алдсан нь Монгол Улсын нэгдэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактын 12 дугаар зүйлийн 2 (d) “...өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх, сувилах нөхцөлийг бүгдэд бий болгох...” гэж заасныг зөрчсөн байна. Хөл хорионы үед зөвхөн нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс хуулийн дагуу хязгаарлалт хийж болох хэдий ч энэхүү хязгаарлалт нь хүний амь насанд хүрсэн, хэр хэмжээнээсээ хэтэрсэн хязгаарлалт болж, хүнд өвчтэй хүнд гарцаагүй шаардлагатай байгаа яаралтай түргэн тусламж, эмнэлгийн үйлчилгээг үзүүлээгүйн улмаас иргэний амь нас хохирчээ. Иймд эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйгээс шалтгаалан хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх, улмаар амьд явах эрх зөрчигдсөн байна.

Халдашгүй, чөлөөтэй байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх

“...Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь

¹⁷⁸ Gogo.mn мэдээллийн цахим хуудас. <https://gogo.mn/r/995v1>

хязгаарлахыг хориглоно...” (Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

“Халдашгүй, чөлөөтэй байх” гэдгийг Хүний эрхийн Хорооны 2014 оны 35 дугаар Ерөнхий зөвлөмжид “чөлөөтэй байх” нь чөлөөтэй ямарваа нэгэн үйлдэл хийхээс илүүтэйгээр бие махбодын хувьд хорих, цагдахаас ангид байхыг илтгэх, “халдашгүй байх” нь бие махбод болон оюун санааны хувьд бүрэн бүтэн, ямар нэг халдлага, дайралтаас ангид байхыг илэрхийлжээ. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур, эсвэл тухайн хүн сайн дураар зөвшөөрөөгүй байхад нийгмээс тусгаарлах аливаа үйлдлээс ангид байх, тусгаарласан эсэхээс үл хамааран ямар нэгэн хүчирхийлэлд өртөх ёсгүй. Иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийн хамгийн гол баталгаа нь төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс хуулийн үндэслэл, нотолгоогүйгээр баривчлахгүй, хорихгүй, эрх эрх чөлөөг нь хязгаарлахгүй байх явдал юм.¹⁷⁹

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох болсон.

Харин 2020 оны байдлаар ялгаварлан гадуурхсан гэх үндэслэлээр 6 эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч шүүхээр шийдвэрлэгдээгүй байна. Иймд Улсын онцгой комисс, Шуурхай штабаас коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ зохион байгуулах, тогтоол шийдвэр гаргахдаа Үндсэн хууль, хууль тогтоомж, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний зарчимд нийцүүлэн ажиллах шаардлагатай байна.

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх”, мөн зүйлийн 5.1.7-д “хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, сэтгэл зүйн дарамт, хохирол учруулж болзошгүй мэдээлэл тараахгүй байх” зарчмуудыг тусгасан. Мөн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарласан шийдвэр, арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг хөндөхгүй, хүнийг ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх шаардлагыг энэ хуулиар тогтоожээ.

Ковид-19 цар тахлын үеэр коронавируст халдвар авсан хүнийг гутаан доромжлох, ялгаварлах, хүнлэг бус хандах тохиолдол гарсаар байна. Энэ нь нийгмийн хэвшмэл хандлага, коронавируст халдварын талаар шинжлэх ухаанд суурилсан үнэн зөв мэдээлэл хүртээмжгүй, халдвар авсан хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байхад чиглэсэн сурталчилгаа, нөлөөллийн ажил хангалтгүйгээс халдвараас айж цэрвэх нийгмийн хандлага зонхилж байна. Мөн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлын зохион байгуулалт тодорхойгүй, хүний эрхийн талаарх ойлголт дутмаг байгаатай холбоотой энэ төрлийн зөрчил үүсэж байгаа юм.

Цар тахлын үед Монгол Улсад хүний эрх хамгийн ихээр зөрчигдсөн талаар хүний эрхийн байгууллагаас мэдээлж буй. Үүний нэг жишээ нь, гадаадаас ирсэн иргэдийг олон хоногоор тусгаарласан шийдвэр байв. УОК-оос өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 10 удаа шийдвэрээ өөрчилсөн ч албажаагүй шийдвэр хэрэгжүүлж, олон мянган хүний эрхийг хязгаарлан, ноцтой зөрчил гаргасан талаар хуульчид судалж тогтоожээ.

¹⁷⁹Б.Нармандах “Хүний эрх”. УБ., 2009он.

УОК-ийн удаа дараалан гаргасан шийдвэрүүд нь хүний эрхийг хүчин төгөлдөр болоогүй шийдвэрээр иргэнийнээ халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн нь илэрхий байна. Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний албан шаардлагад тусгаарлан ажиглах 35 хоног мөрдөгдөж байсан 2020 оны гуравдугаар сарын 26-ны өдрөөс мөн оны арванхоёрдугаар сарын 9-ний өдрийн хооронд Монгол Улсын 24025 иргэнийг гадаад улсаас татан авч, нэр бүхий 40 зочид буудалд тусгаарлан ажиглах арга хэмжээ зохион байгуулсныг дурдсан байдаг. Гэвч, хамгийн харамсалтай нь тухайн үеийн байдлаар гарсан байсан зургаан удаагийн түр журам болон тушаалууд нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлгүй тухай лавлагаа Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсээс 2021 оны есдүгээр сарын 16-ны өдрийн 3-2/65 дугаар лавлагаагаар бүртгэлгүй нь илэрхий болсон байна. Товчхондоо, хуулийн хувьд хүчин төгөлдөр болоогүй шийдвэрээр иргэнийхээ халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн, түүнийг нь Хүний эрхийн үндэсний комисс тогтоогоод байхад хүлээн зөвшөөрөхгүй байгаа¹⁸⁰ хэмээн “Өмгөөллийн фиделитас партнерс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, хуульч, өмгөөлөгч Б.Наранцэцэг ярих.

БАРИМТ

..2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах орон сууцны байрны 00 өрөөг түрээслэгч, иргэн “Х”-ээс коронавируст халдвар илэрч, 11 дүгээр сарын 18-ны өдрийн 5 цагт Халдварт өвчин судлалын үндэсний төвд 10 настай хүүхдийн хамт тусгаарлагдсан. Түүний 4 ба 17 настай хоёр хүүхэд мөн өдөр “Улаанбаатар” зочид буудалд тусгаарлагдсан бөгөөд тэдэнд коронавируст халдвар илрээгүй тул 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 9 цагийн орчимд тусгаарлалтаас гарч, гэртээ ирсэн. Хүүхдүүдийг ирэхэд байранд нь хөл хорио тогтоосон, гэрт нь оруулахгүй байсан тул байрны ойролцоох цагдаагийн байранд түр хоргодон, Халдварт өвчин судлалын үндэсний төвд эмчлүүлж байсан ээждээ энэ тухай хэлсэн. Иргэн “Х” хүүхдүүдээ гэрт нь оруулахад туслахыг байрны “Сууц өмчлөгчдийн холбоо”-ны дарга “Д”-ээс хүсэхэд “танай орцны 16 хүн халдвар авсан учраас оршин суугчид тэднийг гэрт нь оруулахаас дургүйцсэн, байранд хөл хорио тогтоосон” гэжээ. Хүүхдүүдийн талаар мөн өдрийн 10:00 цагт Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт мэдээлэл ирсний дагуу тус газрын алба хаагч “М”-ыг томилжээ. Хүүхдүүдийг тухайн өдрийн 20:00 цагийн орчимд Чингэлтэй дүүргийн хүүхэд хамгааллын байранд шилжүүлэх хүртэл Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны барилгын “Б1” давхарт байрлах ахмадын өрөөнд тусгаарлаж байжээ. Хүүхэд хамгааллын байранд хүүхдүүдийг дахин 14 хоног тусгаарласан... (Хүний эрхийн Үндэсний Комиссын дүн шинжилгээний илтгэх хуудсаас)

Төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг хангалтгүй байгаа нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учруулж байна. Гэрийн тусгаарлалтад байгаа айл өрхийн хаалганд анхааруулах тэмдэг байрлуулах гарцаагүй шаардлагатай, арга хэлбэр нь хүнийг гутаан доромжилсон шинжгүй, энэ арга хэмжээнд хамрагдаж байгаа хүмүүсийг үүсч болох сөрөг үр дагавраас хамгаалсан тохиолдолд хүний эрхийн зөрчил гэж үзэхгүй. Энэхүү хяналтыг хэрэгжүүлэхэд цагдаа, бусад албан хаагчдын нөөц хүрэлцэхгүй, хяналтын оновчтой өөр хувилбар байхгүй тохиолдолд өөрийн, хөршийн болон олон нийтийн хяналт бий болгох үүднээс гэрийн тусгаарлалтын дэглэм сахиж байгаа айл өрхөд таних тэмдэг байрлуулж болно. Гэхдээ тухайн таних тэмдэгт илэрхийлсэн үг хэллэг, дүрс хэлбэр нь айдас түгшүүр төрүүлэхээргүй, хүнийг гутаан доромжилсон, хаяг шошго өгөөгүй байх ёстой. Гэрийн тусгаарлалтад орсон айл өрхийг

¹⁸⁰ “УОК албажаагүй шийдвэрээр иргэдийг олон хоног тусгаарласан” | News.MN

ялгаварлан гадуурхахгүй байх талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэж, эдгээр хүмүүсийн нэр төр, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад байдлаар хохирох эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах ёстой.

Хүний эрхийн хязгаарлалт

“Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй.” (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)

“Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.” (Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

Ковид-19 халдварын цар тахлыг дэлхий нийтээр даван туулж буй цаг үед Монгол Улс коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож эхэлсэн. Энэ хүрээнд зарим байгууллагын үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 01/01 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор хилийн зарим боомтыг түр хааж, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарласан.

Гэхдээ хүний эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах ба Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн гаргах нь зүйтэй юм.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын хязгаарлалт болон татгалзах заалтуудын тухай Сиракузагийн зарчим болон шинжээчийн пактын тайлбарт уг пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хязгаарлахдаа ямар нэг байдлаар ялгаварлахгүй байх; аливаа хязгаарлалт нь нийгмийн, олон нийтийн тулгамдсан хэрэгцээний хариу арга хэмжээ болж, хууль ёсны зорилгоо биелүүлэх ба энэхүү зорилготойгоо эн тэнцүү байх¹⁸¹; улс орнууд хязгаарлалт хийж буй зорилгодоо хүрэхэд шаардлагатайгаас илүүгээр хязгаарлах арга хэрэгсэл ашиглах ёсгүй болохыг анхааруулдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газраас Ковид-19 цар тахлын үед улс орнуудад хандаж гаргасан удирдамжид “Хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод тодорхой аюул заналын эсрэг онцгой байдлын хариу арга хэмжээ авахыг улс орнуудын Засгийн газарт зөвшөөрдөг хэдий зайлшгүй шаардлагатай, аливаа ялгаварлан гадуурхалтгүй байх ёстой. Халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч буй арга хэмжээний зайлшгүй шаардлага үндэслэл, хаана ямар орчин нөхцөлд, хэдий хугацаагаар тусгаарлах арга хэмжээ үргэлжлэх талаар халдвар авсан, халдварын эрсдэл бүхий хүмүүс, олон нийгэд тайлбарлан таниулж, мэдээлэл өгсний дараа тусгаарлах арга хэмжээг авах нь зүйтэй” гэжээ¹⁸².

¹⁸¹ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 2000 оны 14 дүгээр Ерөнхий зөвлөмж, 29 дэх хэсэг, аливаа хязгаарлалт нь “тухайн тулгамдсан асуудалтай тэнцэхүйц...”, “...тодорхой хугацаатай, мөн эргэн хянах үзэх шаардлагатай” байна.

¹⁸² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газраас гаргасан “Ковид-19 удирдамж”, 2020 он.

2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсад коронавируст халдвар дотоодод анх удаа бүртгэгдсэн. Улмаар халдварын тархалтыг хяналтад авах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газар 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол баталж, улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс хүний эрхийг хязгаарлах тохиолдолд авах арга хэмжээ нь зөвхөн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эсвэл өвчтэй, гэмтэж бэртсэн хүмүүст тусламж үзүүлэхэд чиглэгдсэн байх¹⁸³.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор иргэдийн хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэрээс харахад Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 20 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний тухай удирдамж”-д иргэдийг хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хязгаарласан ямар нэгэн заалт байхгүй ч Улаанбаатар хотод иргэдийн зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, хөл хориог мөрдүүлэх шаардлага тавьж байснаар цагдаагийн алба хаагчид болон иргэдийн хооронд үл ойлголцох, зарим тохиолдолд хүч хэрэглэх байдал үүссэн.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хязгаарлалтын дэглэмийг сахиулах хөдөлгөөнт эргүүлд явганаар 7308 алба хаагч, авто эргүүлийн чиглэлд 390 баг, 14 тусгаарлан хамгаалах байр, 31 хяналтын цэгт нийт 900 техник хэрэгсэл бүхий 16907 цагдаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтан, алба хаагчид, Дотоод хэргийн их сургуулийн сонсогчид халдвар хамгааллын болон хязгаарлалтын дэглэм сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан²². Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолын хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамжид заасан хязгаарлалт тогтоохгүй байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд 13 чиглэлийн 1191 байгууллага, эдгээрт хамаарах 70944 ажилтан, алба хаагчид халдвар хамгааллын дэглэмийг сахин, эрх бүхий байгууллагаас баталсан түр заавар, тусгай шаардлагыг баримтлан ажиллажээ¹⁸⁴.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.5-д тус тус зааснаар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлахад тавигдах таван үндсэн шаардлагыг тусгаснаас гадна 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан,

¹⁸³ Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын хязгаарлалт болон татгалзах заалтуудын тухай Сиракузагийн зарчмын 28 дугаар зүйл.

¹⁸⁴ Коронавируст халдвар (Ковид-19)-ын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний явцын 2020 оны тайлан, мэдээ, УБ, 2021 он, 144 дэх тал

бодитой, тохирсон байх ёстой гэж заасныг төрийн бүх байгууллага, алба хаагчид хэлбэрэлтгүй мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Тусгаарлах байр ба хүний эрхийн зөрчил

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт:

4.1.4. “тусгаарлах” гэж халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүн, халдвараар бохирлогдсон сэжигтэй гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмжийг тусгаарлахыг;¹⁸⁵ хэлнэ хэмээн заасан байна.

Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийн дагуу Шадар сайд 2020 оны 3 дугаар сарын 14-ний өдөр “Коронавируст халдвар (Ковид-19)-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам”-ыг баталжээ. Уг журмаар коронавируст халдварын голомт бүхий орноос эх орондоо агаарын болон төмөр зам, авто замаар ирсэн иргэд хилээр нэвтрэх үед эрүүл мэндийн тандалт судалгаа хийх, халдварын сэжигтэй зорчигчийг түр тусгаарлан үзлэг хийх, эмнэл зүйн шинж тэмдэггүй иргэдийг 14 хоног тусгаарлан ажиглах, мөн тусгаарлан ажиглах байрны нөхцөл, хоол хүнсний үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, тусгаарлан ажиглах байранд хүргэх, тус байрны хамгаалалт, хэв журам сахиулах зэрэг харилцааг зохицуулан зааж өгсөн.

Тусгаарлах, хөл хорионы дэглэм сахиулах чиг үүрэгтэй байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, хүн хүчний хүрэлцээ муу, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар тодорхой биш байснаас үүдэн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас иргэдийн халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдсан тохиолдлууд гарчээ. Улсын онцгой комисст арванхоёрдугаар сарын 31-ний өдөр гурав дахь удаагаа сунгасан цар тахлын тухай хуулийн наймдугаар зүйлийн 8.1.8 дахь заалтаар “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний талаар холбогдох тушаал гаргах, дүрэм, журам, заавар, удирдамж батлах” эрх олгосон. Судалгаа, шинжилгээ хийлгүй баталсан энэ хуулиар Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Улсын онцгой комисс зэрэг байгууллагад хэм хэмжээний акт батлах эрх олгосноос цар тахлын үеийн хүний эрхийн зөрчил ихээр гарах болсон байна.

Улсын онцгой комиссын зүгээс тусгаарлах үйл ажиллагааг анх тусгаарлах байранд 21, гэрийн тусгаарлалтад 14, нийт 35 хоногоор тогтоосныг 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс тусгаарлах байранд 14, гэрийн тусгаарлалтад 7, нийт 21 хоног, 2021 оны 2 дугаар сарын 25- ны өдрөөс тусгаарлан ажиглах хугацааг нийт 14 хоног байхаар тус тус өөрчилсөн.

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаалаар “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах “түр журам”-ыг баталсан. Уг журмаар коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа халдвар хамгааллын дэглэм сахих, халдваргүйжилт хийх шаардлага, дагаж мөрдөх хэм хэмжээг зааж өгсөн байна. Улсын онцгой комиссын шийдвэрээр гадаадаас ирсэн Covid-19 халдварын шинж тэмдэггүй иргэнийг 35 хоног тусгаарлах болсон шийдвэр нь иргэд, нийтийн эрх ашгийг хөндсөн байж болзошгүй талаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх дээр хэрэг үүссэн байна. Дэлхийн бусад улс орны хувьд ДЭМБ-аас гаргасан 7-14 хоног тусгаарлах удирдамжийн дагуу Австри, Швейцарь, Бельги, Герман, Норвеги, Литва, Словак болон Словени улсууд гадаадаас ирж буй

¹⁸⁵ www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт :...

иргэдээ 10 хоног, Франц, Болгар, Итали, Латви, Нидерланд болон Турк улс 14 хоног тусгаарлан ажигласан байна. Үүнээс үзэхэд манай улс нь иргэд олон нийтийн эрх ашгийг хүндэтгэх, хүнлэг, энэрэнгүй байх байдал нь аль аль талдаа тутмаг байгаагын илрэл юм.

БАРИМТ

"Сүнжид гранд" зочид буудалд 2021оны 12 дугаар сард тусгаарлагдсан иргэн Б-ийн тусгаарлах байрны талаарх ярилцлага.

-Өвлийн хүйтэнд бага насны хүүхдүүд даарч, зарим нь бүр уйлж байсан. Даарсан хүмүүст юун халдвар хамгааллын дэглэм сахих, хурдхан дулаан газар орохыг л бодно. Тэнд халдвар хамгааллын дэглэм сахиулж байгаа нэг ч хүн байхгүй. Хэрэв тэнд Covid-19 халдвартай хүн байсан бол яах вэ. Урт дараалалд зогссоор зочид буудалдаа арай гэж орсон ч зөвхөн нэг өрөөнд нэг л хүний ариун цэврийн хэрэглэлтэй. Гэр бүлээрээ нэг өрөөнд орсон ч ариун цэврийн хэрэглэл нь ганцхан. Дээрээс нь өрөөнүүд нь ариун цэврийн шаардлага хангаагүй, хоол нь хүйтэн, бас уух усгүй. Бид хоногийн мөнгөө төлж буй. Гэтэл бидэнд ариун цэврийн хэрэгсэл байхгүй, хүйтэн хоолтой, ямар ч зохион байгуулалтгүй л угтаж авлаа. Хоёр жилийн хугацаанд Covid-19-тэй тэмцэж, тусгаарлах гээд бүх улс оронд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Яагаад монголчууд ийм хариуцлагагүй байдаг юм бэ. Яагаад одоо болтол зохион байгуулалттай, иргэдэд хүндрэл учруулахгүй тусгаарлах үйл ажиллагааг зохион байгуулж чадахгүй байна вэ. Бүтэн хоёр жилийн хугацаа өнгөрсөн шүү дээ. Үнэхээр харамсалтай байна. Энд лав хүнд үйлчилж байгаа гэхээс илүү ял үүрчихсэн юм шиг хандлагыг л мэдэрч байна¹⁸⁶ хэмээн бухимдан хэлснээс үзвэл иргэдийн нүүрэн дээр ямар нөхцөл байдалтай, үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхүүд нь зөрчигдөж, үүн дээр хэн ч хариуцлага хүлээхгүй, ямар ч шийдвэр гаргахгүй байсаар олон хүмүүсийн эрх зөрчигдөж байна.

Коронавируст халдварын нөхцөл байдлын улмаас эрх нь зөрчигдсөн талаар 2020 оны 5 дугаар сарын 4-ний өдрөөс хойш Хүний эрхийн Үндэсний Комисст хандан нийт 166 гомдол, мэдээлэл ирсний 11 нь тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуйн нөхцөл, хоол хүнсний чанар, тусгаарлах хугацааны талаарх гомдол байсан. Түүнчлэн Комиссын хууль зүйн зөвлөгөө өгөх 7000-0222 дугаарын утсанд дээрх холбогдох санал, хүсэлт, мэдээлэл иргэдээс олонтоо ирсэн нь бодит нөхцөл байдал ямар байсны тод илрэл юм.

Хол хорио ба гэр бүлийн харилцаа дахь хүчирхийлэл, жендерийн тэгш бус байдал

“Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй эрх тэгш байх үндсэн дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэх баталгааг олгох зорилгоор тэдний бүрэн хөгжил, дэвшлийг хангахын тулд бүхий л салбарт, тухайлбал улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авна.” (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 3 дугаар зүйл)

Дэлхий даяар тархаад буй COVID-19 шинэ халдвараас сэргийлэхийн тулд улс орнууд тусгаарлах, хол хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай зэрэгцэн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх нь өсөж, тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгджээ. Учир нь хүчирхийлэл үйлдэгчтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг гэрт нь тусгаарлах нь тэдэнд тусалж чадах хүмүүс, боломжоос нь холдуулж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас тусламжийн утасны үйлчилгээ, хоргодох байраар хангах хэрэгцээ нэмэгдэж байгаа талаар Аргентин, Канад, Франц, Герман, Испани, Нэгдсэн

¹⁸⁶ "Тусгаарлах байр яг хорих байр шиг байна" | News.MN

Вант Улс, АНУ-ын засгийн газрын эрх баригчид тэмцэгчид, иргэний эмэгтэйчүүдийн эрхийн байгууллагууд тайландаа тэмдэглэсэн байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг мөн бөгөөд тэдгээрт дийлэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд хохирогч болдог судалгаа бий. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын мэдээлснээр дэлхий дээр 2020 оны сүүлийн 12 сарын хугацаанд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртжээ.¹⁸⁷

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газрын шинжээчид болон олон улсын хүний эрх хамгаалагчдын гаргасан хэвлэл мэдээллийн тойм, албан ёсны мэдэгдэл, мэдээллээс үзэхэд гэрийн хорио болон бусад зорчих эрхийг хязгаарласан арга хэмжээ нь жендерт суурилсан хүчирхийллийг нэмэгдүүлдэг болохыг тогтоож, тус газраас 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Жендерт суурилсан хүчирхийлэлд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн талаар болон оролцогч талуудын авч болох зарим чухал арга хэмжээний талаарх зөвлөмжийг гаргасан. Тус зөвлөмжид “... цар тахлын хөл хорионы үед гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэйгээ нэг орчинд тусгаарлалтад ордог учраас илүү хяналтад орох, цагдах нөхцөл бүрддэгээс хохирогч тэр бүр утсаар цагдаад дуудлага өгч, тусламж авч чаддаггүй тохиолдлууд их гарч байна. Иймд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч дуудлага өгөх, тусламж хүсэхэд тусгайлсан аргыг бий болгох, хохирогчдод шаардлагатай үйлчилгээ, тухайлбал хамгаалах байрны тоог нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ, цагдаа, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагааг цалгардуулахгүй байх, яаралтай тусламжийн шууд утасны үйлчилгээний хүрэлцээ, тоог нэмэгдүүлэх” талаар улс орнуудад зөвлөжээ.

Өнөөдөр манай улсад COVID-19 цар тахал гарсантай холбоотойгоор хорио цээрийн дэглэмтэй байгаа өдрүүдэд ахуйн хүрээний архидалтаас үүдсэн гэр бүлийн хүчирхийлэл анхаарахгүй өнгөрч болохгүй асуудал болжээ.¹⁸⁸

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (16.7%, 52)-үүд дийлэнх хувийг эзэлж, гэр бүлийн хүчирхийллийн талаас илүү хувь нь согтуугаар үйлдэгдэж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 2017 онд 4369 бүртгэгдсэн бол 2018 онд 5821 болж, 33.23 хувиар өссөн, 2019 оны эхний 2 сарын байдлаар 1285 бүртгэгдсэн тоон үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг төдийлөн буурах хандлагагүй, энэ талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллага хоорондын үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага буйг харуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний гурван сарын байдлаар 388 бүртгэгдсэн нь өмнөх жилийн мөн үеэс 39 хувиар өссөн, энэ төрлийн дуудлага, мэдээлэл 11300 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй адил байна. Харин зөрчил 2777 бүртгэгдсэн нь өмнөх жилийн мөн үеэс 18 хувиар буурчээ. Хөл хорио тогтоосон 2021 оны дөрөв дүгээр сарын 10-ны өдрөөс хойш дол дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд цагдаагийн байгууллагын 102 дугаарын утсанд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 1365 дуудлага ирсэн байна.¹⁸⁹

Засгийн газрын шийдвэрээр улсын хэмжээнд арван нэгдүгээр сарын 11-ээс арван хоёрдугаар сарын 14-нийг хүртэл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн. 2020 оны эхний 11 сарын байдлаар хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага Баянзүрх дүүрэгт хамгийн өндөр буюу 9082 бүртгэгдсэн байна. Сонгинохайрхан

¹⁸⁷ Гэр бүлийн хүчирхийлэл. Статистикийн тойм. УБ., 2020он., 2 дахь тал

¹⁸⁸ Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль. 2020 он

¹⁸⁹ <https://police.gov.mn/as/article/>

дүүрэгт 8721, Чингэлтэй дүүрэг 3730, Сүхбаатар дүүрэгт 3260, Багахангай дүүрэгт 27 бүртгэгдсэн байна.¹⁹⁰

2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1138 болж өмнөх оны мөн үеэс 153 хэргээр буюу 15.5 хувиар өссөн байна. Мөн 2020 оны 12 дугаар сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 94 байсан бол 2021 оны 1 сард 120 болж, 2020 онтой харьцуулахад огцом өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 2019 онд 8, 2020 онд 18, 2021 оны эхний 2 сарын байдлаар 1 бүртгэгдсэн байх бөгөөд тухайн хэрэг бүртгэгдсэн нь туйлын харамсалтай юм.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөр 2020 онд 1795 хүн үйлчлүүлсэн нь өмнөх оноос 56 хувиар өссөн. Үүнээс түр хамгаалах байраар 233 хүн үйлчлүүлсэн нь өмнөх оноос 12.9 хувь, итгэлтэй утас болон цахим зөвлөгөөнд 1377 үйлчлүүлэгч хандсан нь 30 хувиар тус тус өссөн боловч түр хамгаалах байр, итгэлтэй утасны зөвлөгөө өгөх үйлчилгээнд 2021 онд төрөөс тусгайлан санхүүжилт хуваарилаагүй байна.¹⁹¹

Хөл хорио тогтоосон хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой хэрхэн холбогдож ажилласан эсэхийг тодруулахад 48.6 хувь нь биечлэн уулзсан, 44 хувь нь гар утас ашиглан холбогдсон, 7.4 хувь нь цахимаар холбогдсон байна. Хөл хорионы үед нөхцөл байдлын үнэлгээ хийсэн эсэхийг тодруулахад 63.4 хувь нь биечлэн уулзаж, 14.8 хувь нь утсаар, 21.8 хувь нь хөл хорионы үед үнэлгээ хийх боломжгүй байсан гэж хариулжээ.

Дээрх тоо баримтаас үзэхэд Ковид-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэж улмаар хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо өссөн байна. Үүнд Ковид-19 цар тахлын улмаас нийгэм эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж, ядуурал, ажилгүйдэл нэмэгдсэн, хүмүүсийн орлого буурч, иргэдийн амьдралын ердийн хэв маяг өөрчлөгдөж, стресс бухимдал нэмэгдсэн нь нөлөөлсөн байж болзошгүй юм.

Хөл хорио тогтоосон хугацааны эхэн үед гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл 2 дахин, дараагийн хөл хорионы үед бага зэрэг буурчээ. Үүнд Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12- ны өдрийн А/1242 дугаар захирамжаар согтууруулах ундаа худалдахыг хориглосон нь нөлөөлсөн байж болзошгүй байна. Нөгөө талаас гэр бүлийн хүчирхийлэл илүү далд хэлбэрт шилжсэн байх магадлалтай гэж салбарын мэргэжилтнүүд дүгнэжээ. Түүнчлэн хөл хорионы хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийн тоо буурсан нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг илүү удаан хугацаанд хүчирхийлэгчийн хяналтад байлгаж, тусламж авах боломжийг нь хязгаарлах, гэр бүлийн хүчирхийлэл далд хэлбэрт шилжих нөхцөлийг бүрдүүлж байна гэсэн дүгнэлтийг баталгаажуулж байна.¹⁹² Иймд Ковид-19 цар тахлын үед энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийн дуудлага мэдээллийг хүлээн авах, үр дүнтэй хариу арга хэмжээ авах, далд хэлбэрт шилжсэн хүчирхийллийг эрт шатанд илрүүлэх оновчтой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Дүгнэлт

Нийтийн аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай онцгой нөхцөл байдал үүссэн, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зэрэг зайлшгүй тохиолдолд олон улсын эрх

¹⁹⁰ Police.gov.mn

¹⁹¹ Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэдээлэл, 2020 оны 3 дугаар сар

¹⁹² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны "Ковид-19 цар тахлын Жендэрт суурилсан хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийлэл түүний хохирогчдод үзүүлэх үйлчилгээнд үзүүлэх түргэвчилсэн үнэлгээ"- ний тайлан, УБ, 2020 он.

зүйн хэм хэмжээнд заасны дагуу хүний эрхийг хязгаарлахыг хүлээн зөвшөөрдөг. Гэвч энэ нь бодит нөхцөл байдал дээрээ зохих түвшинд буй тал дээр хяналт, зохион байгуулалт чанд сайн байх шаардлагатай юм.

Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэр нь хүний эрхийн суурь зарчимд нийцсэн, ялгаварлан гадуурхалтгүй, эрх тэгш хандсан байх ёстой. Гэвч Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй шийдвэр, үйл ажиллагааны талаар иргэдэд нээлттэй ил тод мэдээлэл өгөхгүй байх, шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх удирдамж, зааварчилгаа удаа дараа өөрчлөгдөж байгаагаас хүний эрхийн зөрчил үүсэх, ялгаварлан гадуурхалт гарах нөхцөл байдал бий болж байна. Мөн төрийн албан хаагчдын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хувийн мэдээлэл алдагдаж, олон нийтэд түгээсний улмаас ялгаварлан гадуурхагдсан тохиолдол цөөнгүй гарсан.

Тусгаарлан ажиглах арга хэмжээ нь иргэний чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах боловч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, халдашгүй чөлөөтэй байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрхийг хязгаарлахгүй болно. Иймд коронавируст халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг тусгаарлах, тээвэрлэх явцад хүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэх, аливаа хэлбэрээр гутаан доромжилсон, хүнлэг бус, хэрцгий харьцахыг хориглох талаар төрийн зүгээс анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

Улсын онцгой комисс болон холбогдох байгууллагаас өгч буй мэдээлэл уялдаа холбоогүй, шийдвэрийн агуулга, үйлчлэх хэм хэмжээ, тогтоосон хязгаарлалт нь иргэдийг төөрөгдүүлсэн, мөн хяналт тавьж байгаа албан хаагчдад баталсан шийдвэр, журам, заавраар тогтоосон хэм хэмжээний зохицуулалтын талаар нарийвчилсан мэдээлэл, удирдамж чиглэл хүргүүлж ажиллахгүй байгаа нь хүний эрхийн зөрчил гарах үндсэн нөхцөл болж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор тодорхой байгууллага, хяналтын цэгийн нөхцөл байдалтай танилцаж, Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн талаар ахиц дэвшил гаргахад чиглэсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлэн ажиллах шаардлагатай байна.

Санал

- Иргэдийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх суртал ухуулга, сонин сэтгүүл, цахим орчинд мэдээлэл хангалттай хэмжээгээр түгээх
- Цагдаагийн алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалтыг улирал бүр зохион байгуулах
- Төрийн албан хаагчдын сургалт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарах, чадварлаг шинэ боловсон хүчин бэлтгэхэд анхаарах хэрэгтэй байна.
- Хууль тогтоомжийн хэрэгжилт болон боловсруулалтад төр иргэдийн зүгээс хяналт тавьдаг байхад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах
- Олон улсад хэрэгжүүл буй арга хэмжээ, эрх зүйн орчин судалж өөрийн орны онцлогт тохируулан үлгэр жишээ авч хууль зүйн орчин, сургалт үйл ажиллагааг явуулах.

Ашигласан материал

- 1.Монгол Улсын Засгийн газрын тогтоол
- 2.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

- 3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Хорооны 2019 оны 36 дугаар Ерөнхий зөвлөмжийн 5, 7, 26 дахь хэсэг.
- 4.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газраас гаргасан “Ковид-19 удирдамж”, 2020 он.
- 5.Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын фактын хязгаарлалт болон татгалзах заалтуудын тухай Сиракузагийн зарчмын 28 дугаар зүйл.
- 6.Коронавируст халдвар (Ковид-19)-ын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний явцын 2020 оны тайлан, мэдээ, УБ, 2021 он, 144 дэх тал
- 7.Улсын Онгой Комиссын шийдвэр
- 8.Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын хүний эрхийн цуврал илтгэлүүд
- 9.Б.Нармандах “Хүний эрх”. УБ., 2009он
- 10.Монгол улсын үндсэн хууль
- 11.Ш.Нарантуяа “Хүний эр ба цагдаа”. УБ., 2010он
- 12.Хүний эрхийн түгээмэл тунхаг
13. Д.Сэржмядаг. “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч”, УБ., Монгол улс.
14. Монгол Улсын Үндсэн хууль //legal info.mn//
- 15.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нэгдүгээр бүлэг, 3 дугаар зүйл,

--oOo--

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

THE RIGHT AND FREEDOM OF PUBLIC INFORMATION AND ITS LEGAL REGULATION

А.Мөнхцэцэг

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч

Munkhtsetseg.A

University of Internal Affairs of Mongolia, Law and Social
Science School, Department of Social Science, Instructor

Товч агуулга: Олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, харьцуулан судлах.

Abstract: Analyzing legal regulations providing public rights to get information, comparative study.

Түлхүүр үг: Олон нийт, Хэвлэл мэдээллийн байгууллага, эрх чөлөө, Нэгдсэн Үндэстний Байгууллага;

Key words: Public, press organizations, freedom, united nations;

Оршил

Хэвлэл мэдээллийн байгууллага иргэдийн мэдэх эрхийг хангах, үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангагдахын тулд нэн тэргүүнд шаардлагатай зүйл бол мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөө юм.

Манай улс НВБ-аас 1948 онд тунхаглан зарласан "Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал"-ын үзэл санааг хүлээн зөвшөөрсөдөг, Мөн "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт"-ад /1966 он/ 1974 онд нэгдэн орсон байгаа. Үүгээрээ Монгол улс дээрх чухал баримт бичгийн хүний эрх, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг дагаж мөрдөнө гэж хүлээн зөвшөөрсөн байдаг.¹⁹³

Үндсэн хэсэг

Манай улсад 2016 оны 12 дугаар сарын 01-нд батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хууль 2017 оны 09 дүгээр сарын 01- нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 1995 онд баталсан Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчингүй болсон юм.¹⁹⁴ Хүчингүй болсон Төрийн нууцын тухай хууль нь аливаа Мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур зарчим, нууцлах мэдээллийн хүрээ, ангиллыг хэт ерөнхий тодорхойлсон учир "төрийн нууц"-ын халхавчаар иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг хязгаарлах боломж нээлттэй байсаар байгааг судлаач, иргэний нийгмийн байгууллагынхан нилээн шүүмжилж ирсэн.

Гэвч шинээр баталсан "Төрийн болон албаны нууцын тухай хууль"-д энэхүү сул талыг залруулаагүй бөгөөд, харин "Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль"-д багтаж байсан, нууцад хамааруулах мэдээллийн ерөнхий хүрээг яльгүй өөрчилж шинэ хуульд оруулжээ. Мөн аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулахад удирдлага болгох Үндсэн шалгуур өмнөх хуульд хэт ерөнхий томъёолсон байсныг өөрчлөөгүй, “хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх” гэсэн хуучин зарчмаа хуулбарлан хадгалжээ. Ингэснээр тодорхой мэдээллийг хуулийн дагуу нууцалсан эсэхийг хянах явдал бэрхшээлтэй байхаас гадна төрийн нууцын хүрээ өмнөхийн адил хэт өргөн хэвээр үлдэх юм.

Нууцалж болох мэдээллийн шалгуурыг хэт ерөнхий байдлаар томъёолсон, нууц мэдээллийн жагсаалтыг нийтэд ил болгох механизмыг баталгаажуулаагүй нөхцөлд нууцын тухай хуулийг буруугаар ашиглах, нууцлалд хамааруулах шаардлагагүй буюу тэр бүү хэл нийтэд заавал ил байх ёстой мэдээллийг санаатайгаар болон санамсаргүйгээр нууцлах хандлага гардаг юм.¹⁹⁵ Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс Тус улсын хувьд "Тухайн мэдээлэл (эд зүйл) нь төрийн өмчлөлд байх, эсвэл төр, түүний байгууллагаас эсвэл төрийн байгууллагын даалгавраар, эсхүл түүний хяналт дор бүтээсэн байх шалгуур нь мэдээллийг нууцад хамруулах үндсэн болзлын нэг байдаг.

Туркменистан Тус улсын хувьд тахлаар өвчилсөн тохиолдлуудыг төрийн нууцад хамруулсан байна.

Улс Тажикстан Улс Тус улсын хувьд 2003 оны эдийн засгийн өсөлтийн тухай мэдээллийг хамруулсан байна. Үүнээс үзэхэд нууц мэдээллийг зөвхөн шаардлагатай хэмжээнд хязгаарлах үүднээс нууцалж болохгүй мэдээллийн жагсаалтыг Нууцын тухай Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажуулдаг олон улсын практик түгээмэл байна.

Нууцалж болохгүй мэдээллийн жагсаалтад гол төлөв хүний эрхийн зөрчил болон байгаль, хүрээлэн буй орчинд учруулж буй аюул, хохирлын талаарх мэдээлэл

¹⁹³ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дэх хэсэг

¹⁹⁴ Төрийн мэдээлэл Төрийн болон албаны нууцын тухай хууль 2017 он.

¹⁹⁵ Мөнхмандах М., Иргэний мэдэх эрх ба төрийн нууцын зохицуулалт. Судалгааны тайлан. Нээлттэй Нийгэм Форум. УБ., 2010

багтдаг. Жишээ нь: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу хүний эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг нууцлах боломжгүй.¹⁹⁶

Түүнчлэн НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын /UNECE/ Мэдээлэл хүртэх, шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах конвенц, Байгаль орчны асуудлаар шударга байдлыг хангах конвенцийн дагуу олон нийтийн эрүүл мэндэд болон байгаль орчинд учирч болзошгүй аюул заналхийллийн тухай мэдээллийг нууцлахыг хориглодог¹⁹⁷.

Харин 2014 онд Монгол Улсын Засгийн газраас Нууц мэдээллийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулж байсан бөгөөд тэрхүү хуулийн төсөлд иргэдийн амь бие, эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлсэн гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, осол, сүйрэл болон бусад онцгой нөхцөл байдлын тухай; эрүүл мэнд, халамж, боловсрол, хүрээлэн буй орчин, нийгэм, хүн амын байдал, соёл, хөдөө аж ахуй, нийгмийн судалгааны талаарх статистик мэдээ; хүнсний бүтээгдэхүүн, ахуйн эд зүйлийн чанарын тухай; хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн тухай; төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай болон тэдний хууль бус үйл ажиллагааны тухай зэрэг мэдээллийг нууцалж үл болох тухай санал дэвшүүлсэн нь олон улсын практикт нийцэж байв. Гэвч энэхүү дэвшилттэй саналыг шинээр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд харгалзалгүй орхигдуулсан юм.

Нөгөө талаар, "Мэдээллийг хамгаалалттайгаар ил болгох" (Protected disclosure) тухай олон улсын хэмжээнд түгээмэл болж буй зохицуулалт Монголын холбогдох хуульд үгүйлэгдэж буйг дурдъя. Энэ нь нууцлагдсан мэдээлэл дараах төрлийн аль нэгэнд багтаж байвал нууцлалын төрөл, зэрэглэлийг үл харгалзан (эхний ээлжинд салбарын хэмжээнд) ил болгож болох тухай заалт юм. Үүнд:

- Төрийн байгууллага, албан хаагчийн ;
- Гэмт хэргийн шинжтэй үйлдэл;
- Хүний эрхийн зөрчил;
- Олон улсын хүмүүнлэгийн хууль журмын зөрчил;
- Авлига;
- Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулсан үйлдэл;
- Байгаль орчныг сүйтгэх, аюулд учруулах үйлдэл;
- Улсын нөөцийг буруу ашигласан, гарз хохирол учруулсан;
- Дээрх үйлдлийн талаарх мэдээллийг ил болгосны төлөө өширхөх үйлдэл;
- Дээрх үйлдлийн талаарх мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан тухай мэдээлэл тус тус багтдаг.

Ийм төрлийн мэдээллийг төрийн байгууллага дотор хүлээн авч шийдвэрлэх дотоодын механизмыг бий болгох, шаардлагатай үед хараат бус хяналтын байгууллагад шилжүүлж мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах эрх мэдэл, үйл ажиллагааг хуульчилж өгөх нь чухал юм. Шинээр баталсан хуульд “Төрийн нууц”-аас гадна албаны нууц гэх ангилал нэмж багтаасан нь иргэдийн болон хэвлэл мэдээллийн мэдээлэл авах эрх чөлөөг хязгаарлах заалт болж буй юм.

“Албаны нууц” ны зөвхөн төрийн байгууллагад хамааралтай бөгөөд хувийн болон төрийн бус бусад байгууллага өөр өөрсдийн нууцыг Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу тодорхойлж, хамгаалах боломжтой хэвээр байх аж “Албаны нууц” гэж "салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд

¹⁹⁶ The UN Working Group on Arbitrary Detention⁸ Recommendation: Human Rights and State Secrets, E/CN.4/2001/14, 20 December 2000

¹⁹⁷ Олон улсын Хүний Эрхийн конвенц

хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг” хэлнэ хэмээн тодорхойлсноос өөр ямар нэгэн тусгайлсан шаардлага, шалгуур, үндэслэл, хугацаа тогтоогоогүй, ийм төрлийн нууцыг төрийн нууцтай ижил түвшинд ангилж, хадгалж, хамгаалахаар зохицуулсан нь мэдээллийн эрх чөлөөг хангах олон улсын зарчим, практикийг илт зөрчиж байна.

Мөн 2013 онд Өмнөд Африкийн Чуэинд баталсан Үндэсний аюулгүй байдал, мал авах эрхийг хангах олон улсын зарчимд (цаашид Чуэнийн зарчим гэх) зөвхөн улс Үндэстний аюулгүй байдал, ардчиллыг хамгаалах, олон нийтийн ашиг сонирхол болон хувийн нууцыг хамгаалах зайлшгүй шаардлагатай нөхцөлд мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж болно гээд, зайлшгүй шаардлагатай байх нөхцөл нь дараах шалгуурыг хангасан байна гэж заасан байдаг. Үүнд:

1. Задруулбал үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхолд бодитой хохирол учруулах эрсдэлтэй хохирлыг тодорхойлж хэмжих боломжтой байх;

2. Задруулснаас үүсэх хохирол нь олон нийтийн мэдэх эрхийг хангах шаардлагаас давамгайл байх;

3. Нууцлалын түвшин нь хохирлыг багасгахад зайлшгүй шаардлагатай хязгаарлалтын хамгийн доод хэмжээнд байх;

Өөрөөр хэлбэл улс үндэстэн, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах явдал мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах үндэслэл байж болохоос биш, байгууллага бүр өөрийн ашиг сонирхолд нийцүүлж мэдээллийг нууцлах нь ардчиллын зарчимд, мэдээлэл авах хүний эрхэд шууд харш юм.

Үүний зэрэгцээ Төрийн болон албаны нууцын тухай шинэ хуулийн дагуу хувь хүн, хувийн болон төрийн бус байгууллагын эзэмшилд буй мэдээллийг “нууцлах шаардлагатай гэж үзвэл” төрийн нууц болгож, төрийн өмчид авч болох тухай заалт орсон нь иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг шууд зөрчих, мэдээллийг нууцлах үйл ажиллагааг зайлшгүй шаардлагатай бөгөөд үндэслэлтэй хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэх үндэс суурийг тавьж байна. Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагаас 2007 онд гаргасан Зөвлөмжид “Хувь хүн, хувийн байгууллагын бүтээсэн, тэдний эзэмшиж буй мэдээллийг төрийн нууцад хамруулах ёсгүй” гээд, зөвхөн гэрээт харилцаа бүхий байгууллагаас гэрээний үндсэн дээр бий болгосон мэдээллийг хуулийн хүрээнд нууцлах тухай заасан байна.

Түүнчлэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6.2-т “Нууц мэдээлэлтэй танилцсан эсхүл мэдсэн Монгол Улсын төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад хуулийн этгээд, улс төрийн нам, хөдөлгөөн, төрийн бус байгууллага, албан тушаалтан Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн нууц мэдээллийг хамгаалах үүрэгтэй” хэмээн заасан бөгөөд хууль зөрчсөн иргэнд эрүүгийн, иргэний, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэх юм.¹⁹⁸

Нууц мэдээллийг мэдсэн энгийн иргэнд тухайн нууцыг хамгаалах үүрэг оноож буй нь олон улсын зарчимд нийцэхгүй бөгөөд энэхүү заалтад сэтгүүлчид нэн тэргүүнд өртөх магадлалтай юм. Энэ талаарх олон улсад баримталж буй Чуэнийн зарчмын 47-д “Төрийн байгууллагад ажилладаггүй иргэнд нууц мэдээллийг хүлээн авсан, эзэмшилдээ байлгасан, ил болгосны төлөө хариуцлага тооцохгүй” гэсэн байдаг.¹⁹⁹

¹⁹⁸ Төрийн мэдээлэл Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6.2 дахь хэсэг

¹⁹⁹ Чуэнийн зарчмын 47 дэх хэсэг

Олон улсын туршлага, экспертийн зөвлөмжүүдээс харахад Мэдээллийг нууцлах, ил болгох ажиллагааг хянах үүрэг бүхий хараат бус байгууллага бий болгоход онцгой ач холбогдол өгдөг.

Ийнхүү хяналтын үүргийг гүйцэтгэх байгууллага нь Засгийн газар, тагнуулын байгууллага мэдээллийг нууцлах, нууц мэдээллийг хамгаалах эрх, үүрэг бүхий бусад байгууллагаас хараат бус байх, хянах үүргээ гүйцэтгэх эрх зүйн чадамж, санхүү, хүний нөөц, техник технологийн боломжтой байх ёстой. Гэтэл Төрийн болон албаны нууцын тухай хуульд мэдээллийг хуулийн хүрээнд, үндэслэлтэйгээр нууцалсан эсэх, тийнхүү нууцлах нь зайлшгүй шаардлагатай байсан эсэхийг хянах механизмыг бүрэн орхигдуулсан бөгөөд гагцхүү нэгэнт нууцалсан мэдээллийн ашиглалт, хамгаалалтыг Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн байгууллага, албан тушаалтан болон Тагнуулын байгууллага хянах үүрэгтэй байхаар зохицуулжээ. Хуулийн 19.1-д Мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон тохиолдолд ил болгох тухай заасан хэдий ч, үндэслэлгүйгээр нууцалсан эсэхийг хянах субъект, түүний эрх үүрэг, хариуцлага, бие даасан байдлыг хуульчлаагүй учир энэхүү заалт хэрэгжих магадлал бага байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зэрэгцээ өндөр албан тушаалтнуудын харилцаа холбоо болон захидал харилцааных нь нууцыг хамгаалах тухай тусгай заалтууд Ерөнхийлөгчийн тухай, УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын тухай, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд тусгагдсан бөгөөд энэхүү нууцад чухам юуг хамаатуулж болох нь одоо ч тодорхойгүй байна.

Дүгнэлт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 19 дүгээр зүйлд хүний үзэл бодлоо хэлэх эрхийг тунхаглан баталгаажуулсан.

Мөн тус Пактын 20 дугаар зүйлийн 2-т “Алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглоно” гэж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хязгаарлалтын зохих шаардлагыг тусгаж өгсөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14.1-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” хэмээн зааж, хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэйг тунхагласан байдаг.

Хэвлэл мэдээлэл, нийгмийн мэдээллийн сүлжээн дэх мэдээллийг төрөөс, хуулиар зохицуулах нь нэг талаас түүнд өртөж байгаа хүн, хүмүүсийн эрхийг хамгаалах мэт боловч нөгөө талаас үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хязгаарлахгүй байх ёстой юм. Олон нийтийн мэдээлэл авах эрхийг зөрчихгүй байх шаардлагатай байна.

Санал:

-Олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах хүрээнд эрх зүйн орчныг сайжруулах;

-Олон нийтийн мэдээлэл авах эрхэд хөндлөнгөөс халдахгүй байх;

-Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хаалтын гэрээ хийхгүй байх, тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөл боломжийг хуулийн хүрээнд хангах гэх мэт.

Ашигласан материал

1. Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа. УБ., 2019 он
2. Болд-Эрдэнэ.Д, Олон нийтийн харилцаа. УБ., 2006 он
3. Төрийн мэдээлэл” эмхэтгэл. УБ., 2010 он

- 4.Хэвлэлийн Хүрээлэн”, УБ., 2021 он
5. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал
6. Төрийн болон албаны нууцын тухай хууль
7. Өмнөд Африкийн Чүэйднд баталсан зарчим

--o0o--

ЭКОЛОГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА.

LEGAL PROTECTION OF THE ENVIRONMENT,
EXPERIENCE OF SOME FOREIGN COUNTRIES.

И.Ургамал

ЭЗНУС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн
дэд профессор, Цагдаагийн ахмад

I.Urgamal

Associate Professor of Public Law Department,
Police captain

Хураангуй:

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан бөгөөд байгалийн объектуудыг хамгаалах, нөгөө талаас хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, түүнчлэн төрийн нийтийн өмч хөрөнгийн эрхийг хангах нь улс орны амин чухал асуудал юм.

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах асуудлыг хуульчилсны гол зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх”-эд чиглэгдэх учиртай.

Тус өгүүлээр манай улсын хууль тогтоомжоор байгаль орчин , хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг хэрхэн хуульчилсныг товч судлахын сацуу энэ асуудлыг гадаадын зарим улсуудад ялангуяа эрүүгийн хууль, тогтоомждоо хэрхэн хуульчлан зохицуулсан байдаг талаар судалж харьцуулан дүгнэлт хийхийг зорилоо.

Abstract: In Constitution of Mongolia “In Mongolia the land, its subsoil, forests, water, fauna, flora and other natural wealth shall be subject to people's power only and be under the State protection.”. The land, except those owned by the citizens of Mongolia, as well as the subsoil, its wealth, forests, water reserves, and wildlife shall be the state public property. Therefore protection of natural objects, on the other hand, ensuring people's right to

live in a healthy and safe environment, as well as the right to public property of the state, is a vital issue of the country.

The main goal of legalizing the protection of the environment, as stipulated in the Constitution of Mongolia, is that "the state policy for the use of natural resources is based on long-term development policy, to guarantee the right of every citizen of the present and future generations to live in a healthy and safe environment, and to transfer the benefits of underground resources to the National Resources Fund it should be focused on providing equal and fair benefits.

In this paper, while briefly studying how the laws of our country have legalized the issue of environment and environmental protection, we have aimed to compare and make a conclusion about how this issue is legally regulated in some foreign countries, especially in their criminal laws and regulations.

Түлхүүр үг: хүрээлэн байгаа орчин, байгалийн баялаг, экологи, эрүүгийн хууль, эрх зүй, хамгаалалт.

Keywords: environment, natural resources, ecology, criminal law, law and protection.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн нэгд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн, 6 дугаар зүйлийн хоёрт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.”, “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.”, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”

Мөн 16 дугаар зүйлийн хоёрт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” зэрэг зүйл заалтыг Үндсэн хуульдаа тусгаж өгсөн байдаг²⁰⁰. Үндсэн хуулийн энэхүү зүйл, заалтад суурилан гэмт үйлдэл, эс үйлдлийг Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), Зөрчлийн хуульд тусгаж өгсөнөөс гадна Усны тухай хууль²⁰¹ (шинэчилсэн найруулга, 2012 он, 8 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан), Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994 онд баталж, 15 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан), Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 онд баталж, 32 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан) Ойн тухай хууль (шинэчилсэн найруулга 2012 он, 11 удаа нэмэлт өөрчлөлт орсон)- Ашигт малтмалын тухай хууль (шинэчилсэн найруулга 2006 он, 40 удаа нэмэлт өөрчлөлт орсон) , Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009 он, 1 удаа нэмэлт өөрчлөлт орсон) зэрэг олон

²⁰⁰ Legalinfo.mn

²⁰¹ Legalinfo.mn

төрийн хуулиудыг батлан мөрдүүлж байна. Мөн эдгээр хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор олон тооны захиргааны дүрэм, журмыг батлан хэрэгжүүлж байна.

Үндсэн хэсэг

Хүрээлэн байгаа орчныг хамгаалахад төрийн оролцоо, зохицуулалтын анхдагч үүрэг бол хүрээлэн байгаа орчныг хамгаалах зохистой, зөв эрх зүйн орчинг бүрдүүлэх явдал бөгөөд судалгааны дүнгээс харахад манай улсад хууль, дүрэм, журам, актууд хүрээлэн байгаа орчны чиглэл бүрээр батлагдан гарч хэрэгжиж байгаа боловч зохицуулалтгүй буюу төрийн хяналт, зохицуулалтаас ангид харилцаа байсаар л байна.

Энэ нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах тал дээр нийтийн эрх зүйн хэм хэмжээний системчлэл дутмаг (жишээ нь: ус бохирдуулахтай холбогдсон үйлдлийг эрүүгийн хуулиас хассан) мөн эрүү болон зөрчлийн хуулийн давхардал хийдлийг арилгах (Жишээ нь: Эрүүгийн хууль болон зөрчлийн хуульд тухайн үйлдэл, эс үйлдлийн объектив талыг адил зааж өгсөн байдал, үүнээс болж сэжигтэн яллагдагчид ашигтай зүйл заалтыг хэрэглэх зарчмын дагуу зөрчлийн хуулиар тогууль оногдуулдаг.) шаардлагатай байгааг харуулж байна. Иймээс тус өгүүллийн зорилго нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах тал дээр олон улсын туршлагыг судлах болон ялангуяа эрүүгийн хуульд хэрхэн хуульчилж өгсөн байгааг судалж дүгнэлт, санал боловсруулсан болно.

Нэг: Хүрээлэн байгаа орчныг хамгаалах зохицуулалтыг Эрүүгийн хуульдаа тусгасан улс орнууд.

ОХУ-ын²⁰² Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэгт “Экологийн гэмт хэрэг” гэсэн бүлэг хуульчлагдсан байна. Тус бүлэгт дараахь гэмт хэргүүдийг хуульчилжээ. Үүнд:

- 1.Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүрээлэн байгаа орчныг хамгаалах талаар тогтоосон журам зөрчих гэмт хэрэг /246 дугаар зүйл/
- 2.Экологийн аюултай бодис ба хаягдалтай харьцах талаар тогтоосон дүрмийг зөрчих /247 дугаар зүйл/
- 3.Микробиологийн болон бусад биологийн хорлуулагч бодистой харьцах талаар тогтоосон аюулгүй байдлын журам зөрчих /248 дугаар зүйл/
- 4.Ургамлын хортон болон бусад өвчинтэй тэмцэх талаар тогтоосон журам, мал эмнэлгийн дүрэм журам зөрчих гэмт хэрэг /249 дүгээр зүйл/
- 5.Ус бохирдуулах /250 дугаар зүйл/
- 6.Агаар орчныг бохирдуулах /251 дүгээр зүйл/
- 7.Далайн орчныг бохирдуулах /252 дугаар зүйл/
- 8.ОХУ-ын эдийн засгийн бүс эх газрын хамгаалалттай бүсийн талаар тогтоосон журам зөрчих /253 дугаар зүйл/
- 9.Хөрс бохирдуулах /254 дүгээр зүйл/
- 10.Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар тогтоосон журам зөрчих /255 дугаар зүйл/
- 11.Ургамал, усны амьтдыг хууль бусаар агнах, түүх /256 дугаар зүйл/
- 12.Загасны нөөцийг хамгаалах талаар тогтоосон журам зөрчих /257 дугаар зүйл/
- 13.Хууль бусаар ан агнах /258 дугаар зүйл/
- 14.Тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчин, ан амьтан, ургамал хамгаалах журам зөрчих /259 дүгээр зүйл/
- 15.Ой модыг хууль бусаар огтлох /260 дугаар зүйл/

²⁰²Уголовный кодекс Российской Федерации.М.1996.116-124стр

16.Ойг гэмтээх, устгах /261 дүгээр зүйл/

17.Байгалын объект, онцгойлон хамгаалагдсан байгалийн тогтоцыг устгах, гэмтээх /262 дугаар зүйл/ зэрэг үйлдэл, эс үйлдлийг хуульчилж өгчээ.

Санкцын хувьд их хэмжээний буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200-500 дахин нэмэгдүүлсэн рублиэр торгох, олсон орлогыг хураах, 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилжээ. Ихэнхи гэмт хэрэгт 2-5 жил хүртэл хугацааны хорих ялаар шийтгэхээр хуульчилсан байна.

Манай улсын эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулахад хуульчлагдсан гэмт хэргүүд нь дийлэнх нь төстэй хуульчлагдсан ба харин химийн болон цөмийн хорт бодис, цөмийн хог хаягдлын талаар тогтоосон журам зөрчих гэмт хэрэг энэ бүлэгт хуульчлагдаагүйгээр ялгаатай байна.

БНХАУ-ын²⁰³ эрүүгийн хуулийн тусгай ангийн 6 дугаар хэсэгт Байгалийн баялагт халдсан гэмт хэргийг тусгай бүлэг болгон хуульчилжээ. Энэхүү бүлгийн гэмт хэргүүдийг дурдвал:

1.338 дугаар зүйл: Хуулиар тогтоосон журмыг зөрчиж газар шороо, ус, агаар мандалд хортой цацраг идэвхт бодис, халдварт өвчин үүсгэгч бодис, хортой, аюултай бодисуудыг хэрэглэсэн, асгасан, хадгалснаас байгаль орчныг хүчтэй хордуулсан, бусдын эд хөрөнгөд хүнд хохирол учруулсан, хүний эрүүл мэндэд хор хоршиг учруулж эрүүл мэндийг гэмтээсэн бол...

2.339 дүгээр зүйл:Цөмийн хаягдал, үүсгүүрийг хилээр хууль бусаар оруулж ирсэн, түүнийг нутаг дэвсгэрт байршуулсан, хаясан бол...

3.340 дүгээр зүйл: Усны эх баялгийн хамгаалах талаар хууль тогтоомж зөрчиж хориглосон аргаар, хориотой хугацаанд, хориглосон газар загас бусад усны амьтдыг барьсан нь хүнд ноцтой байвал...

4.341 дүгээр зүйл: Улсын хамгаалагдсан газар ховор болон нэн ховор мөхөхөд хүрсэн амьтдыг хууль бусаар агнасан, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүнийг худалдаалсан бол....

5.342 дугаар зүйл: Газар хамгаалах хууль тогтоомж зөрчиж тариалангийн газрыг өөр зориулалтаар ашигласан, их хэмжээний хохирол учруулсан, тариалангийн талбайг их хэмжээгээр устгасан бол...

6.343 дугаар зүйл: Хууль тогтоомж зөрчиж, зөвшөөрөлгүйгээр уурхайн үйл ажиллагаа явуулсан, улсын төлөвлөгөөт уурхайн орд, улс ардын аж ахуйд үнэ цэнэтэй ордыг ухсан, дур мэдэн эрэл, хайгуул хийж уурхайн ордыг ашигласан, түүнийг зогсоох талаар мэдэгдэж шаардсаар байхад хууль бус үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн бол...

7.Ойн тухай хууль тогтоомж зөрчиж ховор, нэн ховор модыг огтолсон, сүйтгэсэн бол....

8.Ойн шугуй, бусад модыг их хэмжээгээр огтолсон бол.... гэсэн гэмт хэргүүдийг энэхүү бүлэгт хуульчилжээ. Дээрх үйлдлүүдийг мөн манай улсын хуульд тусгагдсан байдаг боловч ялгаатай тал нь ихэнх гэмт хэргүүдэд их хэмжээний, ноцтой хохирол учруулсан байхыг объектив талын шинж болгон хуульчилсан, материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүд дийлэнх нь байна. Оногдуулах ял нь торгох, албадан хөдөлмөр хийлгэж хорих бөгөөд харин эд хөрөнгө, ашиг орлогыг хураах ялыг нэмэгдэл ялын шинжтэй оногдуулахаар хуульчилснаар ялгаатай байна.

ХБНГУ-ын²⁰⁴ Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт “Байгаль орчны эсрэг гэмт хэрэг”-т доорх гэмт хэргүүдийг хуульчилжээ. Үүнд:

²⁰³ Орч.Б.Батзориг,Э.Зууннасан.БНХАУ-ын эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.2006 он.94-96 дахь тал

-Ус бохирдуулах /324 дүгээр зүйл/
 -Хөрс бохирдуулах /324а дугаар зүйл/
 -Агаар бохирдуулах /325 дугаар зүйл/
 -Дуу чимээ гаргах, чичиргээ үүсгэх, ионжуулаагүй цацраг ялгаруулах /325а дугаар зүйл/
 -Хууль бус хог хаягдлын менежмент явуулах /326 дугаар зүйл/
 -Хууль бус үйлдвэрлэлийн үйлд ажиллагаа /327 дугаар зүйл/
 -Цацраг идвэхт болон бусад төрлийн аюултай бодисын хууль бус хэрэглээ /328 дугаар зүйл/
 -Тусгай хамгаалалт бүхий газар нутагт аюул учруулах /329 дүгээр зүйл/
 -Байгаль орчны эсрэг гэмт хэргийн онц ноцтой тохиолдол /330 дугаар зүйл/
 -Хорт бодис ашиглах замаар ноцтой аюул учруулах /330а дугаар зүйл/
 -Сайн дураараа татгалзах /330b дугаар зүйл/
 -Хураан авах /330с дугаар зүйл/
 -Нэр томъёоны тодорхойлолт /330d дугаар зүйл/
 Санкцын хувьд 1-5 жил хүртэл хугацаагаар хорих, торгох ялыг тус тус оногдуулахаар хуульчилсан байна.

Манай улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлгийн зохицуулалттай үндсэндээ адил, зарим шинэ төрлийн тодруулбал “дуу чимээ гаргах, чичиргээ үүсгэх, ионжуулаагүй цацраг ялгаруулах, хууль бус үйлдвэрлэлийн үйл ажиллагаа” зэрэг гэмт хэрэг хуульчлагдсанаар ялгаатай. Түүнчлэн тухайн бүлэгт хуульчлагдсан тусгай, мэргэжлийн болон бусад нэр томъёоны тайлбарыг, мөн тухайн гэмт хэргээс сайн дураараа татгалзах үндэслэлийг мөн гэмт хэргийн улмаас буй болсон ашиг, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл зэргийг хураан авах талаар тусдаа зүйл хэсэг болгон хуульчилсан байна.

Хоёр.Хүрээлэн байгаа орчны эсрэг үйлдэл, эс үйлдлийг тусдаа бие даасан хуулиар зохицуулдаг улс орнууд.

Канад улс²⁰⁵: Байгал орчны эсрэг гэмт хэргийг холбооны хууль, мужийн хууль эсвэл аль алианаар зохицуулдаг.

Байгал орчны эсрэг холбооны хууль: Канад улсад байгаль орчныг бохирдуулсан үйл ажиллагааг зохицуулдаг холбооны гол 2 хууль байдаг. Үүнд Канадын байгал орчныг хамгаалах Хууль: Хортой бодис болон байгал орчинд аюултай хог хаягдлын хяналт болон менежментийг зохицуулдаг.

Загас агнуурын хууль: Загасны амьдрах орчинг сүйтгэх загасанд болон загас хэрэглэдэг хүмүүст сөргөөр нөлөөлөх бодис болон хаягдлыг загасны амьдардаг орчинд хаях үйл ажиллагааг хориглодог.

Байгал орчны эсрэг мужийн хууль:

Мужийн байгал орчныг хамгаалах хуулиар байгал орчныг бохирдуулах бодис ялгаруулахыг хориглодог бөгөөд бохирдуулагчид байгал орчин болон хүний эрүүл мэндэд хортой хатуу, шингэн, хий бодис, дуу чимээ, чичиргээ эсвэл цацраг туяа багтдаг байна.

²⁰⁴ Орч.Б.Тамир,Б.Батбаяр,Т.Золбоо.Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль.УБ.2021.481-486 дахь тал

²⁰⁵<https://www.canada.ca/en/environment-climate-change/services/canadian-environmental-protection-act-registry/publications/compliance-enforcement-policy/chapter-7.html>
<https://www.legalline.ca/legal-answers/environmental-offences-and-penalties/>

Канадын Байгал Орчныг Хамгаалах Хууль (1999):

Хууль сахиулагч хяналт шалгалт явуулсны дүнд хууль зөрчсөн гэдгийг нотлох хангалттай баримт илрүүлээгүй, эсвэл хууль зөрчсөн үйл ажиллагаа болоогүй тохиолдолд арга хэмжээ авдаггүй. Харин хууль зөрчсөн үйл ажиллагаа явагдсан нь тодорхой, эсвэл хангалттай нотлох баримт илрүүлсэн бол доорх шалгуурт нийцсэн тохиолдолд шийтгэлийг оногдуулдаг.

Шийтгэл оногдуулах эсэх шалгуур:

Хэрвээ хууль сахиулагч тухайн үйлдэл Канадын Байгал Орчныг Хамгаалах Хуулийг (1999) зөрчсөн гэж үзэж байгаа бол дараах хүчин зүйлсийг харгалзан ямар арга хэмжээ авахыг шийддэг. Хууль зөрчсөн үйлдлийн шинж чанар: Энэ шалгуураар хууль зөрчсөн үйлдлийн хор уршгийн хэмжээ, тухайн үйлдлийн зорилго, уг үйлдлийг давтан үйлдсэн, мэдээллийг нуун дарагдуулахыг оролдсон эсэх, эсвэл уг хуулийн бусад зүйл заалтыг зөрчсөн эсэхийг авч үздэг.

Хүссэн үр дүнд хүрэх эсэх: Хүсэж буй үр дүн бол аль болох богино хугацаанд дахин хуульч зөрчихгүйгээр хууль тогтоомжийг дагаж мөрдөх юм. Шийдвэр гаргахад нөлөөлөөлөх хүчин зүйлсэд хууль зөрчигч өмнө хууль зөрчиж байсан эсэх түүх, хууль сахиулагчтай хамтарч ажиллах хүсэл эрмэлзэл, арга хэмжээ авахуулсан баримт нотолгоо, мөн адил шалтгаанаар холбооны, мужийн, бүсийн, эсвэл уугуул иргэдийн засгийн газрын хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг авч хэлэлцдэг. Авч буй арга хэмжээний тогтвортой байдал: Хууль сахиулагч хууль зөрчсөн үйлдлийн эсрэг авах арга хэмжээнүүдийг тогтвортой байлгахыг зорьдог. Ингэснээр хууль сахиулагч үүнтэй адил тохиолдолд ямар арга хэмжээ авч байсан туршлага дээр үндэслэн шийдвэр гаргадаг.

Дээрх шалгууруудыг харгалзан үзсэний дүнд дараах шийтгэлүүдээс аль нэгийг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Анхааруулга;
- Хууль сахиулагчийн өгсөн үүрэг чиглэл;
- Торгууль;
- Ерөнхий сайдын тушаал;
- Байгал орчныг хамгаалах хуулийг дагаж мөрдөх тушаал;
- Усан онгоцны хөдөлгөөнийг хязгаарлах;
- Шүүхийн хориг;
- Ял оногдуулах;
- Байгал орчныг хамгаалах бусад арга хэмжээнүүд;
- Шүүхийн шийтгэл;
- Хохирлыг барагдуулах иргэний хариуцлага.

Дээрхээс үзэхэд Канад улсад байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхдээ юуны өмнө шийтгэл оногдуулах, зөрчил хүндэрсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг онцлогтой байна.

Япон улс²⁰⁶: Байгал Орчны Эсрэг Үндсэн Хууль бол ерөнхий бодлого болон удирдамж зэрэг байгал орчны хуулиудын үндэс суурь болсон гол хууль бөгөөд тодорхой заалтууд салбар хуулиудад тусгагдсан байдаг. Байгал орчныг бохирдуулагч хүчин зүйлсээс сэргийлэх болон түүнийг бууруулах хуулиуд: Агаарын Бохирдлыг Зохицуулах Хууль – үйлдвэр, бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас ялгарч буй агаар бохирдуулагчийн хэлбэр болон байгууллагын цар хүрээнд тохирсон стандартыг тогтоодог хууль бөгөөд энэхүү хуулиар хууль зөрчсөн үйлдлийг залруулах,

²⁰⁶[https://content.next.westlaw.com/8920?__lrTS=20200730153036334&transitionType=Default&contextData=\(scDefault\)&firstPage=true](https://content.next.westlaw.com/8920?__lrTS=20200730153036334&transitionType=Default&contextData=(scDefault)&firstPage=true)

хортой бодис ялгаруулдаг тусгай үйл ажиллагаа болон зарим тээврийн хэрэгслийн утааны ялгаруулалтыг зохицуулдаг.

Усны бохирдлоос сэргийлэх хууль –нийтийн усны эх үүсвэрт бохирдсон усаа ялгаруулдаг зарим байгууллагын ялгаруулалтанд стандарт тогтоодог. Уг хуулиар дараах үйл ажиллагааг зохицуулна:

-Бүртгэлд авах

-Заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх

-Ялгаруулж буй бохирдлын хэмжээг хянаж мэдээлэх

-Хөрсний бохирдлын эсрэг хууль – зарим төрлийн хортой бодисоор хөрс бохирдуулсан тохиолдолд хяналт шалгалт хийдэг.

Байгал орчныг хамгаалах хуулиуд:

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн хууль – Иргэдийн амралт, эрүүл мэндийг дэмжих, биологийн онцлогийг таниулан сурталчлах, байгалийг хэвээр нь хадгалж үлдэх, үүний тулд үндэсний, хагас-үндэсний болон мужийн цэцэрлэгт хүрээлэн болгож тохижуулах зэрэгт анхаардаг.

Байгал орчныг хамгаалах хууль – Байгал орчныг хадгалж хамгаалах зайлшгүй шаардлагатай газруудыг хамгаалдаг хууль бөгөөд байгал орчныг хамгаалах судалгааг 5 жил тутам хийх үүрэг даалгаврыг өгдөг ба тусгай хамгаалалттай газруудыг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах бүсийн хамгаалалтын системийг хариуцдаг.

Зэрлэг шувуу, хөхтөн амьтдыг хамгаалах, хянах, ангийн зохицуулалтын хуулиар зэрлэг шувуу болон хөхтөн амьтдыг хамгаалдаг. Уг хуулиар шувуу болон хөхтөн амьтдын үржил явагддаг газрыг дархан цаазтай болгон уг газар зэрлэг амьтдыг агнахыг хориглодог. Цаашлаад даархан цаазат газарт “тусгай хамгаалалттай газар” байх ба энд бүтээн байгуулалт хийх бол Байгал Орчны Яам болон мужийн захирагчаас зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.

Эдгээрээс гадна Байгал Орчинд Үзүүлж буй Нөлөөг Хэмжих Хууль (байгал орчинд ноцтой нөлөө үзүүлэх томоохон хэмжээний бизнес хийдэг байгууллагуудад байгал орчны үнэлгээ хийдэг), Олон Улсын Байгал Хамгаалах Хууль (уур амьсгалын өөрчлөлт, байгал орчин, нийгэм болон хувийн байгууллагуудын удирдлагын асуудал зэрэг байгал орчны шинэ асуудлуудад гарсан дэвшлүүдийг хамардаг) байдаг.

Захиргааны байгууллагуудын чиг үүрэг:

Засгийн газрын олон яамдаас Байгал Орчны Яам шийдвэр гаргах, захиргаа болон байгал орчны хуулийн хэрэгжилт зэрэг байгал орчны асуудлыг хариуцдаг гол яам юм. Батлан хамгаалах яамнаас гадна Эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэлийн яам, Газар, дэд бүтэц, Тээвэр болон аялал жуулчлалын яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам болон Хөдөө аж ахуй, ой болон загас агнуурын яам зэрэг олон газрууд хамтран ажилладаг. Үндэсний засгийн газраас гадна бүсийн засгийн газрууд үндэсний болон бүсийн хуулийн хэрэгжилт, сахиулалтанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хууль сахиулах хүрээнд бохирдуулагч бодисын ялгаралтыг хязгаарлах, зарим үйл ажиллагааг хориглох, байгал орчны стандартыг хангуулахаар шаардах зэрэг багтдаг.

Эдгээр хязгаарлалтыг зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Жишээлбэл, Агаарын бохирдлыг зохицуулах хууль агаар бохирдуулагчийн ялгаралтад стандарт тогтоож тогтоосон хэмжээнээс хэтэрсэн бохирдуулагч ялгаруулж буй зарим байгууллагуудын захиргаанд хориг тавьдаг. Зохицуулагч аудит хийх эрх бүхий этгээдүүд нь хяналт шалгалт хийх, хууль зөрчсөн үйлдэлд захиргааны хариуцлага оногдуулах эрхтэй байдаг. Захиргааны хариуцлагыг дагаж мөрдөөгүй болон ноцтой

зөрчил гаргасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ (эрүүгийн хариуцлагыг засгийн газрын хууль сахиулах байгууллагын ажилтан хүлээлгэнэ).

Хэдийгээр хууль зөрчсөн үйлдэлд хуулийн хариуцлага хүлээлгэдэг ч зохицуулагчид эхлээд анхааруулга өгч өөрийн саналаар зөрчлийг арилгах боломж олгодог. Иймэрхүү өөрсдийн хүслээр зөрчлийг арилгахыг дэмжсэн олон төрлийн аргууд эрэлттэй болж байна.

Жишээ нь, бизнес эрхлэгч нь байгал орчны стандартыг хангаж ажиллах нөхцөлтэйгөөр харьяа захиргааны байгууллага болон оршин суугчидтай тохиролцоонд хүрч болдог. Нарны эрчим хүчний ашиглалтыг жишээ болговол, байгал орчныг сүйтгэхээс сэргийлсэн олон төрлийн арга хэмжээ авах нөхцөлтэйгөөр харьяа захиргааны байгууллагатай хэлэлцээр хийдэг. Хэдийгээр ихэнх тохиолдолд бизнес эрхлэгч иймэрхүү тохиролцоонд хүрэх шаардлага байдаггүй ч ингэснээр харьяа захиргааны байгууллагатай хамтарч ажиллах, цаашлаад төсөл амжилттай хэрэгжихэд дэмжлэг болдог байна.

Хориглосон үйл ажиллагаа:

Уг хуулиар хориглосон олон үйл ажиллагаа байдаг. Жишээ нь, урсгал усны бохирдуулалтын стандартад нийцээгүй хэмжээгээр нийтийн усны сүлжээнд бохир ус цутгасан байгууллагын үйл ажиллагааг хориглодог.

Цэвэрлэгээ, нөхөн сэргээлт:

Хэрэв гүний ус бохирдож эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн, эсвэл нөлөөлөх эрсдэлтэй бол мужийн захиргаа хариуцлага бүхий байгууллагад нөхөн сэргээлт хийх тушаал өгч болдог.

Шийтгэл:

Урсгал усны бохирдуулалтын стандартыг зөрчиж бохирдсон ус эсвэл хаягдал ус ялгаруулсан хувь хүн, байгууллагыг 6 сар хүртэл хорих, эсвэл 500,000 иенээр торгох шийтгэл оногдуулна. Үүнээс гадна, мужийн захирагчийн тушаалыг биелүүлээгүй тохиолдолд 1 жил хүртэл хорих, эсвэл 1 сая хүртэл иенээр торгох ял оногдуулна.

Агаарын бохирдолт:

Агаарын бохирдлыг зохицуулах хуулиар 4 төрлийн агаар бохирдуулагчийг тодотгосон байдаг:

- Хөө тортог болон утаа
- Ууршилттай органик химийн бодисууд
- Тоос тортог
- Мөнгөн ус

Байгаль орчны яам дээрх 4 төрлийн агаар бохирдуулагчийг ашиглаж болох байгууллагыг тодорхойлдог бөгөөд бодис тус бүрийн ялгаруулж болох стандарт хэмжээ болон шаардлагыг тогтоодог.

Цэвэрлэгээ, нөхөн сэргээлт:

Хэдийгээр цэвэрлэгээ хийх ерөнхий шаардлага байдаггүй ч их хэмжээний бодисыг санаандгүй ялгаруулсан тохиолдолд хариуцлага бүхий этгээд яаралтай арга хэмжээ авч хохирлыг барагдуулах, харьяа захиргааны байгууллагад мэдэгдэх шаардлагатай байдаг.

Шийтгэл:

Стандартаас хэтэрсэн хөө тортог, утаа ялгаруулсан бол 6 сар хүртэлх хорих ял, эсвэл 500,000 хүртэлх иенээр торгоно

Мужийн захирагчийн тушаалыг биелүүлээгүй бол 1 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл 1 сая хүртэл иенээр торгох ял оногдуулна

Ялгарлыг нарийн хэмжиж мэдэгдээгүй тохиолдолд 300,000 хүртэл иенээр торгоно

Япон улсад байгаль орчныг хамгаалах журам зөрчсөн үйлдэлд захиргааны шийтгэл эхлээд хүлээлгэх бөгөөд ял шийтгэл оногдуулахаас өмнө анхааруулга санамж өгч түүнийг биелүүлээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна. Дийлэнх тохиолдолд торгох ялыг оногдуулдаг ажээ.

АНУ²⁰⁷: Сүүлийн 5 жилийн хугацаанд АНУ-н Конгресс байгал орчны хэд хэдэн чухал хуулиудыг баталж, шинэчилсэн.

Ихэнх гол хуулиудаар мужийн захиргааны байгууллага хуулийн хэрэгжилтэнд гол үүрэг гүйцэтгэж, холбооны засгийн газар түүнийг хянах, зөрчлийг арилгах хариуцлага хүлээлгэхийг заасан байдаг. Мужийн засаг захиргаа холбооны хуулиар хориглоогүй бол холбооны хуулиас илүү хатуу чанга хууль хэрэглэж болдог.

Байгал орчны гол хуулиуд²⁰⁸

Цэвэр агаарын хууль – уг хуулиар агаарын чанарыг зохицуулдаг бөгөөд цахилгаан станц, боловсруулах үйлдвэр, газрын тос шатахууны станц болон үйлдвэрүүд зэрэг тогтвортой эх үүсвэр болон ачааны машин, онгоц зэрэг бусад хөдөлгөөнт эх үүсвэрээс ялгарч буй агаарын бохирдлыг хянадаг. Энэхүү хуулиар усанд ялгаруулж буй бодис болон гадаргын усны чанарыг зохицуулдаг.

Ховордсон амьтдыг хамгаалах хуулиар ховордсон, устаж үгүй болох эрсдэлтэй амьтад болон тэдний амьдрах орчинг хадгалж хамгаалдаг. Хортой бодисын хяналтын хуулиар химийн бодисын үйлдвэрлэлт, импорт, хэрэглээ болон хаягдлыг зохицуулдаг.

Байгал орчны хариу арга хэмжээ, нөхөн сэргээлт, хариуцлагын цогц хууль – Уг хуулиар хортой бодис бүхий газрын цэвэрлэгээ болон хортой бодисын осол, асгаралт болон бусад байгал орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулдаг.

Байгалийн нөөцийн хадгалалт болон нөхөн сэргээлтийн хуулиар хортой бодис үүссэн газраас эцсийн устах цэг хүртэлх хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, устгал зэргийг хянадаг. Түүнчлэн уг хуулиар хор нөлөөгүй хатуу хаягдлын менежментийг зохицуулдаг.

Хортон шавьж, мөөгөнцөр болон мэрэгч амьтан устгагчийн холбооны хууль – Уг хуулиар пестицидын тараалт, худалдаа, хэрэглээг лицензийн программар хянадаг.

Аюулгүй ундны усны хууль – Нийтийн усны шугам сүлжээг хянаж ундны усны хэрэгцээг зохицуулдаг. Түүнчлэн газар доорх худгийн байгуулалт, ашиглалт, зөвшөөрөл болон хаагдалтыг хянадаг.

Үндэсний байгал орчны бодлогын хууль – Зөвшөөрөл олгохоос өмнө холбооны байгууллагуудаас хэлэлцэгдэж буй төслийн байгал орчинд үзүүлэх нөлөөг үнэлэхийг шаарддаг.

Зохицуулах байгууллага нь:

Ихэнх нь холбооны байгууллага байдаг ба үүнд:

АНУ-н байгаль орчныг хамгаалах агентлаг–Дээр дурьдсан хуулиудын хэрэгжилтийг хариуцдаг.

АНУ-н Дотоод алба – Нийтийн газрын менежмент, эрдэс баялгийн болон зэрлэг байгалийг хамгаалах холбооны хуулиудыг хэрэгжүүлдэг.

²⁰⁷ <https://content.next.westlaw.com/>

²⁰⁸ <https://guides.loc.gov/environmental-law/federal-laws>

АНУ-н инженерүүдийн цэргийн корпус-Цэвэр усны хуулийн дагуу газар шороо болон бусад дүүргэгч материалуудыг усанд ялгаруулах ажиллагаа, Гол эргийн хуулийн дагуу усан замын бүтэц үйл ажиллагааг зохицуулдаг.

Үндэсний далайн загас агнуурын алба – Далайн эх үүсвэрийн хадгалалт, зохицуулалттай холбоотой программыг хариуцдаг алба.

АНУ-ын хууль зүйн яам – Байгал орчны холбооны хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх байгууллага.

Усны бохирдол, хориглосон үйл ажиллагаа:

Цэвэр Усны Хуулиар тогтсон эх үүсвэрээс улсын харьяалал бүхий усан санд хориотой бохирдол ялгаруулахыг хориглодог бол Аюулгүй ундны усны хуулиар ундны усаар хангагч байгууллагуудыг стандарт зөрчихийг, мөн ундны усны чанарыг тогтмол хянаж, мэдээлэхгүй байхыг хориглодог.

Шийтгэл

Цэвэр усны хуулийг зөрчсөн тохиолдолд ноцтой захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага тооцдог. Уг хуулиар шийтгэлийн дээд хэмжээг тогтоосон байдаг ч Байгал орчинг хамгаалах агентлаг 2016 оны 7 сард дээд хэмжээг нэмэгдүүлсэн.

Зөрчил тус бүрт өдөр бүр 52,414 хүртэл доллароор торгох иргэний ял оногдуулдаг ч дээд хэмжээгээр шийтгэдэггүй. Түүнчлэн шийтгэлийг үл ойшоосон, мэдсэн ч зөрчил гаргасан, хуурамч мэдүүлэг өгсөн тохиолдолл эрүүгийн хариуцлага хүлээлгэн торгох эсвэл хорих ялаар шийтгэдэг.

Аюулгүй ундны усны хуулиар мөн ноцтой захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага тооцдог. Нийтийн ундны усны сүлжээг бохирдуулсан, санаатайгаар шаардлагыг хангаагүй бол өдрийн 54,789 амд-р торгох, эсвэл эрүүгийн хариуцлагаар торгох юмуу хорих ял онооно.

Агаарын бохирдол

Цэвэр агаарын хуулиар, байгал орчныг хамгаалах агентлаг шалгуур бохирдуулагчийн (озон, азотын ислүүд, хүхрийн давхар исэл, жижиг ширхэглэгт тоосонцор, хар тугалга, нүүрстөрөгчийн дан исэл) гадаад орчны агаарын чанарын минимум стандартыг тогтоодог.

Хориглосон үйл ажиллагаа:

Цэвэр агаарын хуулиар хэд хэдэн үйл ажиллагааг хориглосон байдаг:

- Шаардлагатай зөвшөөрөлгүйгээр агаар бохирдуулагч ихээр ялгаруулдаг эх үүсвэр барьж байгуулах, ажиллуулах
- Зөвшөөрөлд тусгасан заалт юмуу ялгаруулах стандартыг зөрчих
- Хөдөлгүүрт тээвийн хэрэгсэл болон замын стандартыг зөрчих, шатахууны шаардлагыг хангаагүй тохиолдол
- Зохих шаардлага болон аажмаар багасгах хуваарийг зөрчин озоны давхаргыг гэмтээх бодисыг үйлдвэрлэх юмуу ашиглах
- Хянах, мэдээлэх шаардлагыг хангахгүй байх
- Зохицуулагчид худал мэдүүлэг өгөх, Цэвэр Агаарын Хуулийг зориуд зөрчих

Цэвэрлэгээ/нөхөн сэргээлт:

Ихэнх тохиолдолд агаарын бохирдлыг цэвэрлэх, нөхөн сэргээх шаардлага тавьдаггүй ч ийм арга хэмжээ авах тохиолдол байдаг. Хэрэв агаарын бохирдол хэн нэгэнд хохирол учруулж байгаа бол нөхөн олговор шаардаж болно.

Шийтгэл:

Цэвэр Агаарын Хуулийг зөрчсөн тохиолдолд ноцтой захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага тооцдог. Уг хуулиар, зөрчил тус бүрт өдрийн 45,268АМД-р торгох иргэний хариуцлагын дээд хэмжээг тогтоосон байдаг. Эрүүгийн зөрчил гаргасан тохиолдолд их хэмжээний торгууль болон хорих ялаар шийтгэдэг.

Дээрх улс орнуудын эрүүгийн хуулийн зохицуулалт нь:

Канад, Япон, АНУ зэрэг Англо-Саксоны системт орнуудад байгаль хамгаалах журам зөрчсөн гэмт хэрэг, зөрчилд тусдаа бие даасан хуулиар ял шийтгэл оногдуулах бөгөөд тухайн хуулиудад ямар субъект ямар шийтгэл хүлээлгэх, ямар тохиолдолд ял оногдуулахыг тусгайлан хуульчилсан байна.

Дүгнэлт

2017 оны байдлаар дэлхийн 176 улс байгаль орчны цогц хуультай, 150 улс байгаль орчныг хамгаалах буюу эрүүл орчинд амьдрах эрхийг үндсэн хуульдаа тусгаж, 164 улс байгаль орчныг хамгаалах үүрэг бүхий Засгийн газрын түвшний байгууллагуудыг байгуулжээ²⁰⁹. Хүн төрөлхтний өөрийн амьдрах орчноо амар амгалан байлгаж, ирээдүйгээ ухамсартайгаар төлөвлөж, байгаа бүхнээ ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх гэсэн хүсэл тэмүүлэлтэй байдаг. Иймээс өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг төлөвлөн зохион байгуулахдаа хойч үеийнхэндээ байгалийн нөөц баялгийг зөв зохистой хэмжээгээр эдэлж хэрэглэх нөхцлийг бүрдүүлэхээр зохицуулах шаардлага тулгарч байна. Иймд өнөө үеийнхэнд байгаль орчноо нөхөн сэргээх замаар доройтлыг нь бууруулахад хувь нэмрээ оруулж, ирээдүй үеийнхний амьдрах нөхцлийг сайжруулах үүрэг, хариуцлага тулгараад байна. Тогтвортой хөгжил нь эдийн засгийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бүрэн тооцсон, дахин хэрэглэж, нөхөн сэргээж болох, бүрэн шавхагддаггүй байгалийн нөөцийн ашиглалт дээр үндэслэсэн, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй эдийн засгийн хөгжлийн үзэл баримтал гэж тодорхойлсон байдаг.

Гадаадын зарим орнуудын эрүүгийн хууль тогтоомж дахь “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг”-ийн талаарх харьцуулсан судлалыг хийх явцад манай улсын эрүүгийн хуультай ижил төстэй буюу эрүүгийн хуульдаа бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан орнууд нилээдгүй байх бөгөөд энэхүү бүлэгт хуульчлагдсан гэмт хэргүүд дийлэнх нь манай эрүүгийн хуулийн зохицуулалттай адил байлаа. Харин манай улсынхаас өөр онцлог зохицуулалт бүхий орнууд тодруулбал Англо-Саксоны системт орнуудад байгаль хамгаалах журмын эсрэг зөрчил, гэмт хэргийг эрүүгийн хуулиар бус тусдаа төрөлжсөн хуулиар зохицуулдаг. Ийм орнуудад төрийн захиргааны байгууллагууд зөрчил, гэмт хэргийг илрүүлж эхлээд анхааруулга өгөх, дараа нь шийтгэл хүлээлгэх, ноцтой хохирол учруулсан тохиолдолд эрх бүхий субъект торгох ял оногдуулдаг онцлог зохицуулалттай байлаа.

Дээрх дүгнэлтээс үүдэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Манай Улсын Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулиудад тусгасан байгаль орчны эсрэг үйлдэл, эс үйлдлүүдийг ялгамжтай зүйлчлэх. Жишээ нь объектив талыг ялгаатай тусгах.

2. Захиргааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж урьдчилан сануулах, арга хэмжээг нэмэгдүүлэх.

²⁰⁹<https://sdg.iisd.org/news/environmental-laws-impeded-by-lack-of-enforcement-first-ever-global-assessment-finds/>

3.Хүрээлэн байгаа орчныг бохирдуулах ялгаралын хувь хэмжээг нарийвчлан зөрчлийн хуульд тусгаж өгөх. Гэсэн тус тус саналтай байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Эрүүгийн хууль 2015 он
3. Зөрчлийн хууль 2017 он
4. Агаарын тухай хууль 2012 он
5. Амьтны тухай хууль 2012
6. Байгалийн ургамлын тухай хууль 1995 он
7. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995 он
8. Усны тухай хууль 2012 он
9. Газрын тухай хууль 2002 он
10. Газрын хэвлийн тухай хууль 1988 он
11. Ашигт малтмалын тухай хууль 2006 он
12. Ойн тухай хууль 2012 он
13. Цөмийн энергийн тухай хууль 2009 он
14. Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль 2006 он
15. Орч.Б.Батзориг,Э.Зууннасан.БНХАУ-ын эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.2006 он.94-96 дахь тал
16. Уголовный кодекс Российской федерации.М.1996.116-124стр

Цахим эх сурвалж:

1. <https://sdg.iisd.org/news/environmental-laws-impeded-by-lack-of-enforcement-first-ever-global-assessment-finds/>
2. [https://content.next.westlaw.com/0-503-4622?__lrTS=20210205132930881&transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true](https://content.next.westlaw.com/0-503-4622?__lrTS=20210205132930881&transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true)
3. <https://guides.loc.gov/environmental-law/federal-laws>
4. [https://content.next.westlaw.com/6-502-8920?__lrTS=20200730153036334&transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true](https://content.next.westlaw.com/6-502-8920?__lrTS=20200730153036334&transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true)
5. Орч.Б.Тамир,Б.Батбаяр,Т.Золбоо.Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль.УБ.2021.481-486 дахь тал
6. <https://www.canada.ca/en/environment-climate-change/services/canadian-environmental-protection-act-registry/publications/compliance-enforcement-policy/chapter-7.html>
7. <https://www.legalline.ca/legal-answers/environmental-offences-and-penalties>

--o0o--

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ОРЧИН ҮЕИЙН БОЛОВСРОЛЫН МЕНЕЖМЕНТ

MANAGEMENT OF MODERN EDUCATION

Д.Цэрэнлхам

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх
зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

D. Tserenlham

Police School of the University of Internal Affairs
Teacher of the Department of Police law t

Хураангуй: Монгол улсын дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого нь Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Боловсролын талаар төрөөс баримтлах бодлоготой уялдаж, мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, нийгмийн тэгш байдлыг баталгаажуулахад боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгох талаар дурьдаж авч үзсэн.

Abstract: Mongolia's higher education sector development policy is aligned with the World Sustainable Development Program 2030, Mongolia's Sustainable Development Concept 2030, and the government's policy on education. mentioned about the establishment of the system.

Түлхүүр үгс: Дээд боловсрол, мэдлэгийн зах зээл, менежмент, нийгмийн хариуцлага

Key words: higher education, knowledge market, management, social responsibility

Үндсэн хэсэг.

Дээд боловсролыг төгсөгчдийн чанараар хэмждэг болсон өнөө үед Монголын дээд боловсролын эрэлт нийлүүлэлтийн харьцаа алдагдаж, хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролтой ажилгүйчүүдийн тоо буурахгүй байсаар байна.

Нийгмийн өөрчлөлтийн мөчлөг өмнө нь 60 жилээр тоологдож байсан бол одоо 10 жил болж богиносж байгаа (Kai-ming Cheng, 2011) нь нийгэмд өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэн гаргадаг дээд боловсролын реформын бодлогыг зайлшгүй хийх шаардлага улс орнуудын өмнө бий болсныг харуулж байна. Энэ ч үүднээс Их Британид оюутны сонголтыг дагасан санхүүжилтийн реформ, нийлүүлэгчийг дэмжих хялбар зохицуулалт, өрсөлдөөнийг дэмжих (Дээд боловсролын цагаан ном, 2011), Австралид өрсөлдөөн, хувьчлал, зах зээлийн зохицуулалтыг нэмэгдүүлэх (Нелсоны реформын хөтөлбөр, 2003), гүйцэтгэлтэй холбоотой санхүүжилт (Брэдлэйн илтгэл, 2009)-ийн бодлого, ХБНГУ-д элит их сургууль, судалгааны “кластер”-ийг сонгон дэмжлэг үзүүлэх, сургалтын төлбөр авахыг зөвшөөрөх, Японд үндэсний их сургуулиудыг корпорацчилах, бие даасан байдлыг нь нэмэгдүүлэх, ОХУ-д Холбооны дэмжлэгтэй бүсийн академик төвүүд байгуулж, дэлхийн түвшний их сургууль болгох бодлого тус тус явуулж байна.

Аль ч улс орны дээд боловсролын реформын бодлогыг авч үзлээ гэсэн нийтлэг хандлага байгааг дурдвал, өсөн нэмэгдэж буй глобалчлал, харилцан холбоо хамаарал нь

орон зайн хүндрэлийг арилгаж, мэдлэг, бүтээлч сэтгэлгээ нь байгалийн нөөц, биет капиталаас илүүтэй эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч үйлдвэрлэлийн хүчин зүйл болж, мэдлэгийн секторын өрсөлдөх чадварыг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өгч байгааг анхаарах хэрэгтэй.

Дээд болон мэргэжлийн боловсролын сургалт нь улс орны өрсөлдөх чадварын 12 тулгуур үзүүлэлтийн 5 дугаар үзүүлэлт бөгөөд манай орны хувьд 2019-2020 оны тайланд дурдсанаар дэлхийн 138 орноос их дээд сургуульд хамрагдалтаар 38 дугаарт, математик, шинжлэх ухааны боловсролын чанараар 40 дүгээрт тус тус эрэмбэлэгдсэн нь Зүүн Ази, Номхон далайн бүсийн хөгжиж буй орнуудтай харьцуулахад дээрх үзүүлэлтээр харьцангуй давуу талтай харагдаж байгаа юм.

Монгол улсад 2022-2023 оны байдлаар төрийн ба төрийн бус өмчийн 68 их, дээд сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгааг гадаад улс орнуудын 100000 хүнд ноогдох их дээд сургуулийн тоотой харьцуулж үзвэл ОХУ -аас 4 дахин их, Туркээс 12 дахин их, Японоос 5 дахин их байна. Өөрөөр хэлбэл, дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, их дээд сургуульд хамрагдалт зэрэг зарим үзүүлэлтээр дээд боловсролын хүртээмжийг хэмжинэ гэж үзвэл энэ тал дээр Монголын дээд боловсролын хүртээмж дэлхийн “рекорд”-ыг эвдэхээр “хангалттай сайн” гэж хэлж болохоор байна.

Дээд боловсролын чанар: НҮБ-аас жил бүр гаргадаг “Боловсролын илтгэл”, “Хүний хөгжлийн илтгэл”-д боловсролын чанар гэдгийг байнга хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн дотор боловсролтой иргэн хүний амьдрах ухаан, өрсөлдөх чадвар, иргэний төлөвшил гэж ойлгох шаардлагатай болж байна... Боловсролын чанар нь хувь хүний, иргэний, ахуйн болон мэргэжлийн чадамжийг нийгмийн (төрөл бүрийн бүлгүүдийн) хэрэгцээ, хүлээлттэй уялдуулан, нийгэм дэх боловсролын үйл явцын тухайн үеийн байдал, үр дүнг тодорхойлно гэж үзсэн байдаг.

Их дээд сургуулиуд хөтөлбөрийн чанар, багшийн чанар, сургалтын технологийн чанарыг ажил олгогч, цаашилбал хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй нийлүүлэхгүй л бол, мөн үүний төлөө өрсөлдөх чадваргүй л бол боловсролын чанарын тухай, улмаар үр ашгийн тухай ямар ч яриа байх боломжгүй юм. Боловсролын менежментийг олон янзаар тодорхойлсон байдаг.

Боловсролын менежмент гэж төрөөс боловсролын талаар дэвшүүлсэн үүрэг, зорилгыг хэрэгжүүлэх бүх шатны боловсролын байгууллагын удирдлагын тогтолцоо, үүрэг, зорилт түүний төлөвлөлт зохион байгуулалт, хэрэгжилт, хяналт, шийдвэр гаргах үйл явц юм²¹⁰.

Боловсролын менежмент гэж суралцагсад, сургагч багшийн боловсролын үйл ажиллагаанд тавигдах нөхцөлийг бүрдүүлэхэд дүн шинжилгээ хийх үйл явц юм²¹¹.

Боловсролын менежмент нь боловсролын зорилгод хүрэх хэд хэдэн арга, хэрэгсэл, арга барил, зарчмуудын тусламжтайгаар бий болж буй харилцан уялдаатай менежмент юм.

Удирдлагын чиг үүрэг, боловсролын удирдлагын чиг үүрэг ерөнхийдөө төстэй байдаг. Энэ нь төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт, сэдэл, зохицуулалтын чиг үүрэгтэй. Гэсэн хэдий ч менежментийн үйл ажиллагааны механизм нь инновацийн менежмент, хүний нөөцийн менежмент, нийлүүлэлтийн удирдлага, үйлдвэрлэлийн менежмент, маркетингийн удирдлага, чанарын удирдлага, санхүүгийн удирдлага, олон улсын удирдлага, байгал орчны менежмент зэрэг ерөнхий болон үйл ажиллагааны онцлогтой.

²¹⁰ Р.Намжилдагва “Боловсролын менежмент” хичээлийн лекц

²¹¹ <https://moluch.ru/archive/207/50770/>

Удирдлага нь зөвхөн шинжлэх ухаан төдийгүй, бодит хүмүүсийн менежментийн урлаг юм. Оюуны болон практик үйл ажиллагааны өөр бусад талуудын нэгэн адил менежментийн шинжлэх ухааны шинж чанар, менежментийн урлаг нь бие биенээ нөхдөг. Үүний үр дүнд удирдлагын тогтолцооны үр нөлөө нь менежер нь тодорхой нөхцөл байдалд менежментийн шинжлэх ухааны зарчмуудыг бүтээлч хэрэглэх аргыг эзэмших чадвараар хангагддаг.

Менежментийн шийдэл ба зохицуулалт: Монгол улсын дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого нь Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Боловсролын талаар төрөөс баримтлах бодлоготой уялдаж, мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, нийгмийн тэгш байдлыг баталгаажуулахад тусалж чадах дээд боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгохыг зорьж байгаа юм.

Их дээд сургуулиудыг тэргүүлэгчдийн байрлал руу шилжүүлэх дараах бодлого хэрэгжүүлбэл Монголын сургуулиудын өрсөлдөх чадвар сайжирч, дээд боловсролын тогтолцоо эрүүлжих боломж бий гэж үзсэн байдаг.

1. Дээд болон мэргэжлийн боловсролын хүртээмж/хуваарилалтын оновчтой бүтцийг бий болгох.
2. Дээд боловсролын байгууллагуудын санхүүжилтийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлэх.
3. Дээд боловсролын байгууллагуудын менежментийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлэх

Сургалтын чанарыг дээшлүүлэх механизмуудыг хангахад санхүүжилтийн олон эх үүсвэр хэрэгжүүлэх бодлого чухал. Үүнд:

- ✚ Их сургуулиудын бие даасан байдлыг хангахад Төрийн оролцоо хязгаартай байх,
- ✚ Төвлөрсөн болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээ судалгааны ажлын санхүүжилт, сургуулийн өөрийн үйлчилгээнээс олох орлого, сайн дурын хандив, зээл зэрэг санхүүгийн солонгорсон бүтцийг бий болгох,
- ✚ Чадварлаг оюутнуудад олгодог дотоод болон гадаадын ашгийн болон ашгийн бус байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит хандив, тэтгэлгийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- ✚ Эдгээрээс өөр бусад хэлбэрүүдийг сайтар судлах хэрэгтэй

Глобалчлал, интернационалчлагдах үйл явцын аясаар дээд боловсрол нь хэрэглэгчиддээ ойртсон үйлчилгээ буюу интерпренёр хандлагатай болж буйтай холбоотой их сургуулийн менежментийн хандлага ч өөрчлөгдөж байна. Тодруулбал, их сургууль нь суралцагч байгууллага байх, мэдлэг бүтээгч байх, интерпренёр байх гэсэн менежментийн шинэ парадигмын шинжийг үүсгэж байгаад дээд боловсролын бодлогын түвшинд анхаарах шаардлагатай.

Сургалтын чанарыг харьцангуй дээшлүүлэх менежментийн арга нь нийт суралцагчдын 58 хувийг төвлөрүүлсэн төрийн өмчийн сургуулиудад илүү хамаатай. Үүнд:

- ✚ Стратегийн ач холбогдолтой гэгдэж буй сургуулиудын болон бусад төрийн өмчийн сургуулиудын ажиллах хэмнэлттэй нөхцлийг хангах; ингэснээр дээд боловсролын үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлнэ.
- ✚ Сургуулийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх; Энэ хүрээнд их, дээд сургууль, коллежид тэнцээгүй болон ерөөс техник мэргэжил эзэмших

хүсэлтэй иргэдэд тодорхой мэргэжил эзэмших бололцоог нь хангах үүднээс тусгай болон мэргэжлийн дунд боловсролыг санал болгох хэрэгтэй. Мөн хүний эрх, хэрэглэгчийн эрх ашиг, хүрээлэн буй орчин, олон нийтийн оролцоо ба хөгжлийг хангасан үйл ажиллагааг аль ч сургалтын байгууллага явуулах ёстой.

Дүгнэлт: Энэхүү сэдвийг судлаад дараах товч дүгнэлтийг гаргаж байна.

1. Дэлхийн улс орнуудын дээд боловсролын реформын бодлого нь мэдлэг, бүтээлч сэтгэлгээг эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч үйлдвэрлэлийн хүчин зүйл болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

2. Монгол улсын дээд боловсролын төлөв байдлыг тодорхойлох хүртээмж, чанар, үр ашиг гэсэн үзүүлэлтүүд харилцан хамааралтай ч, тэнцвэргүй байгаагаас хөдөлмөрийн зах зээл дэх дээд боловсролтой мэргэжилтний нийгмийн үнэлэмж буурах шалтгаан болж байна. Иймээс мэргэжлийн болон дээд боловсролын хуваарилалтын оновчтой бүтцийг бий болгох, их дээд сургуульд элсэгчдийн чанарын шалгуурыг сайжруулах ёстой.

3. Дээд боловсролын санхүүжилт, менежментийг их сургуулиудын амьдрал (элсэгч авахаас эхлээд төгсөх хүртэлх)-ын мөчлөг, тэдэнд тулгарч буй бодит бэрхшээл (хөдөлмөрийн зах зээлийн болон нийгмийн хөгжлийн хувьсамтгай нөхцөл байдал)- тэй нь уялдуулан сайжруулах замаар боловсролын чанарыг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой.

Ашигласан эх сурвалж

1. <https://www.slideshare.net/razukhannurbek/20171023-84413661>
2. <https://moluch.ru/archive/207/50770/>
3. “Дээд боловсролын шинэчлэлийн тулгамдсан асуудлууд” 2015 он
4. Р.Намжилдагва “Боловсролын менежмент” хичээлийн лекц

--ооо--

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ
ХАРЬЦУУЛАН ШИНЖИХҮЙ НЬ**
COMPARATIVE ANALYSIS ON LEGAL REGULATIONS OF CONFLICT
INVESTIGATING AND RESOLVING ACTIVITIES IN CERTAIN FOREIGN
COUNTRIES

**МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн магистрант,
М.Амартунгалаг**

Amartungalag.M
A

graduate student,

Law School of National
University of Mongolia,

Хураангуй. Нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг сахиулах зорилгоор тусгайлан эрх олгогдсон этгээд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргадаг.

Энэхүү өгүүлэлд а)Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ практикт хэрэгжиж буй нөхцөл байдал; б)Канад, Унгар, Казакстан улсуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтай харьцуулж, судлаачийн үүднээс өөрийн үзэл бодлын талаар товч авч үзсэн болно.

Executive Summary. In order to maintain the norms of social relations and living conditions between people in the society that ensure social peace, the right to freedom and inviolability of people, the integrity of property, and the normal operation of enterprises and organizations, a specialized authorized officers make decision on administrative norms.

In this article, I made a research on following subjects and made discussion from my point of view a) the situation of the practical implementation of the Revised Law on Conflict Investigation and Resolution of Mongolia; b) the legal regulations of

law on conflict investigation and resolution of Canada, Hungary, and Kazakhstan are compared with certain regulations of Law on Conflict Investigation and Resolution of Mongolia.

Түлхүүр үг. Зөрчил, эрх бүхий албан тушаалтан, хүлээлгэх шийтгэл

Key word. Violations, authorized officers and penalties

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”²¹² гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг хангах, нийгмийн дэг журмыг хангах үүднээс эрх бүхий субъектээс нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргадаг.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдийн заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн шийдвэрийг хэлдэг.

А. Монгол Улсад 1990-ээд оноос өрнөсөн эрх зүйн шинэчлэл, Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх зорилтын хүрээнд зөрчил, түүнийг шалган тогтоох, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэгтгэн зохицуулах зорилгоор Захиргааны хариуцлагын тухай хуулийг²¹³ (1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр), мөн төрийн хяналт шалгалт болон салбарын хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрөлжсөн хуулиудыг батлан хэрэгжүүлж иржээ. Захиргааны хариуцлагын тухай хууль нь захиргааны зөрчил, түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байан ганц хууль бөгөөд энэхүү хууль нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд дорвитой өөрчлөлт ороогүй, 1995, 1997, 2004, 2006 онуудад нийт 20 гаран удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт хийгдээгүй байжээ.²¹⁴

²¹² Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

²¹³ <https://legalinfo.mn/mn/detail/280>

²¹⁴ https://nli.gov.mn/pdf/eruugiin_bolon_zahirgaanii.pdf

2013 оноос хууль болон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд шалган шийдвэрлэхээр тодорхойлсон төрөлжсөн хуулиудад салбарын хүрээнд үйлдэгддэг зөрчлийг тодорхойлж, улмаар шалган тогтоох, хянан шийдвэрлэх журмыг тухайн салбарын асуудлыг зохицуулсан хуулиар буюу өөр өөр байдлаар хуульчилж хэрэгжүүлсээр ирсэнийг өөрчлөх цаг болсон гэж үзсэн байдаг.

Тухайн цаг үед зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтын ажиллагаатай адилтган зохицуулсан нь салбарын онцлог нэрийн доор салбар бүрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өөр өөр стандарт тогтоон хэрэгжүүлж байна. Тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар зөрчлийг 14 хоногт багтаан хянан шалгахаар²¹⁵ заасан бол Өрсөлдөөний тухай хуульд 60 хоногт багтаан шалгахаар²¹⁶ зааж байсан нь эрх зүйн маргаан үүсэх нөхцөл болж байжээ.

Тиймээс УИХ, ЗГ-аас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хууль шинэчлэх ажлын хэсгийг байгуулж, төслийг боловсруулж хэлэлцүүлсэний үр дүнд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталж²¹⁷, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг эрх бүхий албан тушаалтнууд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч нэгээс бусад тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд бус харин өөр бусад хуулийн шинэчлэлтийг дагалдуулан Зөрчлийн тухай хуульд тодорхой зөрчлийг хуульчилсантай холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх субьектийн харьяалал тогтооход чиглэсэн байна.²¹⁸

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал нь нутаг дэвсгэрийн харьяалал болон эрх бүхий албан тушаалтны харьяаллаар тогтоогдоно. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн тодорхой ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр харьяалах нутаг дэвсгэрээс гадна явуулж болох бөгөөд зөрчил хэд хэдэн нутаг дэвсгэрт

²¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail/280> Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт

²¹⁶ Өрсөлдөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт

²¹⁷ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

²¹⁸ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас хэсэгчилэн авав.

үйлдэгдсэн бол сүүлийн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага шалган шийдвэрлэхээр хуульчилсан байна.²¹⁹

Өнөөдрийн байдлаар зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийг 31 байгууллагын 216 нэгжид харьяалагдах 10011 эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж байгаа бөгөөд Улсын ерөнхий прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих бие даасан хэлтэс ажиллаж байна.

Монгол Улс 2017 оноос нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн хэм хэмжээ, түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг Зөрчлийн тухай хуулиар, харин гарсан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тус тус зохицуулж эхэлсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийн шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.²²⁰

Б. Бид энэ хэсгээр гадаадын зарим улс орон буюу Канад, Унгар, Казакстан улсуудад Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэрхэн явагддаг, түүний эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалттай харьцуулалт хийхийг хичээлээ.

Монгол, Канад, Унгар, Казакстан улсуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжуудын нэршлийг харьцуулан авч үзье.

Хүс
нэгт №1

Асуулга	Монгол Улс	Канад улс	Унгар улс	Казакстан улс
Хуулийн нэр	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	Зөрчлийн тухай хууль	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль	Захиргааны эрх зөрчлийн тухай хууль
Бүлэг зүйл	18 бүлэг	4 бүлэг, 17 зүйл	31 бүлэг, 254 зүйл	53 бүлэг, 920 зүйл

Дээрхи хүснэгтээс үзвэл Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль нь 53 бүлэг, 920 зүйлтэй байгаа нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай процессын хууль нь зөрчлийн тухай материаллаг хуультайгаа хамтад нь оруулсантай холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн Канад болон Унгар улсуудад зөрчлийн тухай материаллаг хууль болон зөрчил шалган шийдвэрлэх процессын харилцааг хамтад нь оруул сон юм байна. Унгар улсын

²¹⁹ Ю.Оюунаа. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ.2021. 39 дэх тал

²²⁰ Зөрчлийн хууль тогтоомжийн эмхтгэл. УБ.2018. 167 дахь тал

хуулийн нэршил нь шийдвэрлэх ажиллагаа гэсэн үг орсон бол Канад , Казакстан улсуудын хувьд зөрчлийн тухай хууль хэмээн нэрлэжээ.

Канад Улсын Зөрчлийн тухай хууль

1992 онд батлагдсан Канад Улсын Зөрчлийн тухай хуульд²²¹ “зөрчил” хэмээх хэргийн шинэ ангиллыг тусгасан бөгөөд энэ төрлийг хэргийг шалган шийдвэрлэх зорилгоор “зөрчлийн тухай мэдэгдэх хуудас”-ны шинэ системийг нэвтрүүлжээ. Энэ нь хөнгөн зөрчил болон эрүүгийн гэмт хэрэг хоорондын ялгааг тодорхой болгож өгснөөр хөнгөн зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, торгуулийн хэрэгжилтийг сайжруулах, маргаангүй хэргийг шүүхээс хасаж шүүхийн ачааллыг бууруулахыг зорьсон байна.²²²

1.Канад Улсын Зөрчлийн тухай хууль

1.1.Зөрчлийн хууль тогтоомж

1.2.Зөрчлийн хуудас, түүнийг бүрдүүлж хүргүүлэх

1.3.Тээврийн хэрэгслийн зогсоолын зөрчил

1.4.Насанд хүрээгүй хүн ба түүний хэргийг хянан шийдвэрлэх шүүх

2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа

2.1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх

2.2.Зөрчилд холбогдогчид олгох сонголтууд

2.3.Мэдүүлэг өгөх журам

2.4.Шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргах журам

2.5.Зөрчил хянан шийдвэрлэх

2.6.Шийтгэл оногдуулах шүүхийн шийдвэр

2.7.Эс үйлдэхүйд шийтгэл оногдуулах

3.Шүүхийн шийдвэрийг хянах

3.1.Шүүхийн шийдвэрт гомдол гаргах

3.2.Зөрчилд холбогдогчийн эзгүйд гаргасан шийдвэрийг хянах

3.3.Шүүх хуралдааны дараа шийдвэрийг хянах 7

4.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх журам

4.1.Шүүхээс албадлагын арга хэмжээ авах

4.2.Саатуулах, эсхүл хорих арга хэмжээ

4.3.Торгууль төлөх бусад хэлбэр²²³

²²¹ Contraventions Act (S.C. 1992, c. 47). <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-38.7/fulltext.html#right-panel>

²²² Contraventions Act Evaluation, Final Report. Department of Justice Canada, Office of Strategic Planning and Performance Management, Evaluation Division. November 2010. <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/cp-pm/eval/reprap/10/ca-lc/cae.pdf>

²²³ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

Канадын улсын Зөрчлийн тухай хуулиас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой онцлог бүхий зохицуулалтыг түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Зөрчлийн тухай хуулийн дагуу шүүхээс зөрчил үйлдсэн этгээдэд хорих шийтгэл оногдуулахгүй. Харин тэрээр торгуулийг заасан хугацаанд төлөөгүй бол түүний торгуулиа төлөх хүсэл байгаа эсэхээс хамаарч дараагийн арга хэмжээг авна. Тухайлбал, торгуулиа төлөх боломжтой боловч төлөх хүсэлгүй байгаа зөрчил үйлдсэн этгээдэд хорих хүртэл шийтгэл оногдуулж болно. Торгуулиа төлөх хүсэлтэй боловч төлөх боломжгүй зөрчил үйлдсэн этгээдийн хувьд торгуулиа үе шаттайгаар төлөх, эсхүл хугацааг сунгаж бусад хэлбэрээр төлөх боломжийг олгохоор хуульд зохицуулсан байна.²²⁴

Канадын улсын Зөрчлийн тухай хуулийн 1.2. Хууль сахиулах байгууллагаас зөрчлийн хуудасны хуулбарыг зөрчилд холбогдогчид хүргүүлэх ба дараах байдлаар хүргэнэ (§10):

- хувь хүнд – хуулбарыг зөрчилд холбогдогчид биечлэн өгнө. Хэрэв хуулбарыг зөрчилд холбогдогчид биечлэн өгөх боломжгүй бол түүний хамгийн сүүлд бүртгэгдсэн оршин суугаа газарт нь хүргэж, тэнд байгаа 18-аас доошгүй насны хүнд хуулбарыг үлдээнэ;

- хуулийн этгээдэд – хуулбарыг тухайн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтанд биечлэн өгнө, эсхүл хуулийн этгээдийн төв оффис руу баталгаат шуудангаар илгээнэ;

- Канад Улсад оршин суудаггүй хувь хүнд – хуулбарыг түүний хамгийн сүүлд бүртгэгдсэн оршин суугаа газар руу нь баталгаат шуудангаар илгээнэ. Баталгаат шуудангаар илгээсэн зөрчлийн хуудас нь түүний хуулбарыг шуудангаар илгээснээс хойш 7 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Дээрхи зохицуулалтаас үзвэл Канад улсад мэдээллийн цахим технологи ашигладаггүй, баталгаат шуудан ашиглах, биеэр хүргэж өгөхөд ихээхэн ач холбогдол өгдөг нь харагдаж байна.

Зөрчлийн хуулийн 2.2-д зөрчилд холбогдогчид олгох сонголтуудын талаар тусгажээ. Зөрчлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар зөрчилд холбогдогч нь зөрчлийн хуудас хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дараах процессын аль нэгийг сонгоно:

(а) торгуулийг төлөх: - гэм буруугаа хүлээн зөвшөөрч, зөрчлийн хуудсанд заасан газарт (*зөрчлийн хуудаст заасан*) торгуулийг төлөх;

(б) мэдүүлэг өгөх: - гэм буруугаа хүлээн зөвшөөрч, Зөрчлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлэг өгөх;

²²⁴ Канад Улсын Зөрчлийн тухай хуулийн 1.1 Зөрчлийн хууль тогтоомж

(в) шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргах: - Зөрчлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргах;

Зөрчлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зөрчилд холбогдогчийн мэдүүлэг өгөх журмыг зохицуулсан байна. Зөрчилд холбогдогч буюу зөрчлийн хуудас хүлээн авсан этгээд нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч, зөрчлийн хуудсанд заасан шүүхэд, цагт, эсхүл тухайн шүүхийн оффисын эрх бүхий албан тушаалтанд мэдүүлгээ өгнө. Зөрчилд холбогдогч нь оногдуулах торгууль буюу бусад хариуцлага, эсхүл торгууль төлөх хугацааны талаар мэдүүлэг өгнө.

Холбогдох шүүх, эсхүл түүний оффисын эрх бүхий албан тушаалтан нь мэдүүлгийг зөрчлийн хуудасны хамт дараах журмаар хянан шийдвэрлэнэ. Үүнд тухайн зөрчлийн хэргээр шүүх хуралдаан явуулахгүйгээр мэдүүлэг авах (эсхүл авахгүй) бөгөөд зөрчилд холбогдогчийг бууруутай гэж үзвэл түүнд торгууль оногдуулна, эсхүл торгуулийн хэмжээнээс хамаарч тухайн зөрчилтэй холбоотой аман нотлох баримт авна, эсхүл шүүх хуралдааныг Ерөнхий прокурорын²²⁵ оролцоотой хийнэ.

Зөрчлийн хуудасны дагуу эхлүүлсэн зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

- зөрчилд холбогдогч нь Зөрчлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан бол;
- зөрчилд холбогдогч нь насанд хүрээгүй бөгөөд зөрчлийн хуудас хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Зөрчлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд тусгасан сонголтуудын аль нэгийг хийгээгүй бол.²²⁶

Канад улсад зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэж хариуцлага хүлээлгэдэг байна. Өөрөөр хэлбэл тус улсад Зөрчлийн шүүх²²⁷ гэж тусгайлсан чиг үүрэг бүхий шүүх ажилладаг байна.

Унгар Улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль.

Унгар улс 2012 онд “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль” баталсан байна. Уг хуулийн 1-5 дугаар бүлэгт зөрчлийн тухай ерөнхий зохицуулалт, 6-21 дүгээр бүлэгт зөрчил шалган

²²⁵ <https://www.justice.gc.ca/eng/trans/transition/2015/tab2.html> Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор (Minister of Justice and Attorney General) - 1868 онд батлагдсан Хууль зүйн яамны тухай хууль (Department of Justice Act)-д заасны дагуу Хууль зүйн сайд нь Хууль зүйн яамыг удирдахын зэрэгцээ тус улсын Ерөнхий прокурорын албан үүргийг хамт хариуцна. Хууль зүйн яам нь сайдын энэ хоёр үүрэгт нь дэмжиж ажиллана.

²²⁶ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

²²⁷ Зөрчлийн тухай хуульд “зөрчлийн шүүх” гэж тухайн мужийн Губернаторын захирамжаар томилогдсон бөгөөд тухайн мужийн нутаг дэвсгэрийн харьяалалд үйлдэгдсэн зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхийг ойлгоно гэжээ

шийдвэрлэх ажиллагааны журам, 22 дугаар бүлэгт шийдвэр гүйцэтгэл болон зөрчлийн бүртгэлийн тогтолцооны талаарх зохицуулалт, 23-31 дүгээр бүлэгт бусад зөрчил буюу Зөрчлийн хуулийн тусай ангийн зохицуулалтуудыг агуулжээ.²²⁸

Тус хуулиар “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь хөөн хэлэлцэх хугацаа 6 сар байх бөгөөд зөрчил үйлдсэнээс хойш 2 жил өнгөрсөн бол зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй” хэмээн тодорхойлжээ.

Зөрчилд дараах төрлийн шийтгэл оногдуулдаг. Үүнд:

- баривчлах /1-60 хоног/;
- торгууль ногдуулах /5000-150000 форинт, хэрэв баривчлах шийтгэл оногдуулах хэмжээний зөрчил гаргасан бол 300000 форинт хүртэл/;
- нийтэд тустай хөдөлмөр хийлгэх /6-180 цаг/;

Зөрчлийн улмаас оногдуулсан шийтгэлийн ялтай байх хугацаа 2 жил байна. Энэ хугацаа нь давтан үйлдсэн зөрчилд хүндрүүлэх нөхцөл болдог. Үүнээс гадна эрх хасах, эд хөрөнгө хураах, хориглох, сануулах арга хэмжээ авах боломжтой байдлаар зохицуулсан.

Тус хуульд өсвөр насны хүүхэд, цэргийн алба хаагчдад хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан зохицуулсан.

Зөрчил гаргасан этгээдэд шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллага:

- Нийслэл, аймгийн Засгийн газрын алба;
- Энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд Цагдаагийн байгууллага, Үндэсний татвар, гаалийн алба;
- Захиргааны баривчлах шийтгэл оногдуулах зөрчилд орон нутгийн шүүх;
- Энэ хуулиар зөрчил үйлдсэн этгээдэд газар дээр нь торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны жагсаалтад орсон байгууллага, албан тушаалтан багтана.

Унгар Улсын Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуулийн 43 дугаар зүйлд зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог зохицуулсан байна. Прокурор Зөрчлийн албаны үйл ажиллагаа, авч буй арга хэмжээ хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, мөн зөрчлийн бүртгэлийн тогтолцоонд хууль ёсны хяналт тавьж ажилладаг.

Дээрх байгууллага прокуророос тавьсан шаардлага хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн бол хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, шийдвэрийг өөрчлөх, буцаах арга хэмжээ авах ба энэ тухай прокурорт мэдэгдэх үүрэгтэй.

²²⁸ (3)45 Szabalyisertesi elzarassal is buntetheto, valamnt e torvenyben meghatarozott szabalysertes miatt elso fokon a jorosbnrysog joe el

Хэрэв Зөрчлийн алба прокурорын шаардлагыг хангаагүй тохиолдолд прокурор 30 хоногийн дотор хүчин төгөлдөр шийтгэвэрийн эсрэг орон нутгийн шүүхэд хандах бөгөөд энэ тухайгаа Зөрчлийн албанд мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээж авсан Зөрчлийн алба 8 өдрийн дотор хэргийн холбогдох материалыг харьяаллын дагуу шүүхэд хүргүүлнэ.²²⁹

Зөрчил шалган тогтоох ажиллагааны явцад шаардлагатай үйл ажиллагаа явуулах, эд хөрөнгө хураах асуудлын хүрээнд зөрчил шалгах эрх бүхий байгууллага, хууль тогтоомжийн дагуу үйлдэл дээр нь шууд торгох эрх бүхий албан тушаалтан зөрчлийн эд мөрийн баримт болох эд зүйлийг хурааж авах эрхтэй. Ингэхдээ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1/ Зөрчлийн эд мөрийн баримт байх;

2/ энэ хуулиар хурааж авахыг зөвшөөрсөн эд зүйл байх.

Мөн хурааж авсан эд мөрийн баримтыг хэрхэн хадгалах, өмчлөх эрх бүхий этгээдэд буцааж олгох, ийм этгээд байхгүй тохиолдолд улсын өмчид шилжүүлэх, олон өмчлөгчтэй байвал хэнд нь буцааж олгох, хэрэглэх боломжгүй эд мөрийн баримтыг устгах тухай зохицуулалтыг оруулжээ.²³⁰

Зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах тухай шийдвэрийг зөвхөн шүүх гаргана.

Давж заалдах хэлбэр нь санал, давж заалдах өргөдөл, гомдол байна. Бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Зөрчлийн албаны шийтгэвэр, эсхүл арга хэмжээ авах тухай шийдвэрийн эсрэг санал, бусад шийдвэр, арга хэмжээ болон авах ёстой байсан арга хэмжээг авалгүй орхигдуулсан тохиолдолд гомдол, эсхүл шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах өргөдөл гаргана.²³¹

Давж заалдах хугацааны тухайд тухайн шийдвэрийг танилцуулснаар, авах ёстой байсан арга хэмжээг авалгүй орхигдуулсан тохиолдолд энэ тухай мэдээлэл авсан өдрөөс эхлэн 8 хоног байна. Хуулиар хориглосон, давж заалдах эрхгүй хүнээс гаргасан, эсхүл хугацаа хоцорсон, эсхүл давтан нэг асуудлаар гаргасан тохиолдолд зөрчлийн алба, прокурор, шүүх санал, гомдол, давж заалдах өргөдлийг хүлээж авахаас татгалзана.

²²⁹ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

²³⁰ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

²³¹ (2) Jogorvoslatok a kifogas, a fellebbezes es panasz. E torveny eltero rendelkezesenek hanyaban a)
(4) A jogorvoslati hatarido-e torveny elterro rendelkezesenek hanyaban2 a kozlestol, az intezkedes elmunasztasa eseten az Errol vola tudomasszerzestol szamitott nyloc nap.
(5) az arra nem jogosulttyl, szormazy, az ismnotelten azonos tartalomasztasa tartalommal az arra nem jogosulttyl valamint az azonos tartalommal.

Унгар Улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуульд ажиллагаанаас зарим онцлог зохицуулалтуудыг авч үзвэл

- Тус улсад Зөрчлийн алба үйл ажиллагаа явуулдаг;
- Баривчлан шийтгэл оногдуулах хэмжээний зөрчил гаргасан бол торгууль оногдуулж болдог;
- Хуульд өсвөр насны хүүхэд, цэргийн алба хаагчдад хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан зохицуулсан зэргийг дурдаж болохоор байна.

Казакстан улсын Захиргааны зөрчлийн тухай хууль

Бүгд найрамдах Казакстан улсын парламент нь 2014 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 53 бүлэг, 920 зүйл анги бүхий “Захиргааны эрх зүйн зөрчил”-ийн тухай хуулийг баталж, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар захиргааны хариуцлагад тооцох үндэслэл, зарчмыг тогтоох, ямар үйлдлийг зөрчилд тооцох, зөрчил гаргасан этгээдэд ямар төрийн байгууллага, албан тушаалтан, ямар шийтгэлийг, ямар журмаар оногдуулах асуудлыг зохицуулдаг. Тухайлбал уг хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Захиргааны шийтгэл гэж зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах болон зарим эрхийг хасах тухай хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан, шүүхийн зүгээс авч хэрэгжүүлж буй албадлагын арга хэмжээ мөн” гэж заажээ.

Мөн “захиргааны шийтгэл нь зөрчил гаргасан этгээдийг хүмүүжүүлэх, хууль журмыг сахих, хүндэтгэх байдлыг дээшлүүлэх, зөрчил гаргагч болон бусад этгээдийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх ба хувь хүн, хуулийн этгээдийн нэр хүндэд халдах, доромжлох, бие махбодь, сэтгэл санааны хохирол учруулах зорилго агуулахгүй²³² гэж заажээ.

Тус улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль дахь зарим онцлог заалтаас дурдахад, энэ хуулийн 74 дүгээр зүйлд Бүгд Найрамдах Казахстан улсын иргэншлийг авахад саад учруулсан албан тушаалтан хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тенгегээр торгууль ногдуулдаг.

Харин энэ үйлдлээ 1 жилийн хугацаанд давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлэх хэмжээний тенгегээр торгодог. Харин хуулийн 73 дугаар зүйлд гэр бүлийн харилцаан дахь зарим хууль бус үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан бөгөөд тухайлбал “хүнийг зүй бусаар хараах, басамжлан доромжлох, гэрийн эд хогшлыг эвдэж сүйтгэсэн, гэр бүл

²³² Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 40 дүгээр заалтын 1-5 дахь хэсэг

ахуйн харилцаанд гарсан, тэдний амгалан тайван байдлыг алдагдуулсан, хүндэтгэлгүй хандсан зэрэг эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд, хэрэв энэ үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулаагүй 3 хүртэлх хоногийн хугацаанд захиргааны баривчилгаанд татдаг, хэрэв энэ үйлдлээ 1 жилийн дотор давтан үйлдвэл 10 хоног баривчилдаг бол 2-оос дээш удаа энэ төрлийн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тенгегээр торгууль ногдуулах шийтгэл оногдуулдаг байна.

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу дараах төрлийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Үүнд:

10. Сануулах;
11. Торгох /хувь хүнд нэг өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин, албан тушаалтанд 700 дахин, аж ахуйн нэгжид 1000 дахин, томоохон хуулийн этгээдэд 2000 дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний торгууль ногдуудаг/;
12. Зөрчил үйлдсний үр дүнд олж авсан эд хөрөнгө, эд мөрийн баримт эсхүл зөрчил үйлдсэн зүйлийг хураан авах;
13. Зөрчил гаргахад хэрэглэсэн эд зүйл, багаж хэрэгслийг хураан авах;
14. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах /1 сараас 2 жил хүртэл/;
15. Тусгай зөвшөөрөл хураах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг зогсоох /6 сар хүртэл хугацаагаар/, данс битүүмжлэх;
16. Үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсвэл зогсоох /10 хоног хүртэл/;
17. Хууль бусаар барьсан болон баригдаж байгаа барилгыг албадан буулгах;
18. Захиргааны баривчилгаа /30 хоног хүртэл/, баривчилгааны хугацааг 3 цагаас хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно²³³ гэж заасан.

Үүнээс үзэхэд захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд оногдуулсан хамгийн хүнд шийтгэл нь захиргааны баривчилгаа бол хуулийн этгээдийн хувьд их хэмжээний торгууль ногдуулах эсхүл үйл ажиллагааг нь зогсоох, зарим тохиолдолд тодорхой үйл ажиллагаа явуулах лиценз, эд хөрөнгө хураах зэрэг зохицуулалт оруулсан байна.

Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн хуульд дараах Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд байхгүй дараах шинэлэг зохицуулалт байна гэж харлаа.

Энэхүү зохицуулалт нь бол зөрчил гаргасан иргэнд тухайн зөрчлийг анхны удаа гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тенгегээр, тухайн үйлдлээ нэг жилийн дотор

²³³УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

давтан гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлэх хэмжээний тенгегээр торгодог явдал юм.

Түүнчлэн манай Зөрчлийн тухай хуульд тусгагдсан танхайрах, гэр бүлийн хүчирхийлэлд хамаарах үйлдлүүдийг гаргасан тохиолдолд тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулаагүй 3 хүртэлх хоногийн хугацаагаар баривчилдаг, хэрэв энэ үйлдлээ 1 жилийн дотор давтан үйлдвэл 10 хоног баривчилдаг, 2-оос дээш удаа энэ төрлийн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээр тенгегээр торгодог нь манай Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хуульд тусгавал зохих шинэлэг зохицуулалт гэж харж байна.

Хүснэгт

№2

Монгол Улс	Канад Улс	Унгар улс	Казакстан улс
1. торгох; 2.баривчлах; 3.эрх хасах. ²³⁴	1. торгох; 2.баривчлах; 3.бусад.	4. баривчлах; 5. торгууль ногдуулах; 6. нийтэд тустай хөдөлмөр хийлгэх;	1. Сануулах; 2. Торгох 3. Зөрчил үйлдсний үр дүнд олж авсан эд хөрөнгө, эд мөрийн баримт эсхүл зөрчил үйлдсэн зүйлийг хураан авах; 4. Зөрчил гаргахад хэрэглэсэн эд зүйл, багаж хэрэгслийг хураан авах; 5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах; 6. Тусгай зөвшөөрөл хураах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг зогсоох; 7. Үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсвэл зогсоох; 8. Хууль бусаар барьсан болон баригдаж байгаа барилгыг албадан буулгах; 9. Захиргааны баривчилгаа ²³⁵

Дээрхи хүснэгтэд зөрчилд оногдуулах шийтгэлүүдийг харьцуулан авч үзвэл дээрхи 4 улсуудын хуулиудад торгох, баривчлах гэсэн шийтгэлүүд байгаа бол Монгол, Казакстан улсуудад эрх хасах шийтгэл байна. Түүнчлэн дээрхи 4 улсын зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын төрлүүдээс Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд сануулах, эд зүйл хураан авах, үйл ажиллагааг зогсоох, хориглох, барилга албадан буулгах шийтгэлүүд байгаа нь

²³⁴ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

²³⁵ УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс 2021 онд орчуулсан материалаас хэсэгчилэн авав.

онцлог шийтгэл гэж үзэж байна. Унгар улсын хуульд тухайн зөрчилд баривчлах шийтгэл оногдуулсан ч түүнийг торгох шийтгэлээр сольж болдог зохицуулалт байгаа нь судалж үзвэл зохистой туршлага гэж үзэж байна.

Дүгнэлт. Монгол Улсаас бусад Казакстан, Канад, Унгар улсуудын зөрчил шалгаж буй процессын ажиллагаануудыг бүгд материаллаг хуультайгаа хамтад нь нэг хууль болгон нэгтгэн оруулж ирсэн нь зөрчил болон зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаа нь нэг бүхэл цогц ажиллагаа гэж үздэгтэй холбоотой гэж үзэж байна.

Канад Улсын хувьд зөрчил үйлдсэн иргэнд зөрчлийн хуудас өгдөг бөгөөд энэхүү зөрчлийн хуудсыг биечлэн хүргэж өгөх, эсхүл баталгаат шуудангаар хүргэдэг, цахим сүлжээ ашигладах талаар хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй байгаа нь сүлжээний баталгаа хангагдаагүй, эсхүл зөрчил бүрийг шүүхээр заавал оруулж шийдвэрлэдэг тогтолцооноос үүдэлтэй гэж үзэж байна. Түүнчлэн Казакстан улсын зөрчилд хүлээлгэж буй шийтгэлийн төрөл бусад улсуудынхаас олон байгаа нь зөрчил тус бүрийн онцлогт нь тохируулж шийтгэл оногдуулах бодлого баримталсанаас харагдаж байна.

Казакстан, Канад, Унгар улсуудын зөрчил шалгаж буй процессын ажиллагаануудыг өөр өөрийн улс орны хууль зүйн бодлого, баримталж буй үзэл хандлага гэж үзэж болохоос гадна дэг журам сахиулах арга барилтай холбоотой гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах зохицуулалтуудыг Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг сайжруулах боломж байна гэж үзэж байна. тухайлбал:

5. Канад улсын Зөрчлийн тухай хуульд заасан жишгээр Зөрчлийн төрөлжсөн шүүх байгуулах талаар судалгаа хийж, үр нөлөөг нь тодорхойлох

6. Унгар улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуульд заасан “баривчлах шийтгэлтэй зөрчлийг өндөр мөнгөн дүнтэй торгуулиар сольж болох зохицуулалтыг судалж, нэвтрүүлэх

7. Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд өсвөр насны хүүхдэд хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан тусгаж өгөх

8. Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд заасан зөрчил давтан үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан зохицуулалтыг нэвтрүүлэх, мөн зөрчилд хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг зөрчлийн хор аюул, учруулсан хохирлын хэмжээнээс нь хамааруулан нэмэгдүүлэх зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль

18. Монгол Улсын Үндсэн хууль
19. Зөрчлийн тухай Монгол Улсын хууль
20. Зөрчил шалган шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль
21. Өрсөлдөөний тухай Монгол Улсын хууль
22. Канад Улсын Зөрчлийн тухай хууль
23. Унгар улсын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль
24. Казакстан улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль

Ном, гарын авлага

25. Ю.Оюунаа. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ.2021
26. Зөрчлийн хууль тогтоомжийн эмхтгэл. УБ.2018

Сэтгүүл

27. Төрийн мэдээлэл. 1992. №1.
28. Төрийн мэдээлэл. 2017. №24.

Судалгааны материал

29. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын матераил
30. УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгийн 2021 онд хийсэн орчуулгын судалгааны материал

Цахим эх сурвалж:

31. <https://legalinfo.mn>
32. <https://nli.gov.mn>
33. <https://laws-lois.justice.gc.ca>
34. <https://www.justice.gc.ca>

**ХАЛДВАРТ ӨВЧИН БА ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБА ХААГЧААС АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**
**CONTAGIOUS DISEASES AND SOME CONSIDERABLE ISSUES
ON OFFICERS AND POLICE**

Б.Эрхэмбаяр
ДХИС-ийн магистран,
цагдаагийн ахмад

*B.Erkhembayar - student,
University of Law Enforcement,
police captain*

Хураангуй. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах нь хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймрийн нэгэн адил аюулт үзэгдэл юм. Энэ аюулт үзэгдлийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдож, улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлдөг учраас гамшигт тооцдог байна. Энэхүү өгүүлэлд хүн, мал, амьтны гоц халдварт өвчний тухай ойлголт, шинж, халдварт өвчин гарсан үеийн хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагаанд оролцож буй цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, анхаарах зарим асуудлын талаар товч авч үзсэн болно.

Astract. Outbreak of highly contagious diseases of humans, livestock and animals are like as dangerous phenomenon a strong snow and dust storms, droughts, floods, earthquakes, desertification, and fires. Due to this dangerous phenomenon, human health and loss of life, livestock and animals are killed in large numbers, and it has a negative impact on the country's economy, so it is considered a disaster. In this article, we discussed briefly about concept and symptoms of highly contagious diseases of humans, livestock and animals, also some considerable issues, operations of police officers who are taking part in quarantine operation during the outbreak of contagious diseases.

Түлхүүр үг. Өвчин, халдвар, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цагдаагийн алба хаагч, хорио цээрийн дэглэм, хязгаарлалт

Key word. Diseases, contagions, highly contagious diseases of humans, livestock and animals, police officers, quarantines, restrictions,

Үндсэн хэсэг. Дэлхий дээр мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг 200 гаруй өвчин бүртгэгдэж байгаагаас манай улсад 30 орчим өвчнийг оношилж бүртгэж байна. Сүүлийн жилүүдэд тарваган тахал, боом, галзуугийн халдварын

намжмал голомтын идэвх сэргэж, хачигаар дамжих халдвар нэмэгдэж, хумхаа, корона, эбола, зика, денгийн чичрэг зэрэг өвчин бусад улсаас зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл өндөр байна.

Эмэнд тэсвэртэй нянгийн халдвар, ялангуяа эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх, тандах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, лабораторийн чанарын хяналт, биоаюулгүй ажиллагааг сайжруулах, хүний нөөц, тоног төхөөрөмж, оношлуур урвалжийн хангамжийг нэмэгдүүлэх хэрэгцээ тулгарч байна.

Орчин үед хот, суурин газрын агаар, хөрсний бохирдол нь бага насны хүүхдийн дунд зонхилон тохиолдох амьсгалын замын болон гэдэсний халдварын өвчлөлд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Улаанбаатар хотын 1 грамм хөрсөнд агуулагдах бактерийн нийт тоо өвлийн улиралд 3.1-5.4 сая, зун 3.2-21 сая байгаа бөгөөд хөрсний бохирдолтой шууд хамааралтай байдаг гэдэсний халдварт өвчинд гэр хорооллын хүүхэд илүү өртөж байна. Ундны усны нян судлалын шинжилгээгээр нянгийн тоо, коли индексийн үзүүлэлт өндөр байна. Агаарын бохирдлоос үүдэлтэй хүүхдийн өвчний ихэнх хувийг уушгины доод замын халдвар буюу хатгалгаа өвчин эзэлж, уг өвчний улмаас эмнэлэгт хэвтсэн хүүхдийн 80 хувь нь өвлийн цагт эмчлүүлж байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, даяаршил, хотжилт, шилжилт хөдөлгөөн, ядуурал, ажилгүйдэл, эм бэлдмэлийн зохисгүй хэрэглээ ихэсч, халдварт өвчнөөс сэргийлэх иргэдийн зөв зан үйл төлөвшөөгүй байгаа нь зонхилон тохиолдох халдварт өвчин, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний тархалт нэмэгдэхэд нөлөөлж байна.²³⁶

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гэж олон улсын хил хязгаараас үл хамааран богино хугацаанд дамжин тархаж хүн ба мал, амьтны эрүүл мэндэд болон улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулж, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх халдварт өвчнийг хэлнэ.

Өвчин гэж гарал буюу эх үүсвэрээсээ хамаарахгүйгээр хүмүүст ихээхэн гэм хор учруулах эсвэл учруулж болох өвчин эмгэг буюу эрүүл мэндийн төлөв байдлыг хэлнэ.

Халдвар гэж хүн амьтны эрүүл мэндэд аюул учруулж болох халдвар үүсгэгч хүн болон амьтны биед нэвтрэн орох өсөх буюу үржихийг хэлнэ.²³⁷

Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.7."олон улсын хөл хориот өвчин" гэж Олон улсын эрүүл мэндийн дүрэмд заасан өвчнийг²³⁸ хэмээн тус тус тодорхойлжээ.

²³⁶ <http://uv.mohs.gov.mn> Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралт. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр

²³⁷ Г.Даваадорж, С.Цогтбаатар. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. УБ. 2009. 54 дэх тал

²³⁸²³⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №21. Эрүүл мэндийн тухай хууль

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед Онцгой байдлын алба, эмнэлгийн байгууллага, мэргэжлийн хяналтын албадтай хамтран өвчний голомт болсон бүс, нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагаанд оролцдог. Цагдаагийн алба хаагчид хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагааны явцад халдварт өвчин тусах магадлалтай тул эрүүл мэндээ хамгаалах, хувийн эрүүл мэндийн аюулгүй байдлаа хангах мэдлэг, ур чадварыг тодорхой хэмжээнд эзэмшсэн байх шаардлага тулгардаг.

Өвчин бол хувь хүний үзэл бодлоос үл хамаарч, хүний бие организмын хэвийн байдлыг алдагдуулдаг зүйл бөгөөд цаг алдалгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ²³⁹ үзүүлж чадвал эрүүл мэндийн аюулгүй байдлаа хамгаалж чадах боломж нэмэгдэх юм. Түүнчлэн хувь хүний эрүүл мэндийн аюулгүй байдалд амьдрах орчин нөхцөл болон ажлын байр нь “эрүүл ахуйн нөхцөл шаардлага”²⁴⁰ хангасан байвал тэр хэмжээгээр эрүүл мэндийн аюулгүй байдал хангагдах нэг нөхцөл бүрдэнэ.

Бие махбодийн эрүүл мэнд бол гадаад үзүүлэлтээр үл хамааран амьдралын үйл явцын төгс зохицуулалтыг баримталж буй хувийн шинж чанар юм. Хувь хүний сэтгэцийн эрүүл мэнд нь дотоод болон гадаад орчинд хангалттай хэмжээнд хүрч чадах чадвар юм. Нийгмийн таатай нөхцөл бол хувь хүн тухайн цаг үеийн нийгмийн орчинд амжилттай дасан зохицох чадвар юм.²⁴¹

Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.2-д “эрүүл мэндийг хамгаалах гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг” хамааруулан авч үздэг байна. Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад нэг томоохон хүчин зүйл бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй авах болон эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан орчинд ажиллахаас гадна халдварт өвчний талаар мэдлэгтэй байх шаардлага тулгардаг. Гэвч алба хаагчид халдварт өвчний талаарх мэдлэгийн ач холбогдлыг төдийлөн ойшоохгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/86 тоот тушаалаар “Хорио цээр тогтоох өвчний жагсаалт”-ыг баталсан. Үүнд:

1. Боом
2. Шүлхий

²³⁹ Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.3. “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг;

²⁴⁰ Төрийн мэдээлэл. 2016. №07. Эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.3. “эрүүл ахуйн нөхцөл, шаардлага” гэж эрүүл ахуйн дүрэм, журам, заавар, стандартад заагдсан хэм хэмжээг хангасан байхыг;

²⁴¹ <https://mn.unansea.com>

3. Цэцэг /хонь, ямаа, адуу, тэмээ/
4. Өндөр хоруу чанартай шувууны томуу
5. Үхрийн мялзан
6. Ямааны годрон
7. Гахайн мялзан / сонгомол, африкийн /
8. Туулайн вируст цусан халдвар
9. Туулайн миксоматоз
10. Шувууны Ньюкасли өвчин
11. Үхрийн цээж
12. Хорт салст халуурал
13. Гахайн үржил амьсгалын замын хам шинж
14. Бог малын мялзан төст өвчин
15. Галзуу
16. Гахайн ёлом

Харин хязгаарлалт тогтоох өвчний жагсаалтад дараах 62 өвчин багтсан байна. Тухайлбал: Цусан халдвар, Листериоз, Адууны томуу, Адууны ям, Бруцеллёз / үхэр, хонь, маа, гахай, нохой/, Энтериобактериоз, Шөвөг яр, Дотрын халдварт хордлого, Сохор догол, Аденоматоз, Хонь, ямааны Маэди-Висна, Гахайн сальменоз, Шувууны гамбора, Шувууны ларинготрахеит, Адууны халдварт цус багасах, Үхрийн сүрьеэ, Шувууны сүрьеэ, Үхрийн ринотрахеит, Адууны пневмони, Үхрийн диарей, Адууны иж балнад, Колибактериоз, Адуун сахуу, Нохойн гударга, Иж балнад, Гүүний иж балнад, Некробактериоз, Үхрийн лейкоз, Зөгийн үжил, Зөгийн аскосфероз, Зөгийн варрооз, Нийлүүлгийн өвчин, Хонины энзоот зулбах, Дэлэнгийн өмрөө, Хэл хөхрөх, Зогсоо, Ботулизм, Адууны вирус артрит, Ёлом, Туляреми, Ку чичрэг, Токсоплазмоз, Лейшманиоз, Хачигт реккетсиоз, Хачигт энцефалит, Баруун Нилийн халдвар, Анаплазмоз, Бабезиоз, Нохой муурны парвовирусын халдвар, Шувууны микоплазмоз, Шувууны пуллороз, Марекын өвчин, Кампилобактериоз, Хулгана яр, Адууны хачгийн халуурал, Тэмээний амруу, Гахайн миксоплазмоз, Үхрийн тархи сархиатах, Сул хоруу чанартай шувууны томуу, Дуут хавдар, Иж сүрьеэ, Лептоспириоз, Хамуу зэрэг өвчнүүд хамаарч байна.

Дэлхийн улс орнуудад гарсан болон гарч байгаа халдварт өвчний нөхцөл байдлын мэдээг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага дараах 3 түвшинд ангилан гаргадаг байна. Үүнд: 1)Өвчнөөр тайван бус орнууд; 2)Өвчний анхны тохиолдол бүртгэгдсэн дэлхийн улс орнууд; 3)Өмнө нь өвчнөөр тайван биш байсан орнуудад бүртгэгдсэн өвчний шинэ тохиолдол зэрэг болно.

Манай улсад мал, амьтны гаралтай олон өвчин гарч байсан бөгөөд үүнээс мал, амьтны шүлхий, хүн малын халдварт боом өвчин хамгийн түгээмэл дэлгэрч, хорио цээрийн дэглэм тогтоодог.

Шүлхий өвчин. Шүлхий нь олон улсын амьтны халдварт өвчний “А” ангилалд багтдаг, маш богино хугацаанд олон төрлийн мал, амьтан хамран сум, аймаг, улс, тив, дэлхийд дамжин тархах аюултай, эдийн засгийн ихээхэн хохирол учруулдаг, олон улсын худалдааны хорио цээрт өвчин юм.²⁴²

Халдварт вирусн тэсэх чадвар: Шүлхийн вирус нь маш хувьсамтгай бөгөөд амьдарч буй орчноос хамааран амьдрах чадвар нь янз бүр байна. Тухайлбал хуурай материалын гадаргад 14 хоног, хүйтэн нөхцөлд 6 сар, шээсэнд 39 хоног, хавар, намар хөрсний гадаргууд 28 хоног, зун хөрсний гадаргууд 3 хоног тус тус амьдрах чадвартай.

Шүлхийгээр үхэр, хонь, ямаа, тэмээ, гахай болон зэрлэг туруутан амьтад (буга, цаа буга, хандгай, цагаан зээр гэх мэт) өвчилдөг байна.

Халдварын голомт: Өвчний халдварыг тараах үндсэн эх үүсвэр нь халдварлагдсан, өвчтэй, өвчилж өнгөрсөн мал, амьтан, тэдгээрээс ялгаран гарсан шүлхийн вирустэй шүлс, сүү, баас, шээс мэтийн зүйлсээр бохирлогдсон гадаад орчин нь халдварын голомт болно.

Үүнд вирусээр бохирлогдсон малын хашаа, саравч, бууц, ус, бэлчээр, малын тоног хэрэгсэл, сав суулга, хөдөлмөрийн багаж, тээврийн хэрэгсэл, хувцас зэрэг багтана.

Шүлхийн онцлог шинж тэмдэг: Шүлхийгээр өвдсөн мал амьтанд илэрдэг хамгийн онцлог шинж бол амны хөндийн салст бүрхэвч нь үрэвсэн цэврүүтсэнээс шүлс нь асгарч, туурай нь үрэвсэж өвчилдөг. Ийм учраас энэ өвчнийг зарим улсад “Туурай болон амны өвчин” гэж нэрлэдэг билээ. Энэ нь олон улсын нэршлээр “Foot and Mouth Disease” буюу (FMD) гэж нэрлэдэг байна.

Хүн малын халдварт боом өвчин. Боом өвчин нь арьсны тунгалгийн зангилаа болон дотор эрхтэнд шүүст цусархаг үрэвсэл бий болгож, өвөрмөц хатиг буюу үжил үүсгэдэг хурц хордлогот, нянгийн гаралтай, мал амьтнаас хүнд халдварладаг хурц халдварт өвчин юм. Ихэнхи тохиолдолд хүний арьс, булчирхай болон судсийг нь гэмтээж хүчтэй хордлого үүсгэдэг өвчин бөгөөд таван хошуу мал, гахай болон өвсөн тэжээлт ан амьтан, хүн өвчилнө. Мал, амьтнаас халдварладаг боом өвчинг эмчилгээг нь цаг алдалгүй, шуурхай хийхгүй бол хүний амь насанд аюул учруулж болох юм.

Халдвар дамжих зам: Боом өвчний үүсгэгч ВАС. Anthracis. Үүсгэгч нь гадна (хүчилтөрөгч, температур) нөлөөнөөс хамаарч хуяг үүсгэдэг, тэр нь газрын хөрсөнд олон жилээр хадлагдан гол төлөв дулааны улиралд тэжээл боловсруулах

²⁴² П.Дамдин. Гамшгийн эрсдлийг бууруулах менежмент. УБ. 2005. 79 дэх тал

замаар болон шархаар дамжин халдварлаж, ихэвчлэн хурц, хурцавтар явцтайгаар өвчлүүлдэг.

Өвчилсөн мал, амьтан үжил, хордлогын хүнд хэлбэр болон халдварын шинж тэмдэгтэй илэрдэг, үхлийн хувь өндөр, дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан эрүүл ахуйн кодексийн “Б” жагсаалтад хамаардаг халдварт зооантропоноз өвчин юм. Өвчний нууц үе 7-20 хоног, өвчин гарч эмнэлзүйн болон лабораторын шинжилгээгээр онош нь батлагдсан тохиолдолд (Тухайн аймаг, сумын Засаг даргын захирамжаар) хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоож, халдварын голомтыг устгах, малыг вакцинжуулах, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үхсэн малын хүүр, сэг зэм, бохирлогдсон хөрс, ус, бэлчээр, хашаа хороо, өтөг бууцыг хлорын нохойн 10-20 хувийн цийдмэгээр, килссагийн 1:500 уусмалаар шүршиж, арьс, шир, ноос, ноолуурыг 10 хувийн давсны уусмалаар, содын 0.25-0.3%-ийн формальдегидын 2%-ийн уусмалаар угааж халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагын хяналт дор хийж гүйцэтгэнэ²⁴³

Халдварт өвчин гэж 1~5 дугаар зэрэглэлийн халдварт өвчин, шимэгч хорхойн гаралтай, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын тандалтад байдаг, биологийн зэвсэг болгон ашигладаг халдварт өвчнүүд болон бэлгийн замын болон зоонозын, эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад халдварлан дамждаг өвчнүүдийг хэлнэ.²⁴⁴

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай²⁴⁵ хуульд халдварт өвчний тодорхойлолтыг оруулж өгөөгүй байна.

Халдварт өвчний ангилалыг хүснэгтэд оруулан авч үзвэл.

Хүснэгт №1

Ангилал	Ухагдахуун
---------	------------

²⁴³ П.Дамдин. Гамшгийн эрсдлийг бууруулах менежмент. УБ. 2005. 114 дэх тал

²⁴⁴ Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хяналт тавих тухай хуулийн 2.1 дүгээр заалт. (Хүчингүй болсон)
<https://m.easylaw.go.kr/MOM/SubCsmOvRetrieve.laf?langCd=700109&csmSeq=1598&ccfNo=1&cciNo=1&cnpClsNo=1>

²⁴⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №46

1 дүгээр зэрэглэлийн халдварт өвчин	Биологийн зэвсэг болгон ашигладаг халдварт өвчин, нас баралтын зэрэг өндөртэй, хэсэг бүлэг хүмүүсийг хамрах, олон нийтийг хамран дэлгэрэх хандлагатай үед даруй мэдээлэх үүрэг бүхий, тусгаарлалтын бүрэн тоноглолтой хэвтрийн өрөөнд тусгаарлах, өндөр аюулын зэрэглэлд тусгаарлах шаардлагатай халдварт өвчин
2 дугаар зэрэглэлийн халдварт өвчин	Халдвар тараах чадварыг нь харгалзан халдварт өвчин дэгдэж, дэлгэрсэн тохиолдолд 24 цагийн дотор мэдээлж, өвчтнийг тусгаарлах шаардлагатай халдварт өвчин. Үүнд: дотоодод гэнэт нэвтэрч, дэлгэрэх шинжтэй болсны улмаас яаралтай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хяналт тавих шаардлага үүссэн, Өвчний хяналтын газрын дарга, Эрүүл мэнд, халамжийн яамны сайдын нэр зааж тогтоосон халдварт өвчнүүд багтана.
3 дугаар зэрэглэлийн халдварт өвчин	Дэгдэлтийн тохиолдлыг нь байнга тандаж байх шаардлагатай, дэгдэж, дэлгэрснээс хойш 24 цагийн дотор заавал мэдээлэх халдварт өвчин. Үүнд: дотоодод гэнэт нэвтэрч, дэлгэрэх шинжтэй болсны улмаас яаралтай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хяналт тавих шаардлага үүссэн, Өвчний хяналтын газрын дарга, Эрүүл мэнд, халамжийн яамны сайдын нэр зааж тогтоосон халдварт өвчнүүд багтана.
4 дүгээр зэрэглэлийн халдварт өвчин	1~3 дугаар зэрэглэлийн халдварт өвчнөөс бусад дэлгэрч байгаа эсэхийг нь тогтоохын тулд халдварт өвчний тандалт судалгаа хийх шаардлагатай халдварт өвчин
Шимэгч хорхойн гаралтай халдварт өвчин	Шимэгч хорхойн халдварын замаар дэгддэг халдварт өвчин
Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тандалтанд байдаг халдварт өвчнүүд	Өвчний хяналтын газрын даргын нэр зааж тогтоосон Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас Олон улсын нийгмийн эрүүл мэндэд онцгой байдал үүссэн нөхцөлд бэлэн байх зорилгоор тандалтад хамрагдах объект болгосон халдварт өвчнүүд.
Биологийн зэвсэг болгон ашигласан халдварт өвчин	Өвчний хяналтын газрын даргын нэр заасан халдварт өвчний үүсгэгчийг зориуд, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах зорилгоор ашигласны улмаас дэгддэг халдварт өвчин.
Бэлгийн замын халдварт өвчин	Өвчний хяналтын газрын даргын нэр заан тогтоосон бэлгийн замаар дамжин тархдаг халдварт өвчин
Амьтнаас хүнд дамжин халдварладаг халдварт өвчин	Өвчний хяналтын газрын даргын нэр заасан мал, амьтнаас хүнд дамжин тархдаг халдварт өвчний үүсгэгчээр дэгддэг халдварт өвчин
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад авсан халдварт өвчин	Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөн, жирэмсэн эхэд дамжин халдварладаг, Өвчний хяналтын газрын даргын нэр зааж тогтоосон, байнгын тандалтанд байх шаардлагатай халдварт өвчин.

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөр хүн өвчилсөн үед Эрүүл мэндийн яамны харъяа Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/, Байгалийн голомтод халдварт өвчинтэй тэмцэх үндэсний төв /БГХӨСҮТ/, мал, амьтан өвчилсөн тохиолдолд Хүнс, хөдөө аж ахуйн яамны харъяа Улсын мал эмнэлгийн газар /УМЭГ/, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори /УМЭАЦТЛ/ гоц халдварт өвчний оношыг баталгаажуулж, Улсын мэргэжлийн хяналтын газар дүгнэлт гаргана.²⁴⁶

Дээрхи мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлтийг үндэслэн хүн, мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийг дараахи байдлаар тус тус тогтооно. Үүнд:

1. Хоёроос дээш аймгийн нутаг дэвсгэрт болон төмөр зам, нисэх, усан замын буудал, хилийн боомт, улсын чанартай авто болон мал тууврын замд гоц халдварт өвчин гарсан тохиолдолд тухайн төрийн захиргааны төв байгууллага /ЭМЯ, ХХААЯ, УМХГ/-ын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар тогтооно.

2. Орон нутагт гоц халдварт өвчин гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагууд /БГХӨСҮТ, ХӨСҮТ, ЭМГ, УМЭГ, УМЭАЦТЛ, УМХГ болон орон нутгийн үйлчилгээний нэгж/-ийн дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

Хорио цээр тогтоосон нөхцөлд тухайн шатны Засаг дарга хүн хүч, хөрөнгө гаргаж, малын өвчинтэй тэмцэх шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан бүс, нутаг дэвсгэрт хорио цээр тогтооход оролцож байгаа цагдаагийн байгууллага болон мэргэжлийн байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоол “Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам”-ыг баримтлан ажиллана.

Хорио цээрийн дэглэм тогтоох гэдэг нь хүн ба мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед халдварын тархалтын голомтыг хязгаарлан зогсоох, халдвар дамжин тархахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлнэ.

Халдварлалт, тархалт, гарз хохирол багатай халдвартай өвчний цаашдын тархалтыг таслан зогсоох, зарим онцгой аюулт халдварт өвчний үед тогтоосон хорио цээрийг татан буулгасны дараа мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл, ус, бэлчээр, хашаа, байрны ашиглалтыг зохицуулах зорилгоор халдварын голомт, нэг буюу хэд хэдэн хот айл, суурь сүрэг, баг, сумын нутаг дэвсгэрийг хамруулан авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хязгаарлалт гэнэ.

²⁴⁶Даваадорж, Г., Цогтбаатар, С. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. 2009. Улаанбаатар. х. 56

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан бүс, нутаг дэвсгэрт хорио цээрийн бүс байгуулж, дэглэм тогтооход оролцох цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаандаа а)Ажиглалт хийх; б)Шалгалт хийх; в)Хязгаарлалт, хориг тавих; г)Мэдээлэл цуглуулах; д)Хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих; е)Тайлбарлан таниулах; ё)Техник хэрэгсэл ашиглан хяналт тавих зэрэг аргуудыг ашиглана.

Хүн, мал, амьтны халдвартай өвчин гарсан тохиолдолд “Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”²⁴⁷, “Хязгаарлалт хорио цээр тогтоох журам”²⁴⁸-ын дагуу Улсын мал эмнэлгийн албаны зохих байгууллагуудын гаргасан дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга, Засгийн газраас хязгаарлалт, хорио цээр тогтоож нийтэд зарлан мэдэгдэнэ.

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөр хүн халдварлагдсан үед өвчтөнийг үзэж анхны онош тавьсан эмч, эмнэлгийн ажилтан өвчтөнийг тусгаарлаж хавьтагсдыг тодруулан цаашид, орох, гарах хөдөлгөөнийг зогсоож, голомтод авах анхны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Халдварын сэжигтэй өвчтөн илэрсэн тухай мэдээг эмнэлгийн удирдлагад яаралтай мэдэгдэнэ.

Халдварлагдсан гэдэг нь халдвар авсан буюу бохирдсон, эсвэл халдвар буюу бохирдлын эх үүсвэрийг тээж яваа, ингэснээрээ хүн амын эрүүл мэндэд аюул эрсдэл учруулж буй хүн, гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмж буюу хүний цогцосыг хэлнэ.

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин мал, амьтанд халдварлагдсан үед шуурхай бүлгийн мэргэжлийн ангийн малын эмч, орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран халдварын голомтын болон сэжигтэй бүс дэх мал, тэжээвэр амьтанд үзлэг тандалт хийж, өвчний тархалтын зааг хязгаарыг тогтооно.

Цагдаагийн байгууллага тухайн тогтоосон хязгаарын хүрээнд хорио цээрийн дэглэм тогтоох бүсээ байгуулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд хорио цээрийн дэглэм тогтоох бүсийг өвчний тархалтын байдлаас хамаарч дөрвөн бүс болгон хорио цээр тогтоодог. Үүнд:

1. Халдварын голомтын бүс
2. Сэжигтэй бүс
3. Хамгаалалтын бүс
4. Эрүүл бүс

²⁴⁷ Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль //Төрийн мэдээлэл. 2001. №25

²⁴⁸ <http://www.legalinfo.mn/law/details/7957?lawid=7957>

Халдварт өвчний голомтын бүс. Энэ нь гоц халдварт, халдварт өвчин анх гарсан нутаг дэвсгэрт бэлчээр, ус нэгтэй нэг ба хэд хэдэн хот айл, байран маллагааны цогцолборыг бусад хот айл, цогцолбороос тусгаарлан хамгаалалтанд авч хүн, мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн хориглосон бүсийг хэлнэ.

Сэжигтэй бүс. Энэ нь бэлчээр, ус тусгаар боловч халдварын голомттой хил залгаа оршдог, уг өвчний халдвар авсан байж болзошгүй хэдий ч өвчний ил шинж тэмдэг илрээгүй байгаа хот айлуудыг хамруулан хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон бүсийг хэлнэ. Тус бүсэд байнгын харуул, харуулын цэг ажиллуулна. Сэжигтэй бүсийн өргөн 10 км-ээс доошгүй байх бөгөөд айлуудын байршил, тухайн бүс, нутгийн онцлогоос хамаарч дээрхи зай өөр өөр байна.

Хамгаалалтын дархлаажуулсан бүс. Уг бүсийг халдвар эхэлснээс хойш голомтын ба сэжигтэй бүсээс хүн, мал тухайн нутаг дэвсгэрт орж ирээгүй байгаа хот айлуудыг хамруулан сэжигтэй бүсийн заагаас гадна талд тогтооно. Хамгаалалтын бүсийн өргөн сэжигтэй бүсээс 10 км зайд орших бөгөөд өдрийн цагаар хөдөлгөөнт эргүүл томилон ажиллуулна.

Эрүүл бүс. Эрүүл бүс гэж хамгаалалтын бүсийн заагаас гадна орших өвчний халдвар дамжин тархах эрсдэл ба өвчний тархалтаас урьдчилан сэргийлж, дархлаажуулсан эрүүл мал бүхий нутаг дэвсгэрийг хэлнэ.²⁴⁹

Нэг сумын нутаг дэвсгэр дээр хоорондоо зайтай хэд хэдэн голомт үүссэн нөхцөлд тус бүр дээрх бүсүүдийг тогтоох бөгөөд голомтууд ойртох тутам тэдгээрийг нэгтгэн нэг голомтоор хамруулна.

Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь тууврын мал, тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний чиглэлд хүн, мал эмнэлгийн байгууллагатай хамтран шалган нэвтрүүлэх цэг, шаардлагатай үед тусгай зөвшөөрөлгүй ариутгал хийлгээгүй ачаа, хүнсний зүйл оруулах, иргэд болон тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхэд хяналт тогтоох зорилгоор дараах ажиллагаа явуулна. Үүнд:

- Хорио цээрийн дэглэмийг хангах, нийтийн хэв журам сахиулах ажлыг уг дэвсгэрт байгаа цагдаагийн байгууллагын хүч хэрэгслээр гүйцэтгэнэ.
- Цагдаагийн байгууллагын ажилтан бүрт урьдчилан сэргийлэх тарилга хийлгэж, ариутгах хэрэгсэл олгож, тэдгээрийг ашиглах журмыг заасан байна.
- Халдварын голомтод албан үүрэг гүйцэтгэх хугацааг эмнэлгийн албатай тохиролцсоны үндсэн дээр цагдаагийн байгууллагын дарга тогтооно.
- Хорио цээр тогтоосон дэвсгэрийн гаднах бүслэлт болон халдварын голомтод хорио цээрийн арга хэмжээг хангахад хөрш зэргэлдээ орших аймаг,

²⁴⁹ Даваадорж, Г., Цогтбаатар, С. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. 2009. Улаанбаатар. х. 58

хот, дүүрэг, орон нутгийн бусад байгууллагын хүн хүчийг Монгол Улсын шадар сайдын шийдвэрээр татан оролцуулж болно.

- Усан хангамжийн эх булаг, усан сан, халдварт өвчнийг эмчлэх, эмнэлэг өвчтөнтэй шууд харилцаж байсан хүмүүсийг тусгаарлах байрыг хамгаалтад авна.

- Хорио цээрийн дэглэмийг иргэд, албан тушаалтнаас сахин биелүүлж байгаа байдалд хяналт тавих, түүнчлэн эрүүл мэндийн ба мал эмнэлгийн байгууллагаас хяналт тогтоох арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх, эргүүл пост гаргана.

- Халдварын голомтын бүсэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажлыг зохион байгуулна.

- Онцгой тохиолдолд хорио цээр тогтоосон дэвсгэрийн хилийн дагуу бүслэлтийн хоёр дахь шугам тогтоож, зохих зөвшөөрөлгүйгээр халдварын голомтоос гаргах, голомтод орох явдлыг хориглох зорилгоор шилжүүлэн нүүлгэх цэг байгуулна.

- Эрүүл мэндийн болон мал эмнэлгийн байгууллагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулахад дэмжлэг үзүүлнэ.

- Тээврийн хэрэгсэл, явганаар зорчигчдыг халдварын голомт тойрон явах замыг тогтооно.

- Хорио цээр тогтоосон дэвсгэрт хорио цээрийн албыг зохион байгуулж цагдаагийн байгууллагын даргатай найдвартай холбоо, харилцан, хамтын ажиллагаа тогтооно.

Малын гоц халдварт болон халдварт өвчний гаралтыг бүрэн таслан зогсоож, мал эмнэлэг, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авсны дараа мэргэжлийн албадын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр хорио цээрийг цуцална.²⁵⁰

Өвчний гаралтыг таслан зогсоож, мал эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээг зохих зааврын дагуу хэрэгжүүлсний дараа хязгаарлалт, хорио цээрийг тэдгээрийг тогтоосон байгууллага, албан тушаалтны шийдвэрээр татан буулгана.

Цагдаагийн алба хаагч хүн, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин гарсан хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд орон нутгийн төрийн захиргаа, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, үүргийг чанд сахина.

Дүгнэлт. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин нь агаар дуслын зам болон ойрын биет харилцаагаар дамжин тархаж, эрүүл мэнд болон эдийн засгийн хувьд ихээхэн хор уршиг учруулдаг хөнөөлт өвчин юм.

Цагдаагийн байгууллага, алба хаагч хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан бүс, нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн дэглэм сахиулах,

²⁵⁰Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 1994 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн А/54 тоот тушаалаар батлагдсан “Хязгаарлалт, хорио цээрийн тогтоох журам”

хязгаарлалт тогтоох ажиллагаанд татагдан оролцдог бөгөөд ажиллагааны явцад халдвар авах магадлал өндөр байдаг. Тиймдээ ч цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч, халдварт өвчний тухай ойлголт, онцлох шинж тэмдэг, дамжин тархаж халдварлах замын талаарх мэдлэгийг олгох талаар бодлогын хэмжээнд анхаарах шаардлага байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдад “Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний тухай ойлголт, илрэх шинж, халдварлах зам” сэдвээр эрх зүйн мэдлэг олгох тусгайлсан сургалтыг жил бүр зохион байгуулах;

2. Халдварт өвчний үеийн хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч нарт зориулан “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зүйн заавар” боловсруулж, хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

3. Нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч нарт зориулан “Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” гарын авлагыг Цагдаагийн сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран боловсруулах.

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хяналт тавих тухай хууль
3. Эрүүл мэндийн тухай хууль

Ном бүтээл

4. П.Дамдин. Гамшгийн эрсдлийг бууруулах менежмент. УБ.2005.
5. Г.Даваадорж, С.Цогтбаатар. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. УБ. 2009.

Цахим эх сурвалж:

6. <http://uv.mohs.gov.mn>
7. <https://mn.unansea.com>
8. <https://m.easylaw.go.kr>
9. <http://www.legalinfo.mn>

Сэтгүүл, эмхэтгэл

10. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №21
11. Төрийн мэдээлэл. 2016. №07
12. Төрийн мэдээлэл. 2001. №25
13. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №46

Бусад эх сурвалж:

14. Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралт. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр
15. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 1994 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн А/54 тоот тушаалаар батлагдсан “Хязгаарлалт, хорио цээрийн тогтоох журам”